

Д.ПҮРЭВДОРЖ



ТАРЧИЛСАН СҮНС

Тарчилсан сүнс
Зохиолч: Д.Пүрэвдорж

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

“АМЬДРАЛЫН НУЛИМС” ХЭМЭЭХ

ДЭЭД БҮЛЭГ

Чөдөртэй ухаан

...Хаалганы хонх гаслах мэт гангинахуйд миний зүрхний ховдолд мөсний хэлтэрхий унах лугаа агдасхийв. Өтгөс маань толгой дээрээ хонхтой нүд анихын түүс болдгийг санаад ч тэр үү энэ хэлгий хонх муу ёрлож , миний толгойг эрж уйлагнаад байх шиг.

Би гэдэг буруу номтон, бөөмсүү зангүй атал харин одоо ямар нэгэн далдын хүчний эрхшээлд мөлхөн буй ажаам. Ерөөс хүн үхлийн өмнө эрүүл саруулын омогшил, үзэл бодлын мугуйдал, маргаашийн шалдар горьдол мэтээс ангижирч, сэтгэл цөлшихүйд оюуны хохь хоосон зайг бурхан хойд насны мухар сүсгээр цагган өөрийгөө дэмий мэхлэхийг оролддог буй за. Цагтаа “Хэнхэг” Хөнхөр, час улаан коммунист хочтой явсан би,үзэл суртлынхаа үнсэн дээр одоо хөрвөөж хэвтэнэ. Хуруу инчдэх зуур хорвоо холбирч хоймрын бурхад шоо болохын чинээ зүүдэлсэнгүй явжээ. Улаан даавуу харуулахад улангасан дайрдаг суманд сэглүүлсэн цуст тоглоомын бух шиг явсан би өнөөх өмхий хөрөнгөтнийхөө хөлд хөх адсагаа дэвсжээ. Инженер Ламид надтай тохууралцаж байгаад “Та улаанаас өөр өнгө мэдэх үү” гэж даапаалахад “ тэр чинь миний цус. Би цусаараа эрх чөлөө олж авсан юм” гэж сүржигнэсэнээ санаж байна. Гэтэл надтай хамт улаан оросын дэлэнг цус шүүртэл сорж байсан коммунистууд цөм чөтгөр, аз жаргалын алтан өргөө хэмээн үлгэр зохиож байсан диваажин хий үзэгдэл болчих ч гэж дээ.

Цагаан морин жилийн булгианд харуулдан унахдаа, тархи нь суга үсэрсэн гавлынхаа хөндийд нялзуур төдий үлдсэн хөх эсийг цоомойлох гэж би ядаж байна. Энэ бол эцэг дээдсийн хэлхээнд хулгайгаар нууж үлдсэн үндэсний үзлийн үр хөврөл юм. Бид уг гарваль, эх оронч үзлээ онолын шоронд хорьж, түүнийгээ устгах гэж адангатаж явснаа хичнээн зальхай ч зөвтгөж чадаа гэж үү. Ийнхүү би биеийн өвчин, сэтгэлийн зовлон хоёрын бахинд тасар хавчуулжээ.

Бархас орж ирээд:

-Данги уу гэж тоомжиргүйхэн асуугаад орны өмнөх мухар сандал дээр суухад сэрүү татах шиг болов.Тэрвээр миний мэндийн хариуг хүлээлгүй,

-Хөнхөр минь царай чинь сайхан байна гэж улайм цайм зулгуйдав.

-Яахав дээ хоногийн тоо гүйцээгүй юм болов уу даа...

-Чиний өөрийн лай ланчиг гэж юу л аж. Бурхан болооч эцэг эхийн сүнс л эргэж хургаад байгаа бололтой юм билээ гэж Бархасын өгүүлэхэд цочин харвал, түүний бугуй дахь шар буурцаг эрхи нүдэнд тусав. Одоо цагт элдэв үзмэрч , хувилгаад үлийн оготно шиг үржсэн болохоор би нэг их гайхсангүй. Харин энэ удган эрвээхэй, улс төрийн дэнд бус зулын тосонд

үйж үхсэн нь ч дээр биз хэмээн дотроо мушилзав. Өөрийн нь үгийг үл ойшоож буйг гадарласан ч юм уу Бархас,

-Чи ч яахав улаан хувьсгалч. Би бол улаан шар судалтай амьтан...

-Шар нь чамд илүү зохих болов уу

-Тийм ээ. Бурхан л биднийг аврана...

-Долоон зуун сүм хийд, зуун мянган ламтай байхдаа чадаагүй юмыг одоо барах болов уу даа.

-Чаднаа. Маркс бол бурханы дэргэд манай дарга “Хар” Сэтэв гэсэн үг. Бурханд л залбир.

-Яамай даа, самуун цагт улс төрөөс хол явсан нь дээр...

-Тэгж ч тэрийж хэвтээд турсагаа хуулуулахгүй гэж тэрвээр заналтай өгүүлэхүйд хамры нь самсаа нь сархалзан, нүд нь булингартан эргэлдэв. Би түүний согогтойг мэдэх тул жүдүүгий нь дэвэргэхээс төвөгшөөж хар цагаан дуу гарсангүй.

Бархас надаас хоёр үе мултарсан дүүмэд авч, тэнгийн мэт аашлана. Тэрвээр ерөөс ахлах захлахыг мэддэггүй, хүн бүхнийг “чи” гэдэг хярдуу зантай. Өнөөдөр харин үхлийн зайц эрж буй миний босгыг алхсны учрыг битүүхэн тандавч олсонгүй.

Бархас, миний тойнтрог бодлыг үргээж:

-Цаана чинь ардчиллын ”пизда”-нууд бидний хормойд түймэр тавьж байгааг мэдэж байна уу.

-Цаг нь болсон бол яая гэхэв.

-Болоогүй ээ. Эдний тоосыг гөвөх ёстой.

-Тэднээс бидний тоос л гарах байх даа.

-Гараг. Муу цусыг ханадаг биздээ.

-Ухаан хүрэхгүй юм даа.

-Хүсвэл хүрнэ. Эс тэгвэл золбин гөлөг болно.

-Чи чинь тэгэхээр аль талын хүн юм бэ дээ?

-Хол замд хос морьтой явдаг, хогийг хойроос гадна хатавчнаас шүүрддэг юм.

-Хэнийг шүүрдэх гэж ...?

-Дээрээс өнхөрсөн бул чулуу замдаа бусад чулууг оглож буудаг. Түүн шиг Сэтэв даргыг хусах гээд байна. Энэ хүний буянд чи бид эр эмгүй бөөр нь өөхлөж бөгс нь гадарласан. Сэтэв газар дээр ойчвол, мань мэт нь гав руу нь унана. Мэдэж байна уу. Түүнийг хамгаалж байгаа нэрээр

өөрсдийгөө аврах ёстой.

-Хэнээс тэр вэ?

-Ламид мэтийн новшнуудаас. Тэдний Ардчилсан Холбооны салбар өргөх бичиг барьсан. Бид ч хариуд нь барьсан. Харин чамаас уучлал гуйхад гарын үсгий чинь зурчихсан шүү.

-Сэтэв даргад ч чи хайртай даа

-Тэр муу халтар амтай пизда-д биш, би өөртөө, бас чамд хайртай. Тэр сарьсалсан буханд гунжны бөгс үнэрлүүлчихээд дуртай зүг рүүгээ хөтлөж явахад эмнэг дарга дөрлөх гэж ноцолдсоноос дээр. Тэгээд ч хуучин малгайг хадгалзнаад хаяхад толгой үлдэнэ. Амьдралаа зохиох газар нэг, алхаа буулгах гадас нэг бай гэж түүх бидэнд сануулж байна. Бид хоёр элбээд балбахад Ламид мэтийн гадасны тархи бяцрахгүй яадаг юм. Тийм биз дээ?

Би түүнийг цаашлуулмаар санагдаж ,

-Сэндэрмаа ч сайхан гунж даа. Чи тэгээд маргаашийн хадам аавыгаа сэжээд зэлэн дээр нь хэвтэш олдох болов уу...?

-Эцэг эхийн аяыг харна гэдэг феодалын янаглал. Ардчиллын үед аавыг нь “нет” болгосон ч хамаагүй. Эрх чөлөөт дурлалд эрэг байхгүй... Ар нь “түүз”.

-Хөзөрт чинь хар, цагаан хүн ч билүү байдаг байхаа.

-Бантангаасаа салах л гэвэл барын сүүлнээс чангаах байлгүй.

-Нээрэн тийм дээ. Бархасын өөдөөс сарвайдаг аминаасаа уйдсан хүн олдохгүй гэж би түүний омойтлыг хөөргөв.

Миний амнаас ийнхүү чихэр үг амссандаа оодорч буй бололтой тагтаачлан хүг хүг инээснээ ширээн дээрх зэс халаагуурыг шохоорон ,

-Маарамбад байдаг эд. Анагаахаас ардынх нь өлзий гэх болж. Сүжиглээд хүртэхэд шовойгоод ирнэ гэснээ бяцхан боодолтой юм тавиад одов.

Би гойгорон босч сайхь боодлыг задалваас цагаан даавууны өөдсөнд барласан ямар нэгэн бурханы дүр, мөн завилган боосон утлага байсанд галд хийж орхив.

Бархас хэмээх энэхүү үргэсэн тором шиг нүдтэй орон гаран хархүүд би сүжиг хүрдэггүй ч түүнтэй хэмхэлцэхээсээ төвөгшөөдөг юм. Элэнц дээдэс нь нэг өдөр Чингис хааны хиад боржигон, нөгөө өдөр Жамухын Жадран болно. Архи балгаж агсарахаараа Амбагай хааныг чинь модон илжгэнд хадаж алсан Алтан улсын удам шүү би, амбаарт чинь хадна гэж сүржигнэнэ.

Ураг хөөвөл Бархасын өвөг эцэг солгой Равжих хэмээгч нь зах хошууны цэхэр шилэн жинстэй хохь тайжийн охинтой ханилж байгаад хувьсгал болоход хар феодалаас толгой салж, эхнэр

охин хоёроо хаяжээ. Тэрхүү хоцорсон бүсгүй удам бутач хөвүүн төрүүлсэн нь Бархас гэдэг аж. Уг нь Гөнжөөгийн гэж эхээрээ овоглох ёстой байтал, Базар хэмээх багийн даргаар овоглосон нь зусар буюу хулгар эцгийн алин болохыг хэн ч үл мэднэ. Нутгийн нь хүн ийн хуучлахыг сонссоноос би үл хэтрэх бөгөөд хэрхэн түүний үүх түүхийг мэдэх сэн билээ.

Намайг амрах хооронд Сэтэв дарга түүнийг үйлдвэрлэлийн тасгийн тоо бүртгэгчээр авчихсан юм. Уг нь хойт газар хэлний сургуульд яваад овилгоноосоо болон орхиж албаны сэжүүр атгаж чадаагүй зайж явсан бололтой юм билээ. Бархас нам бус, бас тушаал асаргүйн тул намын талаас хяналт тавих онц шаардлагагүй гэж би бодсон тул долоон булчирхайг нь тоолоогүй, бусад номонд оюуны сөв хэр онгойсныг би мэдэхгүй. Харин орос хэл гэвэл “пиздаадахаас “ цаашгүй юм шиг харагддаг юм. Бархас бид хоёр “Иргэдийг үйлчлэх товчоо” хэмээх хачин нэртэй ёрын газар хоол хороодог бөгөөд би орлогч бөгөөд намын үүрийн даргын сонгуультай. Ламид гэж инженер бий. Бархас тоо бүртгэгчээс гадна Үйлдвэрчний хорооны дарга. Товчоор хэлбэл бид энэ болон хойт насны хил дээрх махан мануухайнууд. Сүүлийн үед Бархас бид хоёрыг Сэтэвийн тойрон “ хүрээлэгч” гэх үг чих дэлсэх болсон юм.

Сэтэвийг энэ газрын даргаар бурхан тохоосон хүн гэх нь бий. Одоо цагт тушаал голохгүй булаалцалддаг болохоор түүнийг огцруулах гээд байгаа юм байж л дээ. Сэтэвийн тойрон хүрээлэгчдийн нэг нь Жагай хэмээх ятга шаазгай шиг хүүхэн бий. Жагай манайдаа л “мисс” бөгөөд даргын туслах бичиг хэргээс гадна “нуудгай” нь гэгдэн хэрдээ сээрдэж огтор хамраа огшоосон нэгэн. Жагай байгууллагын ховыг балын зөгий мэт дарга руу зөөнө. Гэтэл хүний гэнэн барагдах биш дээ. Нярав Чойдор цоожны нүхээр шагайж дарга, Жагай хоёрын аашаа эвдэж байхыг харчихаад маргааш нь “Даргын өрөөнд далд цоож хийлгэмээр юм. Хараатайд байтугай хазгай надад хамаг юм ил байх юм. Би яахав хэлээ хазаад өнгөрөв гэхэд юмаар юм хийдэг улс захаас аван бий. Миний дүү мэдээтэй бай” гэж Жагайг улалзуулаад буулгаж авчээ.

Чойдор гэдэг нь манай нярав хуршсан шөрмөс шиг гувчгар шар хүн. Үсээ зулмайтал самнаад хэнэггүй царайлавч цаанаа нэг л хүйтэн, цагаан цорой царцмаар санагддаг юм. Уг нь “До” яамны доодох бөгөөд надтай тэр эртийн танил. Харин цэргийн гэдгээр эрт тэтгэвэрт гарч энд хоол хороох болсон юм. Бархас, Чойдор хоёр хөл хэрээтэй, хөсөг холбоотой. Эд нар л Жагай бүсгүйг олж ирээд Сэтэвийг дөрлөсөн. Хар Сэтэв болдоггүй газраасаа аргуулаагүй бол бас ч тийм зөөлөн хоол биш. Түүнд орлогч сайдын булган малгайнаас хуйх төдийхөн үлдсэн боловч хурган даргын суудалд гулсаж тогтсон нь энэ. Эхнэр нь “дээр үеийн өндөр шаардлага” гэж ярьдаг үжирсэн ямбатны охин шүр шиг улаан авгай бий. Нэр Гаапил. Гаапанз ч гэнэ. Сэтэв энэ авгайн буянаар гандсан сэтэр зүүж яваа нэгэн. Сэтэв эхнэрээсээ арваад дүүмэд тул хуурайсаж шалхайж сувсны ч амтгүй болсон түүнээс уйдаж, хааяа шинэ шөл уух шуналтай. Эднийх Сэндэрмаа хэмээх ганц охинтой. Өөтүүлэх хүнд даравгардуу гэхээс сайхан бүсгүй. Сэтэв энэ охиноороо “Тул” барих санаатай гэлцэнэ.

Эмч нар намайг “гэрийн асрамжинд шөл ус, ургамал амьтны гаралтай эм тангаар додомдвол тэнхрэнэ” гэсэн юм. Тэд үхэлд бууж өгөхөөрөө ингэдэг. Тэднийг үхэлд хүмүүсийг тушаадаг тууварчид гэвэл дэлбэртлээ уурлах боловч дотроо эвлэрнэ. Эмч нар биднээс ялгаатай нь үхэлд дасаж дол цохьсон хүмүүс. Хар дансаа зузаалах дургүй учир намайг гэрийн минь хаяанд цөлсөн гэдгийг би сайн мэдэж байгаа юм. Энэ мэтээр бүх юмыг өөчилж, гоочилдог

зан миний хүмүүжлийн жишиг биз. Насаараа намын сэтэртэй би хэн бүхний нэрэнд хөө түрхэж, буртаглах дадлаасаа салах нь нэгэнт өнгөрчээ. Үүнийгээ би дутагдлын хажуугаар дуугай өнгөрч чаддаггүй коммунист суртахуун гэж цагаатгаж явсан боловч миний өөрийгөө тойруулсан хаяавч нэгэнт тамтагран унажээ. Одоо зөвхөн гутралын буданд ертөнцийг харах гэж тэмтчиж хэвтнэ. Энэ бол гайд гарсан бурангуй хүний ганцаардлын эмгэнэл цөхрөл, мухардал, самгардал төдийгөөс юуны хэтрээ аж дээ. Миний нэг том нүгэл бол хувь хүмүүсийн санаа бодол аяг араншинг өөрийн болхи хэмжүүрээр өөтүүлэн хүн бүхнийг нэгэн эрхинд хэлхэх гэсэн хэзээ ч үл бүтэх дээрмийн оролдлого бөгөөд биеэр хохирогч нь болж үлдсэн харуусалт хувь заяаны хэлтэрхий л үлджээ.

Би элдвийг эрэгцүүлэх гэж саваагүйтэж залуудаа гүн ухааны солио тусч явсан толгой. Миний нэгэн найз намайг “философийн гуйлгачин” гэж шоолсон удаа бий. Гэхдээ миний гүн ухаан Марксын сургаалд хагас хандарснаас хэтрээгүй. Өрнө, дорнын номын үүдэнд нохой уяатай байсан болохоор довон дээрээ догонцох төдий асан нь оронд хадаастай энэ үед орчлонг тайлахыг оролдох гэтэл ухаан өрөөлдөж биеийг чилээх гаслан. “Тэнэгийн ухаан үдээс хойш” хэмээх нь миний өрөөсөн гутал дуганцаг болохдоо дуу алдсан гаслал байж таарна. Би бол ухаан явгадахад, оюуны үгүйрэлд нэрвэгдсэн амьсгаатай хүн мах. Би дурсах санах түмэн учралын ширэлдээнээс үзүүр үл олох алжаалд арга буюу автаж, мааньтай нулимс өдөр бүхэн хэлхэж хашаа гэр хоёрын хооронд бодол санаа минь чөдөрлөөстэй үлджээ.

* * *

Алаг зэрэглээ

...Амьдрал гэж юу вэ? Үхэлд хөөгдсөн хүмүүн сүргийн гэнэхэн хүсэл, үл гүйцэлдэх мөрөөдлийн зэрэглээ. Үүнийг үгүйсгэх гэсэн алив засдаг үг сонсохоос нуруу даган жилбэн гүйж, ертөнцийн жам буюу балар тавилангийн өмнө хүн хэмээх ухаант адгуусны хүчин мөхөсдөж тарчлахыг би улам бүр мэдэрч байна. Амьдрал гэдэг орчлонгийн зүүдэнд аз жаргалын солонгыг харан хууртах нь юутай мунхаг үнэмшил вэ. Одоо би адраас дүүжлээстэй чийдэнгийн цонхир цагаан галт бөмбөлгийг тэврэн үхэх гэж адган буй золгүй эрвээхэйг харж байна. Үйлийн үрдээ хөтлөгдөн үдэшжин удгалж үнгэлдсэн далавчаа хумхалж бараад улайдсан зуухан дээр тэр унаж үнс ч үгүй болов. Хүн гэмээн үүнээс ялгагдах нь өчүүхэн бээр үгүй агаад мөнөөх аз жаргал хэмээх сэтгэлийн сэвээ барьж авах гэж насаараа гал руу дайрлан хярвас болох бөлгөө. Тэд үүнийгээ тэмцэл гэнэ. Тэр ч байтугай үнэний төлөө агуу их эрэл гэж ойврон өөрийгөө ховсдож чадна. Магадгүй ийм мунхагтаа ч гэх үү үнэг мэт үхлийг гүвээ даван мартдагтаа амьд явдаг биз. Өөрийгөө мэхлэх ч яахав, хохь нь тэр. Гэтэл тэд биесээ могодорлоход хэт мэргэжсэнийг яана. Энэ талаараа сайд, хулгайч, цагдаа, яруу найрагч, яс баригч, янхан, лам хувраг цөм адил луйварчид. Өнгөндөө бусдын төлөө амьд яваа гэж хүмүүс домоглох дуртай чиг дотроо явган хонжоо тооцож, яаж нэгийгээ араар нь тавих тухайгаа л бодож явдаг. Энэ бол тэдний дон, бурхан, чөтгөр хоёрын аль алинаас өмчилж авсан араншин. Үүгээрээ тэд бусад бүх адгууснаас долоон дор бөгөөтөл түүнээ нууж төрөлхийн бардам омгоороо хамгийг хаанчлах гэж улайрна. Гэвч долгонцог сэтгэл ханах гэж ер үгүй. Тэдний сэтгэл гэдэг нь цадахыг мэдэхгүй мангасын ходоод тул нэг нь нөгөөгийнхөө эд агуурс, эр, эм, эрх дарх, алдар нэрд атаархан сувьдах учир амар заяа үл үзнэ...

Би бодлоосоо түр ангижрах санаатай дэрний шургуулга тэмтрэн толь авч өөрийгөө хармагц хэрдхийн цочиж “хөөрхий дөө муу Хөнхөр ч өнгөрчээ. Сүлд нь зайлчихаж” гэж ганцаар гүнгэнэв. Угаас ухархай цөмгөр шавилдуу царай дортон л доо. Ямар сайндаа сангийн нэр Очир атал хочоороо Хөнхөр гэж нэрших вэ дээ. Хэзээ нэгэн цагийн долгиотой үс үгүй болж, миний нүүрний гэрэл гэгээ унтарч, гагцхүү агсамаасаа болж хянгы нь сэт цохиулсан модон хамар л үлджээ. Алтан Найдангийн хүү ингэж ч сүг сүүдэр болох гэж дээ. Эцгийн минь нэрийг дуулбал энэ Улаанбаатар хотод эхнэрүүд нь уулга алдаж, эрчүүдийн нь зүрхэнд шар ус хурдаг байсан юм гэнэ лээ. Овсгоотой панзчин, азтай мөрийчин тэрвээр ялангуяа буу тоглож баян хужаа нарын хүүдийний амыг уруу нь харуулж гөвсөн гэх дам үг бий. Эцэг минь амьд сэрүүндээ “Нэг хэсэг тоглоомонд хорхойсож халуурах болсон юм. Тэгэхдээ өглөгийн эзэн, Жандагийн лүд байгаагүй. Азхүү байхад ёозхүү байж авах алдахын аль аль байсан. Сүүлдээ аз харьсан уу, хараал чатга нь байсан уу, шооны нүх цайраад ирэх шиг болсон. Тэгээд “нодго” Жамбал, “ондго” Гүнсэн гээд их гарын мангаанууд ангаалж хавсайдах янзтай болоод ирэхэд хүзүүгээ халцартал ацлаж хөгнөнөөс мултарсан. Угаас тарвага, тоглоом хоёроор хөлждөггүй гэдэг үнэн. Эмээлээ үүрээд эхнэрээ хөтлөөд нохой явган, гахай нүцгэн үлдэж байгаа хүнийг харсан...” гэснээс өөр тоймтой юм надад хэлээгүй. Үгэндээ харам хүн байсан болохоор би ч хэл амыг нь сугалчих гэдэггүй байжээ. Гэвч галав шалав гэсэн огцом хөдөлгөөнтэй давжаахан биетэй намрын цооргонын навч шиг тэр сээмгэр шар хүн буянаа хэлтэлж надад орхисон юм шүү.

Хаалганы хонх гонгинов. Энэ ч лав Сайнаа биз. Уг нь Сайнсанаа боловч Сайнаа гэж нэршсэн

юм билээ. Тиймээ, совин андуурсангүй.

Сайнаа бол хүлцэнгүй бор нүдтэй, ялимгүй сэвхэрсэн нимгэн царайтай дунд зэргийн нуруутай махлаг бүсгүй. Үүдэн хоёр шүд нь үл мэдэг цөмгөр нь хүртэл эгдүү хүргэм. Хал зовлон үзсэн боловч хар багаас өссөн гэр орчны хүмүүжил түүний яс маханд нэвчин шингэсэн гэмээр санагддаг. Тэрвээр эм хүн бол эр хүнд зөвхөн орны жаргал өгч, орчлонгийн бусад жаргалыг хариуд нь авах ёстой гэж итгэдэг.

Эмнэлэгээс ховхорч гэртээ ороод манайх гэдэг айлын яргуй шиг аз жаргал гандчихаа юу даа гэсэн айдас надад төрсөн юм.

Сайнаа орж ирээд эгэлдрэглэсэн цүнхээ мөрнөөсөө мултлан авдран дээр шидэж орхиод баруун орон дээр буруу харан бүхэл хэвтээд төдөлгүй хурхирч эхлэв.

Биднийг дурлал, тэчъяал, шунал, амин зуулгын хяхал, цөхрөл, тайтгарал, хуурмаглал чухам аль нь холбосон юм бол гэхчлэн би элдэв бодлын эргүүлэгт живэв.

...Бурхан хүнийг хэрхэн бүтээсэн юм бол? Эр эм бурхан нөхцөж анхны хүн нярайлсан юм болов уу? Гэтэл тэр эр эм дээдэс өөрсдөө яаж бүтсэн байж таарах вэ? Тэд заавал нэг сөв сүлбээрээс гарсан байх ёстой. Алун Гуа эх юу гэдэг билээ...? Өрх тотгоор шөнө бүр нэгэн цагаан шар хүн орж ирээд миний хэвлийг илэхэд хүүхэд олов гэдэг байхаа. Мөн ч сийрэгхэн айлдаж байгаа юм шүү Тэр цагаан шар хүн хэвлийд хүрсэн байхад хэрхэн цаашлалгүй тогтохсон билээ. Цагаан шар хэмээгч надаас ялгаатай нь тэнгэрийн хоноц л юм биз. Тэнгэр бурхан арай ч тэгж хатавчаар мутраа шургуулж харанхуйд унь тоолж гэтмээргүй еэ.

Эвэртнээс эхлээд над шиг мугалзуурууд цөм тэнгэрийн зарлигаар тэлээ тэмтэрдэг гэж үү. Хн... ёстой нохойн аргал байгаа даа. Хар Сэтэвээс эхлээд харцаараа хүүхнүүдийн дотоож шувталж байдаг мунагуудыг хөнгөлвөл таарна. Тэд нар морь шар шиг болвол энэ хорвоо ариусахсан билээ...

Ойрдоо Сайнааг ажвал түүний нүд ус гүйлгэнээд байх шиг. Би ийм нүдийг бишгүй харсан сан. Тиймээ, хуучин есөн гудамж гэж байхад иймэрхүү усан нүдтэй том алтан ээмэгтэй, хөв чийг хүнгэр дэлссэн хөвхөр царайтай эхнэр хүүхнүүд өндөр шургааган хашааны үүдний дааман хаалганы хажуух сандалд нарлан суудаг сан. Хятадын эл эмс охид гэдэс цатгалан авч сэтгэл өлөнгөөс хот хүрээний элдэв зайгуултай хормой ороолдож голцуу бөөр бөгсний өвчтэй тул ийнхүү усан нүдэлж асан. Гэтэл Сайнаагийн нүд тийн харагдах нь юу вэ? Намайг хоёр сар эмнэлэгт хэвтэхэд тэрвээр хэн нэгэн мунаг эртэй тэлээлж, өөрийгөө цөлмөсөн байж болох юм. Хэрэв тийм бол энэ бузар эмийг гал унуулж ариулахсан гэж амь тэмцэв. Гэвч яая гэхэв, эр хүн эмээлийнхээ оломцогийг элээж чадахгүй болох өдөр ирдэг аж.

Сайнаа надаас хорь гаруй дүүмэд. Намайг анхны эхнэр Цэвэлжидийнхээ өвөрт үнгэлдэж байхад өлгийд чарлаж ойчсон цурав гэж бодохоос анхандаа халгаж байсан ч үүлэн борооны үйлээр нэгэн дэрэнд хэвшсэн юм. Сайнаагийн аав хужаа багад нь өнгөрч, эхийнхээ нөмөрт хоргодон мөчиг тачиг хоолонд хүрсэн юм билээ. Эх Норжинхуар нь цагтаа хүрээ гангачуулын дунд “опель” дугуй, өдөн малгайтай гунхаж явсан ч луухаанаасаа хойш бэл хөл алджээ.

Хоёр жилийн өмнө манай хамар хашааг худалдаж аваад хаяа хатгасан ч мэндийн солионоос хэтрээгүй билээ.

Миний анхны хань Цэвэлжид бидний дундаас гурван хүүхэд төрсөн ч бүтээгүй учир элэг дэвтгээх ганц хүү өргөж авсан нь Оргил юм.

Цэвэлжид минь эхээс хөюул. Ганц дүү Халзан нь хогийн баазад хормойгоо чирсэн тэрэг барьдаг, ядмаг боловч сэтгэл сайхантай гутгар эр бий. Эцэг нь ногоон Дуйнхар гэж товхийсэн малтай, хоймор ашилсан бахим хар хүн байсан юм. Хамтрал хомууны хаялагаар хөлжсөн ч албан татвар, амиггүй малын оногдолд сөхөрч, үлдсэн хэдийгээ нэгдэлд өгчихөөд хотод хоргодон зулаг гээж билээ.

Социализмын туршлагын сармагчин болсон үй түмэн малчин хувхай модоо барьж хот суурин руу дүрвэн шигэхэд буурин дээр нь шарилж ургасан. Гучин долоо, найман оны их хядлагын дараа манай нам Монголын голомтыг ийнхүү самардсанаа хорин нэгэн оны хувьсгалтай дүйцэх хувьсгал гэж улаан даавуун дээр цагаан шохойгоор бичиж байхад би ч оролцсон нүгэлт амьтан. Одоо бодоход тэр үгийг малчин хүний цусан дээр ясаар нь бичиж байжээ гэж санахаас гол харлана. Цагийн салхинд хөөгдөж ирсэн тэр хүмүүс хотын захын борчуулын хорооллын хаяаг тэлж байсан бол өдгөө эрүү өвдөг нийлсэн тэр өтгөс үерийн халианаас гээгдсэн жараахай шиг хаягджээ.

Цэвэлжидийн маань эх Цэнд хэмээх гэдсээрээ хөхөрсөн монхор бор авгай. Ааш зан, ус унд, ажил үйл аливаад тэгшхэн хүн байж билээ. Нөхрөөсөө хойш удаагүй дээ. Хүмүүсийн хорон амнаас цаад золиг хань татчихлаа гэсэн үг ч унаж л байсан. Ханиндаа явах ёстой ч байсан юм билүү...

Миний аав, хадам эцэг хоёр худ урагсаж нутагсаж сүйд болдоггүй, нэг нь нөгөөгийнхөө сэтгэлд нэвтэрч чадаагүй юм даг. Бодвол нүгэл буянаа мэддэг болохоор хэн хэнээсээ цэрвэдэг байсан биз. Харин хоёр ээж “муусайн хүүхдүүд минь” гэж тал талаас хушуу дэвсэж зовлон нимгэлэхээр манайд уулзан, хал балгүй тулга тойрсон бор хууч хөөрч суудаг асан. Чухамхүү энэ хоёр эхийн сэтгэлийн бэлчирт Цэвэлжид бид хоёр дэндүү хатуу гэсгээлт хорвоод хайр сэтгэлдээ ямхын төдий зай олж, үүдэн хоймрын жаргал эдэлсэн юм. Гэвч энэ тэгшрэл аз жаргалын алаг зэрэглээ байлаа.

Амины уяа

Эцэг минь өөрийгөө Илдэн Бэйлийн хошууны ядарсан ард, морин унаатан, модон янгиатан гэж хошигнох дуртай. Тэр Илдэн Бэйлийн хошуу гэдэг нь Өвөрхангайн Хужирт сум хавиар юм билээ. Би аавтайгаа нэг зун очиж түүний үеэл ах “муна” Онолт гуайнд хэд хоносон юм. Дулаан хэмээх сархиагтаа суганы үс шиг модтой хөх уулыг хүрэлгүй Дуутын гол гэдэгт очсон санагдана. Аав намайг нэг өдөр дагуулан мордож оорцог толгойн өвөр дэх хульширсан хондон дээр аваачаад удаан сууснаа чимээгүй урсах нулимсаа гарынхаа алгаар арчиж,

-Чиний өвөг эцэг Чогсом гэдэг хүн эндээс баригдсан юм. Мөн ч их буянтай хүн байсан даа.

-Тэгээд...?

-Аваачаад алчихсан юм

-Хэн...?

-Улаан засаг...

-Яагаад?

-Хошуу тамгын газар бичгийн түшмэл байсан юм. Тэгээд л хувьсгалын эсэргүү феодал гээд л... лам хар мөн ч олон хүний толгой залгисан даа. Нүгэл нь нүдээрээ гарах цаг ирэх л вий. Тэр болтол миний хүү гурван үеийн түүх, биеийн байцаал мэтэд “өвөг эцгээ мэдэхгүй. Эмэг эх Нүрэн гэдэг малчин ард байгаад өнгөрсөн гэж байгаарай. Би эцгийнхээ ясыг өндөлзүүлэхгүй гэж эхээрээ овоглосон юм. Тэгээд ч эсэргүүний удам угсаа гэвэл цаадуул чинь бүх насаар чинь хэмлэнэ” гэж захисан билээ.

Би намд орохдоо ч ингэж л хэлж орсон. Тэгэхдээ намд хайртайдаа бус албаны дөрөөнөөс аягаа тосох гэсэн дажинг дагасан билээ.

Онолт бандгайн айл Орги гуайн хүү Паламтай сайхан танилцав. Шоомондуу чихтэй, өргөн цээжтэй улаа бутарсан энэ хөвүүн надаас цөөвгөр ах учир анхны яргуй зулгаасан ямаа шиг амьдралын амт үзчихээд ид л хорхойсож явсан юм.

Палам нэгэн өглөө морь дэллэж байснаа цагаан шүд яралзуулан инээж:

-Чи юм үзсэн үү?

-Юу тэр вэ?

-Хүүхэн... гээд надаас харцаараа хариу нэхэв. Би муур харсан хулгана мэт бүлтэгнэснээ нэрэлхэх ухаан олж

Хотод юу л байна, хүүхэн л байна гэж саймшрав.

-Их эр байх нээ... гэж тэрвээр дахиад л тачигнатал хөхөрснөө тэртээ баруун ухаад бэлчиж байгаа хонийг зааж ,

-Ногоон Дуйнхарын охин яаж хаяанаас ховхорч хамар дээр гараа юм бол гэснээ,

-Чи цоолж үзсэн үү гэв. Би учрыг нь олсонгүй, толгой сэгсрэв.

Палам миний мөрөн дээр падхийтэл алгадаад,

-Гөлгөөрөө байна даа. Эмнэг байдас шиг чарладаг юм шүү дээ гэж хэлэхдээ аазгай нь хөдлөж байгаа бололтой алгаа үрчснээ,

-За мордьё гэв.

-Уяанаас тэр эгц хойшоо хөдлөхөд би хонины хээрээр навсайтал даган цогиулав. Ашгүй хүүхэнд очихгүй, айлд буух нь ээ гэж бодож явтал,

-Энэ ухааг арлаж очихгүй бол болохгүй. Бузар ороо гичий байгаа юм. Зугтана, ороолгоно. Уг нь нэг л хатгаад өгвөл номхорохгүй хаачих вэ. Даанч баригдахгүй байгаа юм. Хотын чамайг хөлдөө суулгаж магадгүй. Цулбуураас нь нэг л барьж авсан байхад эмээлтэй нь хуу татаад тохом дээр нь өехийгий нь өөд нь харуулж, ах нь өвчүүгий нь түшээд өгнө. Эр хүн байна даа чи, хүүхэн цоолж үз л дээ гэхэд нь би айх шиг болов. Хэрэв тэр охиныг Палам барьж байгаад намайг дээр нь гаргадаг юм гэхэд би чадахгүй байв. Би чинь юу ч үзээгүй юм чинь. Манай арын хашааны банди “эхлээд эгч нараараа заалгадаг юм. Хоёр сураагүй хүн гижиг хүргэхээс хэтрэхгүй “ гэж байсан нь санаанд орж намайг улам ичээв. Хэрэв чадахгүй бол намайг манин ч гэдэг юм уу, чавганц гэж шоолох тул шалавхан хот руу буцахаас өөр арга санагдсангүй.

Би хамар дээгүүр гарч ирэнгүүтээ “хай хэг” гэж хашгирахад хонь сортолзож Дуйнхар гуайн охин .мориндоо үсрэн мордов.Палам над руу муухай харж,

-Яаж байгаа хувхай зульч вэ. Одоо цахилчихнаа гэж шүүрс алдав.

Зугтаагаасай гэж амь тэмцсэн боловч хоньчин охин тэгсэнгүй, биднийг тосч ирээд мэнд усаа мэдэлцэв. Палам хоры нь хусаж,

-Чи их зугтдаг хүн, зугтахгүй яагаав.

-Чамаас бол зугтана. Чамтай хүн яваа болохоор яарсангүй.

-Чи Хөнхөрийг арай хүүхэд гэж бодоогүй биз. Алтан Найдангийн ганц хүүг басч байгаа юм биз дээ. Энэ чинь Баатар хотын хүүхнүүдийг барчихаад хөдөөнийхийг чамаас эхлэх гэж яваа юм шүү гэж Паламыг ангалзахад би ичихдээ нүүр хийх газаргүй болж тонгойн эмээлийнхээ бүүргийг хумсаараа дэмий л зурчив. Хүүхэн мөчөөгөө өгсөнгүй.

-Ямар ч байсан би чамд л хүртээлгүй гэж тас ширвэв.

Паламын хор шар нь буцлав бололтой “хүртэнэ дээ” хэмээн цулбуурдах санаатай ухасхийх

гээд шилбүүрийн суран хуйваар гувруу гүйтэл ороолгуулж хацраа даран “яадаг гичий вэ” хэмээн дальдчин мориныхоо амыг татав.

Хүүхэн нисэн алдаж байгаа сайхан загал морио арай ядан тогтоож агаар цалгитал тас тас хөхрөөд “ахиад хуйвны амт үзмээр байна уу” гэсэн шиг шилбүүрийнхээ хуйвыг ончруулан хий шавхуурдсанаа, надад хандаж,

-Цаадах чинь далдраг. Хоёулаа хонины хошуу эргүүлье гэж Паламд дуулдахаар хэлэв.Бид хоёрыг дөрөө харшуулан эргэхэд Палам миний араас

-Ахаараа амы нь хагалуулсан бол дээр байсан юм даа. За яахав, өөрөө мэд. Наадах шиг юмыг би царайчлахгүй. Салаа салтаатай юм мундсан биш гэснээ морио ташуурдан хар хурдаараа одов.

Хүүхэн түүний араас харж жуумалзан,

-Хөвсөргөн цагаан амьтан. Ам нь даанч болохгүй. Хонины хишигтэй өдөр хааяа ирж нэг ороолгуулаад буцдаг юм гэж хэлээд алчуураа засч зангидав.

Бид хоёр хонины бэлчээрт энэ тэрийг хүүрнэн нар хэвийлгэв. Гилбэртсэн хар гэзгээ хагалан ганц сүлжээд угт нь нарийхан сувдан даруулга зүүсэн нь түүнийг онгон эрхэмсэг болгожээ.Үл мэдэгхэн туяа харвах улаан хацар, нумарсан хар хөмсөг, монхордуу хамар жимбэгэр уруул нь түүнд гайхалтай зохисон нь сэтгэлийг гижигдэж би түүний гоо үзэсгэлэнгийн өмнө сүрдэн автаж байгаагаа өөрөө мэдэрч билээ. Хот руу буцахынхаа өмнө би түүнтэй уулзаж,

-Би чамайг мартаггүй. Захиа бичнэ. Чи битгий мартаарай гэхэд,

-Би ч мартаггүй л дээ. Хотынхон л мартчихдаг юм гэнэ лээ гэж уйтгартай хэлсэн юм. Гэвч бид хэн хэнээ мартаагүй хойтон намар нь тэр маань Анагаахын дундад, би санхүүгийн сургуульд орж удалгүй бид хоёрт аав минь хашаандаа шинэ гэр барьж өгсөн билээ. Цэвэлжид бид хоёр ингэж нийлсэн юм.

Аав нэгэнтээ:

-Бурхан чөтгөр хоёр буруу зөв үүдээр орж гардаг байхад ногоон Дуйнхар бид хоёр худ ураглаж болохгүй нь юу байхав. Ганц хүүдээ галы нь асааж өглөө л байна. Цэвэлжид эцгээ бус, Цэндийг дуурайсан бололтой юм. Хүүгий минь мөрийг улалзуулахгүй биз.

-Дуйнхар гуай та хоёр нэг голын байдаг нь аштай юу.

-Нэг гол байтугай , нэг умайд сор шаар гэж байдаг юм. Бидний явдал та нарынхаас тусдаа. үүнээс цааш үгэнд дурлаад хэрэггүй гэж билээ.

Би битүү тандахаар ээжийг номгочилох гэсэн авч,

-Баривчилга, тавилага, феодалын хөрөнгө хураах үеийн юм байдаг юм болов уу даа, мэдэхгүй

гэснээр мухардаж билээ.

Аав минь буурлын буян гэсэн амны уншлагатай байсныг бодоход өвөө баригдахынхаа өмнө хүүдээ өгдөгөө өгөөд шавхруугаар нь улааныхны амыг хаасан байж мэдэх юм. Тэрхүү амин зуулгыг аав минь салхинд хийсгэчилгүй хямгадаж холбируулж гэмээн өөрөө хонхолзолгүй амь зууж надад хишиг огтолж өгсөн байж таарна. Энэ л намайг горойлгоод амь насны аргамжааны гадас болчихоод байна. Би тэр гадсыг нулимстай ботго шиг тойрч үүдэн хоймроо халцлан цээжиндээ хоргомжийн гуниг чихэн тарчилж хэвтэнэ. Бурханд баярлаж, сэтгэл уужлах ганц юм гэвэл төрөх үхэхийн хувийг ялгаваргүй хүртээжээ. Эс тэгсэн бол үхдэггүй хаад, баячууд, дарга нар насалдаггүй гуйлгачингуудын орчлон бүтэж, эрлэгийн элчүүд нь замын цагдаа шиг гар харж нөгөө ертөнц ч шударга гэсгээлийн толио луйварчингуудад алдах байсан биз. Гагцхүү тэр толинд манай “хулгаруудын” сачий сарвуу хоёр дугах бөгөөд тэд бол улсын мөнгөний авдрыг дундаа тавьчихаад улаан дүнс шиг ороож чадахаас бус оюуны түлхүүрээр орчлонгийн нэгээхэн нууцыг онгойлгож чадахгүй. Махан тэргүүнтэнүүд. Тэдний сагуурал нь уурагны тугалын зунгаг юм. Би, мөн тэдний урхаг агаад монголын ходоодны мухар олгой. Мухар олгой хэмээгч нь байхад илүүдэхгүй үгүйд дугахгүй эрхтэн гэдэг. Тэгэхдээ бас авах гээхийн таалалд бус аминд аргамжаатай гэмээн олох ба гээхэд амаргүй. Ямарч атугай чөтгөрийн хорхой хүргэдгийг бодоход бурхан илүү юм хүнд лав дайгаагүй дэг.

Аав минь чилээрхэж ахуйдаа

-Бурхан хүүд минь гишгүүлэх зулай өгсөнгүйдээ гэж шүүрс алдаж билээ. Энэ үг орой руу оржээ. Хажуулдсан өнчин хайлаас би ханьсал эрээд хаачих ч билээ. Хөлтэй явахад хөлхөж байсан нөхөд гээч намрын навч шиг зулгаран хийсчээ. Хүн хүндээ чоно гэвээс нохойн дайны үнэнч нь элсэнд яргасан алтны элтэс мэт ховор ажээ. Миний хэлхээ хүмүүсээс тасарчээ.

Чингэлтэй хайрхантай холбогдсон ганц шижим үлджээ. Түүний оньсого мэт үзүүр орон дор минь бий. Энэ бол миний амины уяа... тэр үзүүрийг надаас өөр хэн ч мэдэхгүй агаад хэн нэгэн түүнээс барьж авлаа гэхэд алсын цоожийг тайлж хэрхэвч үл чадна.

Амины өр

...Сумын захиргааны үхсэн элээ мэт хар гэр бөөр нь түнхэлзэн, ханын шийр дэгдэлзэхийг хараад би зогтусав. Үүдэнд нь миний зүс мэдэх хурандаа, Чойдор хоёр хүүрнэн зогсох агаад тэдний яриа эс дуулдна. Тэр хоёр шөвгөр хар гутал түрий чивчлэн жийж, шар оломтой суран бүсэнд мөрөвч ташруулан гилгэр саравчтай ногоон малгай хэлтгийхэн дарж, ташаандаа хүрэн ширэн хуйтай буу зүүсэн нь албаны сүр, цэвдэг үзэмж хослон нэг л жихүүцэм. Төдөлгүй нүргэлсэн чимээ гарч тоос чирсэн ачааны тэрэг, хоосон дэвш харжигнуулан хар гэрийн гадаа тургих мэт чимээлээд зогсов.

Чойдор эсгий үүдийг гэр дээр хаяад “гарцгаа” гэж зандрахад үл таних лам, хар хүмүүсээр янхир хар гэр бөөлжих мэт харагдна. Тэдний дундаас гандсан хилэн малгайтай, соёо цагаан сахалтай хөнхөр хөх өвгөн намайг даллам аядаад алхах гэтэл хурандаа ташаан дахь буугаа сурмагхан суга татаж

-Зогс буудлаа... гэж тачигнах нь тод сонсдоно. Би хөдлөх гэвч хөл газарт зоосон мэт хөшчихжээ. Мөнөөх соёо сахалт

-Хөнхөөр! Би Чогсом байна. Өвөө нь байна гэж хашгиртал Чойдор шилбэний нь хянга руу суун тустал өшиглөхөд өвгөн эвхрэн унаж дэлчлэв. Тэрэгний дэвшинд хүмүүсийг хайрцагласан чүдэнз мэт чигжээд бэрзээнтээр бүтээх үед хурандаа бууны амаар толгой бүрийг тоншим тоолсноо

-Нэг эсэргүүн дутуу байна. Яасан бэ гэхэд Чойдор зодуулсан гөлөг мэт гөлөлзсөнөө

-Эсэргүү Чогсомын зулбасага тэр байна гээд над руу үсрэн ирж, “муу бэлтрэг чи сугарч үлдээд хувьсгалын хонго ухах санаатай юу” хэмээн заамдаж тэрэгний тэвшинд ямааны зовлого мэт чулуудав. Нэг л мэдэхэд биднийг харанхуй хавцлын ирмэгт зогсоон хурандаа, Чойдор хоёр араас буудахад үхдлүүд цус отголон нисцгээв. Хамгийн сүүлд тэд “энэ муу гөлчгийг сум гарздаад яах юм бэ” гэлцсэнээ бөгс руу ойтол өшиглөхүйд би түүдэг мэт хийсэн хүүрэн дунд цус залгин ойчоод сэрчихэв. Магнайд хүйтэн хөлс дааварлаж ам зэгэлтэн хатжээ. Таамагаар дэрний шүүгээ рүү гар явуулж аяганы ёроолд хөхөрсөн цайны шавхруу очив. Нойр хулжиж сэтгэл хувхайрчээ. Хорвоогийн нугачаанд учрал зөрсөн Чогсом өвөө одоо болтол төрөл олоогүй, надаас буян гуйж яваа юм байх гэж бодоод аман дотроо хэдэн маани хүлхэв.

Цус амтагдах шиг... Өвөөгийн цус... Тиймээ, тэд биднийг эцгийн цус эхийн нулимсаар угжсан шүү дээ. Яргачид гэж би шазуур зуун үг алдав. Гэвч хэн сонсохсон билээ. Өширхөл өр зурж би цухалдалд хахав. Бид чинь яахаараа хэдэн зууны турш араатан авирлаж биенийхээ багалзуурыг тас хэмлэгдэгсэн билээ? Нэгэнт цагт их эзэн хааны зовж байгуулсан улсыг алдар атаа хоёрын араанд хэмлэж голомтоо самардсан маань багадсан гэж үү? Цагаан хэрэмний ёроолд царцуу толгойдоо шувууны өд хатгуулах гэж сэвсэн дээрээ орилолдсон бус уу. тэгээд улаан хэрэмний ёроолд мөлхөж, цустай энгэртээ одон сөрлүүлсэн улаантнууд хар шараар сүрэглэн бойлж цусан балчигт сэнтийд төрийг зайдагнан хичнээн жил биднийг мэхлэв ээ. Тэд диваажингийн үлгэр ярьж, түүнд нь бид моншрон хууртаж, мөхлийн тэвчээр гаргаж л

суусан. Монгол хүний хүлээц, уужуу тайван ухаан гэж худалчийн хувилгаад одоо хэлээ ясанд минь билүүдэж байна. Тэгэхэд ардчиллын томоогүй жаалууд тэдний ямбыг огшоосноос бус ял асуусангүй. Монгол орны жалга бүхэнд цайсан ясны цаана амины нэхэл байхгүй гэж үү. Доль Чойдор бид хоёр шиг худалч холчигонуур, хоёр нүүртэй сүгнүүдийг тамын тогоонд шалзалвал газар тэнгэр минь ариусахсан даа.

Бархас намайг нэгэнтээ “Сталины бөөс” гэж дамшигласан. Тэгэхэд нь би гал залгисан мэт цочирдож түүнийг “ревизионизмын сохор хорхой” гэгчхээд өөрийгөө шагнан ангалзан инээж билээ. Одоо бодоход бид үнэхээр улаан оросын шуумагны бөөс төдийхэн байжээ. Бид чинь бөгс дааж ор шивгэрлэснээс бус толгой дааж төр гийгүүлсэн нь юусан билээ. Миний мэт улс төрийн хэвлээр явагчид л монгол улсыг элгээр нь газар харуулдсан биз дээ. Толгой дүйрч нүд аргав.

...Нэг муу хөх хожуул шиг авгай золтой л машин доогуур орчихсонгүй. Арайхин тэргээ зогсоогоод намалдгий нь нээх санаатай уурсан гарч заамдан түлхэхэд замын хашлага дамнан тэрий хадав.

-Аминдаа хайргүй гичий юу гэж зандарвал тэрвээр хэвтсэн чигээрээ хэлээ гаргаснаа дээлийн тамтагнахаа хормойг сөхөн өмдөө шувглаж, умдагаа алгдан “Май. Уран чимхүүр байхад нь чи муу банзал усан пайлуур болгосноо мартаа юу. Чи намайг тоосгон дээр зогсоож хашаа түшүүлж байгаад сарьж байгаагүй юу. Амьтан унтсан хойно хашааны үүдний явган вандан дээр өвөр дээрээ суулгаад дороос залгалдаж тачаалаа намаглаж байгаагүй гэл дээ. Алцаа чинь загатнахгүй байна уу, “Алтан” Найдангийн муу тэлээгүй банзал минь гэснээ шороо самардан нүүр рүү цацав. Намайг юу ч харахгүй тэмтчин атал асаалттай тэрэг хаазлан ухасхийх нь сонсдов. Би дэмий л сарвайж тэрэгний бөгсийг алгадаад хоцрох нь тэр... Зүүрмэглэх төдийд ийн тарчлав. Ямар гээчийн ёрын шөнө вэ. Тэр салдирхалсан авгай залуудаа хурганы сүүл шиг булцгар цагаан охин байсан. Үнэхээр би гудамжинд түүнийг нохойчлон хагсаа гаргасаар сүүлдээ салахын түүс болж уйлж унжхад нь “Юундаа усан нүдлээд байгаа юм бэ. Би чамайг эр хүний дор тэлчлэхтэй болгож өгсний ачийг санаж яв. Миний гаргасан нүхээр аз нь гозойсон аавын хүү шургахаа л шургана” гэж ярдаглаад хаяж билээ. Хүний бүсгүй үрийг шавхайдаад золбин гөлөг шиг хаясан хойно голоо харлатал гомдоо биз. Гэхдээ яая гэхэв. Энэ хорвоод би ганцаараа эмнэг байдас чарлуулсан биш дээ. Хүний өөрий нь долгонцол, илүү харж, билүү долоож хормын жаргалд хормой түлж явдаг заяа нь тэр шүү дээ. Тэгээд ч муусайн эмс өөрснөө нүүр өгөхөөр бөгс өгч эр хүнийг ивэлгээний тугал шиг үлгэхдээ жаргалын тамд амиа алдахын заваан хорвоог хоноцын шээсээр дүүрэгдэг нь худлаа юм биш. Эр хүнд тэд гомдох эрхгүй хэмээн би өөрийгөө цагаатгахчаа болов.

Үүр тэмдгэрч байна. Ямархан өдөр айсуй юм бол? Ямар ч байсан надад хамаагүй, хаданд чимээгүй болжээ.

Сайнаа нэгэн хэмээр нуугиулан хухирах нь чих гижигдэх шиг. Тэнхээтэй ч болоосой. Түүний өвөрт гулсан орж хөхий нь алгаараа бумбадан халуу цоноож, хэвлий, хасыг нь дагуулан илбэхэд тэрвээр нойрмоглон эргэхэд нь тас тэврүүлэхсэн. Би уруулыг нь шовхийснээ гэнэт адангатан озож аяархан гэдрэг харуулж янагийн орныг нь эзэгнэхэд чичирхийлэн шигшиж байснаа “Ямар сайхан юм бэ” гэж уухьчин үглэхээр биеэ хураан уруул хазан чарлах авиа

гаргаж хамаг бие нь алдуурах мэт сулархуйд халуун хөнжилд нилхийн тэнгэрийн амгаланг эдэлдэг байсансан... Яахин би үүнийг бодох болов оо? Нүгэл нь гүйцээгүй юм байх даа. Эр хүн гэдэг эцсийн мөчөө хүртэл эмэгчний салтаанд тэчъяал шүглэж, мунагийн халуун хярвас болдог тийрэн байх нээ. Эсхүл би ганцаараа тэлээний буг ч байж болох юм... Сайнаа нэгэн ханын дотор байгаа ч саран дээр мэт холджээ. Амьдрал бид хоёрын зай гар бүү хэл санаа цуцахаар алслах цаг ирсэн нь энэ буй за.

Би хүчээр нүд анин, хөнжил тумлайдавч мөнөөх соёо сахалт хөнхөр хөх өвгөн “би Чогсом байна” гэж даллах нь харагдаад болдоггүй. Тэрвээр надаас маани гуйх бус амь нэхэж байгаа бололтой. Тиймээ, би амьны өртэй... бас...

Солгой санаа

Оронд сүүж хадан орчлонгийн явдлыг тойнтроглон эрэгцүүлэхүйеэ өөрийгөө ээрэх нь их байх юм. Хөнхөр чи хэн юм бэ! гэж эрхээх тоолон, улсын тавагтай идээнд шавсан ялаануудын л нэг гэхээс илүү мужиг олсонгүй. Би гээч эх орон гэж индэр, ширээ хоёр дээр цогнойн бахирсан улаан хэрээ л юмсанж.

Албаны сэжүүр атгаж, өрөөний буг болж суусан маань хэрэг дээрээ долоон хөл зовлогоо тээснээс хэтэрсэнгүй явсаар тэтгэвэрт гарах болж. Тэтгэвэр гэдэг өлөм зөлмийн зогоолоор тонилгох хөөлөг төдий юм. Энэ бие элэгдэж навтрага болоод заазлуулах нь элэнцгийн гавьяаны амралт байхав дээ.

Би гэдэг хүн санхүүгийн сургуулиас сампин тэвэрч гарсан бэрд, намын сургуулийн тогооны богшил, нийгэм журмын тууринд хаягдсан хогжруу юм даа. Дэндүү хувьсгалч дэвэрлээр дэлхийг өөрчилнө гэж халуурч явснаа бодоод хөх инээд хүрэх юм. Гэвч үхлийн өмнө инээд хулжиж, цөмөрсөн ухархайд нулимсны ширгээш л үлддэг бололтой. Над мэт нь алив суртлын хүлээснээс толгой мулталж эс чадсан төөрлөө үүсгэгч мэтээр эргүүтсээр эс оршихуйн эргүүлэгт сураг алдрах нь юутай гачлан. Эв хамтын ёсонд орохоор эхнэрээ яаж хэрэглэх юм бол гэснээс өөр гайхаш надад байгаагүй үе байсан. Тэр үед л аав минь:

-Төр засаг хаашаа ч хөрвөө билээ. Энэ засаг яаж амьтныг цөлмөв? Халимагтай луйварчингууд мундахгүй. Тэгэхээр чиний шүтээн Чингэлтэй хайрхандаа байж байг. Хичнээн шиншээд түүнийг олохгүй. Харин чи хоосон хонохгүйн тулд өнөөдөр дутуу цадаж бай. Байхгүйн зовлонд хэцүүдэхээс байгаа юмыг барах арга олдоно. Өвчүү цорой хоёр нийлэхийн цагт өөдсөө өнгийдэг юм шүү. Өнгөөр гайхуулж хүний хэл, нохойн хуцал болуузай. Амь зууж яваа төдий л харагдаж байвал амьтны шуналын нүд цаггалан байдаг юм. Аав нь буурлын буянаас эмтлэн ээмэг бөгжхөн “гөлөглүүлж” хэдэн халтар цаас унагадаг байсан болохоор “Алтан Найдан” хоч зүүсэн ч муу дамын панзчин хойд урд хормойны аль нэг нь өмөрхий явдаг гэж итгүүлж чадсаны хүчинд чөтгөрийн амыг чөмөггүй булуугаар хуурч чадсан юм гэдэгсэн. Надад хэдийвээр тарвалзмаар үе байсан ч “орон бүхний гуйлгачингууд нэгдье” гэсэн модоо барьж явбал ёсонд нь нийцдэг нам засгийн хяхал, бас хажуугаас хавирга сүлбэхээс дөлж явах нь аминд өлзий гэж бодсон сэрэмж байв. Гэтэл... хаалганы хонх...

Чойдор босгонд тээглэснээ “том олз орох нь ээ” гэж үглэхэд нь би “гарз ч юм билүү” гэж хэлний үзүүрт гарч ирсэн үгээ арайхийн залгив.

-Мань эр гялалзаж байна гэж Чойдор холчигноод, аргагүй ээ, залуу эхнэр эр хүний яргуй гэдэг дээ гэж наг наг хөхөрхөд нь би төвөгшөөж эс дуугарсанд намайг үгээр домнож,

-“Алтан” Найдан гуай ч хашаанд байтугай Халхад багтахгүй буянтан гэдэг сэн хөөрхий. Буянтны буянг эдлэх ёстой юм гэдэг шүү. Чи бол мөнхийн ус олж чадах бэлтэй хүн. Өөрийгөө тойлж өндийхөө бодно байгаа гэж ятгав. Түүний хөлхгүй нүд нь шөвөгний үзүүр мэт гялалзаж надаас ямар нэгэн юм эрж буйд би сэжиглэж,

-Хүний сав гэж байдаг. Аав минь наймаа, тоглоом хоёрт жаахан буянаа өргөчихөөд буцсан

даа зайлууул. Би ч та нарыхаа л гарыг харж хэвтэнэ гэж амыг нь таглав.

Чойдор бол сохор хүн биш. Өрөөсөн нүд үүлтэй анивчуураас манайхан сохор, долир гэх мэтээр хочлоно. Тэгээд ч нүд бол сэтгэлийн хурц үзүүр болохоор хоёр буюу өрөөсний ялгаа юун. Хүн буу шагайхдаа өөрөөсөн нүдээ аньж гэмээн тусгалын цэцээр сумаа хулхинд сөвлөдөг гэвэл Чойдор тун муугүй бууддаг байж мэднэ. ..

Чойдор шилээ маажин намайг цаагуураа дамшиглан,

-Нэг нь нөгөөгөө илүү үзэж билүү долоодог хойно доо, чамайг гэр дэх нь гэдсэндээ ороогүй гэлцэх юм. Үйлсээ алдмарууд. Намайг ч тэгдэг биз. Гэтэл бид чинь цагаан цоройгоо татаж цалингийн үзүүр уулзуулах юм байна шүү дээ. Нэрэлхэлгүй хэлж бай. Хөгшний нь гар богино ч түмний буян хаачихав.

-Хойч өдрөө бодож явсангүй. Олдсоноо идчихдэг хүн, нэг л өдөр элгээрээ мөлхдөг юм байна. Надад чамаас өөр наана цаана гэх хэн байхав дээ гэж түүний хормойг огшоож өгөөд гаргав.

Чойдор ходоодныхоо мухарт хар инээд богшоож явааг би мэдэж байна. Тэр инээд яаж гадагшлахыг таах аргагүй. Ядарсан цагт хүн гэдэг хүйтэн мишээлээр ч тайтгардаг ажээ. Харин би хүн бүхэнд ядуу гучуухан харагддаг атал Чойдорт яагаад гоочтой санагддаг юм бол? Газар дээр түмэн нүд хариулсан мөртөө ганцыг дотогш нь алдсан юм болов уу. Сум ганцдахгүй гэдэг билүү.

Хотын намын хорооны, хамаг нүүрээ хамар дээрээ овоолсон нэгэн гайхал намайг “нийгмийн гарлаа маш тодорхой үнэн зөв бич” гэж шаардаж байсан удаа бий. Би нийтийн жишгээр “цагаан бароны цэрэг, хувьсгалын эсэргүү хэрэгт ял шийтгэгдсэн хүнгүй, ядуу ард гэхээс цааш нас гүйцэж мэдэхгүй гэхчлэн эрээчиж өгөхөд “танай удамд хар шар феодал байгаагүй юу” гэж нухаж асуухад нь “үгүй” л гэсэн.” Аав чинь нийгмийн тустай хөдөлмөрт оролцож байсан уу” гэж могогтоод араандаа нэг юм зуугаад байх шиг санагдсан. Бодвол миний тодорхойлолтыг хийх гэж далан давхрын булш төнхөн алдаж “До” яамны утаа зуусан цаваг шиг хавгаст хэргийг шагайж хамраа шархиртал найтаалгаа биз. Тэд монгол хүнийг түүхий эдэд тушааж буй турсага шиг дугаарлаж гологдлын хар дансанд чихэж байсан юм чинь. Үүнийгээ боловсон хүчний судалгаа гэж гоёчлон, эсэргүүцлийн хялгасгүй эрчгүй дээс сонгож ачаагаа татаж байсныг эрхбиш би гадарлана. Өөрийнхөө хавтсыг би сөхөж үзээгүй, үзүүлэх ч үгүй. Харин Чойдорт хэрэгтэй цагт хар дансныхаа сэжүүрийг харуулаад миний өсгийд хөлхтэй нүдийг нь зоосон байхаа ядахгүй. Ямарч атугай “нам ингэж үзэж байна” гэж дүлэгнэн үгээ зөөж, орой дээр эвэр ургах янзтай хөндүүрлэж байх үед минь, миний албаны өгсөх шатыг хурааж уруудах гулсуур тавьсан юмдаг. Тэрхүү гулсуурын эцсийн тээг үхэгсдийн “яаманд” чагталж, одоо тэвх нь мултрах гэж байгаа нь энэ. Өөрсдийгөө өөчилж гоочилж толгой нь өндийсөн бүхнийг доштой нь тэгшилж байдаг улс яаж ч өөдлөх вэ дээ...

Хуучин түрийвчээ ухаж гялгар цаасанд боосон зураг гаргаж харав. Дугуй малгай хэлтийхэн тавьж хүзүүний ороолт зөрүүлсэн хоширсон дээл цагаан ултай гуталтай бүсгүй цомбогор тавиур дээрх ваартай цэцгийн дэргэд номхон зогсож миний өөдөөс уруулаа жимийлгэн дүрлийн ширтэхэд би дальдрасхийв. Хөөрхий Цэвэлжид минь! “Би чамайг жаргаасан билүү?” гэж өөрөөсөө асуусан боловч өчиг олсонгүй. Хоосон шахуу хавтас сугавчилсан

хойморсог албаны сэнтэг би чамайгаа угаатай зуухны аманд хадаж бохиросоор уураг биеийг чинь урсгажээ. Чиний битүү цомирлогийг зоргоор задлан балыг нь шунан сорж эзэгнэн талхин хоосолсноос өөр юугаар гийгүүлсэн билээ? Араа мөр хоёрт чинь амт өнгийг гар татах хэрнээ гамгүй эдэлж гаргуунд нь гаргасан нь миний нүгэл биш гэж үү? Чи надаас уйтгартай нүдээр жаргал гуйж, өглөггүйд хилэн цоройлголгүй, өөрөө дотроо мэгшин нулимсанд нэвчиж үжирснийг одоо би ухааран халаглахад юуны тус билээ.

Хүүхэд тогтохгүй адилхан дээлтэй хатаж явсан мөртөө “Хөнхөр минь энэ бол миний лай. Үрийн зулай үнэрлүүлэхгүй эмээр чи яахав дээ. Насныхаа танагтайд чи арга бодвол яасан юм бэ. Намайг харж яваад нартыг эр ганцаар баралтай биш” гэж Цэвэлжидийн аргадангуй хэлж нулимс унагахад миний өр ханзрах шиг болж Оргилыг өргөж аваад онгорхой зайгаа нөхөж билээ. Үүнээс бусад ямарч үед тэрвээр ам ангайсныг би санахгүй байна. Үеийн нөхөдтэйгөө дарвих хааяахан шалиглаж үүр цүүрээр ирэхэд хоол цай богшоон хүлээж “амар мэнд л яваа бол яахав дээ” гэж нойрмог нүдэндээ нулимс цийлээгээд сууж байдаг сан. Их хайр гэдэг гомдолд элтрэхээс эвдэрдэггүй буюу үүний нь шанд би түүнийг элэг барьж хоногийн борын хойноос сэм шүлхийрч сэтгэлийг нь цуулж явсан увайгүй зайгуул. Хэрэв Цэвэлжидээс өөр хүн байсан бол сангасваа болон ноцож миний батлахны завсар эмсийн огтровч хавчуулж намын хянангийнханд би салтаагаа бойлуулах байсан биз. Тэр үед нам бөгсөнд бөөлж өмд үнэрлэх дон шүглэснийг хэлэх үү. Улс төрийн цээжний өвчин ум хумын ян болдог юм биш байгаа гэж сэжиглэх өдөр байсан шүү.

Цэвэлжид минь элэгний айхавтар өвчинд нэрвэгдэн хоногоо хүлээж байхдаа “Чиний буянд байдаг л арга чарга бүхнийг барлаа. Ийм л төөрөгтэй юм байж. Надаас хойш яана даа гэж чамайг л өрөвдөх юм. Үхсэний хойноос үхэх биш дээ. Амьд хүн чи, аяга цайгаа хувааж уух хүн олоорой. Тэгвэл миний сүнс хоргодохгүй “ гэж билээ. Би юу ч хэлж чадаагүй. Эдгэнэ босно гэх юм уу эсхүл за гэхийн аль ч арга байдаггүй юм билээ. Тэгээд л Сайнааг өвөртлөхдөө ханийхаа захиасыг дагаж байна хэмээн нохой мэх гохлож өөрийнхөө алдуурсан жолоог зөнд нь тавьсан билээ. Харин одоо “Хойд насандаа уулзъя. Би чинийхээ хойноос заавал очно” гэж зүрхэндээ шивнээд сайхь зургаа завилган боож далд хийлээ.

Би Цэвэлжидээс өөр хүнийг чухам сөхрөн хайрлаж чадаагүй бол түүндээ ч сэтгэлээ бүтэн хүртээж чадаагүй солгой санаатан гээч нэгэн ажээ

Ялт эзэгнэл

Хайр дурлал гэдэг хүний сэрэхүйн цочролд үүсдэг дотоод сэтгэлийн алдуурал, сэтгэгч адгуусны дур урамшлын туйлшрал гэж болно. Гоо сайхныг дангаар эзэгнэх сувьдалд нэг нь нөгөөгөө өмчлөн мөнхийн орооныхоо гагсааг тайлах, хязгааргүй тэчъяалыг юүлэхийн тулд түүнийг тэнгэрлигийн сууд өргөмжилнө. Харин хайр дурлалын хөлчүүрэлд гал ус руу үйж үхэхээс буцахгүй залуу нас элэгдэхүйд, бор хоногийн өнчрөлд ганцаардахын аймшгаас ангижрахын тулд учирсан сатаарлын амраглалаас болж өөрийгөө егүүтгэх мунхаглал бас ирдэг шиг байна. Үүнийг дурлал, гэмшил хоёрын алин болохыг хэрхэн ялгах билээ. Эр хүний бие нь эс тайвшрах сэхлүүн санаагаа гүйцэхгүй явгарах цагт, мөнөөх дурлалын сүг сүүдэр гаслангийн үүдийг нээж түүнийг амьдын тамд түлхдэг ч байж болох юм.

Нэг үдэш Сайнаа орж ирээд:

-Ээж таныг еэвэн ид гэж байна

-Еэвэн...?

-Тиймээ. Еэвэн сар шүү дээ гэчихээд үсрэн гарав.

Хүн ариун цагаан төрөөд орчлонгийн хүнгэрт дэлсүүлсээр эцэсд дороосоо ялзран мөхдөг хойно доо. Хоромхон зуур би элдэв шидийн муу бодолд орооцолдов. Еэвэн сар чинь нөгөө монголын толгой хагалж байна гэж ёролдог нь биш байгаа даа. Гэтэл орохгүй бол ойрмогоос гэр хашаа тандаж айл хамрын бараанд болох бүтэхээрээ яваа хар элэгт улс юм саначихдаг болов уу. Орж гэмээн бас нөгөө нүд чихнүүдийн нэгэнд өртөж Хятадын баяр тэмдэглэж улс төрийн талаар доголдсон намын үүрийн дарга гэх ч юм уу, элдвээр өөтүүлж аяга цай цалгиачих юуны магад гэхчлэн тээнэгэлзсэнээ, харанхуйд хэн л хараа аж хэмээн өөрийгөө тайтгаруулан Норжин гуайнд оров.

Аяганы ширээн дээр тавганд зэрэглэсэн бор голтой улаан еэвэнгийн үнэр хамар цоргих агаад, бас шимийн будгаар өнгө ялгасан цэцгэн боов тэргүүтэнг өржээ.

Цуунд хөрвөөсөн чихэн банш дарсан шанцайтай савхдах нин таатайг хэлэх юун. Норжин гуайд шахуулж гурван хундага уусны дараа цагааширч өөрөө хундагалан татсаар нилээд халамцаж үгний хамжаараа алдан энэ тэрийг хүүрнэх зуур Норжин гуай:

-Хүнийг мөчиж, хясаж гэмээн бах нь ханадаг хорвоог яая гэхэв дээ. Үхсэний хойноос үхэж, үгүйрсний хойноос хувхайрах биш дээ. Хөнхөр чамайг харахаар өрөвдөх юм. Ганц бие эр хүн хатавч хоймор хоёрынхоо хаана нь ч сууж болдоггүй гэдэг. Чи ямар надтай адил эрүү өвдөг нийлсэн чавганц биш дээ. Эр хүний тавь эргэм нас идэртээ орно. Алийн болгон сүүдрээ хөтөлж явах вэ. Чиний хэр эрдэм ном, алба тэгширч, бор гэм нь арилж ухаан суусан хүнд хань ижил хаанаас мундах вэ дээ гэж учирлав.

-Норжин гуай минь одоо намайг хэн тоох вэ дээ гэвэл,

-Нүгэл гэм. Өөрийгөө тэгж уруу татаж яаж болох вэ хүү минь.Би Сайнаагаа эрүүдэх л юм.Айлын өрх татахыг үзээд хадан гэртээ харих юмсан. Чам шиг хүргэнтэй болбол хоймроо тахиад л дээж өргөж мөргөөд суухаас яахав дээ гэхэд Сайнаа

-Ээж дэмийрээд уналаа...хэмээн эгдүүцэх аядав.

-Цөг.Чи хожид. Намайг дэмийрүүлэхгүй гэсэн юм бол нарны галтай, ногооны сөлтэйд утаа гаргах чинь яасан юм бэ гэж ээжийгээ зандрахад дуугарсангүй.

Норжин гуай:

-Энэ муу охин минь яахав дээ эмнэлгийн тоос гөвсөн болж ээжийгээ тэжээж сууна. Үртэй хүний ам тостой гэж үнэн юм. Аравдугаар ангид байхад нь нэг муу хөлстэй цагдаа охины минь толгойг эргүүлээд сургууль соёлгүй завсардаж орхисон юм. Айл хүний амь нэг гэдэг дээ. Адилхан зовлон үзсэн улс үнэр бараандаа явбал зүгээрсэн дээ...гээд мишилзэв.

Сайнааг ахин нэг лонх юм гаргаж ирэхэд би,

-Болно, болно .Маргааш ажилтай гэж худлаа нэрэлхэв.

-Түрүүнийх ээжийн хувь. Уухгүй бол гомдоно шүү хэмээн намжирдан инээв. Согтуу толгой би бас сээтэн хаяж

-Уувал хоёулаа л ууна гэж нялуурахад,

-Тэгнээ...гээд хундагалан надтай адилхан татаж орхив. Хэд уусны дараа Сайнаагийн биеийн хүлээс тавигдаж байгаа бололтой эгдүүтэй аяглаж, хэлээ хазлан эрхлэнгүй загнах нь миний дотор Цэвэлжидийг өөд болсноос хойш хоёр жил нойрссон чөтгөрийн адыг өдөн сэргээв.Би нүдээ нухлан ,

-Их согтож байна.... Гэрийнхээ барааг яаж харна хэмээн албаар үгээ орооцолдуулан баашилахад Норжин гуай,

-Аргагүй хөөрхий. Уудаггүй хүн цочирдож байгаа нь тэр. Сайнаа миний охин, Хөнхөр гуайгаа хүргэж өгөөд, гал хөсийг нь янзлаад өг хэмээхэд би дотроо баярлан босч Сайнаатай хамт гарав.Тэнцвэр алдах гэж байгаа мэтээр аян шалтаж түүнийг тэврэхэд ер тоосонгүй, хацар дээр нь аяархан үнсэхэд ч ажирсангүй. Гараа ахиулсаар хөхийг нь тэмтрэхэд Сайнаа бус, харин би галд хүрсэн мэт өөрөө гараа огцом татав. Гэртээ ороод орон дээр зэрэгцэн сууж илж, таалж цочоогий нь гаргаад алгуурхан барьцаа ахиулсаар даран авахад Сайнаа хувцастай дэмий шүү дээ орондоо орьё гэж шивнэв.

Бид хоёр тас тэврэлдэн үнгэлдэхүйд Сайнаагийн хөх цээжний тус газар гижигдэн цонож, миний бүх булчин шөрмөс чилийн хөвчирч дэлбэрэхийн даваанд хөрвөн дороо хийвэл түүний бие бөмбөгнөн чичирч тэлмэн жороолох мэт хөвсөлзөн орь дуу тавин ёолсоор “үхлээ, үхлээ” гэж хашгиран уруул хазан тайтгарав. Үүлэн борооны явдлыг үзэхээрээ болсон авч эм хүний ийнхүү өөрийгөө эрд шавхан өгөхийн гайхамшгийг би анх үзэж, түүний амтанд анхны

шөнө л нэвгэртэл орж хурьцахуйн энэхүү цаглашгүй цэнгэлээс өөрийгөө татаж авч хэрхэвч чадахгүй болсон юм. Сайнаа бид хоёр ингэж нийлсэн билээ.

Миний хувьд хайр дурлал гэгч анхных нь сохроор учирсан аз жаргал байсан бол сүүлчийнх нь согтуугаар үйлдсэн ялт эзэгнэл байсан юм.

...Чойдор намайг “залуу хүүхэн дээр янгиа тохдог эрийн шийр юм даа. Бэлтэй хүнд олдохгүй юмгүй орчлон хойно доо...”

...Бархас “Молодец Муусайн хүүхнүүдийг хөлий нь шилэнд нь тээглүүлэх хэрэгтэй. Цаадуул чинь мөнгө харуулвал хотны ноход хойноосоо дагуулахаас буцахгүй. Хэрэв гэдсээ цадахаар өөдөөс чинь өмхийгөөр хэхэрвэл нүцгэлж ороолгоод нүдний булай болгохгүй юу”...Харин Ламид “Залуул юм даа танд хань болоосой. Хашир хүн дотрыг нь өнгийж хараа биз дээ...” Сэтэв”Аль болгон гон бие явах вэ. Хэл ам гарвал хөгшин чинь аргалж чадахгүй шүү” гэгцгээж билээ.

Оргил маань Сайнааг зүс үзэхдээ ээж, эгч, найз гурвын алинаар нь ч дуудаж чадахгүй бүлхэлзэж байгаад явсан бол Цэвэлжидийн дүү Халзан “хамар хашааны хүүхэн” гэхээс өөрөөр нэрлээгүй. Хороо хориныхон “Хөнхөр нохой шар сэмжилчихэж. Хүүхэд чихрээр хуурчихлаа. Яасан загатнаа нь гардаггүй зайр вэ” гэх юм уу, ”Норжин хөгшин яайжганаж байгаад ганц охиноо Хөнхөрийн түрийвчинд хийчихлээ. Алтан Найдангийн өвийг ухахаа тэр мэднэ”, ”Сайнаа удахгүй сарьсан дэлэн шиг шалчийгаад өгнө.. Егзөр толгой хусран бяруу шиг ховх сорно доо”, “Залуу хүүхэн зоолоод ирэхээрээ толгойд нь асаж муу хөгшнийг хүйтэн бөгс тэврүүлнэ”, ”Хөнхөр алтан тоногтой хүүхэн харж амьтны шавхруу үнэрлэж үхнэ” гэхчлэн элдэв хов ховсорч миний хоёр муу дэлдэн муу усны нүх болж билээ. Тэр үед би уур зэвүү хоёртоо түлэнхий хөдөс шиг умарцаглаж явсан нь бий. Гэтэл одоо бодоход олны амны шор миний эмзэг газрыг олиод байжээ. Бид зулгүй магтаалд хөөрцөглөн тэвхэрч, үнэн үгний үзүүрээс үнхэлцгээ хагартал айж заншжээ. Бөхөн сэрвээтэй шодон гээгтэй хүүхнийг гол шиг нуруутай, ус шиг гээгтэй гэж хороо хорины шүлэгч нарын магтахад, хөөрхөсийн тэлээ тас үсэрдэг шиг хар овоохойд нь ороод тэнгэр баганадсан цагаан өргөөнд чинь газар даахгүй буян байна гээд ёргиоход турж үхэж буйгаа мэдэхгүй архи гударч шалбаагт тэлчилж хэвтдэг амьтад бид л болов уу. Хоног өнгөрөх бүр амьтны эрүү эцэв бололтой хэл ам хэлтийв.

Би Сайнаад сугадуулж, азарган тахиа шиг таахалзан алхаж амьтны нүд хужирлах дуртай байв. Ямар сайндаа зүс таних архины лүү гудамжинд тааралдаад ханцуйнаас татаж “Та ч эхнэрийн тэнгэртэй эр хүн юмаа” гэж доргиоход шар тайлах мөнгө хаяж байхав дээ. Намайг хөөрцөглөж явах бүр хэн нэгэн хараа чулуудвал шоолж байгааг мэдэхгүй “эхнэрийн тэнгэртэй” хэмээн согсоолж явснаа одоо бодоход ичмээрч юм шиг.

Ийнхүү эх адаггүй бодолд ээрэгдэн гон биеийг зугаацуулан хэвтгэл нөгөө “тогоо нь хагарав” бололтой тог тасрав. Багачуулын хэлдгээр “амбасын үеийн” хэдэн зуухны араа дандаа гацдаг болохоор би цухалдсангүй. Лааны ёзоор асаах гэснээ эзгүй гэрт юу ч харахсан билээ. Сайнаа гэртээ яарахгүй болсонд хардахчаа аядавч, чалх барагдсандаа хор буцалж ямар гайхал түүний осгортсон өгцгөнд алгаа дэвсэн өрөө зуруулсан ямаа шиг бахируулж байгаа бол гэхээс дэмий л доголлон шээс дусаахаас цаашгүй. Гагцхүү харанхуй л миний бодлын сэг, чавцуурлыг өөртөө уусгаж намайг тэвэрч би түүнээс үл мэдэгдэх ханьсал амгаланг олж буй мэт.Хэрэв харанхуй

болдоггүйсэн бол зөвхөн гэрэлт орчлон мөнч олон жаргалаар гачигдахсан биз ээ.

“Тамгатай” буг

Норжин эмээ бяцхан зэс халаагууртай хандмал авчирч аяганд хийгээд,

-Борви тойгны шөлөнд буцалгаад л байгаа. Хүү минь сүжиглээд хүртээд бай. Алив өвчинд амтай хэмээх улигт үгээ давгаад гартал Сэтэв, Жагай хоёр орж ирэв. Сэтэв ажил албанд дарагдсаар арайхийн өнөөдөр бөгс өндийснөө учирлав. Жагай ч хожимдсонгүй, даргынхаа завгүйг гайхаж, бас үл бүтэх юмнууд хуйвалдаж хамт олныг бутаргах гээд гэхчлэн мухар сохор юм шулганав. Би тэднийг моготгох гэж бодсонгүй чухам юу болоод буйг сониучлах санаатай,

-Өвдсөн, өтөлсөн хоёр үнэ юу билээ. Чих бөглөөстэй, нүд аниастай л хэвтэх юм даа. Эхэндээ бачуурч, сүүлдээ цагааширдаг бололтой гэв.

Сэтэвийн санаа чинжүү болохоор миний үгийг тумлайдаж,

-Ханилж яваад нөхрөө гэдгээр үнэндээ мөсгүй юм боллоо. Над шиг хүн бол өдийд айлгал байлгалдаа тулж буруу харчихгүй юу. Харин чи юм үзсэн, намд хатаагдсан тулдаа л мэндийн солиотой байна. Өчигдөр бид өдөржин хуралдлаа. Ламид мэт эрх тушаалд дуртай хүмүүс байдаг юм байна л даа. Тэд дахиад ч дайрч давшлах бололтой. Гэвч хамт олон хар цагааныг ялгах болно гэж янцаглан өгүүлэх нь хүчиндээ итгэсэн далд ихэмсэл мэт

Жагай мөчиг тачигхан нийлэх уруулаа эвлүүлж ядан хиймэл мишээл жирвээж,

-Таны гарын үсэг зурсан өргөх бичгээс асуудалд зарчимтай, улс төрийн хараатай ханддаг хүний нандин чанар харагдаж байна лээ. Хамт олон ч тэгж хүлээж авсан. Эрүүл мэндийн байдлаас ажлын эрх ашгийг илүүд бодож групп тогтоолгох гэсэн хүсэлтийг чинь коммунист хүний эр зориг гэж хүмүүс магтан тэгээд таны хүсэлтийг арга буюу ёсоор болгож Бархасыг түр орлогч болгосон... гэв.

Сэтэв түүний үгийг эвтэйхэн ивэж,

-Чамайг өвдснөөс хойш ганцаардаад хэцүү байна. Одоохондоо Бархасд орлуулчихлаа. Уг нь томилох ёстой ч шахалтанд ороод яаж ч чадсангүй. Чиний сайхан чанар түүнд байхгүй л дээ гэж бялдуу үг дайв.

Би гайхаж цочирдсонгүй. Эд нар нийлж, миний дээрээс хүрзнийхээ хэрээр шороо хаяж дээ гэсэн бодлоо гадар ухаанаар барьж,

-Аа тэгээ юу. Үзэх ёстойгоо үзээд үлдсэнийг нь хүлээж байгаа хүн албаны явдалд хуруу дүрээд яахав гэхэд Сэтэв,

-Хөнхөр минь сэтгэлээ бөхөл. Амьд явбал ...

-Ус нь байхад аяга нь хаанаас олдов гэж

-Хорвоо бөөрөнхий...

-Тэгээд хөрвөчихсөн юм биш үү?

-Ардчиллын шуурганд зарим нь уруудаж байг. Эрэг мөргөх гэж нэг юм бий.

-Нүдгүй шуурга сөрөх ч хэцүү дээ.

-Тийм ээ. Тэгэхдээ түүх хариугаа авах гэж нэг юм бий гэж Сэтэв зуунгтан өгүүлэв.

Сэтэвийн нэг гэм нь өрцөө цоортол өс санаж, нэг зуувал эрүүгий нь заахаас нааш тавьдаггүй хүн. Түүний дотор хэрэгтэй цаг хүлээж отоонд хэвтээд залуучуудын хонгонд хоёр соёо зооно гэсэн бэтгэрэл бугшиж буй бололтой.

-Нохойноосоо гинж нь гэгчээр нэг л олон нам. Шинэ нь дэггүй жаал шиг хуучин нь нөмгөн чавганц шиг л санагдах юм гэж миний сонжиход Жагай урдуур нь орж ,

-Хүүеэ, яанаа. Ахмад коммунист ингэж хэлж болдог юм уу хэмээн шөвөгнөөд Сэтэвийг тохойгоороо ёвроход Сэтэв ихэд таашаан хүд хүд инээж,

-Хашир хандгай доргиож байж судас барих гэж байгаа нь тэр гэснээ-хориглож байгаад давших “таагчиг” цаана нь байгааг чи юун эс андах вэ.

-Удаан атирсан амьтан бие нь оршчихоод хөдлөж чадахаа байх ч ёс бий гэж би унгаагий нь ухав.

Сэтэв царайгаа төв болгон удирдах хүний намбалж,

-За, за улс төр яахав. Амьдрал ярья. Ажил өөрчлөгдлөө гээд бид чамайг орхихгүй ээ.Байнга анхаарлынхаа төв байлгана. Аливаа асуудал гарвал бидэнд хэлж бай. Боллоцооны хэрээр тусална. Группийн хугацаанд биеэ сайн тордоод ав. Ардын эм тан ууж байгаа юмаа даа. За даа мэдэхгүй. Зарим нь тус, зарим нь ус л гэх юм. Эм чинь хөрчихөв үү дээ.Эрүүл байвал бүх юмны арга олдоно. Алба, цалин аль аль нь буурахааргүй ажилд тавих тухай удирдлагын сонорт хүргэж тохиролцсон зүйл бий. Энэ удаад нэг сарын цалингийн хэмжээнд буцалтгүй тусламж үзүүлснийг гардуулья хэмээн дугтуйтай юм сарвайчихаад хүзүү сээрээр татсан ажилтайгаа гайхан эм сүүдэртэйгээ хэлхэлдэн гарав.

Миний хувьд Жагай хэмээх хэлээ зажласан энэ хүүхнээс би жихүүцдэг. Хүмүүс түүнийг будагтай буг шунхтай шулам гэх нь холгүй ам хазайдагт автсан юм биш л дээ. Харин энэ “жалан дугай” Бархас хоёр Сэтэвийн зэгэл толгойг дөрөөлж ямархан гогцоо шүүрэх гээд буйг би тааж ядаад байгаа юм. Үүний цаана атгаар авах алт биш гэхэд аманд ойчих шар тос бий л болов уу. Гэвч миний энэ сэрдлэг хатиар санааны минь сэжиг юмсан уу. Юутай ч гэсэн энэ хоёрын үзүүр езоор хоёр хэрхэн салж нийлэхийг миний нас гүйцэж үзэх нь өнгөрчээ.

Сэтэв бид хоёр хонь чоно хоёр биш ч гэсэн түүний жудаггүй загнасанд нь миний дотор өргөс орчихсон юм.Тэрвээр дээд газарт гаргасан нэг тодорхойлолтдоо:”...албан тушаалд дуртай, эдийн сонирхолтой, улс төрийн байр суурь тодорхой бус, гэр бүлийн талаар ойлгомжгүй, өөрөөсөө олон дүү ажилчин эмэгтэйтэй эд хөрөнгө арга залиар самууран суусан...” гэхчлэн

бичснийг сайн танил минь сэм надад үзүүлсэн юм.Түүнээс хойш Сэтэвт итгэл алдарч орхисон билээ. Үүнээс ч болсон юм уу, энэ удаагийн түүний өглөг, намайг амьдралын эцсийн гишгүүр рүү түлхэх шиг болов. Эрүүл мэндийн заазлал хэмээх нь үхлийн зарлан дуудах бөгөөд чухамдаа хорвоогийн эцсийн босгонд эзнээ аваачдаг. Тэндээс эргэх замыг хэнч олоогүй агаад гагцхүү амьдралд хоргодох цөхрөлд хойт нас хэмээх үлгэрийг хүн төрлөхтөн зохион боджээ. Би өнгөрснийг онгичвол он цагийн хэлхээс бус оочин цоочин тасархай төдий. Зүүн Сэлбийн гол туучсан нүцгэн жаал, Дуутын голын зүлгэн дээр Цэвэлжидийн гэзгэнд ямаан туухай зангидсан Хөнхөр хархүү, Санхүүгийн сургуулийн сампин мэрсэн сурагч, төсвийн газрын модон нябо, хотын Намын Хорооны цодгор зааварлагч, тэгээд Сэтэвийн орлогч...Намайг нябо ахуйд “модон хоргол” гэдэг асан бол намын хороонд шийтгүүлсэн шазруун эр “идээн пид” гэж шоолсон юм.Одоогийн ажлынхан намайг юу гэнэ вэ?. Сэтэвийг”авгай хад”, Бархасыг “салбаан”,Жагайг “эмгэн хумс”, Чойдорыг “долинбуу” гэх агаад надад тийм таатай бус нэг юм зүүчихсэн гэнэ лээ. Намын даргаас жийрхэж юм хэлдэггүй ч “улаан сахиус” гэдэг бололтой юм билээ. Олон хүнийг үзэл суртал, ёс суртахуунаар ялзарсан илжирсэн гэсэн цоохор цаасанд боож хогийн сав руу шидсэн болохоор тэгээ биз. Юм бүхэнд хушуу дүрж, хэн нэгний нүд рүү чичлэн үгүй ядаж л алив жагсаалд оролцож дарга нарын урдуур тоостой гутлаа чирэн навсайтал алхаж цаасан цэцгээр зусрын даллага хийгээгүйн төлөө,хурлаар оруулан хөхөлзүүлж, цалингий нь хасаж байсныг яана. Хүний өөрийн мойногуудын илтгэлтэй сонинг хүмүүсийн хуруунд нь эвэр ургатал хуулуулж, шалгалт шүүлэг авч, ямар сайндаа л манаач Жамбаас орос хэл шалгана гэж нүдий нь газар, тэнгэрт солбиулж байх вэ дээ.

Энэ бүхнийг эрээлжлүүлэн бодоход гутармаар төдийгүй миний амьдралын учир утга байхгүй болж ертөнцийн хязгааргүй орон зай руу унаж байх шиг. Энэ бол оюуны аугаа их сүйрэл ажээ. Одоо би юу ч шүтэж,юунд ч итгэх нь өнгөрчээ.Элгэмсэлээсээ илүү харьслын энэ цаг минийх биш ээ. Би хэнд ч хэрэггүйтэй адил хэн ч надад хэрэггүй. Миний сүүжин тус газар цоорон шархирч байна.Түүний эгц дорхи газар цоорох л үдлээ. Хэрэв тэнхээ хүрдэгсэн бол тэр алга дарам газрыг ухаж шороотой чулуу юутай хээтэй нь гудамжинд цацалтай билээ. Түүн дээр хүмүүс овооролдон бөхийн шангийн боорцог мэт булаацалдахыг харан элгээ хөштөл инээх юмсан.Гэвч газар төнхөх бүү хэл, гараа даахаа больжээ. Амьдрал намайг шүүж яллаж миний хохийг дуудаж тавлаж байна.Миний дотуур тамир өөрийг минь дорхи газартай нэвт сөрлөжээ. Шүд зууж байгаад Оргилыг хүлээвэл түүнд Чингэлтэй хайрхан уулыхаа нууцыг тайлж яс өндөлзхөөргүй үхэх юмсан. Эс тэгвэл би буг бугтаа бүр тамгатай хутагт гэдэг шиг дархан буг болох гээд байна...

Бичил там

Би амьдрал хэмээх хар бараан зүүднээс тарчлан сэрж гагцхүү үхлийн чанад юу үзэхээ төсөөлөх болов.

Эрлэг Номун хаан эрүүдэн байцааж нүглээ нууваас шидэт толинд барин тавин харуулдаг юм гэнэлээ. Арван хар нүгэл гэдэгт хэлсэн, хийсэн хоёр ордог бол намайг арван ес дэх там нээж залхаах вий.

Миний хамгийн том нүгэл юусан билээ гэж мухлайдваас “До” яамны доогуур харцтай балин хамартай хар хүн нүдэнд тусах шиг болов. Анх намайг “До” яаманд дуудахад дотор палхийн толгойтой үс зараалсан юм даг. “Би яалаа?” гэж өөрийгөө байцаан, ам цуурсан, намд тэрсэлсэн, дайсанд урвасан гэхчлэн есөн шидийн оноолд эргүүтэн толгойгоо ганзгалсан амьтан очиж билээ. Давхар давхар харуул давж, хүнд модон хаалга татваас чулуун арслан шиг хар хүн машид эрхэмсэн мэнд ус мэдээд тэр бүү хэл Цэвэлжид сайн уу гэхэд нь би мэл гайхсан... Тэгснээ түүний инээмсэглэл гэнэт унтран гөгийрсөн хүйтэн царайлж,

-Нам эх орны даалгавар биелүүлэхэд бэлэн үү гэхэд би сандарч,

-Үхэхэд бэлэн гэж цочирдвол,

-Би чамд итгэл хүлээлгэж байна. Үүнээс хойш хамтран ажиллах болно гээд хэнтэй холбоо барих, мэдээлэл хэрхэн цуглуулах зэргийг сануулаад ам өчиг авч гарын үсэг зуруулав. Таны хамтран ажиллах ахмад хүлээж байгаа гэсэн нь Чойдор байлаа. Ийнхүү итгэл олсон нь хар толгойд халгүй зайц боловч хажуу хавирганаасаа хэмлэхээс өөр арга байгаагүй. Тэгэхдээ би энэ бүхнийг “чулуун арслан” руу бухна. Гэтэл гайтай толинд хохирогчид, миний гарын үсэгтэй матаас дурайхад өчиг мохно. Нөгөө шар Самдан шоронд үхсэн дуулдсан. Тэр нүглийг Чойдор үүрэх ёстой.

...Тэр жил Чойдор надтай нууцаар шивнэж Самдангийн талаар мэдээлэл цуглуулахыг хурандаагийн даалгавар хэмээн тулгасан юм. Нөгөө “Чулуун арслан” энгийн хувцастай байсан чинь зогдор дор нь хурандаа мөрдөс байсан юмсанж. Самдан нэгэн сургуулийн багш агаад тэднийх Гандангийн хүрд гэртэй. Эхнэр нь Юмжирмаа хэмээх цахилах гэж буй зээр шиг цагаан хүүхэн. Би Самдангийн янагийн од шүүрсэн азанд атаархаж Юмжирмаад нүглийн нүд унагаж билээ.

Самдан үе үе балгадаг, тэгэхдээ хужаа мухлагаар оромхойг ажиглав. Тэгээд л отоож байж хэдэнтээ хамт сууж архидлаа. Тэрвээр цаасан шувуу мэт хөнгөн, гэнэхэн хүн байв. Самдан согтоод л бурж гарсан даа. “Дотоод яамны яргачид Монголын сэхээтнийг хяргасан... Нам засаг, чи бид цөм хариуцлага хүлээх ёстой. Түүх нэг өдөр бүгдийг ялтны ширээнд суулгана. Бид соёлт ертөнцөөс тасархай, социализмын хөмөрсөн тогоонд бүтэж үхэх ёсгүй...” Өөр юу юу ч гэлээ дээ. Би бас жаахан давс нэмсэн байх. Тэгээд л Чойдорт атгуулж орхисон. Самдан ч үзэгдэхээ болив. Гэтэл юу болсон гэж санана. Чойдор нөгөө сайхан хүүхний нь аваад суучихдаг байгаа. Би Юмжирмаагаас хожим нь,

-Та хоёр чинь учиртай улс байжээ гэж тандвал,

-Хэрэв Чойдор байгаагүй бол би Самдангийн хойноос явах байсан. Энэ хүн намайг аварсан. Би түүнийг гомдоож болохгүй биз дээ гэсэн сэн. Чойдор түүнийг сүрдүүлж байж янгиалж л дээ. Бузар амьтан. Ганц Чойдор ч биш миний мэт хөлсний матаачууд өчнөөн хүний гол гогодож, голомт хийсгэснийг тоочиж баршгүй. Өнөөдөртөө улсын нууц гэсэн далдын хар малгай дор тэд олны нүднээс хярж байгаа. Тэдний нэрсийн жагсаалт, нууц нэр, харамж авсан гарын үсэг төмөр шүүгээнд хулширч хэвтээ. Энэ бүх ялт хэрэг сөхөгдөнө. Тэр Эрлэгийнхэн Ламид шиг шударга нь дэндсэн дүднүүд гэсэн. Аргалж ч барахгүй л байх даа. Монголын дарга, сайд нар шиг бол аштай юу. Энэ муусайн юм үзээгүй амьтадыг шармал цаг, архины цуглуулга, тааран өмд за тэгээд хайрцаг янжуур, ганц бохь өгөхөд л диваажинд цохоод өгнө. Ялангуяа аятайхан хүүхнүүдэд бол тамын үүд татна гэж гонж. Сайхан хүүхэн гэснээс эр эмийн явдлыг бас шүүдэг гэсэн байх аа. Манай нам шиг оролцохгүй юмгүй ясан бузар лүд вэ. Тэд нар чинь нөгөө муу хөөрөгний толгой төөнөж байгаад улайлгадаг гэсэн биз. Энэ талаар харин тэлээ чанга явсан болохоор, ёс төртэй хонины хоёроо хоногийн хэдэн бортойгоо нэрлээд салчихаж дөнгөх болов уу...

Там гээчийн зохион байгуулалтыг мэдэхгүй юм. Үндэснийх, намынх гэсэн тасаг байж болох юм. Эс бөгөөс хорвоогоос очиж байгаа бүхнийг холиод чихчихдэг болов уу. Хэрэв намаар ялгавал би эхлээд “МАХН” гэсэн хуаранд очиж таарна. Аягүй бол тэнд Эрлэгийн дэргэдэх намын үүр байгуулагдчихсан миний хосыг шувтарч магад. Намын эсрэг бүлгийн асуудал хэлэлцэхэд “ийм явдал гарахын үндэс нь юу байв гэдэгт дүгнэлт хийх хэрэгтэй” гэснээсээ болж, хотын намын Хорооноос хүүрийн товчоонд цөлөгдсөн, бас “намын батлахаа буцаасан” хэрэг сөхөгдөнө. Тэд намайг өршөөхгүй, нөгөө аймшигт халуун там руу шилжүүлж шалзлах тухай Хаантанд санал болгосон тогтоол гаргавал яана. Юутай ч тэнд Дээд шүүх байх ёстой. Дарга нь Сэтэв байвал “Бид хөнгөлөх талд байна. Гэвч намын үүрийн шийдвэрийг өөрчлөх эрхгүй”... Бархас бол “Энэ Хөнхөр диваажин үзэг гэснээ буцаж, пизда-г эхлээд хамгийн халуун тамд тарчлаавал таарна”... Чойдор бол “Феодалын хөрөнгө нуун дарагдуулж завшсан, хэрэгтэй цагт намаас урвасан хоёр хүнд хэрэг. Уг нь хугацаагүй тамтай л юм байна”... Ламид бол “Там диваажин хоёрын алинд ч ял, гавьяагаар тохирохгүй. Монголд нь буцааж хойт төрлийг нь харъя” гэхчлэн ял оноох биз. Сэтэвийг хүүхнээр, Бархасыг тушаалаар, Чойдорыг мөнгөөр хахуульдаж болно. Ламидлыг яах вэ? Гэвч эд нар тэнд байхгүй. Тэндхийн шүүгчид хаанаас л манайхан шиг хахаж үхэхгүй бол хахууль голохгүй гудардаг гурианууд байв гэж. Ийн бодож хэвтгэл зүүрмэглэжээ...

Тэнгэрийн хаяа цогшин үүлэн зайцад таширлан шингэж буй нар алтны хайлш мэт гялбарна. Уулын наад суугийн хүүшлэн буй сүүдрийн дээгүүр харван асгарах туяан дундаас цасан цагаан хун намайг чиглэн ойртсоор жигүүр нь дэлсэн хоёр гар болж Цэвэлжидийн дүр тодров. Түүний царай дахь ичингүйрсэн мишээл, Дуутын голд анх учирсан орь залуугийн үзэсгэлэн хэвээр ажээ. Миний зогсож буй үүл ороосон хадан хясаанд алхмын зайд тэрвээр агаарт тэлүүлэн хоёр гараа сарвайхыг ажваас араас нь нарны цацрал мянгантаа утасран түүнийг татжээ. Би хоёр гараа өгөхөөр алхах гэвч хөл алдан нисчих гээд болдоггүй. Тэгсээр арай ядан гарын сарвуунд шүргэлцэх агшинд “Хөнхөр минь жаахан ойртооч” хэмээн түүний яралзтал инээн өгүүлэхэд би үл ялигхан зүтгэтэл годройтож үүлэнд орооцолдон эргэлдэв.”Цэвэлжид ээ” гэж хамаг хүчээ шавхан хашгиртал улигт хаалганы хонх намайг

сэрээж орхив. Би Сайнааг эгшрэн хөрвөөж хүлээдэг бол энэ удаа ад үзэн жихүүцэв.

Сайнаа хувцсаа сольж, миний дуртай хөх бошинзыг өмссөн боловч нүд хөрч, хөх даасан хөлдүүс мэт харагдах нь миний яхир, өвчний оёг нийлэн хананаас өөр ханьсалгүй болсных биз. Энэ бодолдоо эрхбиш уядасхийж “энэ амьтны буруу ч гэж юусан билээ. Хөгшин чөтгөр би л хөлийн хөнгөнд, хүний үрийг зовлонд ноолуулж, эр шиншиж, энгэр саамших болгов бус уу” хэмээн хулмасхийв.

Сайнаа миний цээжийг түшиж, халбага шөл оочуулж байхдаа ширэлдсэн буурал үсийг минь илбэн санаа алдаад чимээгүйхэн мэгшихэд түүний нулимс миний хацар даган урсахуйяа, өрөвдөхдөө нүд цавчилан унагасан миний хэдэн дусал нулимс түүнийхтэй нийлж буйг би мэдрэв. Зовлонгийн үер ийнхүү сүлэлдэн байхад хэрхэн би түүнийг харилхахсан билээ. Бид хоёрын хэн хэн нь юу ч хэлсэнгүй гэвч, амьдралтайгаа салах ёс хийж буй мэт. Бид хоёрт өдгөө, цагийн ноёрхолд хүлцэнгүйгээр сөхрөн бууж өгөх ганцхан аврал үлджээ. Бидний амьдрал бичил там байжээ.

...Гадаа азарган бороо шаагиж эхэллээ. Ийм бороонд нэвширтэл цохиулахсан. Тэр жил Цэвэлжидийг сургуульд орохоор ирсэн намар бид хоёр жимсэнд явж Чингэлтэй ууланд яг л ийм бороонд усан хулгана болж билээ. Тэгэхдээ хярын ониос захыг ороож ургасан хуснаас наян нэгэн алхам аав бид хоёрын нууц шавласан тэр газрыг би хэрэг болгон сонгож билээ. Бороо онгойход хоёулаа хувцсаа тайлж дэлгэхдээ би түүний нүцгэн биеийг анх харж билээ. Би тэсэлгүй түүнийг даран авахад цаашаа л даа гэсэн атлаа тас тэвэрч озолдон хөвдөн дээр хөрвөөж билээ. “Болохгүй, болно...Яах юм бэ...Яадаг юм бэ. Дараа ...одоо...гэхчлэн уухирдаж байснаа Цэвэлжид маань гэнэт ёо ёо л доо хэмээн намайг түлхэж доод уруулаа хэгзэртэл зууж “чи муухай” хэмээн намайг илбэх мэт алгадаж билээ. Ямар сайхан, амттай зодуур байсан гэж санана...Бид хоёр тэгэхэд диваажинд байжээ.

Төөрөл

Миний ухаан онгойх, бүтэх овилгогүй тэнгэр лугаа орон гаран болжээ. Чихнээ морин төвөргөөн хазаарын амгайн чимээ тасалдан сонсдох шиг агаад басхүү үл мэдэх морьтнуудын зүүд зэрэглээ сүүдэлзэхэд бугалагтаа хатиардсан арьсыг чимхэх аядваас мэдээ хараахан алдаагүй бололтой. Нүдээ аниваас улайвар гэгээ бугарснаа бүүдийхэд мөнөөх морьтнууд дахиад л сүүмэлзэн жирэлзэв. Би цаг хугацааны хязгаарыг гэтлэн элэнц дээдсийнхээ сүүдрийг сүжирч буйгаас зайлахгүй. Энэ нь миний сэтгэлийг зогоож би удам угсаатайгаа урагсаж үгүйт, бийтийн заагт ирснийх биз. Гэтэл загал морьт нэгэн баатрын дүр тодорч морины нь сагаг руу урсах тусал хөлс хүртэл харагдах шиг болоод сарнив. Энэ чинь хэн билээ? Арай... үгүй ээ магадгүй юм гэж тээнэгтэлзсэнээ, тиймээ мөн байна. Чингис хаантан намайг эргэсэн байх нээ хэмээн тайтгарч эцсийн хүчээ шавхан омогшив. Улаан суртлын угаадас долоосон гөлөг би хүртэл биеэ үгүйлэхгүй түүнийг алуурчин зандалчинд нь хүрч улин хуцаж цогин жороолж байсан атал тэр их хүн гомдож гол хөрөлгүй хагдарч буй хөх бог намайг ивээлдээ багтаасаар аж. Уг нь монгол хүний гүндүүгүй зан, атгагшаагүй ухаан, ясны нүнжиг, цусны хүйсэл гэдэг энэ буй за. Гэхдээ бид их эзэн хааныхаа зарлигийг хөсөрлөж ураг зуураа утаа таслан турсгаа хуулалцсанаас үүдэн илжигний идэш, баавгайн хэвтэш болсны балгийг өнөөдөр амсаж хогжруу толгойлон хохьдож яваа нь худал гэх үү. Хоосон бардамнал, өөр зуурын хувь заяаг өөтүүлсэн бүрэлгэл араатан араншин, хөл гарын хөглөрөл алмайдал, оюуны түгжрэл, алба тушаалын улангасал, сархадын салайрал эл бүхэн биднийг эс оршихуйн эргүүлэгт удгалж буйг ухаарахгүй нь гаслан. Харийн хөлд зулай дэвсэж, хүч илүү гүрний буулганд хүзүү холгож үхэрчлэн сажлах, бич адил бусдыг элэглэх төдий хормой сэнслэх мөчиг ухаарлаас өөрийн толгой зайлсан цагт улс маань улсын дайтай явахсан. Гэвч цувж яваа баруудыг цуглуулах хүн юунд эс төрнө вэ. Чингис хаанаас хойш хэдэн зууны турш улс үндэстнээ дагуулах суутан монголын саванд хэрхэн үл олдоно вэ. Одоо цагт олбог түшлэг зайдалсан зүсэн бүрийн хохь тайжууд хамар давах сунчингүй, улсын өрөм ухсан өт төдий гэвээс даваадуулсан болохгүй. Тэд молхи толхио мэдэхгүй мэдэмгүйрч, хоосон гавалд цаасан малгай углан сүржигнэх, олны төлөө амь зольж яваа мэтээр орь дуу тавих нь хөх инээд хөхүүлнэ. Хэрэв их эзэн хаан эргэн ирвээс тэднийг нүднээс далд болгох гэвэл яанав. Төр цааз нь төрхөөрөө малгай нь толгойдоо, гутал нь хөлдөө байвал улсын үйлс бүтэхсэн дээ. Явган засаг ямаан омогноос үл хэтрэнэ. Аавын минь танил “Ам” Чалхаа гуай “Сондуул толгойтнууд хүзүү боймлоод чивчлээд л байна. Нэг л өдөр тас үсрэнэ дээ. Орос олс бөх ч гэсэн монгол хүзүү гүрийнэ шүү” гэж миний залууд хэлэхэд нь учрыг нь ухах сөгөө надад байгаагүй. Эр хар сур шиг хөх өвгөдийн цөлх бодолд яаж ч хүрхэв дээ. Хөөрхий Чалхаа гуай шоронд үхсэн дуулдсан. Алсан хүнийхээ улаан голоор амьд хүний амыг үддэг цаг хойно доо...

...Доль Чойдор пролетарийн хувьсгал дахиад гарна гэж цанхаалахдаа баян хоосны ялгаа гаарахад сармайгаа хуваалцаж сархинагны салбангаа тоолно гэдэг. Нохой л үг. Бархас бол цус урсахгүй бол тос гарахгүй. Нийгмийн буглаа цусаар гадагшлаж цэвэршинэ гэдэг. Зэвүү хүрч би цочдог юм. Ламид бол үхэх төрөхийн зайд үе мултарч байж үүлэн сиймхий гарна. Шүдтэй нь араагаа шүдгүй нь буйлаа зууж явтал аз дайрч ариусах юуны магад. Тэр болтол тэмээн тавагнаас нохой ноцох ч юм билүү. Ямар ч байсан таны коммунизм жаахан холдчих шиг боллоо гэж егөөднө. Хар Сэтэв бол над шиг ачаа гүйцэхгүй болсон хөгшин ат нар хэвийтэл хөсгийн бараа харж хөл зөөж яваад зогдор дэвснэ дээ гэж уллана. Харин хэнхэг Хөнхөр би

улааны жанч амьддаа халаад эцсийн чагтга тасрах хоромд чармай нүцгэн гутрах л үлджээ. Уг нь үхэх хүнд үг хэрэггүй гэвч бодохгүй байж чадахгүй, бодлынхоо үзүүрээс гэрэл гэгээ олохгүй би тарчилж хэвгнэ. Биеийн шаналгаанаас үхэл намайг салгах гарцаагүй ч сэтгэлийн учигаа наранд орхимсоор санагдах юм. Хүний эцсийн төөрөл энэ буй за.

Бас л нөгөө улигт хаалганы хонх... Зовхио арай ядан сөхвөөс Сайнаа... Түүний царайд харуусал цөхрөл хоёрын аль нь байгааг ялгах тэнхэл надад алга. Бидний хооронд цэвдэгшсэн харьслаас өөр юу ч үлдсэнгүй. Түүний цээжинд хургасан надаас яс салахын түүсийг би буруутгаж үл чадна. Гэвч би нэгэнт хэврэгшсэн голоо тасраасай гэж яарахгүй, ганц өдөр боловч газар улаж нарны чагтганаас зууран учир утагагүй юунд хоргодно вэ. Чингэлтэй хайрханд булсантай шуналын бэтэг цөглөх бололтой. Үхлийн өмнө амины үнийг ухаарахчаа болж байгаа юм болов уу даа.

Бас л хаалганы хонх...

Би нүд нээж чадсангүй. Чимээлвээс Норжин эмээ, бас Жээжээ хэмээх нэр хочийн алин болохыг үл мэдэх нэгэн авгай ирээд миний судсыг барьж үзсэнээ:

-Ясны эртэй хүн юм. Танагтай л байна гэх нь сонсдов. Би даанч зүсийг нь харж чадсангүй. Түүний зуйгар үг унах зай миний мөхсөн итгэлийн саванд байхгүй.

Норжин эмээ, Сайнаа тэр гурав хөлхөлдөн гарав бололтой. Тэднийг шивнээг би тааварлаж байна. Хүмүүс ийм үед “хөсөг нь явчихаж, хойдохыг нь бод” гэцгээдэг юм. Хоногоо хүлээж байгаа хүнийг цайлгах хорвоогийн хохирсон ангижрал энэ ажээ.

Ашгүй хаалганы хонх гонгинохгүй л байна. Яаж ч дуугарах вэ дээ. Одоохон намайг авахаар ирэх зочин үүдээр орохгүй шүү дээ...

Бузрын шүглээс

Сайнаа миний орны хөлд аяархан сууж мэгшин уйлсаар. Би түүнийг аргадах тэнхэл байсангүй. Тэгээд ч эм хүний нулимс бүхэн үнэтэй бус, эр хүнийг дотроо живүүлэх чадалтай сэтгэлийн эзэрхэл, усан уур гэж бий. Сайнаагаас нөхрөө үхэлтэй булаацалдаж, арга буюу хүчинд авган алдах гэж буй эхнэр хүний цөхрөл, амьдралын дөрөөнд чиргүүлэн амь тэмцэж буй мэгдэл, аймшиг, хайр сэтгэлийн гасланг би мэдрэхгүй байгаа юм. Тэрвээр үйлийн үрд арга буюу дөрлүүлсэндээ амин зуулгын хөсөгний араас чирэгдэн гэмшиж байж болно. Түүний нулимс миний зүрхний ховдолд бус, ясны үеэр нэвчих мэт болоход би тэссэнгүй.

-Чи минь битгий уйл л даа. Надад шаналгаатай байна шүү дээ гэвэл тэрвээр шуухитнан,

-Нулимс өөрөө урсаад байна шүү дээ. Би яаж уйлахгүй байх юм бэ. Ганцаараа гүйсээр байгаад бохирч уналаа. Энэ айлын ачааг даахаа байлаа. Надад мэдэл ч байхгүй, хаана юу байгаагий нь ч мэдэхгүй, зарц шиг л амьдарч байна гэж гомдоллов. Түүний үг оргүй ч юм биш ээ. Залуу авгайд эрх дархаа өгчихвөл хөгшин толгойд асах агаад, нэгэнт түүнийг дүүлүүлж орхивол, буцааж буулгах тухай санахын ч хэрэггүй гэдгийг би мэдэж байсан юм. Нэг гэрт нийлснээс хойш ээмэг бөгжтэй болгосон. Нүдий нь цухуйтал гоёогүй гэхэд нүцгэн мөр нь улалзаагүй. Зуны халуунд хөлий нь шивэртүүлж гудамж алгадуулаагүй, суудлын тэрэгний түшлэг налуулж аминдаа эрхлүүлсэн. Тэгэхдээ омогшил, гачаал хоёрын аль ч туйлд хүргэлгүй хоймор, хатавч хоёрын хооронд хоргоосон нь үнэн. Бас түүнээс хайр сэтгэлийнхээ шавхруут харамлаагүй ч, амьралынхаа хамаг нууцыг дэлгэж, дотроо эргүүлж харуулаагүй. Надад түүнээс байтугай, өөрөөсөө бараг нуух юм бий. Одоо тэр нууцаасаа, амьд сэрүүндээ салах уу, хадгалж үхэх үү гэдэг л аанай миний санааг зовоосоор байгаа юм. Харин Сайнаагийн “мэдэлгүй, хаана юу байгаагий нь мэдэхгүй” гэж хэлэхэд нь цочиж “ямар ч байсан миний хань шүү дээ. Үүнээс өөр надад хэн байгаа билээ. Бүх юмаа хэлчихдэг ч юм билүү” гэж бодсоноо сэтгэл түвдсэнгүй.

-Би чамайг жаргааж чадсангүй дээ гэж гунигтай хэлэв. Сайнаа ялимгүй тайтгарч,

-Би жаргалаа чамлаагүй ээ. Харин чи надаас нэгэн юм нуугаад байх шиг санагдах юм. Эр эм хоёр нэгэндээ итгэхгүй бол хэнд итгэх вэ. Ямарч байсан би чиний хань чинь шүү дээ. Ажаад байхад нэг юм хэлэх гээд аман дээр чинь гараад ирэхээр л чи залгичих шиг болох юм. Тэгэхээр би эхнэр бус, хоноц тэвэрсэн эм шиг санагдаад заяандаа гомдох юм.

-Бид хоёр хэрэггүй л уулзаж дээ.

-Үүнийг л хэлэх гээд...

-Бараг л тийм дээ. Тэгэхдээ чамд хэлэхээр би өөртөө хэлэх ёстой. Чамайг бодвол хал үзэж, хамар давсаны хувьд би жолоогоо татах байсан юм.

-Хөгшин толгой, залуу авгай... Энэ бол чиний уншлага шүү дээ. Үүнийг хэлэх гэж зовоогүйг чинь би мэднэ. Хэлэх гээд байгаа юмаа хэлбэл хэл, хэлэхгүй бол яая гэхэв, хэлий чинь

сугалалтай биш дээ.

-Чи юу хэлүүлэх гээд байгаа юм бэ

-Хорвоо хаашаа ч холбирч мэднэ. Би бүх юмыг мэдэж байх ёстой. Хэнд өглөгтэй, хэнээс авлагатайг мэдэх ёстой. Энэ айлын эд хөрөнгө хаана юу байдгийг мэдэх ёстой. Гэтэл асрамжийн газар байгаа балай хүүхэн шиг алцайж хэвтэж, амыг чинь харсан амьтан...надаас өөр хүн байсан бол эзэн нь бишээ мэдээд энэ муу хашаа байшингаар чинь зул өргөчихөөд, хангаж чаддаг харцуул хүзүүдээд алга болох байсан. Би тийм жудагаа алдсан яатуу биш л дээ. Тэгэхэд чиний байгааг...итгэхгүй шүү...гэж тэр уйлагнан газар шагайв.

Сайнаа надаас үг алдуулах гээд, би нэг юм хэлэх гээд залгичихаад байгаа нь оргүй биш. Гэвч түүнд түлхүүрээ өгч болохгүй гэж өөрөө өөртөө өгсөн тушаалаа өөрчилж чадахгүй болов. Энэ удаад түүний сэтгэлийг өчүүхэн атугай ч уужлая гэж бодоод:

-Чиний зөв өө. Чи бүхнийг мэдэх ёстой, би ч хэлэх ёстой. Өнөөдөр үхлээ гэхэд өглөг авлага надад байхгүй. Хэрэв тийм юм босч ирвэл бүү үнэмшээрэй. Мөнгө гэвэл хэдэн төгрөгтэй дэвгэр бий. Гарын үсгий нь солиулаад чи хэрэглэнэ биз. Энэ муу машиныг хүүдээ өгөхөөс дээ. Хашаа байшинг чамтай булаалцалдах хүн байхгүй. Миний хэлэх гээд байсан юм энэ дээ гэвэл Сайнаа ажилдаа явах бололтой үг дуугүй хаалга саван гарав.

Сайнаад эл бүхэн чамлагдаж надаас ямар нэгэн илүү юм нэхээд байгаад би гайхаж үл үзэгдэх далд учигны үзүүрээс тэрвээр барьж авсан гэж үү хэмээн өөрөөсөө асуув. Согтуудаа юм уу, эсхүл янаглалын солиоролд би үг алдсан байж болох л юм. Тэгвэл хэрхэн цайруулах билээ? Нэгэн бөгөөс нүд анитал гэжих, эсхүл бэтэг санаагаа хагалж цагаандаа гарахаас өөр ямар зам байж болох вэ гэж хичнээн эрэгцүүлэвч хариу олсонгүй. Өвчин үхэл хоёроос илүү миний булууг хэмлэж байгаа юм зөвхөн энэ л болов. Хорвоо олон ааштай ч хоёрхон өнгөтэй гэдэг энэ буй за.

Үдийн эргэмд Ламид ирэв. Түргэн хөдөлгөөнтэй, заримдаа шудрага нь дэндэв үү гэмээр харагддаг энэ дүрлэгэр бор хүү бид хоёр уужим дээлэндээ багтахаар ганзага нийлээгүй ч дотуур амьсгаа бүлээн явдаг улс. Ламид зэлгээн цай оочингоо намайг нүдээрээ тэмтрэх мэт удаан ажигласнаа

-Хөнхөр гуай та их ядарчээ. Халамж л хэрэгтэй байна даа гэж түс тас хэлэв. Би ч түүний үнэн үгэнд жийрхсэнгүй.

-Тийм ээ. Ирэх өдөр байхад буцах өдөр гэж байлгүй яахав. Түүнийгээ л хүлээж байна.

-Амьдрал хэдий эрээн бараан ч бас хоргодох юм бий шүү.

-Эцсийн даваа руу уруудаж яваагаа мэдэж байгаа хэрнээ эргэж хармаар санагдах л юм. Хөөө хураасан үүрэндээ хоргоддог юм болов уу даа. За тэр ч яахав. Цаагуур чинь чих дэлсэхээр юу байна даа...

-Хуучнаараа амьдаръя гэхэд бүгчимдээд, цонх онгойлгож агаар оруульюу гэтэл Бархас та хоёр

өөдөөс өргөх бичиг барьж дайраад болсонгүй...

-Тэд ер нь миний нэрийг юунд хавчуулаад явааг би сайн мэдэхгүй шүү.

-Та намайг эрх тушаалд дуртай хутган үймүүлэгч гэж бут аваад, өөрөө үлгэр үзүүлж ажлаасаа чөлөө гуйж, хуучин удирдлагаа хэвээр байлгах ёстой гэж намын өмнөөс зарлиг буулгасан юм биш үү.

-Ламид минь! Цаадуул чинь намайг золиосолж л дээ.

-Тийм байх аа. Үг олдож таныг бүр ядраачихлаа. Амарч үз. Шөл хийлгэж уугаарай гээд хонины хөл мах эрэгнэг дээр тавив.

Би түүнийг “урд цагт бол ч ийм хүү идүүлнэ дээ. Цаг өөр болж байгаа нь үнэн бол үлдэж магадгүй” гэсэн бодлоор үдэв.

Норжин эмээгийн авчирсан хандмал аль хэдүйн хөрчээ. Би түүнийг уух санаатай авснаа буцаагаад тавьчихав. Учир гэвээс үүнийг уугаад дордсоноос цаашгүй. Тэгээд ч ийм үед бурхны элч Хэрээ мөнхийн ус амандаа балгаж ирэхийг хүн хүлээдэггүй юм билээ.

Чойдор ирэв. Ажлын газрынхан ийнхүү цуваад байгаа нь амьд дээр нүүр үзүүлж нэг ёсондоо салах ёс гүйцээж явааг битүүдээ би мэдэж байлаа. Ажлаас бууж гэрээрээ шүргээд наашаа гэлдэрсэн гэнэ. Бид хоёр хэдэн үг солих завсар,

-Хөнхөр минь! Насны бөгсөнд юу үзэхээ мэдэхээ байлаа. Энэ улс толгойгоороо хөл хийчихлээ. Улсынхаа санг ууты нь эргүүлээд гөвчихсөн бололтой. Архи, хулгай, алаан хядааны орон боллоо. Ардчилал гээч нь юм байлгүй дээ. Хойно Горбачев гэж нэгэн улаан халзан тийрэн гарч ирээд самарчихдаг байна шүү. Оросууд түүнийгээ бурхны бүрэлбаа, хувилгаан Михаил гэдэг юм байх. Нохой долоо. Тэр бол тархи руугаа буудуулж үхсэн эсэргүүний сүнс босоод хариугаа авч байгаагаас зайлахгүй. Манайхан хойно доо салхи цохиж хатгаа авчихгүй юу. Ай хөөрхий юм ёсоороо болж хоёр хөлөөрөө сажлах цаг ирнэ биз гэж горьдох юм. Намдаа л залбирахаас яахав гэж Чойдорын шүүрс алдахад “Чи бид хоёрын нам, Гомбогүр бурхны бөгс болсон юм биш үү” гэж хэлэх гэснээ би тэвчив. Бид хоёр эг маг гэлцэж байгаад Чойдорыг гарахаар босоход би халаагууртай хандмал эмийг зааж,

-Үүнийг цацчих гэв.

Чойдор үүдээр шагайлган цацах гэснээ халаагуурын ёроолыг нүдэндээ ойртуулан харснаа

-Чи айхавгар хүчтэй эм ууж байгаа юмаа даа

-Хэн мэдэхэв. Хадам хөгшин хаанаас олсныг мэдэхгүй. Миний ус гүйцсэн үү, эмний тус гүйцсэн үү цаашилхаас наашилсангүй.

-Уухаа больё гэж үү

-Тийм ээ. Зовлон хожоод яахав дээ.

-Зэс саванд буцалгадаг эм гэж байдаг бололтой юм. Би сая өвгөн маарамбаас эм залсан чинь зэс саванд буцалгах ёстой гэнэ. Эрээд олдохгүй юм. Монголчууд зэсээ урагш нь гаргаад дуусчихсан бололтой. Чи хэрэглэхгүй бол ганц нэг хоног барьзнавал яана.

-Сэжиглэхгүй бол аваад яв л даа. Аа тийм би чамд бас нэг юм өгье гээд дэрэн дороос намын баглахаа гаргаж - За чи үүнийг аваад яв. Тэр Дотоод яамандаа өгнө үү, хотын Намын Хороонд өгнө үү, дураараа бол. Амьсгаатай дээрээ намаас чинь гарч, нүглээ нимгэлье... гэвэл Чойдор гайхан нүд нь оройдоо гарч:

-Хөнхөр минь яаж болох вэ!

-Болно. Энэ намыг би төрхөө олохыг хүлээгээд нас гүйцэхгүй нь

-Бузгайрч байгаа шүү дээ.

-Над шиг лаг, бургтаас салтал их новшроно. Нэг ч бол лай зайлж зай гараг. Чи намтайгаа амьдрал руу би нүгэлтэйгээ там руу явья гэхэд Чойдор батлахыг тээнэгэлзэж авав.

Чойдорыг гарснаас хойш цээжний новшоо аанай л ухах гэсэн боловч чадсангүй. Үхэл хаяалахад ухаан санаа явгардаг юмсанж. Уг нь харж байгаа дээрээ сэтгэлээ, анихдаа биеэ цэвэрлэе гэж бодсон юмсан. Гэвч хүнтэй дэндүү адилгүй болсноос чөтгөр хүртэл төөрөөд намайг аваачихгүй мунгинаад байх шиг. Би дэндүү өмгөрхөн зайд дэмий мунхралд өөрийгөө үрж цагийн хавчуу хяхалд хайран насаа хамхуул мэт хийсгэсэндээ харуусч байна. Яая гэх вэ. Хүн гэдэг өөрийн цаг төрийн төлбөрийн зоос юм чинь!

Хамгийн хэцүү даваа үхэхийн өмнөх аймшиг юм билээ. Энэ бол гол тасрах хязгаарыг уулгалахад, сэтгэхийн аргагүй тэсэхүйеэ бэрх янд, сэтгэл зориг, цогцос цөм утга учиргүй тэмцлээ зогсоож, мөнхийн амаршилд шуудрах тушаалыг хүн өөртөө өгдөг гэж болно. Эцсийн энэ даваанд арайхийн гарч ирэхэд хүлээс аажуухан алдарч дотор уужран тавирах шиг болж би нүдээ нээв. Надаас баяр гуниг аль аль нь хийсэн одож, хорвоо цөлшин хүнийссэнийг гадарлав.

Миний нүдний өмнө бүх юм бүрэлзсээр тодров. Сайнаа тариа хийсэн бололтой миний мэдээгүй гарыг өвдөг дээрээ тавьжээ. Оргил орны өмнө явган сууж ямар нэгэн юм угааж буй бололтой. Оргил бол Цэвэлжид бид хоёрын нөгөөх ганц өргөмөл хүү. Багаасаа банзан гитар чирч яваад урлаг уран сайхан гээч саянаас унтарч эхлэхэд амь зуухын эрхээр хуучин Дарханы борчуулын хороонд хашин тосоор барааны саван шиг юм буцалгаж, гол зогоож яваа юм. Тэрвээр юм угаах бус бүлээн усанд алчуур норгон, миний магнайд жин тавьж байгаа юмсанж. Оргилыг уржигдар ирэхэд нь би машины хувийн хэргийг өгч, ганц үг солих гэтэл Чойдор ирж садаа болсон юм. Тэрвээр ахархах буюу янзыг нь үзэх гэсний алийг мэдэхгүй

-Чи ядарсан цагт нь эцгээ тэвхэрлэхгүй яаж голомт залгах хүн бэ. Одоогийн хүүхдүүд уулгамчилахаас цааш ухаан байхгүй. Аягүй бол чи аавыгаа өөдөхөөр өвий нь горьдож ирээ биз гэхихсэн чинь Оргил дүрсхийж

-Хуучин намынхан хөө шиг дотортой. Та аягүй бол “До” яамны хэрээ биз. Бидэнд өвлөөд

өвөртлөөд байх хөрөнгө байхгүй. Гэрийн ноход идээд идүүрт нь юм үлдвэл долоогоорой гэж хэгжүүрхсэн. Чойдор мөчөө өгөхгүй

-Залуурын дэргэд мод шулуун гэдэгсэн. Чи ч сүрхий муруйсан хүүхэд юм.

-Залуурчид нь тэгшхэн байсан гэж үү

-За яахав цаг явж байна.

-Үгүй шүү таны цаг зогссон...

Иймэрхүү мэтгэлцээн болж Чойдор санааныхаа мухарт Оргилын хэдэн үгийг үүцлээд халаагууртай тангаа аваад гарсан юм даг.

Оргил маань огт өөр хүн болж “хөгшин нам”, “балай Бал”, “орос шулам”, “Улаан феодал” гэж огцомдох болсон ч эзэн цаг хоёрын эрх дуранд өөнтөглөж хүүхэд цоровдоод яахав гэж бодоод би хорихгүй гэж шийдсэн билээ.

Чойдорыг явсны дараа Оргил бид хоёрын үг солих сиймхий гараагүй бөгөөд өчигдөр өглөөнөөс миний тамир тасарч үг хэлж чадахгүй болсон юм. Хүн туйлдахаараа хэлээ даахаа байдаг аж.

Би ганц халбага бүлээн цай цутгуулаад нүдээ нээх гэсэн боловч зовхио сөхөж чадсангүй. Халзан ирсэн бололтой дуу нь мөн. Цэвэлжидтэй тийм адилхан дуугарах гэж байхуу гэсэн бодлын учигнаас би барьж аваад алдчихав.

Үхэхийн өмнөх амсхийл дуусч би амьсгал хураах гэж байгаагаа мэдрэв. Хүмүүсийн яриа холдсоор... Оргил миний толгойг түшжээ. Тэгтэл бүх бие татах мэт болсноо хүйт даахад хаалганы хонх гонгинох шиг болов. Яг энэ агшинд ер бусын хүчтэй тийрэлтээр тархи задрах мэт болохуй миний сүнс зулайгаар сум мэт харван очис бутарсан гэрлэн замаар хөөрөх нь тэр.

Оюун санаа буюу тэрхүү биеэс салсан үл үзэгдэх сүнс биегүй, жингүй хоосон чанар ажээ. Энэ бол Хөнхөр мөн агаад биш, тэрвээр оршиж, эс оршиж, нэг талаар мөхөж, нөгөө талаас төрж эхлэл төгсгөлгүй хэлхээнд ер бусын ид шидийг олж байгаа нь энэ ажээ. Би ийнхүү агаар мандалд зоргоор зорчих өчүүхэн цэнэг буюу сүнс болон хувилж, эргэн тойрон юу болж буйг шохоорхов.

Сайнаа алчуураар нүүрээ даран гарч ухасхийснээ гадаа гарч хоёр банз сугалсан хашааны завсраар шурган ээжийнхээ гэрт ороод:

-Өнгөрчихлөө яанаа? гэж айж балмагдсан дуугаар хэлэхэд Норжин эмээ, тайвнаар

-Яахав дээ. Ёсоороо л болж... гэснээ -Чи ороод яахав. Юм үзээгүй хүн айж цочихын нэмэр. Үхээрийн бузар гэж бий гээд нэгэнт бэлэн байсан голт цөгцтэй зул барин гарав.

Сайнаа нүүрээ дарсан алчуураа авахад хуурай агаад түүний нүднээс нулимс гарсангүй.

Харин манайх гэж байсан айлд хөөрхий муу Оргил миний толгойг хадгаар бүтээж эхэртэнэ. Түүний шингэвтэр хонгор үс нүүр рүүгээ унжиж гар нь салганан чичирч байгаа харагдана. Эдүгээ миний хойноос газар дээр ганцхан Оргил ийнхүү гашуудан, элгээ өмлөх атал, сэрүүн ахуйдаа би түүнийг “Хүний хүү хүрэн бөөртэй” гэж бодож явсандаа гэмшивч өнгөрчээ. Би гэдэг ухаан билгүүн хэмээх хүн, хэмээтэл бодол чавцуу, сэтгэл хариг, дотор цэвдэг элбэрэл нигүүлсэлгүй нартыг орхисондоо халаглавч эцсийн даваанаас эргэн харах зайгүйгээр амьдрал намайг буруу үүдээрээ түлхснийг мэдэрч буй нь харуусал агаад гайхамшиг. Хөнхөр үхжээ. Би үхсэнгүй ээ.

“ҮХЛИЙН ИНЭЭМСЭГЛЭЛ” ХЭМЭЭХ

ДЭД БҮЛЭГ

Нэгдэх долоо хоног

...Хөнхөр хэмээгдэх хүн агсан би, бийт үгүйтийн зайд үл үзэгдэх сүнсэнд хувиран хилэнцэт хорвоогоор хий үзэгдэл болон бэдрэх болвой. Амьдралын буртагаас хүй салж, этгээд амаршилд тус буюу гэрийн алинд ч хүртээлгүй атал, үзэх сонсохын үйл хэвээр нь юутай гачлан.

Хүмүүн төрлөхтний мунхрал, хомхойрол, тэчъяал, ичгүүрт араншин, бурангуй явдлыг үхсэн хойноо үзэх лайтай юмсанж. Үнэхээр дөчин есөн хоног хураалгаад сүнс зайлж там диваажингийн аль нэгэнд заагддаг ахул түүнийгээ түргэн үзэхсэн гэж адгана. Ерөөс сүнс хэмээгч нь орших биенээс ойн гарсан оюун сэтгэлийн бичил цөм буюу. Сүнс хаана орших, хаа хүрэх нь түүний зорго хийгээд ер бусын цахилах хурд аж. Амьдын орчлонд мөчиг сонссон дууны болон гэрлийн хурд хэмээх шинжлэхүй ухааны бүдүүн тойм нь үүний дэргэд үхэр тэрэг мэт. Ажлын газар юу болж байдаг бол гэхэд л хүрчихсэн байв

Хамгийн түрүүнд Бархас ирж манаачийн хоргонд шагайн,

-Тайван уу гэж асуугаад – Ажлын хажуугаар Хөнхөр үхэж...гэчихээд мужааны тасагт оров. Тэнд дүүрэн авс хураалттай агаад ус нэвчсэн хар модон чийтүүтэй ноцолдохоос халгасан мужаанууд тамхи баагиулна. Бархас,

-Бэлэн бүтээгдэхүүнээ борлуулах нь яасан юм бэ? Энд ажиллах байтугай амьсгалах зай алга гэхэд хэн нэгэн:

-Үхэл зовлон гайгүй байгаа юм болов уу даа гэвэл Бархас,

-Муусайн пизданууд чинь яагаад үхэхээ байчихав аа гэснээ, за яахав ганц ч гэсэн зай гарна “Хөнхөр конец” гэчихээд эргэв.

Сэтэв ширээнийхээ ард суугаад “Үнэн” сонин гарчиглатал түүний туслах, Жагай ямар нэгэн бичиг барин цээжээ чадлаараа түхийлгэн орж ирээд ширээн дээр нь тавихад Сэтэв гары нь илбэж,

-Юу байна даа, Жагуухай минь гэхэд,

-Нөгөө муу Хөнхөр үхсэн гэнэ

-Аль эрт биднийг очиход сүнс нь зайлчихсан байсан л даа.

-Зовж үхсэн байх аа. Унд ус ч үгүй, ууж байгаа эм нь гэж тэр.

-Тэр зэс халаагууртай юу. Ямар сайндаа би тус уу, ус уу гэхэв дээ.

-Намынхаа батлахыг явуулсан гэсэн. Хүн үхэхээ мэддэг нь үнэн юм даа.

-Зүгээр ч явуулаагүй. Их л муухай үг дайсан байна лээ. За тэр яахав. Харин чиний нүд чинь сэлхэрчихсэн юм шиг. Бие чинь зүгээр үү?

-Зодуулчихсан юм шиг л байна.

-Зодсоны буруу л даа.

-Би зодуур хүссэн юм чинь гэж аальгүйтэв.

Сэтэв түүний гарыг барьж яваа бичигтэй нь атгаж,

-Энэ юун бичиг юм бэ?

-Газар гуйсан хоёр өргөдөл л байна.

-Танилцав уу, ямар улс юм бол?

-Эхнийх нь ахмад багш гэнэ гэхэд Сэтэв тоомжиргүйхэн өргөдлийг авч өрөөсөн буланд нь “Цагаан Даваанд” гэж цохов.

-Хоёрдох нь Нянгар даргын хадам... гэвэл Сэтэв өргөдлийг хичээнгүйлэн уншаад,

-Ээ хөөрхий даргын хадам ээж таалал төгсч л дөө. Буянтай буурал байж таарна гээд “Самбаллхүндэвт олгоё” гэж нямбайлан бичээд буцааж өгвөл Жагай араасаа ад дуудах гэсэн мэт бөгсөө ацлан хаялсаар эргэв. Бусад нь яахав “Жагуухай” гэсэн өхөөрдөл надад содон дуулдав. Ер нь үүдэндээ хүүхэн суулгадаг их бага дарга нар ийнхүү нохойтох нь муугийн бус монголын зан юм чинь. Энэ залуу хүүхэн тэр енхөр буханд орооны гунж шиг хотолзож буй нь Сэтэвийг хуучин хааны ланжуу буутай гэлцдэг нь ортой биз.

...Бархас миний ширээний шургуулгыг онгичин хуучин үзэг харандаа, тал бэх, хугархай шугам, паалантай аяга, дэцэн халбага зэргийг хогийн саванд хаяж байна. Тэмдэглэлийн дэвтрийг маань нугалан эргүүлтэл завсраас нь ганц зуутын дэвсгэр гарахад халаасандаа хийж орхив. Уг нь би намын татвар хураалгах санаатай хийсэн биз. Гэтэл Жагай хаалгыг нь татан:

-Дарга дээр ... гэчихээд хамхичихав.

Сэтэвийн өрөөнд Бархас, Ламид, Жагай гурав уван цуван орж ирэхэд Сэтэв,

-Хөнхөр нас барсан мэдээ байна. Тэгэхээр комисс гаргана байгаа. Бархас толгойлсон нь дээр болов уу. Шаардлагатай хүмүүсээ сонгож авна биз. Байгууллага хамт олны зүгээс бас зүгээр байж болохгүй байх. Энэ асуудлыг шийдчихье. Хэнд ямар санал байна гэв. Бархас бусдаас түрүүлэн ам хагалж,

-Миний хувьд ажилдаа дарагдчихаад учраа олохгүй амьтан гүйж явна. Комиссыг Ламид даргалах ёстой. Байгууллагын зүгээс гэвэл нэг хайрцаг гаргая л даа. Өөр яах вэ. Хамт олноос тав гурван юм цуглана биз. Хувиа өгчихье гээд нөгөө зуун төгрөгийг Ламидын өмнө шидэв. Ламид гайхах мэт харснаа дуугарсангүй. Бархас барьцаа ахиулан,

-За яахав. Би чулуугий нь аргалъя. Үйлдвэрийн бүтээгдэхүүнийг үхсэн бүхэнтэй үнэгүй хаяад байх ч...

Бархасын эрүү хэлнээс Сэтэв залхсан бололтой,

-Ламид ажилдаа орох уу даа... гэснээр зөвлөлгөөн тарав.

Бархасыг өрөөний үүдэнд отож байсан Чойдор даган орж,

-Талийгаачийнхаар та нарыг орвол морины хань татаад...

-Ламидтай ярь. Надад зав алга.

-Тэгж болохгүй. Өндрийн өөдөс, өргөний тайрдас гээд байгаагийн цаана чиний аманд ойчих шар тос л байгаа шүү дээ гэж Чойдорын шазруухан өгүүлэхэд, Бархас таг болов. Зуудаг гөлөг шиг ярзганасан энэ хархүү Чойдорын гарт ийнхүү орсон нь үнэхээр гайхалтай. Энэ хоёр ходоод яагаад нэг сүлбээртэй болсон юм бол?...

* * *

Автобус ойрмог яваагүй бололтой нилээд хүн хий холхино. Ам бүлээсгэх гэсэн юм болов уу нэгэн бүдүүн хижээл эр, залуу хоёр үг сөргөлцөн толхилцохыг хүмүүсийн зарим нь чих дэвсэх аж. Тэр хоёр:

-Чиний тэр ардчиллаас болж турж үхэх нь...

-Тарган мал зуд даадаг биз дээ. Та турж үхтэл хаа байсан юм бэ. Социалист хуримтлал чинь хэвээрээ байна шүү дээ.

-Бид ард түмнээ өлсгөөгүй шүү.

-Өлгийтэй хүүхдийг ч өртэй болгосны хүчинд үү?

-Хүү, тэр өрийг хөхөж өсөөгүй юу?

-Үүнд чинь хамаг гай байгаа юм. Та хэдэн үеийн тархийг агшааж ходооды нь сунгасан. Өөрөө усны захад очоогүй шигээ намайг сэлж сургаагүй учраас өнөөдөр хоёулаа борооны шалбаагт живж үхэх гэж байна шүү дээ.

-Би бүтээдгээ бүтээсэн хүн шүү

-Хүмүүс бүтээж, та тууз хайчилж, дайлаганд орж байсан бол яана. Уучлаарай. Та арай дарга

ангийн нэг эс ширхэг биш биз?

-Намайг анги гэж устгамаар байна уу

-Үгүй, үгүй. Та айх хэрэггүй. Бид ард түмнээ ангиар ялган хүйс тэмтрэхийг хувьсгал гэдэг “Ху” намынхан биш. Бид танд гар хүрэхгүй. Та одоо юу ч хийхгүй байж болно. Гагцхүү юм хийх гэж байгаа улсад л битгий саад бол. Энэ бол Монгол улсынхаа төлөө таны хийж чадах ганц ажил...

Тэр хоёр ийнхүү шөргөөцөлдсөн боловч автобус ирэхэд сайхь залуу, бүдүүн эрийг урдуураа оруулан ямар ч атугай эцсийн буудал биш гэхэд оноолын зайнд нэгэн дээвэр дор багтахгаас өөр аргагүй болов. Өөр яах ч билээ дээ. Зорчигчдын дотроос нэгэн хоржин эр

-Хэрүүл уншиж, сонсож, үзэж, идэж, өмссөн хэдэн монгол бид хаа хүрэх юм бол доо гэж санаа алдахад хэн нэг нь

-Автобусны маань шатахуун дуусчихгүй бол Америкийн хойноос очноо гэхэд хүмүүс хөхрөлдөв.

...Манай гудамжны аман дээр Чойдор Бархасыг зогсоож:

-Өвгөн ах нь өөрийн аманд багтахгүй олзыг чиний аманд хийх санаатай. Талийгаачийн ажил явдлыг өнгөрөөхөд чадлаараа тус бол. Ялангуяа Сайнааг сайн түшиж тэвхэрлэж өөртөө дасгаж авахыг хичээ. Талийгаач чамд “Сайнааг минь харж үзэж халамжилж яв” гэж захсан гэдгийг яс маханд нь шингэтэл итгүүл. Ийм үед хүний сэтгэлд сүү дусаавал дараа нь өрөм хуулдаг юм.

-Би юу ч ойлгохгүй байна.

-Ойлгох цаг ирнэ. Шилэн форд унаад торгон хэвнэг нөмрөөд шотландын сархад Туулын мөстэй холиод шимж суухдаа ойлгох болно. За явъя...

Бархас, Чойдор хоёр гадаа барьсан цэрэг майханд сууж, Сайнаа, Норжин эмээ, Оргил гуравт “...тохиолдсон зовлонг хуваалцаж, ихэд харуусаж байгаагаа, бас бүх талаар туслахад бэлэн байгаагаа” илэрхийлж, ”Хөнхөр бол тусч, шудрага, зарчимтай, нөхөлдөө үнэнч, ховор тохиох сайхан хүн байсан” гэж ам булаалдан зулгуйдаад “Мань мэт нь үлдэж, хүний сайн нь явчих юм” хэмээн баахан гаслалдав.

Сайнаа ирсэн гийчдийг хашааны хаалгаар гаргаж өгөхөд Чойдор нуруугаа үүрэн сажлав. Бархас үлдэж Сайнаагийн нүүр рүү унжсан шанхыг хойш аяархан илбэж:

-Сайнаа минь сэтгэлээ барь. Хорвоогийн хатуу жамыг тойрч гардаг хүнгүйгээс хойш, дагахаас яахав. Талийгаач агуу их ухаантай алсыг хардаг мэлмийтэй хүн. Хөөрхий минь намайг эртэд ирэхэд “За чи Сайнааг минь дааж үлдэнэ шүү Би явахдаа газар дээр ганцхан чамд итгэж Сайнаагаа үлдээлээ шүү” гэсэн. Сайнаа минь чи миний үгэнд орох юм байгаа биз дээ гэхэд Сайнаа тонгойсон чигтээ шуухитнан толгой дохив. Бархас түүний мөрөн дээр

гараа тавьж:

-Би чамайг газардуулахгүй. Хэзээ ч хэнд ч элэг бариулахгүй, амь насаараа хамгаална. Чиний төлөө гал ус руу үсэрч чадна. Чи надад итгэ гэхэд Сайнаа баярласан даа ч тэр үү, ер нь аятайхан ч байсан юм уу Бархасын цээжинд нүүрээ наав. Бархас түүний мяндсарсан гэзгийг илбэн зулай дээр нь үнэрлэн үнсэхүйеэ Сайнаа тайтгарав бололтой.

Тэр оройдоо онц юм болсонгүй. Өглөө нь Оргил миний тэргээр Норжин эмээтэй хамт үзмэрчид очиж өдөр судар үзүүлж алтан сав нээлгэхээр шийдэв. Энэхүү гайхамшигтай учралд би хэдийвээр яаравч өглөө болгохоос өөр аргагүй тул орон дор хоргодон хоноглохоор шийдэв.

Зулын бүдэг гэрэл ёлтолзсон хоосон байшинд бие сэтгэл хоёр ангижран бие маань дээр мэдээ алдран цэвдэж хэвтэхэд би дор нь орчлонгийн явдлыг мэдэрч буй нь үнэхээр ид шид байлаа.

Хар олзын үүд

Оргил, Норжин эмээг аваад миний тэргээр хөдлөв. Сайнаатай нийлэхийн өмнөхөн энэ тэргийг авсан минь бүсгүй хүний сэтгэл урчихсан ч байж болох юм. Хүрээ хүүхнүүд урьдаас хужаа, хувьсгалч, цэргийн дарга, дипломатч, эрдэмтэн, сайд гэж дамжсаар одоо хувийн тэрэгтнийг хүзүүдсэн. Хувийн тэрэгтэнг баячуул гэж хүмүүс жөтөөрхдөг. Баянаа ч хат даа. Чөдрийн унаатай л амьтан. Монгол хүн, нөхрийнхөө хөл дүүжилдэг ганцад атаархаж ад шоо үздэггүйсэн дээ. Хаашаа ч цаг болсон юм бэ дээ...

Машин Баянхошууны зөгийн үүр шиг хашаан дундуур сүлжсээр “Хатан сүйх” угалзтай хаалганд тулан зогсов. Өчигдөр орой сонссоноос хойш энэ мөчийг би тэсч ядан хүлээж байсныг хэлэх үү, энэ үзмэрч авгайн буулгах лүндэн надад эвэртэй тэмээ үзэхээс илүү сонин болов.

Норжин эмээ Оргилд:

-Миний хүү тэргэндээ хүлээзнэж бай даа. Эмээ нь юу айлдахыг нь дуулаад ирье гээд оров.

Үзмэрч хэмээх нь тавь эргэм насны тарган шар авгай аж. Гэр орон тохилог авч шинэ баяны шинжтэй.. Тавилга сэлт нэн орчин цагийн агаад, хаш өртэй ширээ, гясаа шигтгэсэн зандан шургуулга, эрээн паалантай шармал хорготой цаг, жаргалын найман морьтой жангийн хивс зэрэг нүнжиглэж өвлөсөн юмгүй. Норжин эмээ амар мэндээ мэдэлцэн танимгайраад өврөөсөө хадаг гарган, дээр нь нэг зуун төгрөг тавьж үзмэрчид бариад,

-Хүргэн шуу юм маань өөдчихлээ.

-Ум маний

-Цаг зүгий нь ч мэдье. Алтан савыг нь нээлгэе гэж бодоод...

Үзмэрч хадаг, мөнгийг авдран дээр тавиад, талийгаачийн нас, жил зэргийг лавласнаа:

-Насалдагаа наслаад нэг жил илүү явчихсан юм байна. Норжин жээжээ, танай хүргэн их буянтай хүн юмаа...?

-Арай хоосонгүй биз. Сайнаагаас олон ах юм шүү дээ.

-Тэгэлгүй дээ. Сайнаа шиг сайхан хүүхэн буяны ерөөлөөр л учраа биз дээ.

-Яахав дээ. Ховор зэврийн цагт галаа харж хоноогүй л байсан юм. Ганц охиноо хоёрын хооронд хэрэггүй зовлон үзүүлчихлээ.

-Жарганаа, жаргана. Ерөөлтэй хань нь өөрөө ирнэ. Талийгаач ураг садан олуул уу?

-Бараг л эр ганц хүн. Эхнэр нь хоёр жилийн өмнө өнгөрчихсөн. Ганц хүү нь айл болоод аль эрт амиа хөөгөөд явчихсан юм билээ. Хэд хоногийн өмнө ирж толгойгий нь түшлээ.

Талийгаачийн унаагаар намайг хүргэж ирээд гадаа хүлээж байгаа л даа.

-Юмны эзэн гээд сууж байгаа юм биз дээ.

-Ээ буруу хойшоо, юмсах юу байх вэ. Хөгшин хүнтэй, хормой орооцолдсон эмийг хэн тоох вэ. Муу охин минь хаяандаа өтлөнө биз дээ. Амьдралаа үрснээ бодсон ч, асарч тойлж авгай нь гэж явснаа бодсон ч энэ хэлхээтэй төмрийг худалдаж хувилгаад хэд хоног зулгаана биз дээ. Мартсанаас хоргодсон юм юу байдаг бол...?

-Хөөрхий амьтан гол нь тасарч өгөхгүй их л зовж дээ. Газар лусын хорлолтой, бас орон савандаа хоргодсон байх юм. Тэр бүхнийг зайлуулахгүй бол Сайнааг өвчин эмгэг ээрч буян нь цөвтөх л юм байна.

-Яадаг билээ. Би яах вэ?

-Би яаж чадааж дээ

-Чи минь л тус болж үз

-Би хүч хүрэхгүй юм шиг байна

-Яагаад тэр вэ?

-Чи үйлийн үрээр гай зовлонд зүтгээд байгаа хүн шив дээ.

-Тийм гэж үү

-Тийм ээ. Урхинд толгойгоо хийдгээ хийчихсэн юм шив дээ.

-Бурхан минь! Одоо яанаа!

-Яахав дээ. Охиноос чинь үнэтэй юм орчлонд байгаа бол яах ч аргагүй.

-Яалаа гэж... Охин минь л байвал юу ч хэрэггүй.

-Өөрөө л мэд. Чамайг хүсвэл тус болж болох л юм. Үгүй бол тэр л биз.

-Чамд л даатгая. Тэр муу төмрийг авчраад хаячихъя. Чи нүд далд болгоод өг... Бурхан минь... гэсээр Норжин эмээ үглэн гарав.

Үзмэрч хэмээх энэ балай авгайг ямар заяа нь хаясан эр тэвэрч хэвтдэг бол хэмээсэн дэмий юманд би гонсойх шиг. Гэвч “ид шидтэй” авгайн улайм цайм луйвардсан мөнгөөр ямар нэгэн махан толгойтой амьтан архи гударч, согтуугийн мунагаар алтан аяганаас рашаан хүртэж байна гэж альхидаг биз.

Цаг хямрахаар цайны шаар дээрээ хөвдөг бололтой. Ухаантай сэхээтэй нь усанд хаясан чулуу шиг сураг алдарч зүсэн зүйл луйварчингууд үзмэрч, Дар-Эх, улаан шарын хувилгаанаар

тодорч харь гаригийнхантай уулзсан, алтан цөгц алдсан болж, амьтны толгой эргүүлэх нь юутай гутамшиг. Гэтэл тэдэнд итгэж, эрэг мөргөж байдаг эргүү толгойгоо яалтай билээ. Нэгэнтэй би “Та нарын тэр Америк чинь аль зэрэг хол явсан юм бэ дээ “ гэж тохуурхахад Ламид гайхан “холдоогүй ээ. Би харин хоёр мянгаад жилийн хойно явж байна “ гэж билээ. Түүний өмхий үг ортой юм биш байгаа...

Норжин эмээ Оргилд :

-Насны нь хэмжил бараг ч өнгөрчихсөн юм байх. Нар битүү гаргах болж байна. Чиний жил ивээл гар хүрэх ёстой гэнэ. Сайнааг ойртоод хэрэггүй гэнэ. Хүний хань ойртож болмоор л юм. Бид яая гэхэв дээ. Цаадах чинь заавал явна гээд зүтгэчихнэ дээ. Яаж хоргоодог юм билээ. Уг нь ч энэ унаагий нь чамд өгчихье гэж бодоод асуулаа. Чамд байтугай үр хүүхдэд чинь өлзий болохгүй гэнэ. Хөөрхий минь үүндээ хоргодсон байна гэнэ. Нэг их унаад байдаггүй, тоодоггүй л хүн юмсан.Хойт мөрий нь цэвэрлэж буян хийхийг бодохоос доо. Би гэдэг үхэж өгдөггүй үйлтэй сэнкүү. Хүний сайхан үрийн мууг үзчихээд одоо юунд амьд явах юм бол оо? Талийгаач маань бидэндээ уул шиг түшиг байлаа. Охин бид хоёр ингээд цагаан газар алгадлаа. Биднийг яалаа гэж бурхан гэсгээнэ вэ хэмээн үглэн уйлагнана. Оргил бодлогоширон замаа харах бөгөөд эвсэл,тэрслийн аль нэгэн түүний царайд мэдэгдсэнгүй.

Оргилын дэргэд миний хадам ээж, Норжин хуар, Норжин эмээ аль нь ч бус хөгшин чөтгөр сууж явах шиг надад санагдав. Тэр үзмэрч эм, энэ чавганц хоёрыг нэг муу голоор холбоод хөөчих юмсан. Хоёр худалч, луйварчин шаарнууд тамын үүдэнд хамт очоосой нь билээ. Энэ муу хуруувч шиг чавганцын сэтгэлд шуналын өг язганаж, түүний нүднээс нулимс бус цус нэвчиж байх шиг. Ийм бузар сэтгэлийг хүмүүс хөхүүлэн тэжээж, өөрсдийнхөө ертөнцийг дотроос нь бээрлүүлэн мөхлийн харанхуй ангал руу алхам, алхмаар ойртож байгаа нь юутай эмгэнэл. Гэтэл эрхбиш голдоо нүхтэй хэмээгчид нь төр улсын өрхний оосор булаацалдан биесийг хэмхэх буюу ямар нэгэн харь сурталд хамагчлуулан хувь заяагаа даатгана. Үлдэх хэсэг болох ард түмэн хэмээх гоё нэртэй хүн сүрэг улс төрд угжуулж өөрсдийхөө өргөмжилсөн шинэ мунхагийг тодруулан тахин шүтэж, түүнд илжиг мэт зүтгэнэ. Хүн төрлөхтөн энэхүү балар хэвшил, сохор суртлаасаа ангижраагүй цагт зовлонгийн үүдийг хэрхэн хааж чадах билээ.

Норжин эмээ бяцхан боодол задлан бусдад харуулах янзтай:

-Эрднийн зүйл гүйцсэн гэв. Түүнд саатай торгоны утас, ногоон хуванцарын үртэс төдий нь алт, оюу мэт бололтой. Юу хийх нь нэгэнт эзэнгүй болсон цогцсонд хамаагүй гэвч үхэгчийг ийнхүү мэхлэдэг нь нэгэнт эрхэм ёс болжээ. Харин жинтүүнд хадах юм тэд олсонгүй, юу ч олохов дээ. “Сайшаалын үнэмлэх”,”Баярын бичиг” гэсэн хэдэн цавуутай цааснаас өөр юу ч байхгүй юм чинь.Амьд сэрүүндээ хүн амьтан одон, медалиар шагнуулж байхад хор хөдлөх өдөр байсан биз. Гэвч одоо миний цогц одонтой жинтүүтэй, жинтүүгүй гарахын ялгаа өчүүхэн ч байсангүй. “Олон жил ажилласан хүн хоосон баймгүй юм”,”Эрхбиш энгэр цоолж л таараа...” гэсэн хүмүүсийн яриаг унтраах гэж Бархас:

-Талийгаач бол өөрөө одон байсан юм. Тэр бол гавьяа зүтгэлийн дээд үлгэр байсан болохоор одон дээр одон зүүдэггүй юм гэхэд нам гүм болов.

Энэ хүмүүсийн дунд ганц өрөвдмөөр хүн Оргил л байлаа. Тэрвээр хүнийг юм асуувал “за”, “мэдэхгүй” хоёроор хариулж, шөнөд хүж зул сэргээж, тэргэнд суугаараа дуг хийж хононо. Сайнаа, Норжин эмээ хоёрт бүр хөрч гүйцсэн бололтой. Харин оройхон хашаанд ганцаар бөртөгнөн маргаашийн ажил явдал дуусгаад буцах янзтай шөлний юм, цайны сүү авчирсан сав суулгаа шуудайд хийж тэрэгнийхээ ард хийж байгаа харагдав. Би түүнд хамгийн чухал юмаа хэлж чадаагүй дээ харуусаж “түргэн л буц. Энд амьд хүн байтугай сүнс хоргодоход ч хэцүү байна” гэж шивнэмээр авч миний үг хүний орчлонд хүрэхгүй нь хяслан.

Өглөө эрт Оргил, Бархас хоёр миний цогцсыг хайрцганд хийж хадгаар нүүрийг бүтээн дамжлан гарч ачааны машин дээр тавиад Далан давхар луу хөдлөв. Тэнд ёс төр болсонгүй. Бархасын бичиж өгсөн үгийг Оргил өврөөсөө гаргаж ирснээ буцааж хийгээд,

-Миний эцэг...гэснээ түгдэрч...та ...тавтай нойрсдоо гэж арайхин хэлээд эхэртэн уйлав. Хүмүүс хайрцагтай цогцсыг нүхэнд нямбайлан байрлуулаад элс шороо цацаж эхлэхэд, хийх юмгүй зарим нь булшны бичээс уншин үхэгсдийн балгасыг сониучлан тархав.

Бархас, Чойдор хоёр байгууллагын нэрийн өмнөөс хүндэтгэл үзүүлэх гэсэн бололтой ганц хоёр хүрз шороо хаяад багажаа залууст өгч аажимхан нуруу үүрэн алхсаар захласан хойно Чойдор,

-Сайнаа яагаад яваагүй юм бэ?

-Жил нь ивээлгүй гэсэн юм байхаа.

-Би мэдсэнгүй л дээ. Уг нь явах ёстой байсан юм. Хүний хэл, нохойн хуцал гэж айхавтар юм бий. Эхнэр нь даанч яваагүй юм, тэгнээ тэр гэж хожим хойчийн өдөр хүн цочихгүй байх ёстой юм сан. Гоомой л юм болж дээ.

-Та их холын юм бодоод байна. Маргааш л гэхэд бүх юм мартагдаж орхино.

-Хоног хоногоор мартагдах юм байхад, сөхөгдөх юм бас бий. Ер нь хүн алхсан мөрөө эргэж баллаад явсан нь аминд өлзийтэй. Тэр бүхнийг энд яриад яахав. Маргааш ажил тараад манайд уулзъя...

Тэд үүнээс өөр товтой юм яриагүй ч гэсэн энэ хоёрын хооронд үүсээд байгаа учир үл мэдэгдэх хэлхээ хэзээ юугаар төгсөхийг харахаас өөр аргагүй болов.

Улаан хамарт сахиул хүлээж авах нэрээр ирж сэржимний үлдэгдэл хөнтрөх нь зовлонгийн дээж жаргалын шавхруу хоёрын алин болохыг ялгахад бэрх. Сахиул хугас шил архины хувь хүртэж оршуулга дуусах үеэр би хашаанд ирэв. Хороо хорины цөөн авгайчуул голдуу арын албанд үлдсэн хүмүүс байшинд идээ будаахан өрж, зарим нь гадаа гал унгасгаж аминдаа хөл болж байна. Норжин эмээ гэртээ том тогоонд цай чанаж, Сайнаа үс гэзгээ янзалж буй бололтой тольдон сууна. Норжин эмээ:

-Миний охин ямар гоё юмнууд хаанаас олоо вэ?

-Уруу дорой байвал үхэл зовлон баярладаг гэнэ. Өөрийгөө өөд татаж яв л гэсэн шүү дээ.

-Хэн тэр вэ?

-Бархас дарга...

-Сайн л хүн юм даа.

-Их эрдэмтэй, сайхан сэтгэлтэй хүн шиг байна.

-Хүү нь явна гэж байх. Юу өгдөг шуу юм билээ?

-Эцгийн нь эдлэж хэрэглэж явсан юмнаас өгөх ёстой шүү дээ.

-Тэр хэдэн үнэмлэхий нь л өгчих үү?

-За яахав цагт нь больё.

-Миний охин гарч үз. Улс амьтны нүдэнд харагдаж байсан нь дээр гэхэд Сайнаа дурамжхан боловч цааргалсангүй.

Гар ариутгах рашаан, хөвөн шаариг зэхэж суусан хоёр авгайн нэг нь Сайнаагийн хойноос тааламжгүй харж:

-Хань нь ойчоод байхад хаашаа ч хүн бэ дээ харал.

-Яахав дээ, зовлон үзээгүй хүүхэд хүн юм даа зайлууул

-Хүүхдээ алд. Гуч хүрээ биз дээ. Талийгаачийн дэргэд л хүүхэд юм биз дээ.

-Олон ах хүнтэй суусан эм, эрх зоргоороо байдаг хойно, тооно нь толгой руу нь ойчиж байгааг мэдээгүй л яваа.

-Норжин авгайд их учир бий. Цэвэлжидийг өнгөрсөн хойно, охиноо хөтлөж ороод өвөрт нь хийчихсэн гэж шуугиад л байсан даг. Хуучны гарвистай авгай ч хүний санахгүйг санах л байх.

-Цагтаа цалгиж явсан гэдэг юм. Одоо ч больжээ.

-Хутга хугаравч шөвөгний дай бий. Гар нь хүрэхгүй гэхэд санаа нь маньд гүйцэгдэхгүй.

-Өрөвдмөөр л улс үлдлээ.

-Хоёр ч хашаа байшинтай, төвхийсэн хөрөнгөтэй залуу хүүхэн газардахгүй. Тэгэх тусмаа баян нь нисэж, ядуу нь мөлхөж байгаа цагт бэлэн юм руу орох азтай сайхан гуйлгачин олдоно.

-Санаа л мэднэ. Санаа муу болч...гэтэл үдэгсэд ирж буяны идээ амхарч гашуудал тайлаад төдий удсангүй тарцгаав. Оргил Бархасыг хүргэж өгөхөөр хөдлөв. Алба сангаас хэрэглэсэн ширээ сандал, аар саар юм байсан тул Чойдор үлдэж, Сайнаа, Норжин эмээ хоёрт аминчлан:

-Ийм үед олуулаа бужигнаж байхад хүн анзаардаггүй мөртөө амьтан явчихаар эл хулирч гэрийн зай онгойгоод хэцүү болдог юм. Сайнаа минь сэтгэлээ барьдаг юм шүү. Манайхан эргэж тойрч байх юм гэнэ лээ. Би бол муу будааны нярав юу шалих вэ. Гэхдээ хаанаас хаалгач нь гэж түлээ нүүрс мэтийг дөхүүлчихэж дөнгөнө. За даа тэгээд та нарт ганц өрөө ч болсон сууц л хэрэгтэй болно доо. Олоход л бэрхтэй. Харин Бархас даргыг дэлдэж сүүлдээд байвал бүтээж магадгүй. Өөр хүн чадахгүй. Хэлээд үзээрэй. Чонын ходоодоос иргийн сүүл ухаж аваад тогоо тосолчих хүн гэхэд Норжин эмээ:

-Би яахав, бор гэртээ ойчоод өгч болно. Энэ муу охин алийн болгон хуруу хумсаа хугалж нүүрс ухаж суух вэ.

-Бархас дарга өр зөөлөнтэй, хүнд тус болохсон гэж явдаг амьтан, байн байн эргэж тойрч таарна. Нэг эвэнд нь дурсаад авахгүй юу...

Чойдор ийнхүү үлдсэнийг минь бөөцийлж ахуйд би нэг их олзуурхаж, түүний алтан аманд мөнгөн аяга тосоосой гэж адгасангүй.

Хоёрдох долоо хоног

Өглөө Сэтэвийг тандав. Тэрвээр дөнгөж дээшилж буй аж. Түүний дагзны үс тахианы хошног шиг харагдах нь гэдэргээ харж унтсан бололтой. Тэрвээр “Беломорканал” тамхинаас нэгийг сугалах гэж гар нь чичирч байхыг ажихад урд шөнө савж гарилтсан бололтой

Гаапил авгай түүнийг хараад:

-Муу салга амбангийн байж байгааг ...Ийм байж бас банзалтахыг нь яана. Чам шиг хөгшин түнгэрцэгт хүүхнүүд унаж үхээд байна уу. Гайгүй ч хэвтнэ дээ, хэдэн мөнгийг чинь салтаагаар нь сааж байгаа нь тэр...

-Зөнөж үхэж байж хардах нь уу?

-Чи тэгвэл юунд золбин гичий дээр харайлаад байгаа юм бэ. Яасан ханаж цадаж, хатаж эгшдэггүй сэмж вэ?

-Чи юу яриад байгаа юм бэ?

-Үнэсэн толгойт минь чи үнэртэй усанд нэвчээд, уруулын будгаар тамгалуулснаа хар...Цаад өлөгчин чинь чамайг идчих шахсан байна...

Сэтэв цочиж мөрөн дахь алчуураар нүүрээ шудрах нь өчиг мохож буй бололтой. Үнэхээр түүнийг харахад наснаасаа эрт оворжиж, булчин яргай мах нь шуурсан нь хөгшин эм, эр хүний шүлтийг сордгоос юм уу, ерөөс Сэтэв яс дорой эр ч байж болох юм.Гаапэл түүний алчуурыг шүүрэн нүүр рүү нь ороолгоод,

-Хотын Намын Хороо байхгүй, энэ муу хаачихав гэж чи бодож байна уу. Би ажил дээр чинь очоод хамт олны чинь өмнө чиний шившгийг дэлгээд өгөмз.

-Гаапанз минь боль доо. Жаахан юм балгаад хаагуур явж, яаж ирснээ ч би мэдэхгүй байна шүү дээ.

-Аа тийм үү, мэдээ чинь тасарчихаа юу. Чи яаж надтай суулаа. Хэрэв би байгаагүй бол тэр жил чи хүчингийн хэргээр шоронд орох л байсан шүү дээ.

-Ороо л биз. Гараа л биз. Ирээ л биз.

-Нэг муу напраас наранд гараад үйлээ үзсээр өдийд их сайндаа малгайны нь бүс хөлсөнд нэвтэрсэн бараан захын байцаагч болсон бол дээд заяа. Чадаа ч үгүй байх. Өмхий чийгтэй амбаарт ямааны турсган дээр сумгүй буу дэрлэж унтсан хоршооны манаач л байгаа...

-Юмны ховорт мах сүүгээр тасрахгүй харин зүгээр юм биш үү?

-Битгий цувчуулаад бай. Чиний хувь заяа миний гарт бий. Хэрэг хуучирдаггүй юм.

-Хөөн хэлэлцэх хугацаа дуусах гэж бий.

-Шинэ засаг хуучин егзөрүүдийн булхайг ухаж байгаа. Олон хүүхэдтэй ядуу айлын охиныг бузарласан чамайг, аав л ар өврөөр гүйж явж холбогдолгүй болгоод, хохирсоныг буруутан болгосныг чи мартаа юу. Хэзээний чи бөгснөөс л болдог шүү дээ. Тавь даваад загатнаа нь гарах болов уу гэсэн чи чинь бас л өтсөн хэвээр...

Сэтэв элдвээр аргадсан боловч Гаапэл авгай номгорсонгүй “ажил дээр чинь очиж хар цагаанаа ялгана” гэж хангинаад гарч одов. Гэвч тэр автобусанд суух гэснээ, Их дэлгүүрийн сараалжин үүд сөхөгдөж амьтан чихцэлдэн орж буйг харав бололтой тийш дэндэгнэн алхав. Хөгшин агаад тарган байж өндөр өсгийтэй гутал өмсөж улаан буйлаар самар цөмөх мэт ийн ёндгонохын хэрэг юун. Ер нь дүүмэд нөхөртэй хөгшин авгай залуумсан насандаа дүйцгүй аяглах нь ичмээр, бас өрөвдмөөр байдаг. Гаапэл авгай мөн ч их буджээ. Гэвч сэхэл авсангүй, базаад хаячихсан алаг чихрийн цаас шиг харагдана. Ийм амьтан нөхрөө хардахаас ч яахав. Гэтэл Сэтэв чинь эр хүний тооноос гарах болоогүй. Дөнгөж жар дөхөж амьдрал руу эргэж дайрдаг, бас эцсийн жаргалд шүлэнгэтэн шунадаг үе. Тэгээд ч хатаж хуурайшсан будмал чавганц ямар жаргал өгөх юм бэ. Би Сэтэвийг Жагайтай холбоотой гэсэн хов дуулаад зэвүүцэж, эргэлзэж байсан бол одоо харин түүнийг эрийн хугархайд тооцов. Авгай хүүхнүүд тэгш эрх гэж улиглаад л байдаг даа. Бурхан биднийг гэрийн хойморт, тэднийг галын захад гэж газар заасан нь үнэн бол Сэтэвийн буруу юусан билээ.

Гаапэл авгайн хойноос Их дэлгүүрт орвол хүний нүд хужирлах юмгүй. Юутай ч байлаа даа. Дэлхийн хамгийн том хоосон дэлгүүр гэдэг биз дээ.

Дараалалд зогсож буй хүмүүсийн хэрэлдэх хэлэлцэх төдий нь:

-Ядахдаа талхаар таслахгүй байж болдоггүй юм байх даа.

-Хангаж чадахгүй юм бол Оросыг дуурайж яах ч гэж ийм юм идүүлээд сургачихсан юм бэ?

-Ёстой доо, унших ном өгөхгүй байж бичиг сургаад...

-Угаах саван өгөхгүй байж даавуу дэвсүүлээд...

-Уур цахилгаан өгөхгүй байж зуух гаргуулаад...

-Энд дэмийрцгээж байхаар өөрсдөө явж тариа тариач!

-“Ху” намын уриалга уу...!

-“Ху” нам гэдэг чинь юу гэсэн үг вэ?

-Хэн мэддэг юм. Орос эхнэрүүд л лав нүүрээ дардаг юм билээ... гэлцнэ.

Гаапэл авгай валютын барааны тасагт бүх юмыг шимтэн харж харж,

-Будаатай шаазан ямар үнэтэй вэ

-Хоёр ногоон...

-Базарваань... гэж уулга алдахыг сонсоход хатуу мөнгө гартаа имэрч үзээгүй бололтой. “Гоо сайхны” тасагт Гаапэл авгай, Бархас хоёр санамсаргүй халз мөргөлдөж орхив.

-За тэгээд, Гаапанз ажаа данги уу?

-Шороо хөдөлгөсөн шуу л...

-Та ч арван наймт шиг гялалзаж байнаа.

-Ам өлзийтэй болог. Хүүгийн ажил сайн...?

-Сөхөрч унах нь ээ. Ядаж байхад Хөнхөр мажийгаад...

-Дуулсаан...

-Амьтан хүний захиас харах санаатай ажилдаа очих замд шурхийж явна...

Бархас үнэртэй ус, уруулын будаг үнэ цохиж авахыг харсан Гаапэл атаархсан боловч хүний юмаар хүүдэгнэж байна гэж өөрийгөө тайтгаруулаад

-Жагай байгаа юу...?

-Байгаа, байгаа...

-За яахав би нэг очно. Юухэн хээхэн захих л гэсэн юм... гэж шат руу эргэж Бархасын араас хэлсэн ч цаадах нь сонссонгүй.

Хөгшин хүний үг үхсэн хүнийхтэй адил хэмээгч энэ буюу.

* * *

Би орон дор...хоргодож өглөө болгов. Сайнаа түлхүүрдэн орж миний зурагны өмнө зул өргөөд хэсэг зуур тонгойн зогссоноо “өршөө” гэж аяархан хэлээд эргэв. Энэ үгийг бурхан бид хоёрын хэнд нь хэлснийг бүү мэд.

Норжин эмээ “ундаа уу” гэсэн боловч Сайнаа юу ч дуулаагүй юм шиг цүнхээ эгэлдрэгнэн гарч, гүйх шахам явсаар хөдлөж байсан автобуснаас зүүгдэн одов. Би түүнийг дагасангүй, ажлынхаа газраар эргэв.

Жагай долоовор хуруугаар нэгэн шийдвэр тоншиж суухыг харваас “Орон тоогоор цомготгож Ламидыг халах тухай” аж. Бархас орж ирээд,

-Одоохондоо маш нууц гэдгийг мартаагүй биз. Битгий тургичихаарай гэхэд Жагай :

-Яршиг л байна гэж эгдүүцэв.

Бархас өрөөн дундуур холхиж, цонх хавьд хэсэг зогссоноо бичиж дуусмагц шүүрэн Сэтэвийн ширээн дээр тавиад,

-Өчигдар эртдэнэ. Маргааш оройтно гэж гилбэлзэн сандал татаж суув.

Сэтэв шийдвэрийн төслийг уншаад доош харуулан тавьж,

-Ер нь юмны төгсгөлийг эхлэж бодох ёстой гэж би үздэг. Шалтгаан бүхэн үр дагавартай. Бурхны номыг хойноос уншдаггүй гэдэг. Амьдралыг бол бөгснөөс нь унших илүү хожоотой байдаг тал бий. Ийм учраас зөвлөлгөөний уур амьсгалыг харж байж чухам ямар хувилбарыг сонгохоо шийдье.

-За яахав.Та айгаад байгаа бол асуудлыг би тавья гэж хэлээд Бархас төслөө шүүрэн авч шавхчин гарав.

Сэтэв чонын бэлтрэг тэжээснээ мэдэх тусмаа түүний шүдээ ярзайлган архирах дутам айж ухардаг болсон атал энэ удаа дальдчсангүйн учир юу вэ. Магадгүй ар хударганд нь үлдэж, дайсандаа өөрсдийгөө устгах боломж олгож байж ч болох юм. Ламид хэзээ ч билээ Бархасыг авантюрист гэсэн юм даг. Үнэхээр тэр санасандаа хүрэхийн тулд яахаас ч буцахгүй хүн. Бархас нэг удаа халамцаад “албан тушаал, алдар нэрийн төлөө өлгийтэй хүүхдээ нохойд шидэхэд бэлэн” гэж омогдсон гэдэг. Айлын ганц хүү гэж ярьдаг юм билээ. Голомтын хүү савны угаадас хоёр холилдссон ч байж болох юм. Нэг удаа бид хоёр ажлын мөрөөс болж муудалцсан билээ. Олон Улсын хүүхдийн өдрийн ханын сонин бэлтгээд тэр надад үзүүллээ. Ямар нэгэн зурагт сэтгүүл буюу цомогоос Цэдэнбал, авгай хоёр хүүхдүүдтэй хамт байгаа зураг авч наагаад дор нь “Цэдэнбал бол Монголын бүх хүүхдийн эцэг. Анастасия Ивановна бол Монголын бүх хүүхдийн эх” гэж бичжээ. Би түүнд,

-Халамжлан хүмүүжүүлэгч гэвэл яасан юм бэ дээ гэчихсэн чинь,

-Нам ард түмэн хүлээн зөвшөөрөөд байхад та ганцаараа эсэргүүцэж байгаа нь сонин байна. Би бол ийм хүмүүстэй нэгэн цагт амьдарч байгаа хувь заяандаа баярладаг. Үүндээ ч үхтлээ үнэнч байх болно. Намын дарга зөвшөөрөхгүй байгаа бол больё л доо гэж дүвчигнэхэд нь би маргааны сэдвийг дүйвүүлэх янзтай

-Миний эцэг Найдан гэж цагтаа сайн эр явсан юм гэнэ лээ. Ээж минь энгийн эмэгтэй гэлтгүй эртэй хүн байж билээ. Ачий нь хариулж чадаагүй дээ. Чи чинь Очир гэж овоглодог. Ээж чинь хэн гэдэг юм бэ?

-Гөнжөө гэдэг байсан. Өнгөрөөд удаж байна.

-Хүнд ээж аав шиг ачтан үгүй атал хүүхдүүд нь тэр бүр мэдэхгүй юм даа. За тэр ч яахав. Чи намайг уучлаарай. Би зүгээр л санал хэлсэн юм. Сониноо хадчих гэж билээ.

Бархас тэрхэн зуур учры нь олоогүй ч хожим нь Сэтэвг “өгөр пизда, намайг муухай идсэн шүү” гэж ярьсан байсан. Үүнээс хойш түүнтэй зай барьж, тэр ч надаас цэрвэх болсон юм. Гэтэл өнгөрсөн хаврын зөвлөлгөөн дээр “Цэдэнбал бол Оросын төлөөний этгээд, Филатова

бол жинхэнэ шулам байсан” гээд л тачигнах нь хоёр амтай буурхуу санагдсан. Ялгаа нь гэвэл хоёр ам нь хоёр тийшээ салж хажуу хавиргаа эргэн шүршиж мэднэ. Гэтэл одоо олон хүн ийм болсон юм биш үү. Нөгөө энхрий хайрт намдаа үнэнч, би Монголын коммунист болж төрсөндөө бахархана гэж азарган тахиа шиг бахирч байсан улаантнууд таван хушуу руугаа нулимж цагаантан болсон байдаг. Энэ бол түүхийн шалжаа, орчиндоо зохицож турсгаа авч үлдэх гэсэн хүмүүсийн арчаагүй бульхай л юм. Ийм байж чоныг цасны хялаанд цайрч, ногооны хөөнгөнд хөвхөртснийг хачирхах нь юусан билээ. Амь хорих нь алах дайснаас хэцүү гэдгээр өнөөгийн хүмүүс ходоодныхоо төлөө хоёр гурван сум гарздаж сууна. Өрөөлийхөөр явдаг хүмүүст өөрийн толгой ямар хэрэгтэй юм бэ гэж хэн нэгний хэгжүүрхсэн үг орой руу орж дээ. Бид ч хүний толгойд өөрийн бөгс залгахад идэшчихэжээ.

* * *

Гаапэлийг ороход Жагай ихэд дотносон ,

-Хүүеэ, Гаапанз ажаа. Ямар сонин хүн бэ. Ойрдоо таны барааг харсангүй. Ороод ирэх болов уу гэж хараад л...

-Гэр зуурын баг идээнд баригдаад ...

-Аргагүй дээ, тэр айлыг та л авч явж байгаа юм чинь . Та байхгүй бол манай дарга ч хэцүүдэх хүн шүү.

-Харин тийм ээ. Цаадах чинь хааяа балгаад байх юм. Уух нь яахав биеий нь бодох юм. Тэгээд ч эр хүн эцэх турах гэж байх биш.Элдвийн юм уруу татдаг ч юм бил үү.

Жагай, гөлөгнийх мэт жижигхэн цагаан шүдээ цөмийг харуулах гэсэн мэт ангалзан инээж:

-Гаапанз ажаа минь, манайх чинь буяны газар болохоор баярласан амьтад наана цаана гэхийг алийг тэр гэхэв. Харин ч манай дарга хатуу хүн болохоор тэр бүр хөдлөхгүй шүү.

-Тийм нь ч тийм л байх. Нас ахисан хойно түших тулах юм эм хүнд эр нөхрөөс өөр юу байх вэ. Эх захаа алдсан энэ цагт юмыг дандаа муугаар нь бодож сэтгэл өвдөөд байх юм. Чи миний хүүхдээс ялгаа юун. Даргыгаа харж хандаж, хаана яваагий нь эгчдээ дуулгаж байгаарай л гэж гуйх гэсэн юм.

Гаапэл нөхрийнхөө нэрийг бодсон уу, бас өөрөө элэг доог болохоосоо эмээсэн үү, эсхүл шар хор нь дарагдсан уу, ямарч атугай хэлэх гэсэн юмаа дөнгөж цухуйлгаад л явдлын далимаар орсон хүн болоод гарав. Түүнийг гармагц Бархас тэсэлгүй орж Жагайгаас ,

-Улаан эмээ та хоёр чинь юу болоод л хушуу холбоод унав?

-Эмэгтэйчүүлд эрхбиш ярих юм байлгүй дээ.

-Аргагүй л бүх юм өөр болж дээ.

-Юу гэсэн үг вэ ?

-Хонь, чоно хоёр тэврэлдээд л...

-Оролцохгүй юм байхад яадаг юм бэ. Хар ч биш, лам ч биш, хаан ч биш, боол ч биш гэдэг шиг битгий ингэж бай. Өөрөө өөрийгөө шатаачихдаг юм гэдэг шүү. Би чамайг бүрэн бүтэн байгаасай гэсэндээ хэлж байна.

-Эмээд гаргаж чадаагүй уураа надад гаргах нь уу. За за би талийгаачийхаар нэг үзэгдье. Дарга очмоор ярьж байсан юм сан. Намайг явчихлаа гэж хэлээрэй. Жагай түүний араас эгдүүтэй харснаа “хачин амьтан шүү” гэж үглэн хоцров. Жагай аравдугаар анги төгсөөд арван хурууны бичээчийн түр сургууль хийсэн гэдэг. Анхны нөхрөөсөө салсан, аав ээж нь холын аймгийнх тул айлд суудаг бөгөөд төхмийг бодож ажиллагсдын нэрээр сургуульд орох санаатай юм гэнэ лээ. Бархас түүнийг хаанаас олж ирсэн, энэ бүсгүй хэрхэн Сэтэвийн эмзэг газраас атгаж авсан нууцыг яахин мэдэх билээ. Тэгээд ч бүсгүй хүн, эрчүүлийг амтандаа оруулж байгаад хэргээ бүтээдэг нь орчлонгийн нэгэн жам шүү дээ. Овсгоотой эмс хааныг халууцуулж байгаад сэнтийд нь залрах нь юу ч биш. Эм хүний урхинд ордоггүй эрчүүл бол амьсгаатай чулуунаас юуны ялгаа. Харин Гаапэл хаширтай явгарчихгүйн тулд Жагайгийн хөлд сууж буй нь зөвхөн башир арга бус хүний үгүйрлийн эмгэнэл юм даа.

Сэтэв хаалгаа нээн Жагайгаас:

-Байдал ямар шуу байна?

-Онцын юмгүй.

-Бархас ирсэн үү?

-Ирээд талийгаачийнх руу явчихсан.

-Комисст оруулах гэхэд завгүйгээ гайхаад байсан мөртөө, яахаараа улстай зэрэгцээд давхиад байгаа юм бол доо гэж хөндий хүйтэн өгүүлээд өрөөндөө эргэж оров. Сэтэвийн нэг онцлог нь хүнд хар сэжиг авхуулахгүй, хүйтэн хоосон байж чаддаг агаад дотоод цочрол нь бараан нүүрэндээ огтхон ч илрэхгүй. Иймээс түүний дотоод ертөнцөд нэвтрээгүй хүн бол гэмгүй томоотой эр гэж эндүүрэх нь олонтой. Сэтэв өөртөө ашигтай бол хулганыг муур руу довтолсон гэж буруутгаж чадах бөгөөд харуу санасан хүнээ хивэж байж сална. Өөртөө ашиггүйгээр архи амсахгүй, хэрэв увал эргээд тус болж чадах дээд тушаалтан юм уу, эсхүл өврөө өгсөн хүүхэнтэй халаасаа хусартал наргихаас буцахгүй. Тэрвээр эрдэм чадлаараа бус, амьдралын шатарт хэрэгтэй цагт хүү хаяж чаддаг тооцоогоор албаны дөрөөнөс муултралгүй өдий хүрсэн биз. Энэ нь амьдрах ухааны нэгэн хувилбар тэгэхдээ Монголд тохирох хамгийн ашигтай хувилбар ч байж болох юм.

* * *

Бархас, Чойдор хоёр уулзахыг би мэдсэн тул нүд ирмэх зуур Чойдорын дүр хүрээ. Чойдор хоёр өрөө байранд тохь муутайхан айл аж. Арслантай авдар, цагаан толгойтой ор сэлт нь гэрээс байранд орохдоо чирч ирсэн хогшил бололтой. Юмжирмааг хоёр аяга гоймонтой хоол авчрах зуур ажвал түүний залуу наснаас хараахан унтраагүй хоёр нүд л үлджээ. Чойдор лонх юм

задлах зуур ,

-Урд ч амаа ангайгаад хахаж үхэхгүй л залгих ёстой байлаа. Одоо хар. Монголчууд ардчилал гэж оцойж хуцаад юу долоов. Улс Төрийн Товчооны хэдэн талхинууд салаа цэрэг авчраад боривны нь баастай хольчих ёстой юмыг айж байгаад төмсөө сугалуулснаас мань мэт нь шээх савгүй боллоо гээд хундагатай архи өгөхөд Бархас:

-Би ч аяганд хийгээд адууны доозоор явуулдаг хүн шүү.

-Аргагүй ээ. Хойно сурсан улс тэгдэг юм гээд Чойдор мөнгөн аяганд хийж өгөхдөө

-Цаагуур чинь юу болж байна даа.

-Юу болох вэ. Дэгээ чулуудаж байна.

-Зөв дөө. Нэг татахад чинь л алтан загас баригдана.

-Аа мэдэхгүй. “Алтан загасны” эмгэн Анастисия чавганц хоёр шиг үлдэх юм биш үү?

-Тэвчээр хүрвэл тэнгэрээс од шүүрдэг юм даа.

-Хамаг нууцаа хав дараад надаар чулуу хөөлгөөд байгаа юм биш биз. Тэвчлээ гэж бодъё. Тэгээд юу болох юм бэ. Тэвнэ үү...? гэж нилээд халамцсан Бархасын тулытчихад Чойдор яс хөрөөдөх мөт инээж, аяганы ширээний нүд татан гар буу гарган түүн рүү чиглүүлэхэд Бархас “та чинь яаж байнаа” гэж алгаараа хаан дальдчив. Чойдор бууны амыг өөр рүүгээ харуулж үлээгээд үүнээс айх хэрэггүй, үе дамжсан эд. Хүн гэдэг дэндүү мартамхай амьтан болохоор үхлийг өөртөө сануулж байх ёстой. Хороо хорины хонгионууд шиг дүвчигнэх цаг биш. Чи Сэтэвийн охиныг горьдоод юу хожив? Сэндэрмаа чинь лусын дагина. Гуйлагчингийн гуя тэвэрч хэвтэхгүй. Тийм охиныг алтаар аргамжиж, сувдаар гинжилж байж өөрийн болгодог юм.

Бархас:

-Тэр аргамжаа чинь, гинж чинь хаана байна?

-Чи түүнийг Сайнаагаас олно. Тэгэхэдээ чи итгэл олохгүй бол нууцы нь хэлүүлж чадахгүй. Тэр чинь зартай баян хүний алтан дээр сандайлж суугаа хүүхэн. Хөрөнгө нь хаана байгааг мэдэж, эзэгнэсэн хойноо түүний шилийг харж болно. Чиний нэхээд байгаа нууц ердөө л энэ. Ам алдаж л таарна. Харин бүсгүй хүний ам цавиндаа байдгийг мэднэ биз дээ гэхэд Бархас,

-Тэр гичий салхаа байвал яана.

-Эрхтнээсээ салах гэж байгаа биш, эмээс холдоход хаалгы нь гаднаас нь хаахад л болно.

-Хүүхэд олчихвол...?

-Төмөр хүртэл хайлдаг биз дээ. Тэгэхдээ яарах хэрэггүй. Хүүдийний ам олоогүй байж ухаж

болдоггүй юм.

-Үхээрийн худгаас уусан хүний ам руу хүүхнүүд хэлээ хийдэг гэж та хэнээс дуулаа вэ?

-Мөнгөнд боогоод аль ч ам руу нь хийсэн эм хүн буруу дуулахгүй бол үгүй гэдэггүй юм. Түүнээс бус дурлалын шүлэг уншлаа гээд гуйлгачингийн гудас болж турж үхдэг сайхан хүүхэн нартад байхгүй. Эхлээд сүвээ гадарлаж авахаа бод. Талийгаач нууц түлхүүрээ Сайнаад л өгсөн байж таарна. Түүнийг олж авсан хойноо чи хөнжлөө сөхөөд хөлөө жийгээд хэвтэж бай. Орны чинь өмнө охид оочерлох вий.

-Би Сэндэрмааг өөр хүний орны өмнө зогсоомооргүй байна. Хайр дурлалын шүтээнд би өөрөөрөө зул өргөхөд бэлэн байна.

-Уран сайхандах хэрэггүй. Чи түлэгдэхэд хиншүү л гарна биз. Эр хүн гэдэг өөрөө биш, өмнөө эмс шатаж үхэхийг хараад инээж суух ёстой. Чамайг сэхээд ирэхэд Сэндэрмаа өмнө чинь сөхрөөд өөрийгөө аяндаа галдна. Харин чи шатааж шарх сорви болгочихолгүй авахаа л бод.

Бархас ширээн дээрхи аягатай архи шүүрэн залгилаад нүдээ анин агзганаснаа бодолд дарагдав. Бархас ямарч байсан Чойдорын бугуйлд чахалзуураа хийжээ. Эд нар миний үнсэн дээр хөрвөөх нь эргэлзээгүй. Харин Бархас усан дотроос цустай, Чойдор цусан дотроос тостой гарч чадах л вий.

Гуравдах долоо хоног

Сайнаа ажлаасаа эртлэн ирэв. Угаалганд авчсан хөхөлбөр бошинзоо өмслөө. Энэ л үед түүний чилгэр хөх энгэрээ тэвхлэж, зоо нь ацран зөөлөн цагаан хонго гялалзахад би эгдүү хүрдэг сэн. Сайнаа шууд л ээжийгээ хань татан, миний орыг нөгөө хананд гаргаж, байранд нь хоёр авдраа тавилаа. Ийнхүү би орон дор бус, авдрын хөндийд хоргодохоос аргагүй болов. Сайнаа амсхийх зуур цай буцалгаж миний зурагны өмнө дээж өргөхдөө гар нь үл мэдэг салганан ганцхан тусал нулимс унагав. Намайг амьсгал хураахад гараагүй нулимс ийнхүү ивлэсэн нь цээжний бүлээн хур эсхүл хайлсан цэвдэгш хоёрын алин болохыг бүү мэд. Учир гэвээс харуусал, баяслын алинаас ч унасан бай нулимс нь нэг өнгөтэй. Бурхан хүний нулимсыг өнгөөр ялгаж чадах байсан ч ийнхүү нууцалсан нь хүчин мөхөсдсөнөөс бус хүний дотоод ертөнцийг нүцгэлж, биесээ хөнөөхөөс сэрэмжилсэн нь буй за.

Норжин эмээ цай оочингоо:

-Аль ч юмыг алагаараа харж, арваараа барьсан шиг мэдэх юмаа.

-Хэн тэр вэ?

-Сэржээ жээжээ

-Солиорч байж шоронд үхэх нь л дээ. Нөгөө нэг үзмэрч гээд байдаг үхрийн баас шиг хар юм чинь хулгайч л юм байна лээ дэг.

-Улсын үзмэрч үү?

-Тэгээд яагаа вэ. Уулгамч чавганцаар л бас дутаг гэж...Цугаараа луйварчингууд...

-Арай ч дээ

-Нөгөө гал гаргадаг хүүхэн чинь манай эмнэлэгт шүдэнзтэйгээ баригдсан шүү дээ.

-Сэржээ жээжээ түүний дэргэд амилсан Дар-Эх. Би чиний зам дээр бурхны хишиг чулуудах гэж хоёр жил майжигналаа.

-Би өөрийгөө хашаа байшинтай бүрэн айл дээр эзний нь нэмж худалдлаа. Бүх юмыг таны хэлснээр л хийсэн. Больё.

-Миний ч юу байхав. Сэржээ жээжээгийн чинь л хүч.

-Аа мэдэхгүй. Та хоёрын тэр зэс халаагууртай танг уугаад түргэндээ орчих шиг болсон дог.

-Хөөрхий минь өөртөө хадгалж байсан бололтой юмаа өгсөн...Харин оройтсон байж магадгүй...

Сайнаа үг сөргөсөнгүй, миний зурагны өмнө бодлогоширон зогсов. Түүний гөлөрсөн

харцанд, эр хүн өдөж энгэрээ задалсан гэмшил, намайг өвдснөөс хойш нүглийн хүй тасарч зэлгээрсэн сэтгэлийн тамирдал, журамт гэргийн ёс хазайж, хагсаа тайлсан нүгэл, үүнээс хойш хэрхэн амь зуух тухай бодлын мухардал тэмдгэрэх шиг болов. Тэрвээр хэсэг зуур үүлгэртэн зогссоноо эргэж,

-Та ер нь яагаад энд хашаа авсан гэдэг билээ?

-Айлын хашаанаас хөөгдөж арга ядаж явахад Сэржээ жээжээ нь түшигтэй айл бараадуулсан шүү дээ. Таньдаг хүн нь байранд орж эзгүйрсэн хашаа л гэсэн. Би тэр хүний барааг хараагүй. Сэржээ жээжээ таньдаг хүнээсээ хэдэн цаас олж өгсний хүч. Одоо болтол өгч чадаагүй л явна.

-Талийгаачийнхаа хашаа байшинг зараад өрөө дарахыг бодъё.

-Санадаг л санаа. Эздийнхээ толгойг мөлжөөд дууссан савыг авах хүн олдохгүй л байх даа.

-Тэгж яривал энэ хотод хүн үхээгүй атга шороо ч байхгүй. Далан давхрын хулширсан булшин дээр гэрээ бариад сууж байгаа шүү дээ.

-Тийм нь ч тийм. Тэгэхдээ өгөх авахын өлзий, өдөр судар...

-Бас л нөгөө сальдирхалсан чавганц руу гүйх гэж үү. Больж үз. Би та нарын үгэнд орж амьдралаа үрэн таран хийлээ. Өөхөнд хучиж, өвөнд цадсан нь аль вэ. Настай буянтай нар нь хэвийсэн хүн өөдөхдөө эцгийнхээ буяныг орхино гэж сэтээ сэвээгүй түлхэж байгаад Хөнхөртэй суулгасан. Тэгээд яав. Та нарын яншаад байсан, Алтан Найдангийн алт мөнгө хаа байна. Булуу биш чулуу хөөснөө мэдэв үү. Хөрөнгөтэй суусан муу нэртэй, бэлэвсэн сэгсгэр хүүхэн болгож намайг хог дээр хаясан чинь багадаа юу гэж Сайнааг тас ширвэхэд Норжин эмээ нохой хорихгүйгээ мэдэв бололтой...

Энэ үг Хөнхөр гэгдэж явсан надаас ял асууж байх шиг. Үнэндээ ч хахь харам зан гаргаж ганц хүү, ханиасаа түлхүүрээ нууж, үгээ дотроо илжрүүлсэн миний хилэнц амьд ахуйдаа хажуу хавиргаа харилхаж, айлын бууринд хохьлон золбин гөлөг шиг орхисондоо одоо харамсаад ч яахсан билээ дээ. Би хүүхэд нохой цатгах нь байтугай эсгийгээ хийж чадсангүй. Атга чимх ноосоо аль эрт савсан бол яс минь ядахдаа өндөлзөхгүй бус уу.

* * *

Сайнаа ор дэрээ цэмцийтэл засаад цэцгэн хээтэй цэнхэр торгон тэрлэг нөмгөн өмсөв. Энэ бол надтай суугаад эдэлсэн анхны цайны дээл..."Сайн нөхрийн буянаар сайхан дээлтэй боллоо" хэмээн олзуурхаж сүрхий гамнадаг дээлээ ийнхүү мөрөнд тохсоны учир юусан бол...

Хаалганы нугас ханатал тэлж сүр сархийн орж ирсэн зочин Бархас байв. Тэр хоёр мэндлэлгүй, зөвхөн нүдээрээ мишээл шидэлцэхийг ажваас өнөөдөр нүүр учирсан бололтой. Сайнаагийн өгсөн цайг оочоод, Бархас:

-Ээжийн минь цай санаанд орох чинь...гэж санаа алдаад ээжээс хойш төв халхын түргэн цагаан, Улаанбаатарын дошгин хар хоёрт залхлаа шүү гэв. Сайнаа үгээ олж ядан:

-Эжийн цайг эхнэрийн цай оролдог гэж ярьдаг байх аа

-Тэр ч ханиа олсон хүний үг байх аа...

-Та хүн голдог байлгүй дээ

-Царай муутай, цалин багатай болохоор намайг ч тоох хүн олдохгүй юм...гэж Бархас нүдээ жоготой эргэлдүүлэхэд Сайнаа түүний харцнаас дальдран босч лонх юм задлав. Бархас хундага мөргүүлэн тогтоосноо

-Муу талийгаачийг бодохоос гол дээр бөөн хар юм горойгоод байх юм. Хөөрхий минь сүүлчийн удаа бид хоёрыг уулзахад чи байгаагүй. Талийгаач, чиний сэтгэлийг зовоочихгүйн тулд чамайг эзгүйд уулзъя гэсэн юм. Өөрийгөө өнгөрлөө гэж мэдэж байсан л даа. Тэгээд надад “Цуглаж төрөөд цувж үхдэг нартын жамыг яая гэхэв. Миний ээлж болжээ. Хорвоогийн хоёр бөөрөн дээр бишгүй л юм үзлээ, идлээ, өмслөө. Гомдох юм алга. Сайнаадаа л хоргодож гол тасрахгүй зовоож байна. За чамд ганц л юм захъя. Сайнааг минь харж хандаж яваарай. Тэжээгчээ алдсан гээд үглэж дуулж яваад ганц өрөө байр олоод өгчихөөрөй. Энэ муу хашаа байшингийн тамтагийг хэдэн бор цаас болгоод байрны тавилга авч өгдөг юм шүү. Байрны үнэ цэн гээд унавал хэдэн төгрөг дэвтэрт бий. Нэг муу тэрэг ч бий. Сайнаа минь өнхрүүлж чадахгүй хүний идэш болчих хүн шүү. Чи намайг хэлсэн гээд эзэн хүн шиг мэдээрэй “гэсэн юм сан...гэхэд Сайнаа санаа алдан нулимсаа арчив. Бархас шүлсээ гүлсхийтэл залгиж,

-Тэгэхэд миний байж байгаа царай энэ. Хүний толгой бүү хэл өөрийхөө малгайг олохгүй явна. Гэхдээ нөхрийн итгэлийг хөсөрдүүлвэл үйл бүтэхгүй. Энэ тэр амьтны өлмий долоож ганц өрөөний сураг гаргахыг бодноо.

-Ээлж нь болсон шүү дээ.

-Сэтэв дарга ч яахав. Аргалж болно. Цаана нь Хотын Захиргаанд Нянгар гэж нэг нохойны нэртэй туучий бий. Шовгор горьддог чаргуул гэнэ лээ.

-Яахав дээ. Нүцгэрч байгаад ч гэсэн нүхтэй болох юм сан...

-Өвгөний өрөгдөл өнгөрөх биз. Одоо чи өөрийн нэрээр бич гэснээ хэдэн өгүүлбэр дуудаж бичүүлээд хавтсандаа хамжив.

Сайнаагийн нүдэнд эрсэхүйн униар татаж буйг анзаарсан Бархас өрөвдлийн мишээлээр илбэн тогтоож гары нь атган хацартаа наав. Сайнаа гараа татсангүй уртаар санаа алдан үл мэдэг ичингүйрэн доош харав. Эм хүний зовхи ийнхүү буухад дотоож нь шувтарч байдгийг эрчүүл дэндүү сайн мэддэг хойно доо. Бархас сайн хүн болж миний гэрээс мэт юм зохиож худал залахдаа, Сайнааг тугалга шиг хайлуулж орхив бололтой. Одоо гагцхүү түүнийг хэзээ, ямар хэвэнд цутгахаа л шийдэх биз. Сайнаа надад аврага могойд соруулж буй ширэнгийн янзага мэт харагдав. Тэрвээр залгиулна. Чухам хэзээ, яаж...?

Норжин эмээ Бархастай хашааны хаалганд халз тулгаран дуу алдаж мэнд сольсноо,

-Суухгүй яагаа вэ. Цаадахь чинь цай цүй амсуулав уу гэснээ:

- Би өөрөөс чинь нэг юм асуух гэсэн юм. Энэ муу эзэнгүй хашааг дэггүй хүүхдүүд тамхи тариа болж байгаад шатаачих ч юм билүү, авах хүн мэдэж байгаарай гэхэд Бархас:

-Би чинь нам, ном гэсээр байгаад наймааны ухаан арилчихсан хүн. Харин Чойдор л чадна. Танил тал ихтэй гар хөл урттай хүн. Би хэлье гэчихээд зайцав.

Норжин эмээ гэртээ ороод,

-Бархас дарга ашгүй ирээ юу. Нүдэнд дулаахан нүүрийн буянтай, цовоо цайлган хүү шүү. Буруу ишилсэн сүх шиг ааш гаргаад үргээчихгүй юм сан. Чи бид хоёр нааш харсны наана, цааш харсны цаана явахгүй бол Жээжээгийн хэлдгээр шувтарсан цагаан бумбандаа буучихлаа гэж үглээд Сайнааг харцаараа уургалах гэвч цаадах нь ямар нэгэн завхай дуу гиншин аяга таваг арчаад нохойн хуцалд эс тоов. Тэрвээр өөрийн эрхээр зовохоор шийдсэн байж болох юм. Энгэрийн товч хэрдээ мулталж жаргасан биш гэхэд зовлон амссан өдий насны бүсгүй хүн уяа алдуурвал босго тотгын саад арилдаг. Сайнаад тэгвэл буруугүй зөвгүй амьдрах нэг л хувь зохиол үлдсэн байх юуны магад.

* * *

Би Сүхбаатарын талбайг тойров. Амыг нь гинжээр хазаарласан арслангууд ямар учиртайг би ер бодож байгаагүй юм байна. Ертөнцийн нэгэн хүчтэнийг нохойчлон номголсон нь Жанжныг манаж байгаа гэхэд дайрах байтугай архирах аргагүй мэт. Уран хүний бурхан ухаан, улс төрийн молхи санаа хоёрын алиныг бүү мэд. Уг нь энэ талбайд эзэн Чингис заларч байсан бол хэмээвэл Хөнхөрийн дуу газарт хүрэхгүй болжээ. Талбайн баруун хойноос хоёр хижээл эр огтлон ирэх нь танихгүй атал танил мэт. Хөх хүрэмтэй нь кремлийн зурагтай даавуун уут барьж, хуучирсан хүрэн пальтойтой нь “Үнэн” сонин сугавчилжээ. Үгэнд дурлаваас,

-Манай нам ажиллаж байгаа шүү.

-Нагаржунай гээч болж байгаа гэсэн биз дээ. Үсээ хусуулж батлахынхаа оронд чойг өвөртлөх юм байлгүй.

-Энэ бол тактикийн асуудал. Маргааш давшихын тулд өнөөдөр чавганц ч болж болно.

-Цагийн урсгалыг эргүүлэх нь юу л бол.

-Эргүүлэх биш ээ. Татуурга руу түрж гольдролоос гаргана гэсэн үг. Хуучнаа санагалзсан хүмүүстэй ходоодоор нь ярьж өчигдрийг нь сануулах ёстой.

-Ер нь аливаа юманд эхлэх, дуусах цаг бий. Бидний хувьд цагт нь чадаагүйгээс хойш, одоо түмэн маани хөгжөөгөөд хөг өнгөрөө биз.

-Нялцгай сэхээтнүүдийн нялуурлаас л болсон... талбай дээр л тэднийг танкаар индүүдчих байсан юм.

-Маргааш нь иргэний дайн гарвал яах байсан гэж?

-Иргэний дайн гэдэг зэвсэглэсэн хоёр хүчний мөргөлдөөн болохоос биш буутай буугүй хоёр хүний нохой зодоон биш.

-Буутай хүмүүс зөвхөн урагшаа бус хойшоо эргэж буудах ёс бас бий.

-Олны нүдэнд өргөс болоод яахав гэлцээд хоёр тийш салан одов. Тэднийг харж зогссон залуусын нэг нь “тойрон хүрээлэгчид” гэхэд бусад нь инээлдэв. Мань хоёр надаас ялгаатай нь амьдаараа доог тохуу болж төрийн төмөр шилбүүрт ороолгуулжээ. Харин ч азаар цаазын илдэнд хяргуулсангүй.

Манай дарга нар хэмээгчид голцуу л албан тушаалын хоноцууд байсан. Тийм болохоор өвдөг сөхөрч байсан хүмүүс, унахад нь уландаа дэвсэлжээ. Гэхдээ Монголчууд хэргэм зэргийн хойноос хашрахгүй унгалдаж, тушаатай ч байсан дэгэх л вий. Харин нөгөө хууртамхай олон нь сайн даргын эрэлд хатаж хийдийн хашаанд буяны будаа түүх тагтаа мэт явгалан гүйлдэх нь юуны мэргэн билээ.

Тамхи баагиулж талбайд шүлсээ хаясан сайхь залуус гэнэт нирхийн хөхрөлдөхийг ажвал тэдний хажуугаар Чойдор өнгөрч явна. Залуус түүнийг ээрч

-Өвөө та аль талынх вэ?

-Та нар..?

-Бид ардчиллынх.

-Бид нар нэг талынх юм байна. Муусайн коммунистуудыг...хэмээн нудрага зангидан харуулаад бултаж амжив.

Залуусын нэг нь,

-Харав уу? “Ху намын хуйх “ биш байгаа биз дээ. Ард түмэн бидний талд байна гэхэд бусад нь зөвшөөн дагав. Би тэднийг гэнэхэн, харалганыг гайхан урам хугарч Чойдорын араас нэхвээс Дотоод яамны хар бүслүүртэй байшингийн өмнө зог туссанаа Мөрдөн Байцаах газар руу оров. Байцаагч бололтой нэгэн түүнийг суу ч гэсэнгүй.

-Халаагуурын шинжилгээний хариу гарахаар асуудлыг сөхөж үзнэ. Тэгээд ч талийгаачийн цогцонд задлан хийгээгүй хугацаа алдсан юм байна. Та асууж бай л даа гэж тоомжиргүйхэн хэлээд гаргав.

Чойдор надаас халаагуурыг тан буцалгах бус эд мөрийн баримт болгож энд өгсөн байх нээ. Тэгвэл Норжин эмээ Сэржээ хөгшин хоёр булагнасан болж байна уу. Эсхүл...? Би төөрч орхив. Сүнс төөрнө гээч нь юм боловуу...

* * *

Бархасын ширээн дээрх Сайнаагийн сууц гуйсан өргөдлийн буланд “Хөнхөр нас барсныг уламжилъя. Сэтэв”, нөгөөд “Олгох байрыг түүгээрээ шийдвэрлэ. Нянгар” гэсэн цохолт харагдана. Бархас түүнийг эгдүүцэж харснаа “пизда-нууд” хэмээн ширээ дэлдэхэд эрхи бугуйвчилсан гар нь таширлав бололтой ёйлов. Тэгснээ “Бурхан харж байна. Энэ бол хар Сэтэв, халзан Нянгар хоёрын хүн өшиглөдөг тоглоом гэснээ харин хонжвортой юм биш биз” хэмээн мушийв. Бархасыг манайхан СЭМЭГА- гэдэг нь сэтгэл мэдрэлийн гажиг гэсэн үг л дээ. Ганцаараа ярьж аяглаж буй нь үнэхээр тийм буюу. Хаалга нээгдэхэд Бархас өргөдлийг доош харуулж тавьснаа Чойдорыг хараад үг дуугүй түүн рүү сарвайв. Чойдор нүдэндээ ойртуулж хараад,

-Тэгж таарна. Харин үхсэн хүнд алд газар өгдөг гэж цохоогүй нь их юм.

-Эзэн олдноо...

-Хэн гэдгээс л болно. Тэгээд ч талийгаач ам бүл нэг гэсэн албан данстай.

-Талийгаачид өмхөрсөн хашаа байшингаас өөр юу байгаа юм бэ. Түүний төлөө үхээрийн шавхруу долоож миний Монте-Крист гүн болдог ч нохойн туурай байлгүй.

-Одоо бол цалингийн дусаал тосоод ширээн дээр үүргэлж суудаг цаг биш. Дэлэн олж шувтрахгүй бол хар цайтай хатна.

-Тэр өлөгчингийн дэлэнгээс ээдэм л гарна.

-Өөрөө л мэд. Би чиний төлөө л гэж чих дэлссэн улбаагаар хэлсэн юм. Алтан Найдан амандаа үмхэж үхээгүй жоороо хүүдээ, хүү нь эхнэртээ үлдээсэн л байж таармаар юм гэчихээд гарав. Бархас хөмсөг зангидан бодлогоширсноо инээмхийлэв. Энэ хөндий яндан шиг хархүү Чойдорын түлсэн галыг сорж очтой залгас манай дээвэр дээр шидэж буй юмсанж. Харин Чойдор миний голомт хийсэхийг хүлээж, ажлын газрын хатавч сахьсан юм биш байгаа...?

“Алтан” Найдангийн даллаганы савыг хэн ухах нь надад нэгэнт хамаагүй ч шуналын аалзнууд шүлсээрээ тор нэхсээр байгааг сониучилмаар...

Сайнаагийн эцэг хөлдүү жорлон ухаж олсон мөнгөө Норжин хуартай хамт савхдан том нэхий өмдөндөө бээрч байгаад үхэхдээ өөхөн цөвдөл бус эхнэртээ шуналын өт цацсан биз. Харин Чойдор, Сэржээ хэмээх хоёр дугуй Норжин эмээгээр гол хийж, миний улаан гол дээгүүр хортой мөөрөөр тасар татан өнхрөхөөр хэрхэн сүлбэлдсэн юм бол? Бархас бол боохойн түрүүний хэрээ болж хоёр нүдний олзгүй хоосон хоцрох биз. Сайнаа надаар нэг юм хэлүүлэх гээд инээж уйлж элдвээр аяглаж байсан нь учиртай. Түүний судсанд харийн цус үерлэж байгаа шүү дээ. Эцэг минь “урагшаа харж үхэхгүй юмсан” гэдэг сэн. Энэ үг элэнц хуланцын углуургатай монгол ухааны чөмөг. Түүнээс бус аугаа их хүлээцтэй ард түмэн болох гэж толгой

дээрээ сарьж буй хэн нэгний бохир сөвнөөс зуураад, тэнгэрийн умдаг атгав хэмээн монширч хүлцэнгүйрэн хэвтэх нь ухаансах юу байхав дээ.

Бархас хийх юмаа олж ядан, бичиг цаасаа самарч байснаа “Үнэн”, “Ардчилал” гэсэн хоёр хуучин сонингийн толгойг тасдан авч давхарлаад хигэж хогийн сав руу чулуудав. Сайнаагийн өргөдлийг цуу татах гэснээ больж “танилцав” гэж цохоод Жагайгийн өрөөнд орж ширээн дээр нь шидэхэд Жагай тохуурхангүй,

-Ийм халамжтай хүнийг мэдэлгүй өрсүүлчихлээ гэхэд,

-Чиний цоожны нүхэнд хоёр түлхүүр багтах юм уу гээд эргэхэд нь Жагай шугам чулуудав. Бархаст энэ тоглоом аятай санагдсан бололтой.

-Дарга байгаа бол чамайг өнөө орой цохуулах юмсан.

-Чиний түлхүүр гурван цоожинд таарах юм уу. Сэндэрээ, Сайнаа би...хугалчихав даа хэмээн Жагай алгаараа нүүрэн даран инээдийн нулимсаа барьж ядан хөхрөв. Бархас хоёр чихээ таглан нүдээ аньсан чигээр хаалга мөргөлөн дугаахаас өөр арга олсонгүй. Гэвч тэр нэг хилэнцэт өдөр Сэтэвийн хаш аяганд шээхийг хэн байг гэхэв...

Дөрөвдөх долоо хоног

Цонхны хөшиг хаалттай ч сарны гэрэл харваж манай муу байшингийн дотрыг үл мэдэгхэн бүгээлжээ. Сайнаа хөдөрсөн тэрлэгээ орны хөлд хайнгахан шидэж Бархасын өвөрт могой мэт гулсан оров. Бархас түүнийг тэврэн авмагцаа хөхний даруулгын арын дэгээг сурмагхан мулталж хоёр мөөмийг нь хусран бяруу шиг ээлжлэн үлгэхэд Сайнаа зулайгий нь үнэрлэн эзэнгүй болсон гараараа нуруугий нь дагуулан дэмий л тэмтчив. Бархас бүгчимдсэн бололтой хөнжлөө тийрснээ торгон дотоожийг нь шувглах гэхэд “Би өөрөө” гэж Сайнаа шивнэх төдийд чармай нүцгэрэх нь тэр. Тэр юунаасаа ичиж зовохсон билээ. Бархас хөхнөөс хошуугаа гулсуулан цээж хоолойг нь дагуулан толбортол сороход Сайнаа хоёр нүдээ тас анин эрхлэн уруул нь дэмий л өмөлзөв. Энэхэн агшинд Бархас түүнийг озон үнсэхэд Сайнаа хэлээ түүний аманд чихэж мунагийн донд улангассан эр “ямар сайхан амттай юм бэ” гэж гувтнав. Сайнаагийн цангасан цоморлиг хур хүсэн байж ядах мэт хөлөө атирснаа гэнэт жийж Бархасыг дээрээ гаргаснаа бачимдан “би өөрөө” гэж адгаад төдөлгүй “ёо ёо л доо” гэж орилон гиншив. Сайнаагийн бүх бие осгож буй мэт дагжин чичирч орон дээр өөрийгөө шигшин займчих нь даргилан буцлах мэт ажээ. Сайнаагийн ийнхүү бөмбөлзөн чичрэх нь эр хүнийг самран түйвээж нүгэлт жаргалын ёроолд нүд ирмэх зуур живүүлдгийг би хэрхэн эс мэдэх билээ. Бархасын үс нь сэгсийн уухирдах нь надад үрээ азрага шиг харагдахуйяа тэрвээр гэнэт Сайнаагийн хоёр тахимыг мөрөн дээрээ тохоод цогнойн дайрхуйд нөгөөх нь дэрээ орны урд руу чулуудан төмөр орны толгойн хөндлөөс зуурч шүдээ хавиран “үхлээ үхлээ” хэмээн чарласнаа сулбайн үхэдхийлээ. Энэ бүхнийг харж байхад надад харам атаархлын аль нь ч үл мэдэгдэн, тэр нэгэн цагт хэвтрийн миний хардлагыг богшоож асан Сайнаагийн гархилсан нүд, шарласан самсаа үзэгдэх шиг болов. Хүн гэдэг чивэлт адгуус өөрийн шижээргүй нөгцөлдөөнийг булахын тулд хорвоог эрээн, тоост, нүгэлт гэх мэт хочилдог нь зөвхөн амьд ахуйд зэмийн гогцооноос хүзүү мултлах гэсэн нохой заль төдийхөн агаад “үнэнч хайр” гэдэг нь урлагаар хөллөсөн тэнэмэл цуурхал төдий гэлтэй.

Сайнаа”жаахан бай л даа” хэмээн тамирдангуй царайчлан Бархасын уруул хацрыг зөөлхөн хазах үед Бархас сэхээ авч,

-Чи надад хайртай юу гэхэд Сайнаа

-Аа чи гэж цорвойхуйд Бархас түүний уруулыг хөхөн “хайртай” гэнгүүтээ ухрасхийж Сайнааг түрүүлэг нь харуулан отны нохой мэт харайхад аргамж алдуурсан эм дөрвөн хөллөн гичий мэт бөөр нь түнхэлзэн гийнаж эхлэв. Энэ бүхнийг харахаас төвөгшөөж би мөнөөх хоргодсон авдрын хөндийгөөс орны банз үе үе шажигнах чимээнд дөжрөн яргавай.

Үүр тэмдгэрэх хэрд сая сэхээ оров бололтой Сайнаа

-Ингээд дасчихвал яанаа гэж үг өдөхөд Бархас,

-Яахав, айл болно, хүүхэд гарна.

-Хотын хүүхнүүд мундсан биш. Та надаар яахав дээ.

-Хайр сэтгэл гэдэг тэнгэрийн зарлиг. үүнийг давж гарах хүн орчлонд одоохондоо төрөөгүй юм чинь...

-Амьтны хэл ам...

-Яахав. Алтан Найдангийн ганц хүүгийн өвтэй суулаа л гэнэ биз. Би чиний хөрөнгөтэй сууж байгаа юм биш шүү?

-Улс л тэгж золбин үг ярьдаг болохоос талийгаачид юу ч байхгүй.

-Үнэхээр чи надтай нийлье гэж байгаа бол үнэнээ хэлсэн цагт л үнэнчид чинь итгэх болно.

-Үнэхээр надад өмссөн зүүснээс өөр юу ч үлдээгээгүй гэхэд Бархас хариу хэлсэнгүй, цагаа хяламхайн ухасхийн босч хувцаслав. Түүнийг явсан хойно Сайнааг харахад тэрвээр үс нь ширэлдэн зунгаарч, нойрмог нүдний нь зовхи сэлхрэн, шивтэрт бөгс нь няцарсан хорхой шиг амьтан үлдсэн байв.

* * *

Норжин эмээ, Сайнаа хоёр манай гэрийн новшийг Чойдортой хамжин зөөж эхлэв. Миний ор хэдэн хоног эзгүйрсний эцэст Чойдор арал сэлтийг салгаад:

-Үүнийг байшингийн ард хураазная. Эзнээ шилгээсэн эд ээл болохгүй гэхэд цаадуул нь зөвшин дагав. Миний хуучин муусайн хувцасыг гадаа овоолж галдах гэж буй бололтой. Цайны шаазанг минь хага цохиж хаясан хэрнээ Норжин эмээ мөнгөн аягыг маань ханцуйгаараа шудран өвөртлөв. Хэрэггүй эд мундахгүй аж. Хүн хэмээгч үхтлээ новш зөөж сав бүхнээ чигжээд орчлонгоос нүцгэн буцдаг явган шуналын шоргоолж төдий л юм даа. Миний хогшилорхуу ноохойг хаях зөөх ээлжилсээр муу байшин маань могойн хальс шиг хөндийрөв. Норжин эмээ:

-Хогий нь үргээдэг юм билүү гэхэд Чойдор

-Засвар орж новширохын хооронд зовлон хожоод яахав дээ. Уг нь та нар эндээ төвхнөвөл аштай юу. Хий юм шүглээд гай зовлон дуудаад байгаа хойно өөрт хамаагүй болгохоос яая гэх вэ.

-Нөгөө ирж үзсэн хүн маань авдаг л байгаа даа.

-Харин ээ. Ямар лүд нь үхээрийн бузар гайд гаргаж байгаа гэчихсэн юм бэ. Заавал засвар хийлгэж ариулж байж ярина гэж чангаагаад...

-Бас л хэдэн цаас гайтуулах нь ээ дээ.

-Ямааны гарз алийг тэр гэхэв.

-Чиний ачийг яаж шуу...

-Та л буян бодож явбал надад хоргомжлох юм байхгүй...

Энэ яриаг чагнаж зогссон Сайнаа:

-Уг нь голомтыг нь харлуулчихгүйсэн гэж бодсон юмсан гэхэд Чойдор:

-Ёстой доо. Даанч гай түйтгэр хавчаад... гэснээ -Бага хүн гэхэд сүрхий гэрсүү ухаан гаргаж байна шүү. Ханилгаа сайтай, голдоо тостой л хүний үг. Ийм сэтгэл хар юмыг цайлгадаг юм. Харин ёс бодож гал асааж ,тасдаж аваад унаган голомтдоо нийлүүлж орхи гэхэд Норжин эмээ зомгол цаас мэтхэн унгатгаж хогийн гаргуул дээр утаа савсуулан таслаж Сайнаад өгөнгөө:

-Юм үзсэн ухаантай хүн сайхан юм. Би бол ийм юм бодох сөгөө байхгүй шүү гэж Чойдорыг доргиоход

-Буруу хойшоо. Тунгаасан нь бага ч турсан их гэгчээр буурлуудаас чих дэлссэн юмаа л бурж байгаа нь энэ гэж өөрийгөө худал голонгуйрна. Гэвч түүний дотор чөтгөр бүжиглэж буйг зөнөг, тэнэг хоёрын хэн нь ч үл гадарлана. Би “Доль Чойдор та нарын амаар чинь ороод араар чинь гарах гэж байна шүү” гэж хэлмээр санагдавч сүнсний үг, сүүдэртийн чихэнд хүрдэггүй нь амьдрал үхэл хоёрын аймшигт хил авай. Чойдор явахдаа,

-Хар бор ажлыг нь нугалж, хөлсий нь саахгүй бол хадаасны мужаанууд амандаа орсон тоог л хэлнэ. Амралтаа аваад өөрөө жаахан ноцолдъё. Энэ хар чийгтэй шалны доод тал бөөн хөгц л байгаа гэхэд Норжин эмээ:

-Олон жилийн хур чийг хүнийг амьдаар нь хүүршүүлдэг юм гэнэ лээ. Хуучин хужаа нар “хөх гуя” гээч чийг бамын өвчнөөс ухаан гардаг байсан юм. Чойдор амы нь дагуулж

-Нар салхины монгол хүнд энэ шавар нүхнүүд хорхойсохоор юм биш. Ийм юманд суусан хүн харахад цагаан хальстай өмх хус шиг болдог гэж хууцчуул хэлдэг дээ гэж тамшааснаа тоосоо гөвөн явахаар болов.

Миний ганц сониучлал гэвэл Чойдор хэрхэн аав бид хоёрын амин нууцад нэвтэрснийг тандах л үлдэв. Шал ховхлож засварлах гэдгийн цаана хамаг учир буй бөгөөд гагцхүү тэрвээр газрын зулайг олж хатгах эсэхээс өөр эргэцээ нэгэнт үгүй болжээ. Норжин эмээ Чойдорын хойноос хараачлан:

-Энэ муу бидэнд өртэй юм шиг холчигонох юм. Урд насны л учиг байдаг юм байх даа, зайлуул гэхэд Сайнаа,

-Талийгаач олон жил үерхсэн юм билээ. Амьдад нь аяга нэгтэй байгаагүй хэрнээ, үлдсэнийг нь хаячихгүй явааг бодоход ханилгаатай л хүн юм болов уу даа.

-Ижий ахай, ижил дасал болсон нь үргээд явчихаж байхад санаанд ороогүй хүн зовлонд түшдэг дээ.

-Та яаж танилцсан гэдэг билээ?

-Сэржээ жээжээгийн д нь зүс үзсэн юм. Тэр хоёр хэзээ язааны ходий юм билээ л дээ. Би л болсон хойно гэр нүцгэрээд толгой хоргодох аргагүй боллоо. Сайн муу ч гэсэн хашаа байшингийн арга бодох юм сан гэж үглэн дуулахад хөөрхий Чойдор нааш хараагүй бол чи бид тогорууны өндөг шиг сайран дээр хэвтэж байх биз,

-Харин л дээ. Өртөггүй хоол байдаггүй гэж талийгаач хэлдэг байсан.

-“Өр яахав, өвчин биш. Өрөөсөн гуталтай ч болно” гэж хуучуулын үг. Энэ ч яахав. Нөгөө Оргил хүү удахгүй наашаа зүглэх байгаа даа. Унаагийн нь орхих байлгүй дээ гэхэд Сайнаа:

-Залуучуудын хэлдгээр битгий “шуналын микроов” болж үз. Эцэг нь өгсөн юмыг эзэн нь авалгүй яадаг юм бэ гээд үсрэн босч хаалга гаднаас нь тасхийтэл хаахад хадааснаас өлгөөтэй шанага шалан дээр ёнгинон унав.

-Улайдмар чинь утгах юмгүй болгочихов уу даа гэж Норжин эмээ үглэн шороогий нь алгаар арчсан болоод буцааж өлгөлөө. Үнэндээ “утгах “ юм л бодож байсан түүнд өлзий бус санагдаа биз.

Сайнаа яахаа мэдэхгүй тээнэгэлзсэнээ, түлээний тайрдсан хожуул дээр суув. Түүний амьдралын тулгуур чухам л ийм ажээ. Энэ хөөрхий бүсгүй амьдралынхаа үндэс мөчрийг, надтай учрах анхны шөнө л тасчин хаяж билээ. Би түүнийг мэдсээр атал мунагийн мунхаг ганцаардлын гачлан хоёрт мундарласны балаг энэ. Би Сайнаагийн хувьд түмэн буруутай ч надад хойчийн гэсгээлээс өөр юу ч үлдсэнгүй. Миний үхэл магадгүй хорвоог ганц өргөснөөс болов салгасан байж болох юм. Хэрэв мөнхийн ус олдсон бол сүүдэр нь гэрлээ эмтэлсээр орчлон тас харанхуй болох ч байсан юм билүү. Надад бусад буян байхгүй гэхэд хог өвс мэт цагтаа булгаран унасан минь, бурхны таалал бололтой.

* * *

Сэржээ авгайнд Чойдор ирсэн нь хачирхалтай. Тэд урьд нь юунд маргасныг бүү мэд. Чойдор уцаарлангүй,

-Цаад Норжин хуар чинь хэмхэрхий шээзгий шиг жайжганасаар байтал нохойн дуу холдоод л байна. Сэржээ мөчөөгөө өгсөнгүй,

-Намайг яа гэв. Чи л хатгаж шүтгэж байж хамар хашаалаа биз дээ

-Сайнаа талийгаачийн тэр муу өмхий шаварт үлийндээ хоргодоод байгаа юм бэ?

-Галы нь унтраачихгүйсэн л гээ биз

-Унтардагаа унтарчихсан юм чинь...

-Цаад зөнөг, тэнэг хоёр чинь учраа олохгүй. Чи тэр үхээрийн бузар болсон хашаа байшингий нь борлуулаад өгөхгүй юу.

-Түрүүчийн хашааны зээлсэн мөнгийг чи өгөөгүй байхад нэмж үрэгдэлтэй нь биш дээ.

Харин Хөнхөрийн хашаа байшинг өрөндөө авч болох юм.

-Юу сайхан вэ дур сайхан. Миний орооцолдоон багадаагүй. Одоо больё. Тоглоом тоотой нь дээр. Толгой цусдвал төвөг. Алтан Найдан юу орхисон гэж чи доноголзоод байгаа юм бэ. Нүдгүй хүн нүхгүй сувд хэлхгэл лай ч бий зай ч бий.

-Өнөөдөртөө би өвчүү цорой хоёр арай нийлчихээгүй байна. Үлдээсэн юм байдаг бол наад хоёр муу ядарсан амьганд нялзвал зүгээр л гэж бодсон юм.

-Хоёр гурван жил шиншээд юу олж долоов?

-Чи надад юу долоолгов?

-Норжин хуарыг ятгаж хамар хашаанд буулгалаа. Сайнааг Хөнхөрийн өвөрт хийлгэлээ. Хот руу өнгийсөн чононд хонин дээрээ нохойгоо нэмж өг гэх нь үү?

-Завсарт нь би л үрэгдэж гүйцлээ. Хөнхөрийн тэр муу хашаа байшинг өрөндөө авч яс салах минь...

-Донтоод байгаагаараа чи Алтан Найдангийн шалан доогуур мөлхөхгүй юу

-Надаар хусран дэлэн алгадуулаад чи үлдэх юм уу?

-Чиний хий гэснийг хийж, өг гэснийг өгсөн.

-Тэрэндээ тулвал эд мөрийн баримт бий шүү.

-Авсан өгсөн хоёр ханиндаа гэлдрэх биз. Тэгээд ч ичээ ухах гэж чиний сарвуу эхлэж загатнасан биз дээ?

-Амаа хамхихаа мэд. Хааш хэрэг үг алдвал хөх толгойг чинь орооно шүү гэж Чойдор заналхийгээд гарахад Сэржээ “адгийн шаар” гэж үглэв. Эд нар чухам юунаас болж хэмхэлцэв? Ямар ч гэсэн анхнаасаа ам нийлсэн болж таарав. Гэхдээ эдний чухам хэн нь миний орон доогуур хоншоороо хийж үнэрлэсэн байж таарах вэ? Миний өөрөөсөө хүртэл нуусан тэр үмх өөхийг яаж мэдсэн нь надад гайхаш тасрам сонин байлаа.

Гэр хороололын үлд мэт хөрс нь эргэсэн эмсгий хашаануудад борог амьдрал өт хорхой мэт аравганах нь гунигтай. Хотын хаяанд асгасан хог шиг ийм юманд шавааралдаж лагтай хутгалдаж хэвтэхээр хөдөө сэрмүүн газар арай цэвэр амин зуулга эрдэггүй нь олны хөл бараадаж, толгой цувдайхан эргүүлж голоо зогоох нь дээр шүү юм болов уу. Хогийн сайрнаас шалбарсан булаг шүү юмны аманд авгай хүүхэд голцуу шанага зодолдуулж хэрүүл хараалаар хэмхэлцэж байхтай тааралдав. Хуучин хөвөнтэй цамц хөдөрсөн өндөр хөх эхнэр бусдаас илүү цамнаж,

-Ардын засаг алаггүй нь хаа байна вэ? Ямбатнууд нь шилэн байшинд тэлчилж, ядарсан бид борооны шалбааг дээр алалцаж байна. Сохор Богдоосоо илүү нүдтэй нь энэ үү гэж даналзахад, өвөгжөөр нэгэн ямаан сахалт:

-Юун ч Богдсог юм бэ дээ гэвэл нөгөө авгай ярдаглаж,

-Богдоо больё л доо. Тэгвэл Чойбалсан нь алаад л Цэдэнбал нь цөлөөд л байсныг яах гэв?

-Үхсэн амьтадын сүнс үргээгээд яахав. Олдсон хуц ухна нь л тэр биз.

-Олдох юу байхав дээ. Оросын тавьсан ёоз нь тэр.

-Одоо учир нь олдоно биз дээ

-Тэгэх байлгүй. Тэгдэг юм гэнэ лээ. Уураг нь эгшээгүй охидыг тэтгэвэрт хөөгөөд, амьтны хэдэн цаасаар гал ноцоогоод уу. Та тийм сайн юм бол лангуун дээр хэвтээ шороотой давс долоогоод л хэвтэж байхгүй юу. Би л лав чадахгүй.

-Энд цухалдаад эрүү эцэхийн л нэмэр. Хорвоод хоёр заяа бий. Үйл үйлээ дагахаас яах билээ. Мань мэтийн амны хишиг умгарынх биз гэж сайхь эр гүнгэнэв. Түүнийг хэн ч сөргөсөнгүй. Харин нэг сайртай бор хүү,

-Гэрийн хорооллыг ус, дулаанд холбоно гэж зурагтаар ярьсан гэхэд цөм инээлдэв. Тэр инээдийг “гайгүй ч хэвтнэ” дээ гэсэн аазгай гижигдэж байх мэт. “Хүн бүхэн аз жаргалтай амьдрана” гэж бишгүй л довогдож явсан би ч бас энэ бүхэнд буруутан. Улс төрийн худалчууд зөвхөн гоё үгээр бөөлждөг бөгөөд гуйлгачингууд түүнийг долоож элэгддэг хорвоогийн бузар бульхайг яалтай вэ? Үүнд үхсэн би байтугай амьд нь хариу хэлж чадаа гэж үү...

* * *

Бархас дүрэлзэн хилэгнэж,

-Чи яалаа гэж намайг мэхлээд байгаа юм бэ. Яалаа гэж миний сэтгэлийн сүүнд ус тусаах гээд байгаа юм бэ гэхэд Сайнаа туулай мэт бүлхэлзэн,

-Би яасан гэж...?

-Мэдэхгүй гэж мэлзэх нь үү. Би чамд дотроо эргүүлж сэгсрээд, чи өнгөн дороо өргөсөө нуугаад мөн таарав аа. Та нар намайг элбэж идэж, эвхэж түрийлэх гэж байгаа бол санааны гарз. Би халуунд хөлдөж, хүйтэнд хайлж чадна шүү.

-Би юу ч нуугаагүй. Байгаа бүхнээ чамд өгсөн.

-Чи бөгснийхөө үнэнд миний толгойг авмаар байна уу. Чадахгүй. Миний толгойг эмсийн салтаа байтугай эрлэгийн элч олохгүй.

-Юу болох нь энэ вэ. Хэлээч дээ... гэж Сайнаа түүнийг үргэх мэт харснаа асгартал уйлав.

Бархас гурвалжин нүдээр ширэвснээ:

-Хүүнүүдийн нүднээс шавхай гоожихыг бишгүй л үзлээ. Хуурамч эмсийн ийм шалбааг

дундуур төмөр дахтай орос хороомон гутлаар туучиж явсан ахмад үеийнхээ улаан мөрөөр “ажлын хартай” алхахаас би буцахгүй шүү гэж Бархас сэгсэгнэхэд түүний угалзан хамарт хөлс бурзайсан харагдав.

Сайнаа дэмий л мэгшин түүний хоёр мөр нарийн хир суусан дурдан дээлийн мөрөн дороос өвчино. Бархас түүнийг хурга барьж буй чоно мэт хэмхэж буйдаа эрэмшин,

-Талийгаачийн аав Алтан Найдангийн өвийг чамаас булаах гэж би хайрын гуйлгачин болсон юм биш. Надад Арабын Эмирүүд шиг арван авгай тэжээх чадал бий. Тэгэхэд чи бурхан болоочдын буяныг надаас юунд нуугаад байгаа юм бэ. Буян гэдэг буруу зөв хоёр эзэнтэй байдаг. Чи зөв эзэн нь мөн. Хэрэв чи үлдсэн юмыг нь үнэнээр нь хэлсэн бол чиний өмсөх зүүхэд зориулахаас бус өөрөө би сохор зоос өвөрлөхгүй гэхэд Сайнаа нулимсаа арчин түүнийг гайхсан нүдээр харснаа

-Надад захьсан үлдээсэн юм юу ч байхгүй. Хадгаламжийн дэвтрийг нь чамд би үзүүлсэн. Хуучин тэргий нь хүү нь аваад явсан. Өөр юу ч байхгүй гэж учирлав.

Гэвч Бархас:

-Чойдор танай ээж та нар яаж булагнаж, ямар бузар юм хийж байгааг би мэднэ. Тэгж яривал Хөнхөрийн аминд юу хүрснийг ч би мэднэ.

-Чи мэдэж байгаа юм бол хэлээч дээ.

-Би биш чи хэлэх ёстой. Надад хэлэхгүй бол чамайг хэлүүлэх газар олдох байлгүй...

Бархасын энэ үгэнд Сайнаа огтхон ч цочирдолгүй үнэхээр гайхаш нь тасарч буйг тэрвээр анзаарч:

-За яахав, чи өвчиж байсан ч хэлэхгүй Өвөрхангайн хулгайч шиг хүн юм. Биендээ итгэж би чамтай сайхан амьдаръя л гэж бодсон юм хэмээн Сайнаагийн нулимстай шанхыг илбэв. Сайнаа тайтгарсхийж,

-Энэ гайтай хашаа байшингаас Чойдор гуай салгаж өгөхөөр болсон. Хоёр биеэ хайрлавал хоосон хонохоос би айхгүй. Чи надад итгээч дээ гэж өмөлзөв. Шидсэн чулуу хөөж хэмлэдэг ярдаг нохой шиг архираагаар хүнийг угнах гэдэг Бархасын ов энэ удаад тус болсонгүй. Түүний авцалдаа муутай ч үесхэн голчтой цэцэрхэлээс бусад нь надад үл таашаагдах агаад бүр зэвүүцэх болсон чиг өнөөдөр Чойдорын чулуудсан хүнцэл үмхэж ийнхүү уушигныхаа дэлбэнг урчих гэж буйг хараад өрөвдөх шиг болов. Тэрвээр байгалийн заяал гэхээр хэлэмгий ч ухааны ёроол ойр, урсгалын хөл богино амьтан. Амь дүйсэн цагт, түүний мөрийг олж түших аргагүй, хадаг хутга хоёрын алиныг ч сарвайж мэднэ. Өнөө цагийн савалгаанд тал бүрээс барьц эрэн самгардаж улам ч цухалхан болсон биз.

Хүүхдүүдийн ярианд садаа болохоос зайдаж, айлд орсон ээжийгээ орж ирэхэд Сайнаа,

-Та талийгаачийн аавыг таньдаг байсан уу?

-Үгүй ээ. Алтан Найдан гэж айхавгар панзчин гэж дуулснаас цаашгүй.

-Тэгвэл хөрөнгө хогшлоо яасан юм бол?

-Ээж нь яаж мэдэхэв. Ганц хүүдээ үлдээсэн байх л гэж Сэржээ хэлдэг юм. Гэтэл их санасан газар илүү гэртэй л үлдэх шив. Харин талийгаач чамд юу ярьж байсан юм бэ...

Сайнаа ийн эхийгээ тандсан авч, аанай намайг хэдэнтээ ам алдуулах гэсэн шигээ эрэл эцэх шиг болов.

...Чойдорын д хүрвэл Юмжирмаа тэр хоёр галын өрөөндөө цай ууж сууна. Юмжирмаа:

-Охин ч яахав, сайн айлын хоол идлээ. Муу хүү маань гэрт зутруухан байх юм. Хэлмэгдсэн амьтны ар гэрийг харж үздэг юм бол Самдангийн нэрийг бариад явбал байр олддоггүй байгаа даа. Яах аргагүй л мах цусанд төрсөн юм чинь...

-Ам ангайж болдоггүй юм чинь тэр.Цаад газрын дансанд бүх юм байгаа. Чи бид хоёр овгоо солиулсны хүчинд нэр цэвэр яваа юм шүү дээ. Тэгээд бас чамтай холбоотой хэрэг сэдрэнэ. Ялихгүй олз эзнээ зовооно.Амьд улс арга нь олдоно гэхэд Юмжирмаа “нээрэн ч тийм дээ” гэсэн шиг санаа алдав. Уг нь эднийх хоёр хүүхэдтэй. Хүү нь Самдангийнх, охин нь Чойдорынх. Хэдийвээр Чойдор хар хүүг нялхаар нь өөрөөрөө овоглож удмын мөргүй болгож чадсан ч бас л хойд эцгийн өнгөр гаргаж явдаг аж. Цусны харьд хүн ижилсэхээс өөриймсөлж чаддаггүй нь зөвхөн Чойдор бид хоёрын буруу ч биш байж мэднэ. Харин ч Чойдор өрөөлийн жаргалыг булаасан хар нүгэлтэй ч замд хугаслаж хаясангүй. Эрээн ч гэсэн эр хүн гэхээс аргагүй. Тэгээд ч судалгүй цагаан бурхан гэж байдаг, эсэхийг хэн мэдэх юм бэ...

Тавдах долоо хоног

Бархас өрөөнийхөө үүдийг дотроос нь түгжээд ширээний араас зэвүүцсэн царайгаар Чойдорт

-Чиний үгэнд орж бэлбэсэн эмийн шалбаагт чийгтэж үхэх нь. Тэр жингэрийн амаар яс ч цухуйх царай алга. Сүүлдээ надад итгээд ханилах суухдаа тулж хачиг шиг наалдаад салахыг байх нь.

-Та л түлхүүрийг нь тааруулахгүй байгаа биз.

-Юу ярьж байгаа юм бэ. Цоож гэдэг ванлий, түлхүүр шургуулахад л ганжин хайвий юм байна лээ.

-Эм хүн үгээ хэлдэг эгзэгтэй үе байдаг сан даа.

-Түүнд эгзэггүй цаг гэж байхгүй, өлөн цурхай шиг үмхэнэ. Хахааж байгаад асуухад л “юу ч байхгүй” гэх юм. Чи надад амлаад байсан нууцаа хэл. Эс тэгвэл би чамайг “ганц худгийн” махан хадаас болгоно гэж мэд гэхэд Чойдор:

-Цангасан эмийн гижгийг хүргэж байгаад ганц үг унагаж чадахгүй хүн л хадаас байлтай юм.

-Түүнд чинь есөн сөвийг нь төнхөөд ч хэлэх үг алга.

-Хачин юм даа. Бид хоёр чулуу хөөчихсөн л юм байх даа.

-Нүд чих болсон Дотоод яам гэдэг биш билүү.Насаараа хүний цувдай цусалсан хөгшин цөөвөр арьсаа тушаах цаг нь болж дээ.

Чойдор зогьсуулах мэт зэвүүн инээснээ

-Намайг өршөөж хэлтрүүл. Миний мухар таамаг сохор эрэл байж. Уг нь би их савны ёроолд шар тос юуны магад гэж бодоод чамайг олоод үмхчиг л гэсэндээ дэмий юманд орооцолдуулав бололтой. Ингээд больё. Энэ явдлыг мартъя гэж хамар дороо үглэв.

Бархас түүний арга мухардсан мэт байдлыг хараад ялагчийн омгоор

-Миний түрийвчийг шулмасуудтай нийлж долоосныхоо өрийг төлөх л болно доо гэхэд Чойдор:

-Тэр гай болсон амбаарыг нь нохой шиншихтэй болгоод улаан мөнгө ханцуйлалгүй өгөмз. Норжин чавганц нас нь гүйцэж надаас угаадас долоотол нар шингэнэ гээд үүд рүү эргэв.Бархас

-Хэлсэндээ хүрэхгүй бол хэлийг чинь сугалж нохойд хаяна шүү гэж хойноос нь зандрав.

Чойдор ийнхүү Бархасын хөлд худал сууж, түүнийг шавар тэврүүлээд өөрөө шар тос хүлхэхээр банжсан бололтой...

Жагай Бархасын өрөөнд шагайж

-Дарга дээр... гэж бултганав.

Сэтэв сандлыхаа түшлэгийг налсхийж Бархасыг удаан сонжиж харснаа

-Удахгүй хурал болж та бид ажлаа өгөх нь шиг байна. Таныг би алба хэргээ цэгцлэж ажлаа өгөхөд бэлтгэхийг хүсэх гэсэн юм гэхэд Бархас:

-Та Ламид мэтийн юмыг оодруулсан шүү дээ. Одоо тушаал гаргаад халчихаач. Толгойгүй болгочихсон байхад хэдэн мухар бөгс тонгочоод газар хороохгүй.

-Уг нь би чамд ажлаа өгмөөр байна. Яахыг чи өөрөө л шийд.

-Мухар ямааны толгойд та эвэр харж айгаад байвал би тушаал төлөвлөчихье, та гарын үсгээ зур.

-Гарын үсгээр гал унтраадаг цаг биш. Хэрэв чи энэ байгууллагыг аваад явья гэж хүсвэл, түймрийн өөдөөс түймэр сэргөөхөө л бод.

-Та санаа зоволтгүй. Тэр муусайн новшнуудын толгой шийрийг би хуйхлаад өгье гэж эрхий хурууныхаа хумсыг хэмлэв.

Сэтэв түүний аяглахыг тохуутай харж “бэлэвсэн эмийн салтаанд өт цацахаас цаашгүй батгана шүүдээ чи” гэж хэлэх гэснээ болив бололтой.

-Би чам шиг аянга бол аль хэдийн ниргэчихсэн л дээ гэж хормойгий нь хөөрөгдөв.

Бархас “энэ муу хоцрогдсон пизда тархи руугаа татуулахаас өрсөж өөрөө зайлах нь дээр” гэж санаж буй бололтой. Гэвч сайхь хөгшин чөтгөр “өөрөөр нь сор залах” гэж буйг Бархас ухаарсангүй. Сэтэв бол хашир боохой. Тэрвээр Бархас мэтийн түүхий хүүг бэрсний хөлд сул шидээд, амаа хийтэй барьж чадалгүйдээ.

Бархасыг даргын өрөөнөөс гарахад Жагай намжирдаж,

-Та урих юм байгаа биз дээ.

-Юунд?

-Хуримандаа...

-Уринаа. Тэгэхдээ тоо товыг нь чи хэлнэ биз гэж сэргөөв.

* * *

Хотыхны царай баргар ч амь хорихын төлөө хуруу хумсаа хуйхалж явах нь өрөвдөм. Тэд үүлэн чөлөөнд нар үзэж буйгаа таг мартан хорвоод мөнхийн зочноор заларсан мэт биесээ ад үзэж, шөргөлцөн атаархаж, хорон үгээр хорсгож, архи хэмээх гашуун усанд галзууран хамар нармайгаа чихэлцэж, хайр дурлал хэмээн уруул амаа зулгаалцаж буй нь амьд сэрүүнд ердийн атал, үхдлийн сүнсэнд гутамшиг мэт үзэгдэнэ.

...Төрийн ордны хурал болж байна:

Тэд тоглоом булаалдах жаалууд мэт томоогүй хэрүүл хийж адилхан мулгуу мөртөө биендээ дээрэлхэх нь хөх инээдийн төдий. Сүлбээртэй ходоод мэт нэгэн:

-Та нар монголчуудыг хүнтэй, малтай нь хядаж, хүүхэд хөгшидгүй өрөнд унагаснаас өөр юу хийсэн юм бэ? Уг нь цаазын тавцанд олсны гогцоонд өлгөөстэй байх ёстой. Ардчилал, хүний эрх гэхчилэн дэмийрч суухаар амь авар гээд мөлхөцгөө гэхэд бойны яргачин шиг мангар эр:

-Чи битгий хуц. Чам шиг юмыг нэг л нулихад ялаа алсны дайтай цэг үлдэнэ. Даан ч би ордны хана бузарлахаас айж байна. Орос, хятадын муусайн эрлийзүүд монголын толгойд гарах болоогүй. Энд чинь эзэн хааны цустай над шиг хүн сууж улсын жолоог залах ёстой. “Дөчин мянгатын хулигаанууд” минь гудамжиндаа гарцгаа гэж зандрахад хүмүүс инээлдэв. Тэр хэрүүлд нэгэн гувчгар эр хоншоор шааж

-Ардчиллынхан ч “ху” намыхан ч адилхан хулгайч нар. Та нар бол луйварчид, варварууд. Та нарт эх орон байхгүй. Харийн шээснүүд, төрд шургалсан чөтгөр шулмасууд. Бурхан багш та нарыг будаа болгоно. Би бол эх оронч. Эх орныхоо төлөө үхнэ гэж хашгиран цамцаа хүү татахад дахиад л инээдэм болов. Тэгэхэд өөхөн дэн шиг ёлтгор эр огло үсэрч:

-Ардчилал гэдэг ийм байдаггүй юм. Үүнийг анархизм гэдэг юм. Бид жинхэнэ ардчиллыг тогтооно гэж гонгиноход нэг халзан хархүү:

-Жинхэнэ ардчилал гэдгийг хүн төрлөхтөн олоогүй байгаа. Хэрэв та олсон бол раак эмчилсэн хүнд босгох алтан хөшөө таных болж дээ... Дахиад л хөхрөлдөв. Түүнтэй сөргөлцөж, нэгэн төмөр дуутай модон авгай их л намбалзан:

-Монголын ард түмэн намайг сонгосон... гэхэд хэн нэгэн хоржоонтой эр

-Таныг монголын ард түмэн бус нэг л тойрог, тойрог ч гэж барааны саван сонгосон гэхэд хүмүүс инээлдэн үг хэлүүлсэнгүй...

Тэд өөрсдийгөө ”нам засгийн удирдагч” хэмээн эргүүтэж буйг нь харахад эгдүүтэй агаад социализм, капитализмийн холимог хуурга шиг харагдана. Зовлонгийн хажуугаар намайг мэрж буй улс төрийг би үзэн ядаж байна. Улс төр гэдэг эрх чөлөөний сүрэглэсэн дээрэмчдийн булагнал, хэргэм зэргийн сэнтийд алалцахаас буцахгүй талцсан хэмхэлцээн юм шиг. Улс төрч гэдэг нь ердөө л зангиатай чоно, залаатай хэрээ, банзалтай үнэг. Тэнэг мөртөө бүхнийг мэдэн цэцэрхэх, тэнхээгүй мөртөө амандаа багтсаныг донгосоход нь зэвүү хүрэх юм. Тэд ард түмэнд хуурамч хайр зарлан улы нь долоож өргүүлээд эргэж улаан нүүр рүү нь нулимна. Тэд эх орны зарлигаар тодорсон хувилгаад хэмээн индэр дээр цондоглохдоо,

өөрсдөө гуйрамчлан саналын бадар барьснаа мартаж орхидог хойшлогогүй бадарчингууд Тэгэхдээ би үүнийг амьддаа хашгирч чадаагүй нь монгол зан бус, монширсон боолын аймхайн торонд ороолдсон аалз төдий явсны хохь мөн.

Саарал байшингийн дотор тал нь ч хоосон ёсорхол, үр бүтээлгүй албархалын будангуй ноёлж, хонгилын үзүүрт нь ямар нэгэн гэрэл харагдахыг анзаарсангүй.

...Энэ өдрийн гаж сонин гэвэл “өвгөнтийн хөндий” байлаа. Хэн нэгний хэлсэнчлэн энд нийгмийн шаар асгасан мэт ажээ. Уранхай хүрэмний сэг хөдөрч хир даг болсон нэг өвгөн цусан гавьяаны одон алган дээрээ тавьж

-Цусаараа авсан гавьяа.Ганц юмаар ав гэж орилоход, шүлс нь савирсан залуу

-Чиний царай ч хүний цусаар л авсан байж таарна даа гэхэд цаадах нь

-Гадаад, дотоодын дайсантай гал усан дундуур тулалдаж явсан толгой шүү новш минь гэв.Тэдэн дээр нэгэн салдирхалсан авгай ирж

-Гудамжны алчуурууд минь юундаа хэрэлдээд байгаа юм бэ. Аль вэ ам цавлах, шалхийх шавхруу байна уу гэхэд сайхь хөгшин

-Согоо шиг амьтанд бол яая гэхэв. Солиотой чавганцад өгөх юм алга гэвэл авгай тас тас хөхөрч:

-Сайхан явахад минь сайд таалж байсан юм мэдэв үү хэмээн салтаа руугаа гараа шургуулснаа “май!” гэхэд өвгөн архичин “түй” гэж алган дээр нь нулимав. Зодоон болдогийн даваанд шороонд дарагдсан пад хар цагдаа ирж:

-Хогийн архичингууд яагаад уралцаад унав гэж зандрахад өвгөн:

-Хурандаа хүн хугас түрүүчид илтгэдэггүй юм. Авгай:

-Одооны олон давхар будагтай эмсийг бодвол мисс явсан юм шүү. Залуу:

-Чи ардчиллын салхи уу, “ху” намын хулхи уу.Худлаа хуцахаас өөр та нарт юу байгаа юм бэ-гэхэд цагдаа:

-Төр засгийн эсрэг ухуулгаа зогсоохыг би шаардаж байна-гэхэд өвгөн архичин:

-Ард түмний эсрэг байлдахаа зогсоохыг би шаардаж байна. Та нар барина л биз, тамлана л биз, ална л биз. Ганц чаддаг юм чинь энэ. Үгүй гэлдээ “ёвгиймаад” гэж хашгирав. Эднийг ийнхүү урваганаж байтал хөөрөгт хөгжим барьсан бас нэгэн согтуу эр тэднийг гайхах мэт харснаа хөгжмөө байдгаар нь алдлан:

...Сталин таны их хайр

Нар шиг биднийг гийгүүлж байна...хэмээн цахиртал бахирахад бүгд ангайн инээлдэв. Ямар

толгой байна, тийм л хөл байна гэдэгсэн билүү...

* * *

Хүний орчлон гэдэг санамсаргүй тохиолдлын хоормог байдгаараа тайлж ядсан гайхашралыг өдөөж, чухамхүү түүнийг мөшгих нь амьдралыг ад мөрийн сонин болгодог байж болох юм. Үдшийн бор бүрийд сугадалцан алхаж буй залуу хосыг Ламид, Сэндэрмаа гэж би сэрүүндээ байтугай сүнсэндээ итгэсэнгүй. Сэндэрмаа зог тусч тэнгэр рүү ширтсэнээ:

-Чиний од аль вэ гэхэд Ламид:

-Чиний одны дэргэд байгаа...гээд Сэндэрмааг тэврэв. Тэр хоёр одоо оноож буй бололтой, огторгуй ширтэн удаан зогсов. Тийнхүү саатах нь хэн хэнд нь таатай бололтой. Ламид:

-Даарч байна уу гэж асууснаа хариу хүлээлгүй хүрмээ тайлж нөмөргөхөд Сэндэрмаа:

-Чи даарчихав аа яанаа гэж эрхэлвэл Ламид:

-Би яахав, амьдрал минь даарч болохгүй гэж хошуун дээр нь үнсэв. Сэндэрмаа түүнийг хүзүүдэн озолдохдоо сайхь хүрэм мөрнөөс нь гулсан унахыг анзаарсангүй. “Ямар сайхан амттай чихэр юм бэ”, “нээрээн үү” гэхчилэн тэр хоёр хааяахан амьсгаа аваагүй бол бүтэж үхэх байсан биз. Ламидын бүх бие хөвчрөн халуу шатаж буй мэт болж Сэндэрмаа алдран суларч түүний алтан мандарваа цэцэг шүүдэрлэж байхаас зайлахгүй.

Ламид түүний хэвлийг алгаараа дарж

-Энэ юү вэ?

-Ходоо...

-Энэ дотор юү байгаа юм бэ?

-Жижигхэн Ламид гэснээ Сэндэрмаа тас тас хөхрөв.

Би, биеэ орхисноос хойш аз жаргал, амраг сэтгэлийн ийм гэрэл гэгээнд үнэхээр орсонгүй.

Ламид газар шагайн хэсэг зогссоноо санаа алдаж

-Яана даа...

-Яасан бэ?

-Ааваас чинь айж байна.

-Аав минь надад ухаангүй хайртай.

-Тэгэх тусмаа...

-Тэгээд юу гэж...

-Би чамд хайртай мөртөө аавын чинь эсрэг...

-Би мэднээ. Чиний зөв. Аав минь тэр муухай газраас салаасай билээ. Сүүлийн үед ааваар минь дайруулж зарим хүн намайг доромжилдог болсон.

-Хэн тэр вэ? Бархас уу?

-Тийм ээ. Бархас яахав дээ, дөрвөн талаасаа хийсч явдаг хөөрхий амьтан. Би түүний сэтгэлийг мэдэж байсан ч гомдоохоос өөр арга байгаагүй. Яагаад ч гэсэн түүнийг өрөвдөхөөс, хайрлаж чадахгүй. Тэгээд цөхөрч аргаа барахдаа намайг тэгж хэлсэн байх.

-Юу гэж?

-Хүүрний сайдын зулбасаганд хүний үнэр байхгүй гээд намайг хорстол алгасан. Би гомдоогүй л дээ. Хүнийг зовоосны хариу л гэж бодсон.

-Би түүнийг сэнсэлж яваад үрэгдэх вий дээ л гэж зовдог юм.

-За за. Чих нь халууцах байх. Талийгаач Хөнхөр гуайн авгайтай “Low you” гэсэн байх аа. Яахав дээ зайлуул. Жаргалтай л байвал ямар хамаатай юм бэ. Тийм үү гэхэд Ламид толгой дохив.

Сайхан хүүхэн тэнэг байдаг гэдэгсэн. Гэтэл Сэндэрмаа ийнхүү тэгширсэн нь гайхалтай. Сэндэрмаа удахгүй сургуулиа төгсөөд цав цагаан өмсгөлтэй тас хар хөмсөгтэй эмч болоход ямархан үзэсгэлэнтэй харагдах бол. Ламид ч гологдохоор хүү биш. Харин Сэтэв Гаапэл хоёр юу гэх бол... Тэгнээ тэр Гаапанз ажаа цонхоор улаан лаа асаачихсан юм шиг харагдана.

-Хүүеэ Сэтэв ээ. Чи юунд өр алдсан хятад шиг суугаад байгаа юм бэ. Охин бас л байдаггүй гэхэд Сэтэв:

-За за яахав. Залуу явж үзээгүй биш гээд хөдөлсөнгүй.

Гаапэлийн завж татганан:

-Яахав гэнэ шүү. Цэцэг цэврүү шиг ганц охиноо шалдан хар юманд зүүгээд шалбааганд хаях гээ юу. Цаад наадахы нь хардаг байгаа даа. Хөөрхий амьтан хөл нь шивэртэж, хөлс нь нэвчин явган гүйж насыг барах юм уу. Буянтай хүн түшүүлвэл эрүү дэвсэж яваа бид хоёрт хаялга нь хаачихав дээ. Чиний тэр Ламид чинь охины минь мөрийг улалзуулж, чамайг хоолноос чинь салгах гээд байгаа биз дээ. Голд чинь нүх байна уу, годил юм уу чи! Хүүш, дуугараач гэж яншивч Сэтэв хөдөлсөнгүй. “Үнэн” сониноор нүүрээ бүтээгээд буйдан дээр тэрийн хэвтэв. Гэвч түүний дотор түймэр шатавч галы нь өрвөлзүүлэх хэрэггүйг гадарлахтай толгой. Одоо түүнд ганц охиноороо бугуйлдах халагддаггүй сайд олдох нь өнгөрсөн болохоор цээжинд нь өрөөстэй байсан шатарт өөрөө мандан суужээ.

Сэндэрмааг орж ирэхэд Гаапэл уурандаа улайсаж:

-Чи чинь хаагуур тэнээд явчихдаг сухай вэ.-

-Кино үзээд...

-Орой бүр л кино. Чи л болоод кино үзсэн байх даа. Нүцгэн гуйлгачин дагаж давхиад л байгаа дуулдах юм. Бид хоёр амьтны нүүр яаж харах болж байна вэ.

-Танд хувцас нь хэрэгтэй юм бол худалдаж аваад өгчихөөч дээ гэж Сэндэрмаа гараа савчин хөхрөхөд Гаапэлийн уур дэлбэрэв бололтой

-Чамайг бид өөхөнд хучсан бөөр шиг өсгөсөн. Гэтэл чи нохойн хороо, гахайн хашаанд хэвтэш эрж явдаг мөн таарав аа. Энэ толгой мөрөн дээр байсан цагт дураар чинь дургиулна байх аа. Чамайг дахиад тэр муу зэвхийтэй хүзүү сээрээрээ хэлхэлдвэл турсгы чинь хуулаад өгөмз. Мэдэв үү гэхэд Сэндэрмаа:

-Мэдээгүй, мэдэхгүй. Таны цаг үе өнгөрсөн, ёстой мэдэв үү. Чао гэж хацар дээр шовхийтэл үнсчихээд өрөөндөө орж үүдээ торхийтэл түгжив. Гаапэл үүдэнд нь очиж:

-Төрсөн үрийхээ толгойг мэддэггүй ямар гээчийн цаг ирэх нь энэ вэ. Чиний тэр эрх чөлөөгөөр чинь хоол хийж идэх үү, хоргой хийж нөмрөх үү. Нам засгаасаа салаад ингэж заяаны нь нүдэнд шороо чихэх гэж бас байдаг аа. Дөчин мянгатын тэнэмэлүүд дөрөөндөө чиргүүлж үхээсэй билээ гэж цовхочсон боловч нэхлийн өд нь сөдөлгүй болсонд гутарч тархиа базаж галын өрөөний сандалд арайхин онож суун чаавааслав. Олохгүй юм эрэх гэдэг орчлонгийн ойврогогүй зовлон ажээ.

Зургаадах долоо хоног

Сэтэв тоглойн босч “юуны урд хуралд оролцож байгаа Нянгар даргадаа чин сэтгэлийн баяр хүргэе” хэмээн нялууран бөхөлзөхөд хүмүүс унгас савах мэт пид пад хийлгэн алга ташив. Түүний царайг сүлсхийсэн зусрын мөшгөөртэй инээмсэглэл ялимгүй бөхөж

-Энэ хурлыг ардчиллыг дэмжих бүлгээс санаачилж миний бие халуунаар дэмжин та бүхний саналыг сонсохдоо баяртай байна. Миний өчүүхэн мэдлэг ажлын туршлага хэрэг болно гэвэл би цаашид ч хүчин зүтгэхэд бэлэн байна. Харин Ламид мэтийн шинэ залуу боловсон хүчнийг дэвшүүлэх нь зүйтэй гэж үзвэл албан тушаалтай зууралдах хүсэл, хүмүүжил аль аль нь надад байхгүйг та нар мэднэ гэхчлэн цэгц муутайхан бөөрөнхий үг нуршив.

Ламид зөвшөөрөл авч Сэтэв, Бархас нарыг огцруулах тухай өргөх бичиг уншсан боловч олонхийн чихийг оносонгүй. Үнэндээ харанхуй нүхний мухрыг ширхэг шүдэнз зураад гэрэл хэрхэн гарахсан билээ. Энэхүү балар нам гүмийг Бархас үргээхээр овлож

-Би шударга үнэнийг хэлье. Сэтэв дарга бол жинхэнэ хатаагдсан коммунист. Энэ байгууллагыг олон жил удирдахдаа, түүх мартаж аргагүй агуу их гавьяа байгуулсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Дарга минь өнөөгийн шаардлагыг нарийн мэдэрч маргаашийг тод харсны үндсэн дээр өөрийн хашиж буй албыг хойч үедээ нэр төртэйгээр хүлээлгэн өгөхөө илэрхийллээ. Харин шинээр сонгогдох хүн Сэтэв даргын үйл хэргийг үнэнчээр үргэлжлүүлэх ёстой. Өнөөдөр бид сонгууль хийхээр төлөвлөөгүй ч ардчиллыг дэмжих хэсгийн шахалтаар энэ асуудлыг хэлэлцэж байна. Ер нь ардчилал шинэчлэл бүх салбарт хүчтэй өрнөж байхад бид ухарч үлдэх ёсгүй. Ухрал бол үхэл. Өнөөдрийн нийгэм асуудлын голд хүнийг зоож байна. Би хөтөлбөрөө бэлтгэж та бүхэнд тараасан. Энэ бол шинжлэх ухааны диалектик үндэстэй онол практикийн ач холбогдолтой гэдгийг давган хэлье гэхчлэн урсгав.

“Самбалхүндэвийн” сахиул:

-Сэтэв дарга их буянтай хүн. Бархас дарга ч гэсэндээ зайлуул. Тэр нь ч хамаа байжуу. Газар хавчиж ганга жалга хашчихлаа. Яадаг шуу юм билээ. Даргаа! муу хөгшин гал алдах дээр тулаад байгаа. Чойдорт мод чулуу юугайв дээ...

Мужаан:

-Хүний хуучин гэдэг. Нудрага нь хаачих вэ. Бархас дарга, Ламид инженер хэн хэн нь залуу улс. Залуурын дэргэд жаахан байвал яасан юм бэ. Би юугаа мэдэх вэ. Нойтон мод бидэнд ч хэцүү хэрэглэж байгаадаа ч хэл амтай.Хатаалга хэрэгтэй. Ээдээ тачигнасан хуурай мод ч урамтай шүү.

Чулуучин:

Улс төрийн товчооноос эхлээд уван цуван зам тавиад байхад бидний зам дээр социализмын бул хар чулуу саад болж байна. Манай ардчиллыг дэмжих хэсгийнхэн “Сэтэв огцор”, “Бархас

огцор” гэж шаардаж байна гээд тийнхүү бичсэн цаас дэлгэж Ламид инженерийг дарга болгоё гэж хашгирав. “Наран”-ийн сахиул:

-Хүүхдүүд хөлөө жийлцэх гээд байгаа юмуу даа. Өлзийгээ алд гэж. Тэр ардчилал гээд байгаа юманд чинь Сэтэв дарга ордог юм байгаа биз дээ. Хуучин юм гээд гаргаж хаях гээд байгаа юм уу. Сайн хуучин эд муу шинээс дээр л байдаг хундаа. Манай Наранд ус л хэцүү. Заримдаа тарвага болох юм. Ам цавлах аяга ус төхүүлчих арга чарга байх уу..

“Алтан Өлгийн” сахиул:

-Манайх хуучуулын нутаг. Одоо энэ шинэчүүлээс ирвэл хаана нь тавих юм бэ. Сүнс сүүдэр нь хүртэл хоорондоо таарахгүйдээ. Сэтэв дарга бодно биз. Дарга сольсон солиогүй үхэх төрөх жам байж л таарна. Гэгээтэйд гэрийн бараа харъя. Чөлөө гуйя...

Чойдор:

-Би бол тэтгэвэрийн нас болж, эрлэгийн элч хүлээж суух цагтаа туллаа. Залуучуудад зам зайлж өгнө. Сэтэв дарга тулхтай хүн. Эрийг нас гэдгээр ядраад байх шиг харагдаад байгаа юм. Дор нь Ламид инженер шиг шижгэнэсэн залуу байвал яасан юм бэ. Бархас дарга тэртэй тэргүй бидэнд олдохгүй дэвшээд алга болно.

Нянгар:

-Би төвийн бодлогыг танилцуулъя... Нөхөр Сэтэвийг хэвээр үлдээж, Бархасыг өөр ажилд томилох болсонтой холбогдуулан орлогчоос өөрчлөх санаатай байна. Орлогчийн хувьд нөхөр Сэтэвийн саналыг сонсох нь зүйтэй гэж үзэж байна.

Бархас “номинклатур” гэж хашгирсан боловч тэнд энэ үгний учрыг олох хүн байсангүй. Санал хураахад Сэтэв хэвээр үлдэж түүний саналаар Жагай орлогч болов. Хурал шүү юм тарахад Бархас Жагайгийн хажуугаар гарахдаа “Чиний бөгс яасан их үнэтэй юм бэ” гэвэл Жагай араас нь “Чи ч үнэтэй бөгс эрж яваа биз дээ” гэсэн үг чулуудаж амжив.

Хашаны гадаа Чойдорыг гүйцэж очсон Бархас

-Өгөр пизда юу гэж хуцаад байгаа юм бэ.

-Чи өөрөө цовхчиж байгаад амьтныг үргээчихлээ. Би уг нь эргүүлэх гэж оролдсон юм. Тэгэхдээ Ламид нэрээ татаад чамайг давхар халчихлаа. Цээж сөхсөн хүн хөлдөө алддаг хойно доо. Одоо яая гэхэв. Нохой хотондоо, ноён хоймортоо гэдэг. Гэмгүй явцгаая.

Бархас “түй” гэхээс өөр хариу өгсөнгүй, багтарсан уурандаа хөөгдөн зам салав. Тэртэй тэргүй Чойдорт Бархас мэтийн буудсан хонгио хэрэгшээлгүй нь мэдээж. Ерөөс хүмүүсийн зам салж нийлэхэд гайхахын гарзаас өөр юусан билээ. Чойдор хөлд тээглэсэн элэгний нухшны лаазыг Бархасын араас өшиглөв. Сайхь лааз хэдэндээ донгиносноо харанхуйн хаа нэгэнтэй хонхор олов бололтой чимээ алдарлаа. Надад яагаад ч юм бэ манай улс бүхэлдээ л ийм мэт санагдан “яана даа” гэж дуу алдмаар болсон ч би хэрхэн дуугарч, түүнийг хэн

хэрэгшээх вэ дээ.

* * *

Сайнааг хэдэн бор төгрөг дэлгэн барихад Сэржээ ялдамсаж

-Барьц тавьцаар яах нь вэ дээ гэхдээ гар нь сарвайв. Тэрвээр мөнгийг бурхандаа залахдаа:

-Амьтны хайрласан буянг бурхандаа л өргөчихдэг юм гэж жишимгүй өгүүлэв. Сайнаа:

-Талийгаачийн хоног хураах ч ойртлоо. Буян номыг нь асуугаарай гэж ээж хэлүүлсэн. Бас явдлын далимд өөрийгөө ч мэдмээр байна.

Сэржээ түүний гарын алгыг харж бодлогоширсноо

-Буянтай хүн байсан даа хөөрхий. Зам нь шулуудчихсан бурхны оронд очих юм байна. Хүү болж чамд эргэж төрөх юм шив дээ. Хань ижилдээ хоргодсон юм байна. Арга ч үгүй дээ, залуу сайхан амьтныг зам гудагт орхиод явахдаа их шаналсан бололтой юм. Хоногий нь хураахдаа хэлнэ биз дээ. Аргалуулахгүй бол чамайг жаахан ороож магадгүй. Аа, тийм бас оромжиндаа хоргодсон юм байна. Тэр муу хашаа байшингий нь эзэн олгоод чи ер нь голомтоо бараадвал дээр байх. Ээжид чинь би бас хэлж л байсан... гэхэд Сайнаа:

-Тиймээ. Таны хэлснээр болсон. Хөөрхий Чойдор ахын л буяндаа.

-Цаадах чинь арга чарга хийлгэхгүй хэнэггүй царайлаад яваадаг. Хүний гайг өөртөө дуудаж толгойдоо арандаг болох вий дээ зайлуул.

-Тиймээ. Би гэдэг хүн яахаа мэдэхгүй л явна.

-Чи яахав ээ. Сайн ханьтай болох юм байна. Болчихоод ч байгаа юм уу. Дотоод энгэрт чинь хүү охин хоёр байх юм. Хүү нь талийгаач чинь ирж байгаа нь тэр. Танайх өөдлөх өнгөтэй юм байна. Залуу хүн хань, үр буян тэгшрээд ирэхээр жаргадаг хойно доо...

-Хүн чинь ганцаардахаараа л зовлонг мэдэх юм. Талийгаачаас хойш “малгайгаа даахгүй” гэдэг боллоо.

-Аргагүй ээ. Тэгдэг юм. Нас тогтсон хүн тулхтай ч нарны голтойд орхичихоод хүүхэд өнчрүүлчих вий дээ гэж ээжид чинь би дурсаж л байсан даа.

-Ээж танаас асуусан. Заяаны нь хань гэлээ л гэсэн шүү дээ.

-Тиймээ, заяаны ханийг завсараас нь шүүрэх гэж юм байдаг юм.

-Ээж танаас л залсан байх даа. Нэг тан уугаад талийгаач дордчих шиг болсон шүү.

-Арга нь барагдахдаа амьтан хүн царайчлаад л явах шиг байсан. Муу ээжийгээ л сайн өргөөрэй. Зүрх бөөр гээд л үглээд явдаг болсон байна билээ...

Энэ яриа Сайнааг тайтгаруулсан зовлон нэмсэн хоёрын алин болохыг мэдэхгүй. Тэрвээр гэр рүүгээ толгой ганзагалан алхсаар ирэв.

Норжин эмээ түүнийг оронгуут

-За юу гэж байна хэмээн үгэнд дурлахад

-Танд хэлсэн гээ биз дээ. Цаад авгай чинь үнэхээр мэддэг юм уу, амьтны хэдэн бор цаас зулгааж суудаг юм уу...

-Нүгэл гэм. Олон сайчуултай цагт юу вэ гэхээс одоодоо л хувилгаан хүн. Ээж нь мэдэлгүй дээ.

-Энэ хашааг авах гээд үзүүлэхэд чинь үр буян дэлгэрнэ, үүд өрх чинь өлзийтэй гэсэн биз дээ. Тэгээд хаана байна вэ. Шороо үмхлээ шүү дээ.

-Тэгж болохгүй. Буянтан хишгээ орхиод буцлаа. Яахав миний лай ланчиг юм байгаа биз. Бүрлээчийн хоргодоод байгаа орон савыг авчих хүн олдоно. Амин зуулгад ашгай юу даа. Сэржээ жээжээ нь үүнийг харсан л юм билээ. Хүнд чинь заяаны завсрын хоёр хань байдаг. Одоогийн үзэгдээд байгаа хүүхэд эрдэм номтой, алба ажилтай сайхан л хүү харагдаад байгаа юм. Бурхан миний охинд явуулсан ч юм билүү.

Сайнаа дуугарсангүй. Норжин эмээ барьцаа ахиулж:

-Хуруувчин чинээ чавганц би хичнээхэн наслах вэ, нэг л өдөр өнхрөөд ойчно. Миний охин л хичээж үз. Аз дутахад алтан ембүүн дээгүүр алхаад гарчихдаг юм гэдэг шүү.

Сайнаа түүний үгийг тоомжиргүй чагнаж сууснаа:

-Та нар чинь Алтан Найдангийн өвөн дээр тарвалзуулна гээд л ятгаад байсан нь алив дээ. Амбаар, хэлхээтэй зах банз хоёртой л үлдлээ. Талийгаачийн эцэг эдэлдэгээ эдлээд үрдэгээ үрээд ганц хүүдээ гарт багтаж ядсан юм үлдээгээгүй юм байх чинь билээ. Бархас бол бурхан болоочийн захиасаар л эргэж тойрч байна гэж далдаганаж байсан ч өв горьдож явсан зайгуулаас гараа гэж үү.

-Хөндлөнгийн хүнд үг унагаагүй ээ. Харин Сэржээ жээжээгээс нь асуухад нигууртай гэсэн юм дуугарсан. Миний эрүү салаад ойчихоор чамд хэн хэлхэв дээ. Амьд шүү яваа болохоор амандаа ус балгачихсан юм шиг байж чадахгүй юм. Түргэн шиг далдарч чамайг амраах минь гэж Норжин эмээ уйлагнан нулимсаа арчихад Сайнаа буурал үсийг нь илбэж

-Хөөрхийдөө ээж минь гомдчиховуу. За за би үгээ буцааж авлаа гэвээс хөгшин тайтгарав.

Норжин эмээг харахад үнэхээр өрөвдөм. Энэ харанхуй амьтан Чойдор, Сэржээ хоёрт хамагчлуулж яваад хаана сөхөрч унахыг хэн мэдлээ. Түүнд мухар сүсгээр сохор заяа эрэхээс өөр ямар ч хүч байхгүй. Ерөөс сэтгэлд нь гэгээ тусаагүй хүн хэн нэгэн зальхайн идэш болж үүрсэн лайг өөрийн гэмгүй толгойд чихэж өнгөрөхөөс өөр яах ч билээ. Амьдрал хэмээгчийн урсгалыг сөрж эс чадсан нь хоормоглосон давалгаанд хөөгдөн сураг алдардаг нь юутай

гунигт тавилан. Хүлцэнгүйрэл, харанхуйлал хоёрт мөхөх хүний нэгэн нас юутай хайран. Хүний нулимсаар зовлон гадагшладаг гэх боловч Норжин эмээгийн унагаж буй нулимсаар хорвоогийн жаргалын шавхруу нь гарчих шиг.. Харин Сайнаа түүнийг эс анзааран гоморхол төдийд бодож байх шиг. Тэгэхдээ түүний нулимс барагдтал бас ч зай бий.

* * *

“Ганц худаг” хэмээгч газар эрхэж бугласан бээр мэт. Үйлийн мөртөйд сохор азаар үүдийг нь татаагүй мөртөө өргөст тор, үнгэлдсэн харуул, нохойн гинж шиг хэлхээтэй түлхүүр чирсэн хуяг алинд ч үл саатан сэлгүүцэх сонин. Хөгц чийг хөлөрсөн дөрвөлжин нүхэнд борооны хэрээ шиг хэдэн өрөвгөр амьтан хулгайч хэмээн дуудалцах нь урт хумстангууд гэтэл араатангууд бололтой. Сүүдрийн мөөг шиг хохийж цайсан нэгэн эр үг өдөж тэд ийн хөөрөлдөх аж.

-Энэ өмхий зооринд илжирснээс хэргээ хүлээгээд наранд ясаа цацах минь...

-Салтаанд чинь юм байна уу.

-Мухарсан бол луусанд тарвалзаж хэвтэхгүй та нартай энд тамаа цайх уу.

-Муу эрд халдлага, мухар буханд бөлдөг гэдэг юм.

-Таван амтай адуу шиг тасдаж идэх шахсан эмсийн хоёр хөхний хооронд хоншоороо шаагаад хумбан харыг нь худаг шиг лайдах ч жаргал даа.

-Мунаг чинь хөдлөөд байвал муу махаа тасдаад хуягт өгчих. Цаадах чинь нэг золбин олоод шидчихэг.

-Гөлгөөрөө байна даа. Гөнжөө үлгэмээр байна уу гэж нэг солиот өмдөө шувглахад

-Маршалын хүрэн халзан гэдэг шиг мөн ч зангарагтай эд ээ.

-Алцаа нь өөхөлсөн авгай нар арван наймт шиг чарлаад гурав хоног гуяа тэвэрч хэвтдэг юм.

-Шаадаг хулгар аа. Саяын буудуулдаг Сахалтынхыг яана. Халиу нудрага эргүүлсэн хамбан дээлийн ханцуй шиг харагддагсан...

-Эмсэх байж эрсийн шийр заасан цувдайнууд минь хохь чинь гэж үсэн хушуутай бахим эрийн зандрахад бусад нь дуугай болов. Энэ нөгөө амтаман гээч нь бололтой. Нөгөө яриа өдсөн хохигор бас л үг хаяж толхилцов.

-Шорон намайг тэгшлэхгүй шороон доор хэвтэж нурууныхаа чилээг гаргана даа.

-Шинэ засаг өршөөвөл өмхий цувдайгаа чирээд л дэгдэнэ биз.

-Уг нь хуучин лухгаруудыг үхгэл шанаадлаа. Даанч тэнгэрийн аянга газрын бэтэг онохгүй л дээ.

-Хүн болох гээд үзвэл яасан юм бэ.

-Хөг нь өнгөрсөн. Аавынд хүмүүжих азрага унагалахтай адил...

-Сайжраад сайд болчих ч юм билүү...

-Тэд чинь адилхан хулгарууд. Хуулийг нь барьж байгаа тулдаа наранд яваа юм.

-Муусайн новшнуудын өрцний цусыг гавлын ясанд нь хийж байгаад залгилах юмсан.

-Тэрэнд цус байдаг гэж чи арай бодоогүй биз. Бидний нулимс л бий.

-Ардчиллын хэдэн банди нар гар нь цусгүй байгаа шүү.

-Цаадуул чинь цатгалан ишиг шиг дэгдэж яваад чонын хоол болно биз.

-Намрын ирэгний дал дөрвөн өндөр утаа зуусан хошноготой хэд огтлох юмсан. Хувхай хоншоортой байцаагчид ийм сачий байдагсан бол худлаа хэрэг хүлээгээд мөрөн дээр нь таван хошуу зоолтой билээ.

-Өчигдөр намайг нэг муу хуйхалсан таахай шиг хар юм амбаардаж байхгүй юу. “Би шийдсэн хүн. Дүүрээгий чинь дэлбэлчихээд сэвсэн дээр чинь толгойгоо огтолж тавина” шүү гэсэн чинь “гавтай хулгайч гартай” гэж бодоогүй биз гэнэ. Тэгэхэд нь би “Гавгүй гар минь гадаа яваа. Зүрхэнд чинь хутга шаачихаад ёг гэсэн хойно, үг хэлэх гээд үзээрэй. Чи намайг арай хоёрхон гартай гэж бодоогүй биз гэсэн чинь хулхинд нь гадас шаах шиг болно билээ.

-Хоньтой майлж, чонотой улихгүй бол хог дээр гарна шүү.

-Эд нар яахав дээ, төрийн бөөс шүү дээ... Энэ мэт эх захгүй яриандаа таашаал авч буй бололтой хахь өнгөөр ангалзан инээлдэв. Би тэднээс төвөгшөөж, өөр нэг нүхэнд шургаваас нэгэн чавгаарай хэдэн сэгсгэр эмс бүчүүлэн алгыг нь шинжиж “Чи бол хар цагаан хэл амтай л юм байна. Удахгүй учир нь олдono” гэх буюу “газар лусын хорлол болж”, “суудлаа тэгшлүүлэхгүйдээ харла” гэхчлэн лүндэгнэж сууна. Хүмүүсийн үг чагнаваас нөгөө Сэржээ жээжээ гэгч аж. Харин яагаад энд ирснийг шохоорхвол ашгүй нэг хүүхэн:

-Сэржээ жээжээ та ийм лаг байж яагаад орчихсон юм бэ гэж сониучлахад

-Нэг муу үхээр үлдсэнээ ээрээд байхаар нь сүнсийг нь хөөчихсөн чинь эргэж ноцохгүй юу. Би чинь хүний гай үүрч явдаг үйлтэй амьтан.

-Сүнс харагдах уу

-Харагдах хүндээ л харагдана.

-Ямар шуу юм байх вэ

-Барих биегүй хий юм байдаг юм.

-Хаана хоргодох вэ.

-Хамрын нүх, нүдний аяга, хумсны завсар ч байж болно.

-Сүнс яаж эхийн гэдсэнд ордог юм бол?

-Эрийн нүглийн цоргонд бүгэж байгаад эмийн бумбанд рашааны дусалтай... урсаж ордог юм гэхэд “яанаа” гэлцэн шагшилдав.

Гэтэл нэгэн архаг эхнэр:

-Энэ муу хөгшин өлгөчин мөн шаадаг гудрага аа. Энэ л болоод бүлүүрийн нүхэнд бүгээд хөрүүрийн хээлэнд шургаж гэнэ. Хоёр ам руу нь залтас шаагаад ходоодон дотор нь хавирвал таарна гэж хашгирахад Сэржээ хөгшин ухаан алдан балтасхийв. Сайхь эхнэрийн зэрлэг нь туйлгүй чиг инээдэг луйварчин түүнээс дээрсэх нь юу билээ. “Бид л бүрхэг мөчигөөсөө болж өөрийнхөө сэтгэл зовлого хоёроор элдэв хортон шавьжнуудыг цатгаж хар буян үйлддэг юм биш үү. Цагийн бусгаа, ухаарлын мунгинаа хоёрт есөн шидийн хорт могой үржиж цус сордог атал бид юунд ийнхүү өөр гаригаас саяхан газардсан мэт гэнэдэж ханадаггүйсэн билээ” гэсэн ухаантнуудын хөөрөлдөхөд чих сөвлөсөн өдөр надад л лав байсан даа.

Сэржээ хөгшин мэттэй сэрүүн ахуйдаа нүүр тулж яваагүй маань миний нөгөө муу “бурхангүй коммунистын” буян байжээ. Энэ нь миний өөрийнхөө ганц хяхуурхахгүй цорын ганц олзуурхал байж мэдэх юм.

“Ганц худаг” дамжин буцах замдаа тамирдаж туйлдсан, агсарч бачуурсан, хараал урсгасан үй олны царай, мөнөөх шоронд эрэмдэг болсон хүмүүсийнхээс ялгарах гэгээ надад туссангүй. Энэ нь магадгүй миний урьд төрлийн унанги гутралых ч байж болох юм. Ямарваа үзлийн эцсийн зогсоол нэг гэвэл эрхбиш өөдрөг байх нь өөрийг зогоож голоо дэвтээх үзүүр байхаас ядахгүй. Манай хашааны үүдэнд гурынхалсан халтар нохой нуухтай нүдэндээ ялаа шавуулан хэвтэхийг анзаарч түүний хувьгүй төөрөгт бус амьд яваад нь атаархах шиг болов.

* * *

Зорилгогүй зольбирон сэлгүүцэх үе сүнсэнд бас байдаг аж. Өнөөдөр тийн нисэн буун гэхээр үдэш байв. Хотын гудамжинд оочин цоочин гэрэл ёлтойн гологноно. Байшингуудын хүйтэн дээвэр авсны таг мэт агаад цонх нь нүнжиглүүлсэн ухархай мэт хүнхийн харлах нь уйтгартай. Гэрэл дамжин зайсаар Лениний хөшөөний шувууны сангастай толгойд тогтознов. Урд цагт гудамласан улаан хивсэн дээгүүр цаасан цэцэг чирсэн харуулын араас толгой ганзагалсан лагс дарга нар гашуудаж, баярлаж буйн аль нь үл мэдэгдэн гудайдаг цаг өнгөрчээ. Энэхүү нүсэр том хүрэл оросын орчимд нүүрээ зураачийн нийлүүр шиг эрээчсэн огтор банзалтай эмс хөлхөх нь мөнөөх панзны бөгснүүд бололтой. Тэд салтаан хавхаа тэвхдэн болж өгвөл ногоон түрийвчтэй харийн хөрөнгөтнүүдийг барих гэж хадаасан өсгийтэй шаахай дээрээ тогтож ядна. Зочид буудлаас өрнийн царайтай өрөвтас мэт эр тэднийг тойрон хотноосоо шөлний төлөг шилж буй мэт ажигласнаа нэгийг дэгээдэн одов. Үлдсэн хэд нь жөтөөрхөн хошуу холбож “Энэ муу пизда, хэдэн хэмхэрхий англи үгээрээ түрүй барьж дандаа урдуур дайрна”, “үхсэн хойноо ДОХ авчихаад халуундаа татвалзаж

хэвтэхийг нь харах юмсан”, “нэг хужаа цаадахыг чинь усан пайлуур гэж байх чинь билээ” гэхчлэн шивнэлдэв.

Дэлхийг донсолгосон хувьсгалч ингэж хойт амаараа хоолоо олж иддэг хоногийн гувшууруудын шүвтэрт эзгүйрэх ч гэж дээ. Түүний үгийг үхэрчлэн хивж индэр дээрээс бөөлждөг байсан улаан шавь нар нь “хар тамхины” үнэр авч хоосон чанарын зэрэглээнд төөрчээ. Миний сургууль бараадах цагт “сур сур бас дахин сур” гэсний учрыг ухалгүй хичээл давт гэсэн мэт явтал, монгол бичгийн өвгөн багш “дахин ч юу байхав. Сурсан дээрээ сур” гэсэн үг хэмээн тайлж байснаас цаашгүй бөгөөд “халзан Ленин, Хамар Сталин” гэснээсээ болж түүхийн багшид заагуур модоор чичлүүлж хоёр гартаа залтас өргөн бохиртол зогсож байснаас өөр юусан билээ. Сталин гэснээс хэмээн сахалт багшаа үгүйлтэл, новширсон хашаанд тоос хөдрөн хэвтэж байв. “Сталин таны их хайр нар шиг биднийг гийгүүлж байна” гэгчлэн орилж байсан хүний нэг нь би шүү дээ. Гүрж гуталчны хүү хэрхэн дэлхийн аав болсон тухай хоёр чихнээсээ булаг гоожтол яншуулж байсан хэрнээ нэг л мэдэхэд “орос монголыг цусанд үйсэн улаан яргачин” гэж хэлэн дээрээ цэврүү гүйтэл хараах болсон билээ. Тэгвэл нөгөө “Сталины үнэнч шавь... сод маршал...” маань их сургуулийн өмнө болхи хахиураар цутгуулжээ. Аанай л бид магтаалын үгээ үрж гүйцээд өнгөрөхөд нь “өнчирлөө, өнгөрлөө” гэж нулимсаа шавхаж байснаа нэг л өдөр “Сан бээсийн сагсуу цоохор, сахал Сталинаас нугалаа шаасан” гээд л сүнсий нь түймэрдэж хаясан. Тэгээд яалаа? дараагийн маршал... бас л гарамгай удирдагч хазгар хүргэн хадамсаад, харьд хоног тоолсон. Энэ бүх хүмүүс түүх онгичихгүй бол ой тойноос олно гэхэд хэцүү дээ. Бидэнд ийм багш нарыг бурхан юунд илгээсэн юм бол? Түүний дэргэд над шиг нэг муу намын үүрийн дарга суудаг юм биш байгаа?

Ламид бид хоёр нэгэнтээ муудалцаж билээ.

-Чи ер нь манай намын гавьяаг мэдэх үү гэхэд тэр гайхал

-Улаан тариа гэсэн юм.

-Чиний диалектик тасарсан байна гэж хэлчихээд чулуудсан үгнийхээ учрыг олж ядвал Ламид

-Таны заасан замаар таван тив давхиж, дөрвөн далай урсаж байна. Удахгүй зургаадах тив нь даган хайлна. Та айлтгүй. Таны диалетик төмөр гинжтэй болохоор тасрахгүй гэж намайг моготгосон юм. Үүнээс хойш би түүний хүзүүн дээр зөрүүд толгой байгааг анзаарч түүнийг бус өөрийгөө голонгуйрч билээ. Гэвч цагийн өнгөөр царайгаа оодож явсан хөндий мах ганц би биш ээ. Тиймээсээ ч санаандаа баглуулж амьдралын ёроолд новширч үлдсэн биз.

Намын дугуйлан дээр

-Манай нам хамгийн их хэлмэгдсэн гэж миний ярьхад нөгөө гайхал Ламид инээдээ барьж чаддаггүй шүү.

-Чи юунд үймүүлээд байгаа юм бэ.

-Та л намайг үймүүлээд байна шүү дээ. Гишүүн бус хүнийг идэвхтэн гэж бүртэгчихээд

ТОГЛООМ ХИЙХЭЭ БОЛЬ Л ДОО.

-Хэн чамтай тоглосон юм бэ.

-Танд буу нь байсан юм чинь урагшаа хойшоо буудахын ялгаа нь юу байгаа юм бэ. Арай эзэнгүй буу шүршээд амьтан хядчихсан гэх гээгүй биз дээ.

-Манай нам чамаас цаадахы нь хүмүүжүүлээд ирсэн юм шүү.

-Тийм ээ. Та ганц үнэн үг хэллээ гээд инээмсэглэн гарсан юмдаг. Тэгэхэд Бархас гарсан хойно нь

-Сэхээтний ялзрал. Энэ нөхөр бол ревзонист вирус мөн. Нийгмийн ийм бактериудыг шүүрдэж цэвэрлэе гэж уриалахад миний дотор хөх инээд сүүдэсхийвч “Намын гишүүн ийм л байх ёстой” гэж түүнийг огшоож байсан удаа бий. Энэ нь миний дотоод ертөнцөд нуугдсан аймхай эсэргүүцлийн оч төдий байж. Тэсэрч чадаагүй тэр оч, намайг цаг үетэй минь сүнсэнд хэрэлдүүлэх амьдын заяаны адангат шоглоом болгож байна.

...Автобусны зогсоолд тамхи ширхэглэж буй хаврын ингэ шиг хатингар хар авгай нэг л танил царай шиг. юусан билээ?

...Аа тийм, амралтанд нэгэнтээ ийм нэг чивчирсэн хөх хүүхэнтэй танилцаж Туулын бургас руу чирсэн бөгөөд өрөөнийхөндөө үг алдсанаас болж “Хөнхөрийн булигдаг хар” гэж хөөрхийд хоч зүүлгэсэн юмсан. Хормой сэнсхэн гэвч хүүхэд олохоос ухаангүй айж адан дээр булигдаг ааштай амьтан байсан юм. Одоо түүний царай осгортон үрчийж, зэвэр даан өтөлжээ. Ийнхүү санаагүй нэгэн нүгэл сүүдэлзэн босоход удахгүй тохиох их гэсгээлийн аймшиг намайг үргээн шавар нүхэнд минь буцаан цөлж орхих нь тэр. Дэмий тэнэж мартсан нүгэл түүснээс, товгой хэдэн газар эргэсэн нь өлзийтэй мэт. Хулчгар хүн сүнсэндээ хүртэл сөглөө байдаг ажээ.

Долоо дахь долоо хоног

Цагдаагийн газар. Байцаагч ширээн дээр тавьсан зэс халаагуурыг зааж

“Та үүнийг таних уу?

-Танихаар барах уу. Ээжийн минь эдэлж явсан эд.

-Та сүүлийн үед үүнийг хэрэглэж байсан уу?

-Талийгаачид тан буцалгаж өгдөг байсан юм.

-Тан хаанаас авсан бэ.

-Хүн өгсөн

-Хэн ...?

-Таньдаг хүн

-Нэр нь...?

-Сэржээ...

-Та хуулийн өмнө зөвхөн үнэнийг хэлэх үүрэгтэй, мэдэв үү? Норжин эмээ дуугарсангүй. Байцаагч

-Та ямар зорилгоор Хөнхөрт хор өгсөн юм бэ?

-Хор оо? Гончигсум минь! Тан хүртсэн юмсан...

Байцаагч “Сэжигтнийг оруул” гэсэн нь Сэржээ байв. Хоёр хөгшин биесээ гайхшран харсан боловч айсандаа ч юм уу, амар мэндээ мэдэлцсэнгүй. Байцаагч:

-Та нар танилууд уу гэхэд тэд бараг нэгэн зэрэг толгой дохив. Байцаагч:

-Зэс халаагуурын тундсанд шинжилгээ хийхэд хордуулах бодис болох нь тогтоогдсон. Сэжигтэн Сэржээ та Норжинд өгсөн танг хэнээс авсан бэ? Сэржээ:

-Нүгэл ч байгаа. Би эм барьдаггүй.

-Та хэн нэгний заавраар юмуу, хүсэлтээр өгсөн юм биш биз? Норжин эмээ:

-Би л аргаа барахдаа гуйсан юм хөөрхий. Байцаагч:

-Би танд асуулт тавиагүй байна гэж ширвэхэд Норжин эмээ балтасхийн дуугаа хураав. Байцаагч:

-Иргэн Сэржээ та хуулийн өмнө зөвхөн үнэнийг хэлэх үүрэгтэй. Худал мэдүүлвэл ял чинь хүндэрнэ гэдгийг сануулья. Сэржээ:

-Надад хийсэн хэрэг байхгүй. Гэмгүй хүн ял эдэлдэг юм бол тэр л биз. Энэ Норжин юугаа донгоссон юм бол доо? Байцаагч:

-Иргэн Норжин та иргэн Сэржээгээс тан залснаа батлаж байна уу? Норжин:

-Зөнөг амьтан мунгинаад л... Өөрт байснаа л өгсөн гэх гээд...

-Та түүнийг хаанаас олсон юм бэ?

-Бурхан болооч өвгөний ууж байсан юмны шавхруу л даа.

-Ямар санаатай өгсөн юм бэ?

-Эдгээх санаатай л...

-Тэгвэл санаатай өгсөн юм шив дээ.

-Тийм санаатай...

-Хүний амийг санаатайгаар хөнөөсөн хэрэгт, танд буудан алах ял онооно. Гарын үсгээ зур гэж байцаагч цаас сарвайхад Норжин сандал дээр найгаснаа гулдрэн унав.

-Муу алуурчин баашлах санаатай юу? Бос! гэж байцаагч хашгирсан боловч Норжин боссонгүй. Байцаагч түүнийг чирч гулдарсан боловч ухаан орсонгүйд “түргэн” дуудаж эмнэлэгт хүргүүлж Сэржээг урьдчилан хориход шилжүүлснээр энэ хэрэг түр хойшлов бололтой. Гэвч умарцаг чавганц нарт улаан сахиус шиг онгодолсон гүртэн байцаагч, нүгэлтийн нүдийг олж хатгах нь юу л бол. Цагдаагийнхан бүдүүлэг агсруу, балар эрэлхүү, мөчиг таамагтаа автсан, тэрслийг үзэн ядагч, муу эрийн мунхаг жанжирхалаар далайлгасан зэрлэгүүд. Тэд хуулиар нударгаа омоглож нүддэг, гутлаа хоншоорлож өшиглөдөгт нь би ясны дургүй. Тэгсэн атлаа мөрдсөний гуулин шалз ямар ч хэрэггүй паалантай тэмдгэнд хууртаж, гэдэс нь ямагт хонхолзож, ичээ түлхсэн тарвага шиг шороон царайлж явдаг нь бас өрөвдөм. Царайтай хүүхэн цагдаатай суудаггүй гэлцэхээр бол хайр нь хүйтэн халтар байдаг ч юм билүү, чааваас...

Сайнаа гэртээ ирж эх нь эзгүйд холхисхийн байтал Бархас орж ирэн халуун савтай богшсон хар цайнаас оочсоноо.

-За Сайнаа, нүгэл нүдээрээ гарч эх чинь цагдаагаас эмнэлэгт, бас нэг чавганц шоронд хүргэгдсэн гэнэ. Санаа чинь амрав уу гэж тавлав.

Сайнаа дэмий гайхан салганаж “яагаад яалаа гэж” хэмээн уйлагнахад Бархас:

-Яах юу байхав дээ. Талийгаачийн жоорыг та нар надаас нууж идэх гэж байгаад баригдсан юм биш үү.

-Би юу ч нуугаагүй, талийгаачид юу ч байхгүй гэж Сайнаа нулимстайгаа холилдон ойртвоос Бархас түүнийг заамдан “Тийм үү муу хар өлөгчин” хэмээн шалан дээр эвхрэн унатал түлхээд.

-Би чиний байрны төлөө духаа булуу болтол дарга нарын хаалга мөргөөд “нүд аньсан хүнд нүхнээс өөр хуваарьгүй гэхэд нь амь солихдоо тулаад явж байдаг. Гэтэл чи... Хав дарсан хөрөнгөтэйгөө хар нохойн хоол бол” гэж хашгираад арилав.

Аав бид хоёр амьтны арааны шүлсийг гоожуулсны төлөө, шалан дээр цагираглан үсээ үгтээж хэвтээ энэ бүсгүй үйлээ үзэх нь юутай шударга бус эндүүрэл вэ. Ухаантайгаа гайхуулах хүмүүсийн эргүүдэл өөрсдийг нь хөнөөж, алтан шошготой хорыг рашаан хэмээн гудардаг шигээ хомхойролдоо идэгдсээр сөнөх юм гэж үү. Юутай хайран заяа.

* * *

Оргил маань муу тэргээ төнхөж, тогооны бариул шиг болсон харагдана. Орос тэрэг гар салгахгүй ухуулдаг дээр бас махны авдар шиг болсон муу ямбий нь хөл дүүжилж чадахаа байх бололтой. Тэр ч аргагүй. Би түүнийг ясан шүд болтол нь хэдрэгдээд махан дөшин дээр нь өгсөн юм чинь. Ахын хийц төмрөөр зодсон тулдаа гарын бүл дааж гурван хэлхээ нь салаад ойчихгүй шүү яваа биз. Намайг анх хуучин тэрэг авахад “алтан Найдангийн хүү чөмгөө ташчихлаа” гэж байсан юм гэнэлээ. Оргүй ч юм биш. Хүн чөдрийн унаатай байж болдоггүй байсан цагт, ил байснаа гөвж байж л авсан. Тэгээд ч төмөр морь, хүний авгай хоёр зайдагнасан хүн борц болдог хойно доо.

Бэр маань халуун савтай цай хэдэн боорцог барин гарч ирэхэд хоёр балчир хүүхэд хормойноос нь зуурчээ. Энэ муу бэр маань ядуу айлын нонж охин. Олон таван үггүй, нөхрийнхөө аяар хормой өшиглөж гэр гадаа хоёроос холдож үзээгүй амьтан. Анх хадамсаж ирэхэд нь би нэг бэсрэгхэн бөгж, гархи хоёр өгснөөс өөр гар цайлгаагүй. Би ер нь тохой татуу, дотор бачуу явжээ.

Оргил маань эхнэрийн авчирсан цайнд боорцог хөвүүлж оочиж суух зуураа

-Уг нь өнөөдөр хөдлөө үү гэж бодсон чинь ус тос хоёр нь холилдоод гавлын жийрэг сэтэрчихсэн юм шиг байна.

-Хоног нь тулчихлаа. Бас шөлний юмтай очихгүй бол нөгөө хоёр маань юу л байв гэж дээ.

-Тиймээ. Төлөгний нүд хийсэн л дээ. Хүн гуйж хорлуулахаас даа. Хоног дотор нь гол таслаад яахав.

-Муусайн хүүхдүүд туурай нь мултарна гэдэг л болоод байна. Хотын захаар орвол хэд хоног чирчихээр хямд төсөр юм хараарай.

-Харин тиймээ. Олдлоо гэхэд тоолдог дээрээ тулахаар л толгой руу татах байх даа. Чи ч түрийтэй юмгүй...

-Би яахав ээ. Онгорхой цоорхойгоо оёж лэвшээд онд орчихож болох байлгүй дээ.

-Лэвшинэ гэв үү. Чи ээжийн үгийг аваад үлджээ. Би хувцсанд хадаргаатай хүүхэд байсан юм байх. Ээж минь “аль вэ, ээж нь лэвшээд өгье” л гэдэгсэн. Айлын ганц гээд идэх урах хоёрыг л хийж байсан санагддаг юм. Эцгийгээ сайн өргөж чадсангүй. Хар элэгтэй улсын гарт зүдэрсэн л байх даа зайлуул.

-Сайнаа залуудаж, халгаад байгаа биз. Харин Норжин эмээ зовлон мэдэх хүн гар нь зөөлөн, эрхиш тэвхэрлэж байгаа л даа.

-За да мэдэхгүй. Уг нь манай хамар хашаанд морь тэрэгчин өвгөн байсан юм. Хашаагаа зараад нүүсэн гэдэг юм. Тэгээд л Норжин эмээ авсан бололтой юм билээ. Газрын хаанаас ч ирээд наалдчихсан юм билээ мэдэхгүй. Аав минь ганцаардахдаа аяга цайгаа хувааж уух гэсэн юм болов уу даа.

-Тийм л ерөөлтэй байж л дээ.

-Харин л дээ. Хараал, ерөөл хоёрын аль нь байсныг яаж мэдэх вэ. Алтан савыг нь нээлгэх гэж нэг айлд очсон. Үзмэрч, төлөгч гэх шиг л юм хэлсэн. Би ч гадаа нь зогсож байгаад буцсан. Ямар ч учиртай улсууд юм бэ. Энэ муу тэргэнд хоргодсон ч гэх шиг. Аав надад өгсөн юм чинь би юу гэж тэдний идэш болгох вэ гээд дуугай л асаагаад хөдөлчихсөн.

-Норжин эмээгээс асуугаагүй юу.

-Үгүй ээ. Хэнээс нь гарсан үг юм бэ гэж дотор жихүүрхээд... Ер нь дотор гаднагүй л эрээн улс харагдаад байсан. Тэгэхдээ өнгөрсөн юмны хойноос иш мухаргүй юм яриад, яахав дээ гэхэд эхнэр нь тийм дээ гэсэн шиг аяганд нь цай хийв.

Хашаан доторх өмгөр саравчинд тугал уяатай нь ганц үнээ шувтарч цайгаа бүгийлгэдэг бололтой. Өөр нүдэнд өртөх юмгүй. Байшин нь шавар тагзархуу агаад гурван хүүхэдтэйгээ чихэлдээд улам ч эргэх зайгүй болжээ. Гар үйлдвэрийн хоёр авдар, эрэгнэг, “Эх орон” хүлээн авагч гэсхийгээд тавилга төдийхөн. Хүүхдийн гутал хувцас хулдаас дэвссэн шалан дээр ундуй сундуйхан харагдана. Хүү минь ядуу гучуухан л яваа юм байна. Энэ бүхэн бас л миний нүгэл. Хүний үрийг нялх үстэйд аваад загасны махны завсар гаргасан минь юутай гутамшиг. Хөнхөр гэдэг хүн ухаантай мунхаг, хараатай харалган явжээ. Эрлэг намайг нохой болгоод эргүүлж хөөсөн ч идүүртэй угаадсаа, золбинтой хуваах л юмсан. Би Дарханд удаан тогтож чадсангүй.

Тэнд амьд хүн бүү хэл сүнс хоргодоход хэцүү бололтой. Хэдэн жилийн тэртээ газрын диваажин гэж шаагиж байсан цуу дуулиан цуурай мэт замхарчээ. Миний л мэдэхээр бид нэг ч юмыг гүйцэд хийсэнгүй. Туг лоозон, тууз хайч болж баахан үймж, нэг сайн архидаад орхидог нь үнэн. Ламид инженер нэг хурал дээр “хугас хүн”-ий бодол, ажил, боловсрол, сэтгэл цөм хугас байдаг. Ийм хүмүүс бидний дунд байна гэж Сэтэв, бид хоёрыг дайруулах шиг болсон. Тэгэхэд “хугас нь намын гадаа байдаг юм” гэж цэцэрхэж байсан. Ламид үнэн үг хэлжээ. Би өөрөө хугас бас хугасуудын дунд элэгджээ. Ганц тохиох насанд үүнээс илүү гарз юу байх вэ.

Чойдор хадаас авагч царил, сүх авчирч, миний байшингийн шалыг ховхлохыг би гойд шохоорхов. Зэвэрсэн хадаас ёолох лугаа чахарч, хуучин шинэс шалыг сэлтлэх, хадаасны тав сохрох тоолон Чойдор “цус”, “нөж” гэсэн хараалтай хөлс урсгана. Шалан дор дэвссэн нүүрсний үнс бургин хамарт нь ороход үе үе нүдээ сугартал найтаана. Тэрвээр банз сугалахын тоогоор доод газрыг нь царилаар түншиж буй нь үзмэрч, мэргэч хэмээгчдийн дэргэд үнэхээр суут мөрдөгч ажаам. Тэрвээр бүх юмыг гайхалтай тооцжээ. Нэгэн цагт тэрвээр надаас гуйж авсан зэс халаагуурыг эд мөрийн баримт болгон, Сэржээ, Норжин эмээ хоёрыг мөрөөс зайлуулж хударга гаргаад, байшинг засварлаж үнэд хүргэж өгөх нэрээр ачлалт хүн болж, ийнхүү азаа шодох нь биширмээр. Мулгуу буюу хөвсөргөн амьтан ийм зүйл бодож олох бүү хэл зүүдлэхгүй. Чойдорыг би дотуур тамиртай хэмээн цэрвэж асан нь түүний сийрэгхэн ухааныг нэвтэлж эс танисных байж болох юм.

Чойдор хашааны хаалгыг дотроос нь оньсолсон мөртөө цонхоор үе үе хялвалзах нь хэн нэгэн саваагүйрхэж хэрэгт дурлахаас болгоомжилж буй нь илт.

Нар шингэх хэрд тэрвээр миний ор байсны тус газрын хэдэн банзыг ховхлож түншсээр царилны үзүүрт чулуу торохуйд үнс бужигнуулах онгичвоос хуучны гурван ширхэг ховилон хөх тоосго харагдав. Тэрвээр тэдгээрийг царилаар гөнжин авахад үзүүр төө орчим хар ваар гарч ирэх нь тэр. Ваарны амыг лац урсган бөхөлжээ. Чойдорын царайд ер бусын гэрэл бутрасхийж, хормойгоо дэвсэн сайхь ваарыг тонгойлговоос хэдэн ширхэг ёншгойт асгарахуйд бондгосхийн цочисноо, шалавхан буцааж хийн ваарыг таглаж үүргэвчиндээ шургуулав. Тэрвээр хормойд бутран унасан лацны өөдсийг алчууртаа боож халааслахдаа гар нь салганан чичирч байна. Арга ч үгүй биз. эр хүн сул олзон дээр унахдаа аймшиг, баяр хоёрын атганд барьц алддаг байж болох юм.

Чойдор хөлсөө шувтран арчсанаа бяцхан зоорины ховилон тоосгонуудыг үүргэвчдээ хийж нүхийг сайтар үнсээр чигжин дээр нь шалны банз хааш яашхин овоолов. Байшин хашааг цоожлов. Гэвч тэр гэр рүүгээ шууд явсангүй ногоон нуурт ирж хүний нүд хариулан хэдэн тоосгоо хол зайтайгаар ус руу сэмээрхэн цөлж орхив. Бас ваараа суллан шороо чулуу хийж усны гадарга дээгүүр чулуудвал, төдөлгүй пор пор гэсэн чимээ өгч ус руу живэхэд санаа нь амрав боллолтой.

Аав минь амьсгалын тоо шивхнэх үедээ “Миний хүү аавынхаа орыг эзэгнээрэй. Энэ орны гол хэрд шалан дор нэг муу мухар хар ваар бий. Түүн дотор хүний нүд хуурах зай төдий юм бий. Энэ муу байшин цагтаа содон харагдаж хүний нүд унагаж байсан эд. Тэгээд ч нөгөө нүгэлт газрынхан намайг хөрөнгөө дор нь зoorилсон гэж сэжиглэснийг гадарлаад юу юугүй онгичоод унавал хоосон байхаар хомгой долоог гэж хийсэн юм. Энэ засаг хүний юмыг улайм цайм дээрэмдэнэ л гэж бод. Өвөг эцгий маань феодал гэж цөлмөөд аавын хэдэн малыг нэгдэлд булаах үед авдрандаа бид хагас хугасыг хийсэн, нэг л өдөр чамайг жижиг хөрөнгөтөн ч юмуу эсэргүү болгож буу тулгаад хувхайлна. Цаадуултайгаа зүс нийлсэн шуу яв. Харин итгэж үг алдаж болохгүй, Чингэлтэй хайрханы нөгөө газрыг жилд нэг эргэж ууландаа дээж өргөж байгаарай. Ганцхан чи бид хоёр амны хишгээ хэлтэлж нуусан юм биш. Амьтан хүн, бурхан тахил, жаал зугаа хатуу юмаа уул хаданд зайцуулж үрэгдэх нь үрэгдэж үлдэх нь үлдсэн, Өөрийнхөө юмыг хулгайлж зулгаадаг цагт төрсөн заяа хойно яая гэхэв” гэж билээ.

Бүрэнхийд ямар нэгэн юмнаас дутаах мэт бүдчин яваа Чойдор олзны сэжүүр амхарсан ч миний муу байшингийн шалны дор газрыг орвонгоор нь эргүүлж, зовлогоо зодоод хоосон хоцрохоо хэрхэн мэдэх билээ. Чойдор хэдийвээр овтой ч аав бид хоёрын мөнөөх наян нэгэн алхам газар Чингэлтэйн хярд яргаасан “хатуу юмны” шавхрууг даанч шиншлэж чадахгүй. Энэ бол түүний шуналын сүйрэл болно. Ер хүний араншин, заяа иймхэн аж. Харин тэрвээр миний хойноос очих цагт лав л шар Самдан бид хоёрын амь нэхэгдэнэ. Бид хоёр тамд нүүрэлдэх ч юм билүү.

Бурхан анх хүнийг тэнгэрлиг ариунаар бүтээсэн атал, нөгөө гайхал нь орчлонгийн бурангуйд сэтгэл үйлийн бузар буглахуйд арга буюу эгүүлэн татах болсон буй за. Ийнхүү хүнд насны хугацаа өгөөгүй бол хоёр хөлтэй араатан болж биенээ хөнөөсөөр үнс хийссэн үхмэл гариг үлдэх байсан юм болов уу. Хүмүүсийн орчлон цус, нулимсанд буцалж буй нь юутай гутамшиг. Үүний үүдэл нь хорвоод хожиж амьдрах гэсэн мөнөөх цадиггүй шунал, атаархал, сэтгэлийн цэвдэл гэж би тайлна. Гүн ухаанчид бурхны таалал байгалийн амьтны жам, оюун санааны сүлжээнд төөрч гүехэн бодолтнууд сайн хааны ид шидэнд эргүүтсээр тусыг олсон нь үгүй. Тийн ахул хамгийн шударга цээрлэл буюу тэнгэрлиг ариусалыг үхлийн хойморт эрэхээр би амьдралын дөрөөг мултласан ч юмсан уу.

Өөрийн оромжинд хоргодол үгүй болсон би хадмыхаар эргэлдэв. Сайнаа ажлаас ирж буй бололтой. Түүний зүс гундаж нүд нь хиртжээ. Уй гашуу, арга мухардал хоёрын алин болохыг мэдэхгүй. Тэрвээр үлэмжийн чанар биш чиг, эр хүний эгдүү ирвээж нүглийн гижиг хүргэсэн амьтан сан. Би түүний ийм унхиагүй, өнгө гандмал байсныг ер үзээгүй. Эм хүн эр нөхрийн дэргэд сэхлүүн оодруу ч элбэрэл чавцах цагт дэндүү хэврэгхэн гэдэг. Сайнаа юуны ч юм бэ түгшил доноголзолд хямарч байж ядсанаа дэвгрийн тал цаасан дээр ийн бичиж эхлэв. “Бархас аа! Би чамд ... гэснээ дарж... Би чамгүй яаж амьд явах юм бэ. Би чамаас юу ч нуугаагүй, юу ч харамлаагүй. Би чамд цорын ганц бие сэтгэлээ өгсөн. Гэтэл би чамд голоо харалтал гомдлоо. Чи намайг дахиад л “бэрд...эр хүнтэй биш, эд хөрөнгөтэйгөө нөгчсөн банзал. Чи тэр үхээрийн бузар шүглэсэн өвөндөө өт хорхой болоод илжирч хэвт. Чи хүүр тэврэхээс, хүн тэврэх заяагүй амьтан...Өөр юу ч гэлээ...Түүний нулимс үг бүхэн дээр унаж байх шиг харагдана. Сайнаа цааш нь бичих тэнхэл байсангүй. Цаасаа базаж пийшингийн ам руу шидчихээд дэрэндээ нүүрээ шааж тунтран унав. Хэн нэгэн түүнийг аяархан татахад цочин харвал Чойдор байсанд аажуухан босч бударч гөлөрсөн нүдээр ширтсэнээ энгэрт нь шигдэн тэврэн авав. Чойдор түүний даахирсан үсгийг эв хавгүйхэн илж

-Сайнаа минь битгий уйл. Буцсан хүний сүнсийг хар нулимсаар хөөдөггүй юм. Би сая Ганданд хурал айлтгаад ирлээ. Өнөөдөр дөчин ес хоног нь шүү дээ гэхэд Сайнаа сая сэхээ оров бололтой.

-Нээрэн дөчин ес хоног нь... гээд “яхах вэ” гэсэн харцаар түүнээс хариу нэхэхэд Чойдор хийдийн арц гарган унгатгаж амандаа ямар нэгэн юм гөвтнөснөө, Сайнааг бэлхүүсээр нь гурав тойруулан ариулав. Үүргэвчээ ухаж гөөхий, мөөхий, бас нэг шил архи гаргаж ширээн дээр тавиад

-Хоюулаа хоногий нь хураачихъя. Хойд мөрийг нь хуврагууд олгож байгаа хойно бид нар ёслоод л болох нь тэр гэж залбираад, архи ханзлаж хундаганд дээжлэн Сайнаад

-Гадаа гараад явсан зүг рүү нь өрөгчих гэв. Сайнааг орж ирэхэд Чойдор архинаас хоёр шаазанд дундхан хийж “сайн төрлийг олох болтугай” хэмээн Сайнаад нэгий нь сарвайв. Сайнаа халширсхийснээ буян бодов бололтой балгачихаад, тэр дорхноо царай нь улаа бутарч, бие нь тавирч байгаа бололтой. Чойдор

-Сайн хүн үлдсэндээ өлзийгөө өгдөг юм. Сэтгэлээ тэгшилж маргаашаа бодох нь орчлонгийн жам...

-Талийгаачийн минь найз нөхдөөс та л тус болох юм. Би гэдэг эргүү төлөг шиг зүг чиггүй амьтан. Ядахдаа ээжийн хойноос...

-Зовох хэрэггүй. Гэм байхгүй болохоор сүнс нь цайрахгүй яахав. Чойдор архинаас дахин аягалахад Сайнаа “согтчих байхаа” гэсэн боловч цааргалсангүй.

-Ээж минь ямар ч буруугүй шүү дээ, тийм биз дээ.

-Тиймээ. Тэр Сэржээ будилж буруу юм өгөх хүн биш. Өөр хүн амьтнаас гуйсан биз. Харин тэр муу зэс халаагуурыг ямар лүд нь аваачаад цагдаагийнханд өгчихдөг байна гэж бодлогошрох нь надад санасандаа хүрсэн хүний төрхтэй байсан бол Сайнаад авралын бурхан мэт харагдсан бололтой.

-Таны ачийг би насаараа санаж явна гэснээ ухасхийн түүний хацрыг шовхийтэл үнсэв. Чойдор

-Талийгаачийн байшинг би жаахан гар хүрээд эзэнд нь өгчихнө. Хүнээ ч олсон. Чамтай өртөг мөнгий нь хэлцээд өгнө гэсэн. Түүнийг аваад та хоёр амин зуулгадаа хэрэглэнэ биз.

-Хашаа авахад зээлсэн мөнгөө өгөлгүй яахав. Зөндөө удаачихлаа.

-Хагаслаж хугаслана биз. Ах нь өнөө маргаашдаа болох биз. Та нар л хэрэглэ. Надад буян санахад л дээд өглөг.

-Зовох цагт л хүний сайн нь дэргэд байдаг юм байна. Тэгэхэд Бархасын байгаа царайг... Намайг газар доогуур ортол харааж хэмхлэх шахсан. Дотор нь тогооны хөө чихээстэй амьтан байсныг мэдсэнгүй.

-Бархас ханилгаа муутай хүн. Гэхдээ хурал болж Сэтэв, Бархас бид халагдсан. Жагай хүүхэн орлоод чиний гачигдахын өрөгдлөөр ирсэн байранд ороод угааж арчиж ууж идсэн гэнэ билээ. Хар Сэтэв хашир толгой хойно. Ичээтэй болж байхгүй юу. Харин муу улаан авгай нь хамт оччихсон ерөөл хэлэгчээ болж суусан гэнэлээ. Сэтэвийн сүүдрийг Гаапэл харж, сүүгий нь Жагай хөхөж л дээ. хэ, хэ, хэ

Сайнаа “адгийн шаарнууд” гэснээ архи аягалж Чойдорт сарвайгаад өөрөө хөнтөрч орхив. Сайнаагийн нүүр чинэрэн, согтож буйг анхаарсан Чойдор

-Би чамаас нэг юм асуух уу.

-Асуу л даа. Асуугаач.

-Чи залуу хүн. Зовлонд үнгэлдэлгүй өнгө засч, хор шарандаа өөрийгөө өөд татаж нүдээ цухуйтал гоёхыг бод

“Та намайг мисс болгоод чимээд өг л дөө

-Мисс болоход чамд сайхан бие зүс царай байна. Өмсөх зүүх гэвэл өвлөж авсан буян байна.

-Өмхөрсөн хашаа байшин уу?

-Талийгаачийн буян эзэгнэсэн хүн. Чамд юм үлдээлгүй буцах хүн биш дээ.

-Байгаа л юмаа үлдээсэн.

-Тэгвэл хүүдээ өгч л дээ.

-Тэр муу Оргилд юу ч байхгүй.

-Хаа нэг газар л байгаа даа.

-Та мэддэг юм бол олоод аваач...

-Чааваас даа. Таарсан ч хүндээ буян амлаж дээ...

Чойдор Сайнааг тандаж үг алдуулах гэсэн боловч мухардаж

-Харанхуй болчихлоо. Би ч байдгийнхаа баруун хаяаг бараадахаас даа гэхэд Сайнаа хэл нь тультран гуйвалж

-Би Бархасаас хариугаа авмаар байна. Яаж авах вэ? Та хэлээд аль гэж цорвогонов. Чойдор толгой сэгсрэн дүйвүүлж

-Овоо хараа гурван бие зэрэгцэхгүй бол сум тэнээд хоосон хоцордог юм. Яарвал даарна. Талийгаачийн хоногийг хураачихлаа. Одоо чи бэлбэсэн авгай биш бэр хатан болох нь энэ. Алт сувдаа амаараа гартал эдлээд урдуур нь улаан үнэг шиг сунсалз. Цаадах чинь өнгө харвал өвдгөө шалбалаад өмнө чинь мөлхөнө. Тэгэхэд нь гуйсан ам руу нь шээчих.

-Мөр нь улалзаж үлдсэн би өөрийгөө бүрэх юмтай гэж та яаж хэлж чадаж байнаа.

-Алтан Найдан гуайн жоорыг амьтнаас хармална уу гэхээс өөрөөсөө битгий гар тат.

-Бархас, та хоёр яагаад намайг баян бирд гээд байгаа юм бэ. Байхгүй... байхгүй... мэдэв үү хэмээн Сайнаа шал дэвсэн тультчихад Чойдор үг алдуулж чадахгүйдээ цөхөрсөн бололтой худлаа инээж:

-Үнэн үг хэлж байхад нохой хуцахын дайтай санадаг хүнийг хөгшин төгцөг би яалтай билээ.

Хөрөнгө тэвэрсэн гон бие чавганц болох гээд байгаа бол үйлээ дагана л биз... Буяндаа эзэн болохгүй бол нүд аньсан хойноо сүнс нь хоргодож буг болдог юм гэнэлээ. Базарваань хумпад хэмээн ширвээд хялбалзан зайлвай.

Сайнаа хөдөөлүүлэхэд хэрэглэсэн жаазтай зургийг авч халуун сав түшүүлж тавиад гөлрөн сууснаа:

-Хөнхөөлөй минь, чи хаана явна вэ. Сэржээ жээжээ чамайг бурхны оронд явууллаа гэсэн. Үнэн үү? Сайхан юм уу? Өвөлгүй зунаараа, өмсөх идэх өөрийн зоргоор юм гэл үү? Өдийд чи бүх бурхантай үй зайгүй танилцаа бизээ. Чи хамгийн том бурханд аминчилж муу Сайнаагаа харж үз гэж гуйгаач дээ. Муу Сайнаа чинь ёстой золбин нохой шиг зовж явна. Ээж минь өөд болсон болохоор намайг гэх хүн энэ хорвоод үлдсэнгүй. Бархас, Чойдор хоёр намайг баян хүний өвийг хаана чи хав дарсан бэ гэж нэхэж үйлийг минь үзэхийг яана. Хаа очиж муу Чойдор чинь тус болж байшингий чинь аялуулах гэж байгаад шатаж үхсэн. Архинаас л болсон бололтой юм билээ. Бархас бол ёстой адгийн шаар. Хөрөнгө хогшил нуусан газраа хэл гэж миний махыг зулгаасан. Тэгээд нөгөө Жагаа хүүхэнтэй нөгцөж ашгүй нэг далд орсон. Та нар л худлаа сэрддэг байснаас бус Бархас, Жагай хоёр үгсэж цаад муу хар өвгөнийг чинь гол гаргаж байсан юм билээ.

Хөнхөөлөй! Чи үнэхээр алтан Найдан аавынхаа буянд эзэн суусан юм бол надад яагаад юу ч хялайлгаагүй юм бэ.

Би сайн муу ч гэсэн чиний өвөрт үсээ ширэлдүүлж хэвтсэн хань чинь шүү дээ. Залуу нас бие, сэтгэлээ би харамласан гэж үү. Чи намайг дураараа эдэлсэн биш бил үү. Ямар сайхан юм бэ гэж янцаглаж яраглаад хүзүү хоолойг минь хүрэн няц болтол сорж хөх дэлэнг минь базаж үлгэж орь дуу тавьж чи галзууртлаа жаргасан даа. Харин сүүлдээ чи намайг хүлээлгүй дэндүү хурдан болдог байсан ч би чамайг гомдоохгүй гэсэндээ худлаа орилж тэнхээ тамир чинь тасарсан. Би чамаас салах гэсэндээ бус. Нас залуу эм хүн болохоор өөрийгөө аргалах гэж үе тэнгийнхэнтэйгээ хавьтдаг байсан нь үнэн. Ганц би ч биш, эр эмгүй л энгэр зөрдөг юм байх чинь билээ. Тэглээ гээд хонзогnoj юу ч үлдээгээгүй юм уу? Үнэхээр чамд ханьтайгаа хуваах буурлын буян байгаагүй юм уу? Чойдор яагаад миний толгойноос, Бархас яагаад миний бөгснөөс үг алдуулах гээд байсан юм бэ. Тэд яагаад намайг улайхгүй, хамаг юмаа хав дарсан харамч гэж хардаж сэрдээд байсан юм бэ. Одоо би гуйлгачин, бүр хувхай гуйлгачин! Надад юу ч байхгүй. Чи минь даанч яав даа. Өөрөө эргэж ирэхгүй явах гэж байгаагаа над хэлээд байсан мөртөө идэх хоолтой өмсөх зүүхтэй орхиж болсонгүй юу.

Хөнхөөлэй минь ээ. Надад ямар ч хар буруу санаа байгаагүй. Чойдор, Сэржээ, Жээжээ хоёр л ээжийн минь толгойг эргүүлж танай хамар хашаанд буулгасан. Тэгээд намайг заяаны хань, ерөөлтэй нөхөр чинь гэсээр байгаад чиний өвөрт хийчихсэн юм. Эхлээд би муугаа мэдэхгүй хөгшин хүнтэй суухгүй гэж чадлаараа ярдагласан. Тэгсээр байхад намайг цаад хөгшнөө ойчихоор чи алтан Найдангийн хишиг хүртэж насаар барахгүй хөрөнгөн дээр үлдэхээ бод. тэр цагт чамд тэнгийн юм олдно гэж аашилж нэг аргадаж нэг үзсээр байгаад тэд санасандаа хүрсэн. Би ч сүүлдээ эм хүнийг эрхэндээ оруулж чаддаг чиний амтанд орсон л доо. Эр хүнтэй урд нь ойртож үзээгүй гэж худлаа яриад яахав. Чинийх шиг миний цоожинд чихэлдэж орж жаргаадаг тийм сайхан түлхүүртэй би таарч байгаагүй болохоор, өв хогшилд эзэн суухаа мартаад өвөрт чинь шургахыг л боддог болсон. Тэгэхэд чи яагаад намайг улаан нүцгэн

гудамжинд хаясан юм бэ. Яагаад... гэж үглэснээ үхсэн хүнээс үг дуулахгүйгээ мэдсэн бололтой миний зургийг түрүүлэг нь харуулж тавиад үсээ үгтээн цохиртон уйлвай. Түүнийг харахад үнэхээр өрөвдөм чиг сүнсэнд ямар шаналах зүрх, шархирах мах, янгинах яс байх биш дээ.

Энэхэн агшинд эмнэлэгт буй Норжин эмээг эргэвээс тэрвээр аль хэдийнээ хүүрийн зооринд биенээс сүнсээ хөөсөн аж.

Эргэн тойрон ээдэн бүүдийх нь миний ангижралын тохио бололтой. Би хорвоогоос хамгийн эцсийн удаа хагацах хоромд жигшим, тохуурхам болохыг мэдэрч үл үзэгдэх од үл үзэгдэн харвах лугаа элчилгүй орон зай руу цахилан алсарвай.

Хөнхөр оршиж эс оршиж асан явдлыг үгүйсгэл үл үгүйсгэлийн тэрслийн завсарт энэ болон хойд насны тээнэгэлзэлд хохирсон хувь заяаныхаа өчлөөр оддын орчилд шившин орхиж буй санаатай юм. Энэ маань өчүүхэн “би” гээ хэт хэрэгшээсэндээ бус орчлонгийн үл тайлагдах үй түмэн нууцын нэгээхэн боловч ончрооноос машид гэгээрсэн хүмүүн төрөлхтөн учиг татах цагт өртөх юуны магад хэмээсэн горьдол, цөхөрсөн итгэл сохорсон сүсэг, бодлын богшоол, явган бясалгалын зангилаа гэж болно. Бие цогцос генийн удамшилд, сэтгэлийн эрчим хүч огторгуйн хязгаар гярхаггүйн мэдээлэлийн ой санамжид үлдэх ёстой гэсэн миний эцсийн таамнал нь төөрөл ч юм билүү?

Ямар ч атугай би дэлхийн дээвэрт сүлжилдэн буй цаглашгүй үелзэлэлээр хойч үеийн хэн нэгэнд хэзээ нэгэн цагт шүүрүүлэхээр оюуны шидмэс шидэж, хорвоогоос уйдан басхүү хоргодон одов оо.

Эл бүхэн амьдралын нулимс үхлийн инээмсэглэл байлаа.

“ТӨӨРГИЙН ТӨӨРӨЛ” БУЮУ ТООРОЙН ТЭМДЭГЛЭЛ

Нэгдүгээр тэмдэглэл

Энэ явдлын тухай би тэмдэглэл хөтлөхөөр шийдсэн юм.

Намайг Бархасын Тоорой гэдэг. Яг өнөөдөр би Шар хадны эмнэлэгийн өрөөнд албадан хүргүүлээд сууж байна. Энэ эмнэлэгийн гоё нэр нь сэтгэл мэдрэлийн, олныхоор бол галзуугийн больниц. Адангатай зарим нь сагсуугийн, сэргэлэнгийн гэх мэтээр даажигнах нь ч бий. Ямар ч атугай “аль өвчнийг сайхан гэх вэ. Галзуу нь арай цовоо юм уу даа” гэсэн энэ үг бол гарцгүй болсон хүний цөхрөл. Энэ газар эрүүл өвчтэйн завсар, эмнэлэг шорон хоёрын дунд тарчлах азгүй хүмүүсийн амьдын шаналгаа гэмээр надад санагдсан юм. Миний энэхүү тэмдэглэл, шинжлэх ухаан уран зохиолын аль нь ч биш. Харин сэжигтний хөгтэй явдал гэж болох юм.

Миний өөдөөс харж суугаа бульдог нохой мэт жавж нь унжсан хөх эрийг Дагва гэх боловч өвчтөнүүд “дарваан доовтор” гэнэ. Эндхийн эмч нар бусдыг бодвол гар цайлгал бараг үгүй тул цалингийн залгаасанд сунгаастай ядуу даржин даг. Хотод орон сууцгүй нь хавийн гэр хороололд шавар тагз юм уу гэрт суудаг гэлцэнэ. Дарваан доовтор тэдний нэг агаад ширхэг бүдүүн, эрваадуухан эр бололтой. Түүний хүзүүнд тохоостой чагнуур надад яагаад ч юм бэ нохойн хүзүүвч шиг харагдсан юм. Тэрвээр “өвчний түүх” гэсэн дэвтэр гарган “остоор нээнээ” гэж бувгнаснаа:

-Овог нэр?

-Хэнтэй нь ярих юм бэ.

-Юу гэсэн үг вэ?

-Найдангийн Хөнхөртэй юу, Бархасын Тооройтой юу?

-Чи чинь ганц л хүн биш үү.

-Тийм бас үгүй. Сүнс, сүг хоёр гэх үү дээ.

-Яруухан донгоддог шувуу юм даа.

-Үүнээс л үхсэн амьдын хэрүүл гарна даа.

-Эмнэлэгийн дэг, эмчийн болон өвчтөний ёс суртахуун гэж бий. Бага шиг адраарай. Өвчний ямар шинж тэмдэг өөрт мэдэгдэж байгаа, хэрхэн үүссэн тухай ярь. Энэ бол чиний үүрэг... гэж шавдуулв. Би ч “энэ хүнтэй хянгар хуурай” болохнээ гэж дотроо товлов. Үнэхээр ч тийм болсон юм. Бидний яриа тэр чигтээ толхилцоон байлаа.

Эмч:

-Ямар зовиур байна вэ?

-Та нарт “хүчиндүүлж” тариа шаалгавал бэрсүүжиж хөндүүрлэх биз.

-Урд насаа мэддэг гэл үү?

-Там тум...

-Ха, ха, ха.

-Танд бол инээд надад нулимс.

-Тэр яахав. Би чамтай хүн ёсоор ярилцах болно.

-Та намайг нохой шиг архирлаа гэх биз. Миний хөлийг тоол. Хоёр байгаа биз. Тооройд ярих юм байхгүй. Харин Хөнхөрт бол...

-Ойлголоо. Хөнхөрийн тухай Тооройн юу ярихыг сонсьё.

-Та намайг галзуу солиотой гэж дөрвөн хананд хашаад антибиотекоор бөмбөгдөж, алуурын тариагаар сэглэхгүй гэсэн ам өчиг өгвөл ярьж болох л юм.

-Тангараглая! Хөнхөрийн сүнс гэдгээ хэзээ мэдсэн вэ?

-Ухаан орсон үеэс...

-Урд насаа шууд хараад л...

-Үгүй ээ. Хэсэг бусаг юм үзэгдсэн. Одоо ч тийм.

-Тэгвэл Хөнхөр, сүнс, та гурвыг би яаж ялгах болж байна вэ?

-Тэнд сүнсийг биежүүлээд шүүдэг болохоор нэгдмэл мөртөө салангид гэж болно

-Толгой эргүүлээд...

-Харин тиймээ. Хар ухаанаар хэлэхэд сүнсний мөнхийн хэлхээнд би бас оршиж, хувилж, мэдээлэл авч байжээ гэсэн үг.

Дарваан доовгор ярианд шүлэнгэтэж буй бололтой, манайхны “дүрдэг плитка” буюу “цахилгаан бухуур” хэмээх цай буцалгагч залгаад

-Эр улс байна даа хөө. Эмээлээ авч морио тавьчихаад хоюулаа тохмын хөлс хатгал хуучилнаа гээд ашлан суувай.

Бид хоёр харц мөргөлдүүлж нэг хэсэг дуугай гөлрөн хүлгэлзэв. Онгичих гэж байгаа нь ам ухтал жимийх, миний адармаа хаачихав дээ. Тэгээд ч хийрхэл мэтийг шинжлэх арга мухар тул эмч нар өвчтөнийхөө үгээр дөрөөлж өнгийж харах нь ёс.

Эмчийн тэвчээр алдуурав бололтой.

-Хөнхөр болно уу, Тоорой болно уу надад ялгаагүй. Чи үзсэн харснаа нэгд нэгэнгүй яринаа хө. Чиний ярьдгийг там тум сонссон боловч өөрийнхөө хоёр чихээр дуулмаар байна. Ичиж зовох хэрэггүй. Эмчийн чинь толгой хүний үг чихээд амы нь боочихдог хүүдий. Ганц ч үг салхинд алдахгүй.

-Ярих яах вэ. Та миний яриаг хооронд нь хутгаад улаан галзуу гэж гүтгээд нөгөө үхлээ хүлээсэн үүлгэрүүд дунд чулуудчихгүй биз.

-Хутгана гэдэг чинь юу гэсэн үг вэ.

-Хөнхөр, Тоорой хоёрыг хөл толгой салгаж бод гэсэн үг.

-Чи өөрөө самуурахгүй бол, би хольчихгүйг бодъё. За ингээд эхлэх үү.

Би цааргалсангүй.

-Би бол Бархасын Тоорой. Эцэг минь эр чадлаараа ходоодоо баярлуулаг гэж ус нутгаа урагсаж шилийн сайн эрийн нэр өгсөн боловч “амьтан хүн амны салиа хивээд байвал, талын хулгайч биш говийн зандан тоорой мод гэж бай” гэсэн юм.

Ээжийг минь Жагай гэнэ. “Арван цагаан” хэмээх буяны компанийн захирал. Аав тэнд менежер. Бурхан болоочдын хойт мөрийн буян залгуулж авс хийдэг хувийн хугас үйлдвэртэй л дээ. Аав авсаа “шогол” гэнэ. Суман хүрэн өнгөтэй алтарсан бариултай хайрцаг нь эзний эрэлгүй гүйлгээтэй ч хүмүүс үл бэлэгшээнэ.

Би чинь энэ айлын хүү Тоорой боловч нидэртээ энэ нэрэнд шүглэсэн Хөнхөр юм. Гайхмаар байгаа биз. Тийм шүү. Би өөрийн хойт бус урд насаа бүрэг бараг мэднэ. Үүнээс л хүмүүс надад итгэдэггүй, галзуу Тоорой, гажиг сэнтэг гэдэг. Та ч тэгж л бодож байгаа. Гэвч би хүмүүст гомдохоосоо илүү өрөвддөг гэх үү дээ. Өмнөх явдлаа мэддэг над мэт нь нүгэлт орчлонд нүдний гэм учир арга ч үгүй биз. Харин миний аав Бархас намайг “Бурхны бүрэлваа”, “Суут ухаантан”, “Тэнгэрийн зүүдний хүн” гэхчлэн огшооно. Тэгвэл ээж тоохгүй. Эцгийгээ дууриасан “Худалчийн хувилгаан” гэж тохуурхна. Аав түүний хариуд “Номгүй улаан лус чи юугаа мэддэг юм бэ. Энэ чинь хүүхэн хутагтын хойд дүр. Улааны суртлаар угжуулсан буруу номтнууд нохойн хэвтэрт хаяж байгаа болохоос биш, алтан сэнтийд заларч байх ёстой дээрхийн гэгээн. Монголын үйл лайг нимгэлэх гэж бурангуйн оронд буян түдсэн нь энэ” гээд л урсгана. Гэвч би бол хутагт хувилгаан нь биш, зүгээр л Бархас гэдэг айлын голомтод заагдсан сүнс. Тооройн адсага хөдөрсөн Хөнхөр гэж бод. Та нүдээ духандаа зоох гэж огшоогоод хэрэггүй. Урд нас минь Найдангийн Хөнхөр болохоос бус энэ яваа маань Тоорой. Тооройн хорвоод хоргодох нарны зай, насны хэмжил хаа хүрч харлахыг би мэдэхгүй. Үүгээрээ бол үхэх төрөхийн зайд аз эзийн сүүдэр чаргуулж яваа таны адил тарлан заяатан. Харин танаас ялгаа нь гэвэл үхэж, сүнсээ шүүлгэж үзсэн, бас эргэж төрөөд энэ хорвоогийн шороо нөмөрч дэндүү гаж үйлийн үрээрээ ад болж яваа юм. Үзээгүйг үзэж үхрийн эвэр дээр од ойчихыг харсан гэх үү дээ. Тэгэхдээ миний үгэнд итгэх байх нь таны таалал. Би таныг миний

ярианд итгээч гэж дөрвөн хөллөхгүй. Надад эс итгэвэл, эргүү тойруугийн хоч зүүж эрүүнийхээ чилээг гаргана л биз. Таны мэт нь элдэв номлолд төөрч хонь чоно хоёрын хоолыг солих гэж явсан тэр суртлын тогооч байдаг. Хэрэв таны хүзүүнд энэ чагнуур байгаагүй бол аль хэдийн ад шоо болж хавтавчинд хэвтэх байсан шүү дээ. Харин та хувьтай хүн юм. Гэвч таны мөрөн дээрх бөөрөнхийгөөс үнэ алдсан үзлийн шавхруунаас өөр юм эрэхэд хэцүү. Та шинэ цагтай ташаа нийлэхгүй. Таны үеийнхнийг үл бүтэх мөрөөдлийн золиос ч юм уу итгэлийн балгас гэвэл та голоо мөсдтөл гомдоно. Гэхдээ яая гэхэв. Эргэх цагийн эрхэнд автаж ганц та биш, нэгэн цагийн би ч хохирогч болно. Миний цаг болоогүй ч надаас үе үесхэн хуучрал цухалзахыг анзаардаг. Та нар ч тийм байсан. Худал үнэн инээхдээ ярзайдаг бидний шүд махчиныхтай адилгүй ч улай хүсэн улангасах сэтгэлд тасар татах хурц араа соёо нуугдаж байгаа шүү дээ. Тийн атал намайг адлаж гадуурхваас өөрсдийнхөө өрийг өшиглөж байгаагай ялгаагүй. Гэхдээ хүмүүст үүнийг мэдэх үлэг ухаан ч үгүй болохоор намайг бүүрэлхэж дайрч байгааг би мэдэж байна. Тэглээ гээд нохойн хоншоорт ус тогтохгүй. Би мэдэж байгаа юмаа ярих амаа үдүүлэхгүй гэж адардаг хүн. “Би” гэдэг нэгэн цогц бие хүн гээд хэлчих нь өөрийн учрыг төнхөж чадаагүй өнгөц тайлал. Углуургыг ухваас “би” бүхэн ялгаатай гайхшрам өвөрмөц оньсого.

Бархасын Тоодой бол арга билгийн тохиол буюу бороотой шөнийн туурвил гэх нь амин үүслийн алслаагүй нэгэн мөшгөөс л юм. Үүнээс цааш учиг гарвалийг хөөвөөс элэнц хуланц төдийд эргэлдэн он цагийн хязгааргүйд эрэл эцэхээс хаа холдох вэ.

Би хэдийвээр их эзэн Чингисийн удам хэмээн шулдан хаа дээлэн дотор тэвхдэвч Хэрэйдийн хэрчээс Мэргэдийн орхидос, Татаарын тайрдас, Жадарангийн шээс чухам хэнээс нь үсэрсэн цус, үргэсэн сүнс хэдэнтээ төрөл арилжиж хэн хүний хээлэнд ураг төөрснийг мэдэхгүй. Өвөгтөн үү, өрөөлтөн үү бүү мэд.

Ийнхүү улиглахын учир гэвээс эрт балрын алс руу элэнцийн зам татах гэж ёргихдоо бус гагцхүү өөрийн мэдэж буй урд насны явдлаа хэрхэн шүүлгэсэн тухай л дурсах гэсэн юм. Үзээгүй буюу үл мэдэх бүхнээ худал гэж тас шилбүүрддэг та нарын таашаалд нийцээх гэж би үсээ үгтээхгүй. Та нарын хулхинд сум сөвлөхгүй бол онгойхооргүй тагжирсан хэмээн дайрахдаа бус үнэний үзүүрийг үмхээд сууж чадахгүйн эрхэнд ам алдахаас даа.

Найдангийн Хөнхөр хэрхэн Бархасын Тоорой болох зам туулсан тухай оочин цоочин хэлнэ. Тантай Тооройгоос гадна Хөнхөр ярьж буйг битгий мартаарай гэж л гуйх минь!

Эмч итгэж ядсан байдлаар мушилзсанаа толгой дохив.

Хоёрдугаар тэмдэглэл

-Эмч ээ, би энэ тухай ярьж таны цөсөөр хавиргыг чинь дэлсмээргүй байна. Гэвч нэгэнт та миний дотрыг нэгжих гэж хорхойсоод байгаа болохоор далан хэл дэлгэхээс яахав. Би чинь Бархасын Тоорой бус Найдангийн Хөнхөр гээч нэртэй зүстэй яваад, төөрөгт цагаасаа өмнө төрөл арилжсан гэдгээ хэлье. Өвчний хажуугаар өвийн эзэн гэгдэж хорлогдсон гэж байгаа. Тэгээд л тэнэмэл сүнсэнд хувилж төрөөд баривчлагдсан гэж төсөөлж болно.

Сүнс гээч эзэнгүй золбирч яваад эрхэнд автдаг юм билээ. Үүнээс уларлаж, та нарын тулгаж байгаа галзуурал буюу миний үзсэн гайхамшиг эхлэсэн юм.

Энэ хэр миний ой тойнд үлдээсэн гэхээрийг эхнээс нь там тум санахыг хичээе.

Түнэр харанхуйг өрөмдөн эрчилсэн олгойдосоор сүнс харавсаар оддын шуурга гэмээрийг нэвглэн гэв гэнэтхэн гандирсын балгас гэдэг шиг юмны үүдэнд хүрэв. Энд түүнийг хэн хөөж ирснийг үл мэднэ. Мөнөөх хөх дэлэн, сүв нь хүртэл хагасарсан тал үст эхнэр, үнэсэн дээр хөрвөөгөөд хүн ч болдог, чоно ч болдог үнэг ч болдог хувхай сүүжний яс аль нь ч харагдсангүй. Сүнсийг ямар ч атугай тэнд эрлэгийн цагдуулууд хонгио мэтэд бортголж орхив. Сүнсний золбин эрх чөлөө, тэр ч байтугай цаг хугацаа энд зогсдог бололтой юм билээ. Тэнд хэдий удсаныг бүү мэд. Нэг л хоромд хялман гэрлийн бүхээгт орсноо мэдрэв.

Ер бус энэ орчинд хаанаас ч юм бэ, хэн ч юм бэ, хахиртсан дуу цууриалж Үл үзэгдэгч вээр

-Хаанахын хэн гээч вэ гэхэд харагдахгүй нэгэн

-Монгол. Найдангийн Хөнхөр гэж тоомжиргүйхэн өчих сонсдов.

Үл үзэгдэгч:

-Хөнхөр гэнээ? Уг нь Очир. Нэгэнт тэндээ нэршсэн Хөнхөрөөр нь шүүе. Хоёр чавганцын гараас хор ууж хоногоос өмнө амь тасарсан юм байна. Цаана нь Чойдор гээч хэргийн эзэн байж... Аав нь “Алтан” Найдан... Наадах чинь... Намын хорооны зааварлагч... Намын үүрийн дарга... бас “До” яамн далд туршуул... ааш хувирамхай... үг хуурмаг... сэтгэл буртаг... зориг мохоо... шунал цаглашгүй... тэчъяал тэвчишгүй... сайн үйл үл хийсэн... даргаас бас нохойноос айдаг... эрдэмд мэргэнгүй... хэвтэрт байхдаа эндэл, ослоо энд тэндээс эрэгцүүлсэн... юм байна. Одоохон биежүүл! гэж тушаах нь тэр...

Цахилгаан цахилын цуулдас мэт гялбалзахуй агшинд сүнс вээр Хөнхөрт биежин чармай нүцгэн зогсч байв. Ясархаг цээж, шуурсан шуу шулдарсан шулдарсан гуя, тэр бүү хэл умдагны үсний буржаахай дунд эрхийвчилсэн үлхэнцэг хүртэл харцанд өртөв. Сүнс ичингүйрэгчээ болж алгаа салтаанд бумбадвал “ха ха” гэх зүрх царцам мөсөн инээд хайрав. Гэтэл “аль байх” минь алга нэвт харагдаж байгаа юмсанж. “Булай болж ч гүйцэх нээ. Энэхүү ёрын ертөнцөд нөгөө “тамаа цайна” гэдэг л болох вий гэсэн бодол өндөсхийхэд “Тоост орчлонд салдирхалсан мөр чинь л мэднэ. Хэн ч атугай энд л үнэнд гүйцэгдэнэ. Булхай чинь булавч ил харагдана” гэсэн хариу сонсдов. Бодол хүртэл нэвт хардаг байх нээ. Арай манай “До” яам

шиг хилсдүүлэх юм биш биз” гэж сэрдхийх төдийд “Үгүй ээ. Танай тэр “До” яамныхан чинь сохор дүлий яргачид. Хүн гүтгэж хүйс тэмтэрснийхээ шанд эзнээсээ цустай зоос сарвайж хэмлэдэг махчин амьтад. Тэд чинь энд ямбанд сууж байгаа” гэж Үл үзэгдэгч ёжлон тавлав.

Сүнсний хялман гэрлийн хайрцаг хэмээн төсөөлж байсан дэлгэцэрхүү юм маань нөгөө гайхал эрлэгийн толь ч юм уу. Муу Хөнхөрийн долоон хөл зовлого судас шөрмөстэйгээ нэвт гэрэлтэх нь чихүүдэс хүрэм гэх үү дээ. Энэ бол оршихуй эс оршихуйн солбилцол үлгэр үнэн хоёр сүлэлдсэн хуурмаглал нүгэлт орчлонд толгой шондож яваачид, яагаад ч төсөөлөх аргагүй гайхаш тасрахын эцсийн туйл байлаа. Энэхүү этгээд орчны дэргэд хүний ямар ч шидэт зүүд бол хийсвэрлэл огт биш, болчимгүй гансралын эцсэн болжмор төдийхөн юм. Бодот болон хоосон чанарын элдэв сургаал нь хүмүүн хэмээгч амьтан өөрийгөө мөгдорлосон явган аргацаал, сүнс хойт насны тухай таамнал нь сэтгэлийн тэмтрээ төдий агаад ухаарлын сунчин дутсан мөлхөө юм. Ийнхүү амьдрал үхлийн түмэн нууцын ээдрээнээс нэгээхэн боловч үзүүр олж татах эрлийн хатаалд хүмүүн төрлөгтөн зуун зууны зулаг элээх юм даа хөөрхий. Шинжлэхүй ухаан шашин алины нь ч тайлал энэхүү тамлалт нууцын дэргэд хэлд орох гэж буй нялхасын шулганаан.

Сүнсний цуцсан бодлыг бас л харав бололтой.

-Наад муу Хөнхөр чинь ухааныхаа хорголоор тоглож байна. Өөрийг нь харуулаад өчиг ав! гэж мөнөөх Үл үзэгдэгч тачигнаснаа:

-Чогсомын Найдан гэхээс цааш удам судраа мэддэггүй юм банья. Феодал гаралтай болохоос айж ургийн бичгээ устгажээ. Эд чинь үүнээс болж элэг махны тасархайгаа мэдэхгүй, яс цусаа самарчихсан улс. Овогоо Боржгин гэж буудсан юм байна. Дээдэс нь Хүннүгийн орхидос. Хэрэйдтэй холилдож хэрээ шаазгайн нь аль нь ч биш болж. Харин нэг салаа нь саррацынтай сүлэлдэж харьшжээ гэж эхлээд, хаашаа ч зайлах гарцгүй болгож байгаад хамаг хэрэг явдлыг харуулж яриулж шүүсэн юм.

Эмч-Нөгөө эрлэгийн толиндоо л биз дээ.

Хялман гэрлийн хайрцаг гэж төсөөлсөн юм маань, мөнөөх эрлэгийн толь мөн байв. Тэгэвч бидний мэдэх цайртай шил, эсхүл сүүдэр шийний юм уу, зурагтын дэлгэц аль нь ч биш. Орон зайн алслал, явцууралд дүрс бус бодит дүр, аж байдал, өнгө төрх, үйл хөдлөл тэр бүү хэл үнэр амт мэдэгдэхийг яана. Хүний зүүдэнд уулнаас нисэх, усанд живэх мэт шид байдаг ч түүний дэргэд ахуйн тасархайн төдий л юм. Миний толь гэж нэрлэж буйн учир бол өөрөөр оноох үг олохгүй байна.

Эмч цай оочлон гилжийсхийж сууснаа

-Рентген аппарат л юм биз дээ.

-Таны хэлж байгаа бол тэр толины дэргэд шалбааганд нүүрээ харахтай л адил.

-Анагаах ухааны нээлт шүү

-Байх биш, байгаа түвшиндээ л тэр.

-Эрлэг Номын хаан гээч сүртэй амьтан уу?

-Мэдэхгүй.

-Чи уулзсан гээд...

-Бараа нь харагдахгүй далдаас л захиргаадаад байх юм билээ.

-Нууц ноёнтон гэдэг шиг үү.

-Үнэний хаан л юм даа. Түүнийг ер бусын агуурал гэж болно.

-Хаанаас гадна томчуул байна биз?

-Мэдэхгүй. Байсан ч улс төрийн товчоо юм уу удирдах зөвлөл, эсхүл яамны сайд гэх мэтийн үг би сонсоогүй.

-Дарга нар байхгүй яаж шуу болдог юм бол?

-Тэр бол таны ухаанд багтахгүй нь аргагүй. Та өчнөөн жил алба хашлаа гэхэд өөрийн толгойгоор шийдсэн юм бий юу.

-Дарга тэг гэсэн гээд сууж байх шиг жаргал хаана байна вэ? Хар толгойд халгүй байдаг юм.

-Таны дарга нар толгойтой байсан уу?

-Тэнэг асуулт банья.

-Хамгийн том даргын чинь толгой харийн хааны хөлийн хуруунаас уяатай байсныг яах гээв?

-Зөвлөлтийн нөхөд туслаж байсан. Бид тэдэнд асар их өртэй.

-Олон зуун сүм хийд, үй түмэн хүний амь, малын буян, газар нутаг, баялаг, таныхаар бол сохор зоосны үнэгүй байх нээ.

-Тэр тоог би үзээгүй.

-Тооцоо бодоогүй байж яриад яахав. Авлагатай гарах байх шүү.

-Зөвлөлтийн эсрэг үзэл гэж байсан.

-Тэр Советский союз чинь байхгүй. Улс төр хүчирхийлэлийн хуурамч зангиалаа нь задраад бут үсэрсэн. Колони орнууд нь чөлөөлөгдсөн.

-Манайх колони байсан гэж үү?

-Боолын боол борив тойгны яс байсан.

-Одоогийн залуусын хамар дэндүү шантайж байгаа шүү.

-Та нарт хамар байгаагүй. Намалдагаа нээлгэчихсэн шарх л байсан.

-Чи ер нь бузгай сээрдүү амьтан байх нээ?

-Алийн болгон толгойгүй бөгс тонтгонож байхав. Хаврын урь унасан үед нь, хөдсөн хэвнэгээ тайлж хөх арьсаа сэврээе гэж боддогийн нэгэн нь би. Эндээс та бид хоёрын зам дахиад нийлэхгүйгээр салж байгаа юм.

-Эмч, өвчтэн хоёрын зам салах ёсгүй.

-Эрүүл хоёр хүнийх холдож ойртож болно.

-Нялхаараа өтлөөч нь үү эсхүл чи нөгөө вундеркинд гээч нь үү?

-Оюун оворжсон байж магадгүй. Гэхдээ би таны заалгасан Пастерын нээсэн галзуугийн нян тээгч биш.

-Нян тээгч өөрөө мэддэггүй.

-Тийм байхаа. Жишээ нь таны махбодь ямар новшинд дарагдсаныг та мэдэхгүй.

-Би энэ тухай ярих гээгүй. Оюун ухааны буруу хөгжил, гаж нөлөөний тухай дуулснаа хэлж банья.

-Та францын алдарт химич Лавуазег “улсад суутан хэрэггүй” хэмээн цаазалсныг санав уу. Намайг тэгж тонилгох гэж байгаа бол ялаа алсантай адил андуурал болно.

-Манайх цаазын газар биш.

-Шар хад гэдэг чинь...

-Чи яаж мэддэг юм бэ.

-Ааваас л дуулсан. Нэг хэлэхдээ хувьсгалчид дайсныг дарсан гэдэг. Тэгснээ байчихаад “Ху” намын хулгарууд Монголын толгойг мөлжсөн л гэдэг юм.

-Одоохондоо шар хадыг сэргээгээгүй байх. Чи битгий ай. Харин чи яагаад бүх шатны сургууль товчилж анги үсэрсэн юм бэ.

-Таны хэлээд байгаа тэр вундеркинд би биш. Ой гайгүй болохоор багш нарын хэлснийг цээжилдгийн хүчинд анги алгассан.

-Зөвхөн түүгээр үү?

-Тийм ээ, өгсөн будаагийн нь хивж багйаад өөрт нь харуулахад багш нар дуртай.

-Зальг этгээд гэсэн үг үү?

-Том хүн заримдаа хүүхэд шиг санагддаг.

-Ном их уншдаг уу?

-Иддэг гэлтэй нь биш дээ.

-Дэглэмгүй уншлага мэдрэлийн системд нөлөөлдөг юм.

-Одоо үед номын цагаан солио гэж байхгүй болсон.

-Яагаад?

-Уншихгүйн хар мангуу дайрсан.

-Чиний насны багачуултай харьцуулахад яриа чинь ахдаад байна.

-Юу нь тэр вэ?

-Үг хэл чинь орчин үеийнхнээс холдоод байна.

-Буурлуудаас үг сонсож, хуучин ном судар шагайсан сайн номноос үг түүсэн болохоор хэдэн өгүүлбэр хэлхэхтэй болсон.

-Амыг нь сул тавивал арилж өгөх нээ.

-Хэрэв таныг битгий ярь гэвэл хэлээ зажлаж чадна шүү.

-Янзы чинь үзсэн юм. Ярих юм яагаа ч үгүй гэснээ эмч “остоортоо” Шизофрени (үл ялгагдах хэлбэр) хэмээн татлаад баахан шинжилгээ бичвэй.

Гуравдугаар тэмдэглэл

-Эмчээ. Та намайг оношлоод л байна уу? Таны анагаахын сурах бичгээс хуулсан эмгэгийн нэр томъёо хүрэх болов уу даа. Нөгөө ертөнцөд чинь орчлонгийн хүмүүсийн үүх түүх тус бүрдээ хөмрөглөсөн байдаг юм билээ. Тиймээ. Таны жоготой инээмсэглэлд “Одоо би өвчтөнийхөө судсыг барьж байна” гэсэн олзуурхал харагдаад байна. Ингээд болих уу даа.

Эмч:

-Болоогүй ээ. Одоо л эхлэж байна. Чи бид хоёр хужирхай ханатал хуучлана гэж тохироо биз дээ.

-Тэгвэл таны тэвчээрийн тэвхийг мултлахаас даа. Хөнхөрийн хүүхэд ахуй цагаас л тэнд харснаа л хэлье.

-Тэгээч хө. Сонин байна.

...Хүүхдийн часхийх дуу гэнэт хадаж улаан цурав амьтан арвалзаж байх юм. Үл үзэгдэгч:

-Чи үүнийг таних уу? гэхэд нь сүнс эргэлзвээс өөхөн дэнгийн сүүдэлзэх гэрэлд гэрийн хаяанаа хөмөрсөн шээзгий тэврэн жалавч мэт хөлөрсөн эхийн царай, хүйний эмээ хар хайч барин сандчих дүр тодров.

Үл үзэгдэгч:

-Найдангийн Очир буюу Хөнхөр орчлонг бузарлахаар ойчиж байгаа нь энэ гэж ихэмсэхэд

Сүнс: -Төрөх үхэх хоёроо би мэдээгүй. Харах бараагүй хаанахын хэн гээч намайг шалгаагаад байна аа?

Үл үзэгдэгч: -Та нарын хэлдгээр эрлэг Номун хаан болог. Танай шүүгчид хөгшин сэрхний хөсрий эвэр сэжилж нүдийг чинь бузарладаг бол би чамд харагдахгүй. Гагцхүү чамайг үрчгэр нүүрээр чинь үнэнтэй уулзуулна.

Сүнс: -Тэгвэл өмгөөлөгч авч хар цагаанаа ялгуулья.

-Танай гучаад оны “онцгой комисс” гэдэг яргачид өмгөөлөгчтэй буудаж байсан уу? Тэгээд ч энд хахуулийн тулам байдаггүй. Танай өмгөөлөгч нар хуулийн будаа зуусан чавганцууд. Тэд “ялы нь хөнгөлж өгөөч” гэж уруул унжуулахаас өөр мэдэлгүй. Яллагч нь яахав, хүний амь руу баримжаагаар дүрдэг балиус. Харин зоос харвал тугалга болдог биз дээ.

Сүнс: -Тэд чинь тангараг өргөсөн...

-Эзнийхээ хормой дээр эрднийн эврээ шилгээгээд, дордосын судсанд үхлийн хор шахдаг могойнууд...

Сүнс: -Шударга нь ч бас бий

Үл үзэгдэгч: Тэдэнд билгийн мэлмий байхгүй. Хоёр ухархай доторхи ёлтонгоороо хараагүй бүхнээ, багцаалахаас өөр юу чаддаг юм бэ. Хүн гэдэг ариун төрөөд алдар нэр, ашиг хонжоо ад шунал адгуусны тэчъяал, худал хуурмаг, хулгай дээрэмд бузарддаг юм. Тийм учраас бид хорвоогийн хогийг цэвэрлэхийн тулд насны хэмжил хугаслаж нааш нь татдаг юм. Үүгээрээ бид хүний орчлонг мөхлөөс аварч байдаг. Эс тэгвээс хүн төрөлхтөн өөрийгөө гэгээрлийн мөрөөр хөтлөж эс чадан хорслын үүрэнд архиралцан хоорондоо хядалцаад үгүй болно.

Сүнс юу гэж хэлэх учраа олсонгүй...

-Тэр ертөнцөд тэнгэр, газар ой мод, уул ус аль нь ч байхгүй, мананцарын цөл гэж болно. Чухамхүү энэ барин тавин атал барьцгүй хоосны хомрогонд сүнсний өлмий юу тулж, хэрхэн тэнцэж буйг мэдээгүй. Тэгээд ч сүнс бие бүү хэл санаа бодлын нууцлал хүртэл шалдран далдын хүчний эрхшээлд автна гэдэг аймшиг. Тэнд бидний хорвоотой зүс төс, зүйдэл нийлэх юм эрэх нь санааны гарз юм билээ. Харин эд мөрийн баримт гэрч нь хуурмаггүйн учир ороолох зайгүй нь аюултай бас хилсгүй шүү.

Эмч: -Шууд л долоон булчирхай найман найлжуурхай зад татчих юм уу.

-Тийм ээ. Хойшлогогүй. Хүнд суртал гэж мэддэгүй дэг.

-Хараач хөөе. Бариа зөрөөн дээр хийгээд эхлэв үү

-Алхуулдаггүй юм билээ. Ингэж эхлэсэн.

Үл үзэгдэгч: -Үнэнээ өөрөө өчих үү. Үгүй бол бид хэлүүлэх үү

Сүнс: -Амьд явсан хүн алдаа онооны аль аль нь бий

Үл үзэгдэгч: -Бид шагналын тодорхойлолт нэхэхгүй. Хөнхөр ядахдаа хөнгөвчлөхөөр ерийн хүн байж чадаагүй. Бузар бүхний үүр байсан учраас мөрөөр чинь мөшгөж, мөчөөр чинь салгаж шүүнэ. Бид тамлахгүй. Өөрөө өөрийгөө гэсгээнэ. Танай тэндэх шиг худлын хязгааргүй эрх чөлөө энд байхгүй. Зөвхөн үнэний эрхэт дарангуйлал бий. Хорвоогийн бусармагийн хорыг энд тасалдаг юм. Бүх юм энд барин тавин харагдах учраас чи биднийг мэхлэж чадахгүй гэж өчиггүй тусгасан. Тэгээд ч тэдний зоргоор болсон.

Эмч:

-Чи хө Хөнхөр болж дэгслээд...

-Үгүй ээ. Тэр ертөнцөд Хөнхөрийн сүнсийг л шүүсэн. Би бол Хөнхөр биш сүнс...

-Түүнийг юугаар батлах юм бэ

-Арай та тэндээс албан бичиг авчир гэх гээгүй биз.

-Газар мэддэгээрээ...

-Яв гэж үү? Тэгье. Та унаа өгчих...

Эмч намайг доогтой харснаа халууны шил гаргаж сэгсрээд

-Юу ч гэсэн халуунаа үзчих гээд сарвайв.

Миний гэдэн хөдөлж

-Дэлхийн анагаах ухаан хогоо цэвэрлэж байгаа шүү гэхэд тэрвээр гайхшран халууны шилээ эргүүлж тойруулж үзэв. Уг нь “Та хоёр хог дээр гарах болжээ” гэсэн миний ходоодны мухрын санааг эмчийн ухаан уургалж чадсангүй.

Дөрөвдүгээр тэмдэглэл

Эмч:

-Чи ер нь эмнэг адуу шиг дошгин хүн юм. Төрөлхийн ийм байсан уу.

-Төрснөөс хойш намайг чихдсээр байгаад жигшээчихсэн. Харин та намайг чөдөрлөж шар майхтай минь хатаах гээ юу?

-Би бол тангараг өргөсөн эмч. Хүнийг зовлонгоос гэтэлгэх нь миний үүрэг.

-Та намайг зовлонгоос ангижруулж чадахгүй. Харин хорвоод миний хоромхон зуур олдож магадгүй жаргалын амсуургаас л битгий салгаж үзээрэй.

-Өөх өгөхөд чи өөдөөс тургих юм.

-Ус тос хоёрыг би ялгана шүү.

-Хүүхдээрээ атал чиний хэл хэдрэг юмаа.

-Нас бие балчир ч ухаан нь хөдөөлсөн гэж надархуу хүнийг хэлдэг Аварга та амаа буруу аваагүй биз.

-Анагаах ухаанд ам авдаггүй, оноолтоор барилддаг юм.

-Тэгэхдээ найрааны начин байна биз.

-Том бөхчүүл байдаггүй гэдэг биз дээ. Түүнтэй адил.

-Түрийдээ мөнгө шургуулдаг мөрийтэй тоглоомноос болоод хэдэн нүцгэн хар юм хэрэлдээд байгаа юм биш үү.

-Тэд байтугай, төр мөрийтэй тоглоом болсон. Энэ ч дүүрчээ. Харин чи тэр ертөнцөд хүн бүрийн архив байдаг ухааны юм цухуйлгав уу.

-Хөнхөрийнх л лав байсан.

-Яана гэнээ. Ярь л даа.

-Тэнгэр, тунтар хөлд орж, аяганы ширээ мөргөн духаа шалбалж байгаа нь тодорч байна лээ. Хаяа шуусан гэрийн ханын нүдээр аягатай хоолоо нохойтой хувааж идэж байгаа харагдсан. Зүрх цагаан хар нохой зүсээрээ, хоншоор нь бууралтсан, сүүл нь хонхорцоглосон тэр нонж амьтан сүүлээрээ шороо шиврэн завжаа долоон нүд нь цэг мэт тогтон хишиг горьдож буй нь өрөвдмөөр. Хөөрхий муу нохой өтөлж зоо нь ердойсон зовлогоо даахгүй болж үхсэн биз. Тэгэхээр хүний төдийгүй нохойн явдал хамаатай байх нээ гэж та бодов уу. Харин л дээ. Тэр муу нохой хэн нэгний, бүр байгаад хилсээр буудуулсан өвөө Чогсомын сүнс эргэж хань бараа

татсан ч юм билүү.

“Алтан” хочтой аав Найдан хоймроо тухлаж эхнэр нь цай даргилаан улаа бутарч суугаа харагдсан. Аав нь хайчинд хадаг уяж ивээл жилтэй хэмээн шоомон шар хүнээр Хөнхөрийн дахийг үргээлгэхэд бүгд ёсчилсоор түүний толгой хожгор болох нь тэр. Мөнөөх Шоомон шарын тонгорог нийлэхэд хүү айж бахирах юм. Аав нь хүүгээ өвөр дээрээ тас тэврэхэд өнөө гайхал шоомон хожуул толгойг нь шижигнэтэл хусаж эхлэв.

Найдан: -“Ондго” Гүнсэн чи тонгоргоо олигтой бариарай. Хүүхдийн чих хяргаад өөр шигээ болгочихов гэж тохуурхна. “Ондого” нь түүний хариуд

-Хоолтой айлын хүүхэд ходоодтой л байвал барав гэж пар пар инээх юм.

Хүү гэдэг нусан бурантаг, нулимсан цулбуур болж гүйцэхэд толгой нь өндөг шиг болжээ. Эцэг нь хүүгээ “Эр хүн уйлдаггүй юм” гэж тайтгаруулахад хүү толгойгоо илж үзээд “го го” гэж шулганаж байх юм.

Найдан: -Миний хүү урт настай удаан жаргалтай их буянтай яваарай гэж хүүгээ үнсээд, хүүгийн хишиг тогтооцгооё гэхэд эр голдуу айлчид хөнтөрч байна.

Хойморлогчдын нэгэн болох сүлбээргүй ходоод шиг бахим хар хүн хүүд арван янчаан өгөөд

-Алтан Найдангийн буяныг булаах амны хишигтэй хүү юм. Аав шигээ авахаас өөрийг мэдэхгүй бус алга тэнийдэг хүн болоорой гэж байна.

Найдан: -“Нодго” Жамбал нохойтож байна уу. Хэрэв би “ондго” та хоёртой нөхөрлөөгүй бол алт сувд хоргой гурав дотроос авгайгаа эрээд олохгүй зовох байсан даа гэнэ. Сайхь шоомон шар бас улаан аравт өгч

-Баян хүн байна гэж хэлдэггүй. Аавыгаа дууриаж арьс махныхаа завсар буянаа нуулгүй амьтан хүнтэй хувааж яварай гэж банья.

Найдан: -Намайг хэмлэх яахав. Ондого, Нодго хоёр олдсон дээр нь ходоодоо тослож ав. Та хоёр өртөггүй хоолон дээр өлссөнөө мэддэг дээ гэхэд гурвуулаа ёвролцон инээлдэх юм. Гэтэл нөгөө хоёр гайхал “Оосор бүч нэмнээ” гээд Хөнхөрийн түнгэрцэг толгойг хумсаараа зурж домнов.

Хөнхөрийн ээж “Цаад хоёр лүдээсээ холхон яв. Чамайг шургуулсаар байгаад эмээлийг чинь үүрүүлнэ” гэж үглэдэг байсан нь энэ хоёр юмсанж. Эзэгтэй мөрийтэй тоглоомонд дургүй цэхвэлзээд байдаг болохоор энэ гайхлууд тэднийхээр тэр бүр шагайдаггүй хаа нэг газар гурвуул гурвалжин жаа хөөдөг байсан гэнэ.

Эмч:

-Алив юманд аргацаал гэж бийсэн дээ.

-Газрын бидэнд дайрахгүй, тойрох гэж байдаг бол, тэнд улаан халз мөргөлдөхөөс өөр гарц байхгүй.

-Арван хоёр нугалаа гэдэс шувгардаг байх нээ.

-Таны хэлээр бол тийм. Ардынхаар бол хосыг нь хошноготой нь өнгөргүй болгоно.

-Зэрлэг шүүх юм даа.

-Зэрлэгээрээ манайхтай адил ч хилс хэрэг өмсгөж тасалдаггүй.

-Тэд чинь хүнэрхүү юм байгаа биз дээ.

-Зүс царайг нь мэдэхгүй. Хэл яриа нь хүн байсан.

-Тэгвэл осол цэхий юм байж л таарна.

-Та хоёр өөр ертөнцийг ижилсгэх гээд байх юм.

-Чи тэгээд шударга ёс тэнд л байдаг гэх гээд...

-Хорвоогоос илүү нь тэр.

-Чиний “би” гэж яриад байгаа чинь толгой эргүүлээд байна.

-Улирсан баларсан нь Хөнхөр. Одоо таны өмнө сууж байгаа нь Тоорой.

-Нэг хүн харагдаад хоёр хүн болж яриад байхаар чинь би самуурч гүйцлээ.

-Та байтугай би мунгинадаг юм. Ганц биенд өчигдрөө хагас өнөөдрөө бүтэн тээш яваа болохоор “Би” гээд байгаа юм. Эрлэгийн байцаалд сүнс л өчиг өгсөн. Ойлгов уу.

-Ойлгоход хэцүү байна.

-Эрлэгийнхэн чинь энэрэх сэтгэлгүй лүднүүд юм даа.

-Толгой мултлах аргагүй юм билээ.

-Ам өчиггүй атгаад авдаг өвчин шиг айхавтар аа.

-Тиймээ. Мануухай шиг эмчийн өмнө махан тулам шиг хэвтэж байгаад үхэхтэй адил юм даа.

-За хө чи нүдээ аньж байгаад хоёр гарынхаа хурууны үзүүрийг уулзуулаад орхидоо.

-Арай хатуухан тоглоё. Би нүдээ боож байгаад долоовор зэрэгцүүлж хоёр нүдийг чинь гогдоод алган дээр чинь тавиад өгөх үү? гэвэл мань эр “энэ золиг чинь даамжирлаа” гэж бодсон бололтой худал инэвхийлж

-Эр хүн байж тоглоом даахгүй нээ” гэж зайцуулав. Тэрвээр нөгөө гайхал “остоортоо” үг нэмсэнгүй.

Тавдугаар тэмдэглэл

Эмчийн ааш гэж өнөөдөр хүний хайлаан усны тэлмээн гэдэг шиг ер бус ялдам. Энэхүү засдаг өнгө, наалинхайрлын цаана миний амны асгарыг гэсгээж үг алдуулах санаа байгуужин хэмээн би цэнэсхийв. Ерөөс хатуурхал нь ярдаглахуйг үүсгэж, харин уясал бол зоригийн ир эмтлэж дагаар сэтгэлийг урсгадаг шидтэй гэдэгсэн бус уу. Энэ нь миний болгоомж, наснаас өрсөж суусан гэрсүүжил, амьдралын мөн чанарын дотоод руу өнгийж тайлах гэж мунгинасан этгээд араншинтай ч холбоотой байж болох юм.

Эмч:

-Энэ хорвоод эрүүл саруул явах л жаргал

-Өвчний гамшиг, эрүүлийн үнийг мэдрүүлдэг ч юм билүү?

-Магадгүй. Хоюулаа биендээ итгэж чадвал чи эрүүлийн жаргалыг эдлэнэ.

-Урдаар би өвчилж үзмээр байна.

-Өвчин бүхэн өөр өөрийн буюу өнгөц болон далд шинжтэй. Өөрийн биед эс мэдэгдэвч хүнийг цаагуур нь хүлдэг ужиг гэж бий.

-Таныхаар бол би сурамгай доголлон гэдэг шиг долширсон галзуу байх нээ.

-Сэтгэл мэдрэлийн өвчин цочмог дэврэл, архагшлын гөлрөө хоёр илрэлтэй.

-Минийх ямар гэж?

-Магадгүй төрөлхийн гажиг ч байж болно.

-Генийн шинжилгээ иж бүрэн хийдэг газар л хоюулаа явах болж дээ.

-Заримдаа явахаас суух нь дээр байдаг. Чи багадаа адайр жаал байсан уу.

-Та удамшилын өвчин гэж оношлож байгаа бол Тооройн бус урд настай нь уулзвал дээр.

-Түүний тулд би үхэх үү?

-Сүнс сүнсээ шинжилдэг гэж үү?

-Хөнхөрийн бус чиний бага нас надад сонин байна.

-Би эргээд хүүхэд болж чадахгүй байх аа.

-Би ийм этгээд өвчтэнтэй анх удаа дайралдаж байна.

-Аргагүй ээ. Та өвчтэй хүнээс олдог байсан юмаа эрүүл хүнээс эрээд байна.

-Тэр яахав. Гэнэн томоогүй насны өршөөл тэнд эрхиш байна биз.

-Үгүй юм билээ. Бас нэг явдлыг би санаж байна. Та харин Хөнхөрийн явдлыг одоогийн Тооройхтой битгий самуураарай. Хөнхөр шүү!

Дөрвөн өнцөгтөө чүдэнзний булан, өрөндөө улаан таван хошуутай даавуу цүнх эгэлдрэглэн Хөнхөр сургууль руугаа гүйж явна. Шавхайтай нарийн гудамжинд луус тэрэг хөллөсөн, гантай ус бүхий Лоолой хятад тээглээд хажуугаар нь арайхин гарч байх юм.

Сургуулийн хүрэн дүнзэн байшин. Хагархай цонхыг нь цаас хэрээслэн наасан нь хүртэл тод. Дүнзний жийргэвч энд тэнд салбаран унжсан энэ байшин харвын ноорхой тором шиг. Өрөөсөн гуяа чирсэн хашааны яйжиг хаалгаар Хөнхөр амьсгаандаа хахаж цацан шургана. Унтаахай амьтан аанай л хожимджээ.

Ангийнхаа хаалгыг зүрхшээн татаж хамраа цухуйлган

-Орох уу багшаа... гэж царай алдахад хяламхийснээ дуугарсангүй. Түүнийг Сүрэн гэдэг боловч хүүхдүүд “саармаг эгшиг” гэнэ. Тэрвээр хүүхэн мэт, ганайсан нуруундаа бүс ороож шаавайрах боловч дургүйгээ хүрвэл заагуураар чичдэг, самбар мөргүүлдэг аданга ааштай. Хөнхөр сүүл салтаадсан гөлөг мэт суудалдаа суухад түүний хажуугийн хөх Дэжид охин “Дандаа хожигддог балай амьтан” гэж уцаарлана. Хөнхөр гараа сэм явуулж түүний шодон гээгнээс дугтарвал “ёо ёо багшаа” гэж чарлав.

Сүрэн багш хөмсөг зангидан ирж түүнийг угз татан самбарын өмнө чирч аваачаад

-Яагаад хожимдов гэхэд шилээ маажиж “Ээжийн бие муу” гэж гонгиноно.

-Тийм вий хэмээн багш Хөнхөрийг заамдан самбар мөргүүлэв. Өвдсөндөө ярвайвч нулимс унагалгүй шазуурдаж байх юм.

Хичээлийн завсарлагаар Хөнхөр Дэжидийг ангийн булан руу ольж “Яасан ховч гичий вэ” гэж гэдэс рүү нь өшиглөхөд тэрвээр эвхрэн унаж байна.

Дэжид хожим өөрөөсөө хоёр ангийн ах Хуягтай суусан юмсанж. Гэтэл тэр хоёр салж байгаа бололтой. Дэжид нүдээ хавдтал уйлжээ.

Хуяг:

-Бид хоёр ивээлгүй юм байж. Хэдэн жил чамаас удам горьдлоо. Би насны танагтайд үрийн зулай үнэрлэхээр шийдсэн. Надад битгий гомдоорой. Миний буруу биш шүү гэж байгаа дуулдана.

Дэжид усан нүдлэж:

-Хуяг минь. Би чамайг мэхлээгүй. Хөнхөр бид хоёр багадаа муудалцаж тэр намайг унаж тустал өшиглөж дэвссэн. Түүнээс урхаглаад алсдаа сав суулгаа авхуулах юм гэж даанч бодоогүй. Хоюулаа нойтон сормуустай юм өргөж авья хэмээн үглэхэд Хуяг

-Хүний үр хүйтэн бөөртэй. Хоюулаа биенээ хуураад яахав гээд хаалга саван гарч байна.

Үл үзэгдэгч:

-Санаатай үйлдсэн хэрэг биш гэж бултах уу

Манай энд хөнгөнийг хүндэд нь багтаах гэж байдаггүй. Гэм бүхэн гэсгээлтэй гэж тас дайрсан...

Эмч:

-Хүмүүнлэг энэрэнгүй ёс гэж мэддэггүй пиз... нууд байх нээ.

-Таны хэлж байгаа үг бол улс төрчдийн аман зохиол. Араатанлаг нигүүлсэлгүй орчинд амьдарч байгаагаа бүү март. Сүүдэр чинь гэрчилж байхад сүхдүүлэх гэж байгаа үхэр шиг дальдчихаас өөр арга мухар юм билээ.

-Баримтат киноны архив шиг юмтай нь айхавтар аа.

-Тэр архивт чинь сайд дарга нарын индэрт цоройж азарган тахиа шиг бахирч байгаа улиг байдаг. Түүнээс бус эм тахиа элдэж, улаан нүдлэн эрхэнд авгааж эргээд цатгалдан таахалзтал алхаж байгаа нь байдаггүй.

-Сайд дарга нар савсаг гэж би л лав хэлэхгүй.

-Томхон нь арынхаа өрөөнд, арай бага нь албаны буйдан дээр сарвагануулж байдгийг бүгд мэднэ.

-Байгалийн хууль...

-Таны тэр ухнууд өмдөө татаж амжаагүй байж, өрөөлийн завхай зайданг дууддаг байсан гээ биз дээ.

-Чи чинь бас далдыг хардаг болчихсон юм биш биз?

-Таны нөгөө үзмэрч гээд байдаг хулгайч шиг үү. Үгүй шүү. Би дөнгөж данган нүхэнд ойчиж сөхөнд унахгүй мөрөө хараад мөргөлж явдаг боольхой амьтан. Харин та намайг дэгслэж байна гэж байгаа бол өөрөө очоод өчиг өгөхдөө мэднэ...

-Үхэж байж л мэдье. Үхрийн толгой өнхөрч байхад сүүл нь хөдлөж байдаг юм гэнэлээ.

-Танд сүүл байгаа юм уу?

-Ганц надад бус хүн төрөлхтөнд ёзоор бий.

-Уг нь таных уртаараа байсан бол аятай юу.

-Яагаад?

-Эрлэгийн эвэр сүүл хоёртой очвол ял мултрах байсан биз.

-Чи тэнд адгуусыг шүүж байхыг үзэв үү?

-Үгүй.

-Тэгээд...?

-Бурхан байгалийн амьтныг бүтээхдээ нэг хэсгийг нь ухаанаараа бусдыг нь хүчээрээ амь зуу гэсэн юм биш үү.

-Чи дэндүү хол бодох юмаа.

-Жирэмсэн эмийн шээх газар гэдэг байх аа.

-Ядахдаа сувай эмийнх биш байх нээ гэснээ эмч ямар нэгэн завхай дуу гиншиж “хонгор минь ээ” гэсэн үг унагаад “остоороо” эргүүлэн шизоферени (хий үзэгдэлт) гэсэн үг бичиж цаас цоортол цэг хатгавай.

Зургадугаар тэмдэглэл

Эмч буцалсан цайнаасаа оочих гэснээ

-Чи юм уумаар байна уу?

-Аяга хар цай асуудаггүй гэдэг.

-Энийг уу. Генийн алдаанд халдвар байдаггүй юм.

-Тийм л гэдэг. Гэхдээ танд ДОХ-ын халдвар байвал яах юм бэ. Би залуу хүн. Сайхан хүүхэнд санаа чулуудаж, саваа шургуулах гэж яваа болохоор тантай аяганы амсар хуваахаа азная.

Эмч халуун байхуу оочилсноо

-Эр хүний санадагийг л санаж яваа юм байна. Хүүхэд цагийн байцаал тэгсхийгээд дуусаа биз дээ.

-Бас болоогүй ээ.

-Хараач хөөе. Чиний ярианы чихэрт ороод байна гэм.

-Тэгвэл хүлх л дээ. Бас нэг ийм явдал болсныг харуулсан юм.

Баруун Сэлбийн гудамж хөл ихтэй. Хөлтрөг молцогтой моринд эрээлсэн сүйх хөллөсөн хятадууд “Сүү захаа, бараа захаа” гэж адган хашгиралдана. Гудамжны хойт захаар навтгар модон байшингуудад гэрэл зурагчин үсчин, халуун усны газрууд эгнэжээ. Халуун усны байшингийн хаягаар савантай цэхэр ус урсан эхүүрэн шавхайрна. Зүүн этгээдэд Сэлбийн ямбий модон гүүр, өндөр хоршоо, өмнөдөөр элдэв хуурамч ээмэг бөгж, үсний хавчаар, сам, саван мэт аахар шаахар бараа, талх нарийн боов, махны мухлагууд гуанз сэлт харагдана. Тэр дунд Цоохондойн нарийн боовны лангуу тодхон. Үл ялиг дорсгой шар шүдтэй, цагаан бурхны сорви дутуу загссан өрөм мэт цоохортсон бахимхан хужаа бол Цоохондой. Түүний лангуунд улбарттал шарсан маюур маахуур, улаан цагаан еэвэн, шимийн будгаар цоохорлосон цэцгэн боов, гөөхий, өнгөт мөөхий мэт амттан эрээлжлэнэ.

Цоохондой нусан журуудыг нэг нүдээр харахгүй ч хүүхдүүд мэт нь олоны жишигээр “авгай” гэж дуудна. Хөгшин хөвөө хятадыг “авгай” гэж дуудах нь цаанаа басамж доромжийн яргаатай боловч ул дол болсон хэрэг. Өндөр хоршооноос, Шар дэлгүүр хүртлэх сарампай нүүрэвчтэй навс байшин бүхнээс сармисны үнэр сад тавих нь мэдэгдэнэ.

“Шөвөг” хэмээх Осоржам Хөнхөр хоёр тус бүр нижгээд зүү шорлосон дэлэм бургас ханцуйлан Цоохондойн мухлагт орж банья. Гадаа үлдсэн муужгай хочит Даваа мухлагийн араас чулуу нүүлгэж үүдний нь гонхонд тас буулгахад Цоохондой “Цүүний” хэмээн бахиран ухасхийх хооронд Осоржам тэр хоёр нарийн боовноос шордон зуларч байна.

Цохондой хятад уухирдан дэвслэж “энэ муусайн үхэр монголыг яаж барья. Монгу! Үхсэн

хойноо манай биш ваа. Дотор хүн ухаантай. Та нар бол нүх байхгүй махаа шүү. Нохой идваа” хэмээн дэвхцэж байна. Энэ Цоохондой бол Найдангийн арын гудамжинд шарилж ургасан шавар тагзанд суудаг. Эхнэр нь залуухан, хальстай сонгино шиг ухаа хонгор хүүхэн боловч ядуугийн эрхээр энэ муу хужаагийн ханзанд хадаастай хэвтдэг өрөвдмөөр амьтан аж. Эр нь дөнгөнд, эм нь мөнгөнд гэж ярьдаг.

Эрт эдүүгээгийн лай л юм даа.

Үл үзэгдэгч: -Энэ яаж байгаа юм бэ

Сүнс: -Хүүхдүүд зүггүйтэж л дээ

Үл үзэгдэгч: -Үүнээс цааш хумс чинь яаж сунасныг үзье.

...Дэнгийн ёлтон гэрэл анивалзана. Дэлгүүрийн нярав Тэрбиш Хөнхөр хоёр дундарсан лонх архины хажууд гөлрөн сууцгаана. Хөнхөр санаа алдан

-Нягтлан нярав хоюулаа л дээлээ нөмөрч дээ.

-Тэгжээ. Хөнхөр минь

-Угтаа бол нэг нь араа даадаг гэлцэх юм. Би л явахаас даа. Тэрбиш ээ!

-Тэрэн дээрээ тулвал татлаа, түтлээгүй гон бие амьтан би л үүрье. Харин Хөнхөр чи шоронгийн мухарт намайг мартчихгүй юм байгаа биз дээ.

-Хөгшин чинь эр хүний шавхруу шүү. Өөхөнд боох нь юу юм бэ, өлсгөхгүй ээ... Тэрбиш хормойгоо гөвөн “идсэндээ би сав больё. Хэлсэндээ чи эзэн болоорой” гээд гарч байх юм.

Үл үзэгдэгч:

-Хувааж гудраад няраваа алаад өөрөө үлдсэн. Юу болсныг... гэтэл

...Тэрбиш шоронд амьсгал хураах гэж байгаа бололтой. Тэрвээр яс арьс яр шарх болжээ. Банзан наарнаас өндийх гэвч чадсангүй. Хажуудах ялтандаа “Хөнхөр эр хүн биш байж дээ. Өөрийн ял дээр түүнийхийг үүрээд даасангүй. Наранд үлдэхдээ юу гэж ам өчиг өглөө. Наашаа ганц удаа хяламхийсэнгүй. За яахав хорвоог таниагүй ч нөхрийг танилаа. Бурхан харж байна буянаараа болог” гээд амьсгал хурааж байна.

Үл үзэгдэгч:

-Хөнхөрт хүний үнэр байж уу. Тэрбишийн амиар ялаа хааж, олзны овоон дээр суусан. Дэжидийг насаар нь сувайруулж амьд ёдор болгосон. Энэ бүхний өрийг чи төлөх болно.

Сүнс: -Тэр тамдаа түргэн хаяад аль...

Үл үзэгдэгч: -Яарах болоогүй. Там хүртэл зам урт гэж ам руу алгасан даа...

Эмч:

-Чи их юм үзсэн хүн байж. Нэг л өдөр ахын нь ээлж ирнэ. Арай бага шиг тарчлах аргыг мэдэж таараа. Надад зааж өг л дөө.

-Таны эргээ бас л гараагүй байна. Түүнийг чинь Найдангийн Хөнхөр мэдэхээс бус Бархасын Тоорой шонгүй.

-Буг нь байлаа гэхэд бугуйл нь байгаа ч уу үгүй ч үү. Бугуйл нь байлаа гэхэд бултаан дунд онооч уу үгүй ч үү... гээд сууж байх уу.

-Таны бүх итгэл үйрч унасан болохоор эргэлзээ үлдсэн байж болно. Энэ бол билгийн мэлмий нээж байгаа бус зөвхөн өөрийгөө чөдөрлөх төдий л юм.

-Чи намайг сэтгэх чадваргүй гэх гээд...

-Үгүй ээ. Танд байсан. Гэвч түүнийг та үндэс соёолуулалгүй хатаасан. Энэ хувьд бол шүншиггүй хүн.

Эмч толгой сэгсэрснээ

-Хоёр хүн болж чи бусгаад хоорондуур нь би дэмий гүйгээд... гэж үглэм аядсанаа “остоортоо” Шизофрени (байнга дэмийрэх) хэмээн эргэлзэнгүй эрээчвэй.

Долоодугаар тэмдэглэл

Эмч өнөөдөр бодлогошронгуй царайлжээ. Тэрвээр миний эх захгүй ярианд итгэсэндээ бус солиорлын үзүүрийг эрж, чухам юунаас үүсэлтэйг оноох гээд барьц олохгүй тэмтчээд байгаа юм. Тэр нь ч арга байж уу. Над мэт гаж эмгэгтэнтэй анх нүүр тулж онош нь ончролдсоных биз. Миний хэдэр зан эрүүл мэт атал үхсэн хатсан хойноо үзсэн харснаа ярьж байгаа нь түүний ухаанд яаж ч чихээд багтахгүй байгаа юм.

Эмч:

-За байз... гэснээ нэг хэсэг таг болов. Тэгснээ адар өөд ширтэж агаараас ямар нэгэн юм эрэлхийлэх мэт гөлөрснөө

-Цаадуул чинь хар толгойг яахав хаанаас нь хамаагүй мөлждөг байж. Харин бөгс ухаж төнхөөд байхгүй шуу биз?

-Доод тал нь долоон гол тэмтэрч есөн сүвээр шагайна.

-Хуучны хотын намын хороо шиг хучлаган доогуур хоншоороо шаагаад байх нээ.

-Ялгаа гэвэл тэднэр чинь адилхан тэлээгүй байж нөгөөгийнхөө дотоожийг хурал дээр шувталдаг байсан гэдэг биз дээ.

-Гэр бүлийн талаар тогтворгүй бол улс төрийн хувьд нэгэн адил гэдэг байсан.

-Үнэн байхаа. Суртал, өмд хоёроо амархан сольдог гэх юм билээ.

-Гош. Би чинь сайн муу ч гэсэн коммунистын сэтэртэй явсан хүн.

-Коммунистууд хувийн “буугүй” байсан юм уу.

-Хотны буу байлгүй яадаг юм. Энэ хэрэгт Хөнхөрийг яаж ноцов доо...

-Цэвэлжидийн цэл залуу дүр тодроод үл мэдэг ичингүйрсэн мишээл гэрэлтэх эрх харцаар ширтэв. Гэтэл Цэвэлжид үгүй болж Хандаа хүүхний өвөрт Хөнхөр хулмалзан хэвтэж байх юм. Хандаагийн нөхөр Цоохор хужаа үүрээс үдэш хүртэл мухлаг сахьдаг болохоор эзгүйчилж байна. Хандаа Хөнхөрийн хамрын үзүүрийг эрхий хуруугаар сөрмөснөө “Салаарчихаж. Эр хүн болох нь” гэснээ түүнийг тас тэврэн үлгээд түүний шомбоо цогнойх агшинд цочмог хөрвөн дээрээ гаргаж “хий” гэж тушаангүй хэлж байх юм. Хөнхөр өвдсөн мэт ярвайх атлаа, түүний сэвэлзсэн шигшээнд өөрийн эрхгүй автахуйяа, Хандаа “Яанаа, яанаа аллаа үхлээ” гэж үглэсээр “яасан сайхан юм бэ” гэж бие нь тавиран үхчих шиг болов. Хөнхөр айж байгаа бололтой нүд оройдоо гаран буун харайхад Хандаа түүнийг тамиргүй гараар хүзүүдэн чихэнд нь

-Яав? гэхэд нь

-Шээчих шиг боллоо гэнэ.

Хандаа хүүхэн тас тас хөхөрч “тавих” гэдэг юм. Эр хүн болж байгаа чинь тэр. Эр болоход эгчээрээ заалгадаг ёстой. Хэд уулзахад чи хэзээ язааны хар хүн болно. Хаа очиж буу нь бузгай юм гээч”... гэж байна.

Үл үзэгдэгч: -Цэвэлжидэд цэвэр очсон нь энэ үү гэхэд нь

СҮнс: -Дөнгөж л...

Үл үзэгдэгч: -Үүнээс хойш үнэнч явсан уу?

Сүнс: -Тиймээ... гэж түгдэртэл...

Нүцгэн хар уулын доод бэлийн бургасан шугуй, нуруу нь идмэртсэн модон гүүр доогуур мэлмэрэн шургах урсгалыг харваас Туул гол. Гэтэл бургасан дотор Хөнхөр нэгэн бүсгүйтэй үүлэн борооны үерт авгсан харагдана. Тиймээ, тэрвээр энэ ташуурын сур шиг чавхалзсан хөх хүүхэнтэй Сонгинын амралтанд садарласан аж. Тэрвээр хоёр өнгөтэй хөхөлбөр дээл өмсөж толийтол индүүдсэн ногоон бүс шоргоолжны мэт бэлхүүсээрээ тасамлан ороосон адын эрвээхэй байж л дээ. Тэд хотоос хамт очсон болохоор “чемоданы баяр” хэмээх хундага ёроолдон нанцагласнаар хормойн салхи хөвсөргөн “ауг” буюу амралтын тэгээс хэдэнтээ зуларчээ. Тэрвээр ёстой эрийн өвөрт элдэвлэж эмнэг байдас шиг чарладаг шидтэй эм. Түүний хоёр гараараа ногоо зулгаан тэлчилж байснаа гэнэт булгиж, Хөнхөрийн боожгойг үмхэн авах эгшинд...

Үл үзэгдэгч: -Завхай новш... Чи өөр ямар янгиа зайдалсан бэ?

Сүнс: -Санахгүй байна... гэтэл Хөнхөр харанхуй шөнө нэгэн зайлуул эмийг хашаа түшүүлж, бас хэн нэгнийг хотны нохой шиг араас нь ольж, бичээч хүүхнийг буйдан дээр тэлчлүүлж байгаа зэрэг хөврөхөд тэсэж чадсангүй.

Сүнс: Ичсэндээ -Болиоч дээ, би бүгдийг хүлээе гэж царай алдсан.

Эмчийн нүд гурвалжилж намайг дөгөөтэй харснаа

-Юунаас нь ичдэг юм бэ. Хаан харц хавтгайдаа л хандардаг биз дээ.

-Та чинь арай өвчтөнүүдийнхээ өөхийг дээш нь харуулдаг юм биш биз?

-Энд чинь дандаа галзуу сарлагнууд байдаггүй. Сэтгэл сэвтсэн согоонууд ирнэ шүү хэмээн маг маг хөхрөв.

-Тэгвэл тэнд таны халтар манан хөөрөгний толгойг имрэнэ дээ.

-Тэгнэл биз. Тэртээ тэргүй муу усны цорго болсон юмыг...

-Таны үгийг ам зориг гэдэг юм. Эр зоригоос ялгаатай.

Эмч зэвүүрхэн:

-Тэгээд би яах болж байна вэ. Хоёр насанд хохирч байх ёстой юм уу.

-Эхнийх нь хувь зохиол, эцсийнх нь балар тавилан гэж төсөөл. Аль алийг нь алхаад гарахгүй, амсаад өнгөрнө.

-Идеализм!

-Оюун санаа урд хойноо ордог болохоос орны даавууны ар өвөр хоёрыг матерлизм, идеализм гэж ялгаад байгаа юм биш үү.

-Оновчгүй зүйрлэл...

-Ахуйгаас төрдөг таны оюун санаанд таарна.

-Чиний диалектик хазайжээ.

-Тэгж ярьвал тэнхлэгээсээ та ч гарчихсан.

-Хоосон санаа руу бус, матери тийшээ.

-Социализм, коммунизм бодит байдлын тусгал байсан уу.

-Нийгмийн зүй тогтлын үр дүнг урьдчилан харсан шинжлэх ухааны нээлт.

-Болоогүй юмыг төлөгдсөн болохоор үлгэр л байж дээ.

-Диалектикийн хууль гээч...

-Таны хууль батлагдаагүй учир төслийн хэмжээнд үлдэг. Харин та бид хоёрын хана нохойн амаар нийлээд болохгүй нь. Өөр өөрийнхөө оромжинд өвдгөө тэвэрч хэвгье.

-Би чамайг эгэл хүмүүсийн эгнээнд элсүүлнэ.

-Батлах өгөх үү?

-Үгүй ээ. Баталгаа өгнө.

-Эгэл бус хүн эгэлшдэггүй. Тэгээд ч би эргүү бяруу байхаар галзуу нохой байх нь дээр гэж боддог.

-Тэр бол чиний бодол бус өвчний ужиг. Чам шиг сэргэлэн залууг амьдралаас алдвал би энд суугаад яах юм бэ.

-Нөгөө шар тариа гээчээ шаамаар байна уу.

-Үгүй ээ. Чи одоогийнхоо тасагт хөнгөн өвчитнүүдтэй тааваараа тайвшруулах эм уугаад байж

л бай.

-Тэр эмий чинь хурааж байгаа. Явахдаа танд тоо ёсоор нь өгнө.

-Нэг бол би эмчийн эрхээ хасуулна. Эсхүл чи Гиннессийн номонд орно.

-Тэр болтол чоно тарвагацаад л байх уу.

-Чи юундаа яарсан юм бэ. Хоёр биенийхээ амьсгаанд бүлээцэж хэд хоноё.

-Оргож босож таныг хоолноос салгаад яахав. Эв ургүй эр хүнд орвол танд охин тоглоом нь зугаатай юм биш үү.

-Ард түмний эмч аль алинаар нь тоглох эрхтэй байдаг юм гээд эмч марсайснаа “остоортоо” бичсэн оношны ард асуултын тэмдэг зоовой.

Наймдугаар тэмдэглэл

Эмч өнөөдөр шууд яриа өдөж:

-Тэнд чинь улс төр гээчийг даанч нэг ярихгүй биз.

-Тэдэнд улс төр байхгүй. Харин бидний булай улс төрийг шүүнэ.

-Улс төр бузар гэж үү?

-Тамын дархан данстай.

-Улс төрд орох үүд байхаас гарах хаалга байхгүй гэлцэх юм.

-Албан тушаалын амтанд хоргодсон арчаагүй хүний балайрал.

-Урд хойтдоо чи улс төрөөс хол явсан гэж үү?

-Урд насандаа хоёр хөлтэй улаан туг байж. Энэ насандаа эрх чөлөөний хамхуул гэх үү дээ.

-Дөчин мянгатын хулигаануудын нэг үү?

-Далан жилийн хулгайч гэвэл танд аятайхан дуулдах уу.

-Намын эсрэг...

-Баярлалаа.

-Би чамд хэн харагдаж байна.

-Би таныг харахгүй байна.

-Эрлэгийнд очиж сурсан эрдэм чинь үү?

-Эрдэм ч юу байхав. Үзсэн юм маань тэр.

-Арай чи аль эрт бурхан болсон аав ээжтэйгээ тэнд уулзсан гэж Хөнхөрийг гүтгэх юм биш биз.

-Уулзсаан...

-Гайхалтай. Яаж уулзав?

-Найдан цэл залуухан гялбарч гэрэл харавсан ухаавар царай харцанд нь дэгдсэн мишээл ирвэлзэхүйд сүнс дуу алдан ухасхийх гэвч хөдлөж болсонгүй. Тэгтэл л шаасан гадас шиг зоолттой байж. Тэрвээр сүнсийг олж үзэхгүй буюу түүнд харагдахгүй байгаагийн алин болохыг хэрхэн мэдэх билээ. Найдан мөрдөс мөрөвч бүхий хоёр хүний хамт давхар нуруутай

дааман хэмээх хаалгаар орж байна. Хашаан дотор мөөртэй шалтай их таван ханат дүнхийнэ. Цэргийн гэж миний анзаарсан хоёр бол “до” яамны ногоон малгайтнууд аж. Тэдний нэгэн болох угзчуур эр гэрийн хаалгыг тонших аядсанаа онгойлгохын завдалгүй оньсыг мулт татан оров.

Гэрийн хойморт дунд хэр насны зузаан бор хар хүн тэрмэн тэрлэг нөмрөн мөнгөн аягатай цай оочиж сууснаа

-Дээшээ морил! гэхэд сайхь шазгар оломтой цүнхнээс алгын чинээ цаас гарган сарвайв. Гэрийн эзэн гүйлгэн харснаа эхнэртээ “дулаан хувцас” гэсэн үг чулуудав. Эхнэр нь “яадаг билээ бурхан минь” гэж уйлагнахад тэрвээр “Надад хийсэн хэрэг байхгүй. Төр нүдтэй. Удахгүй эргээд ирнэ” хэмээн тайтгаруулав.

Сайхь хоёр гэрийн эзнийг тууж гарахдаа Найданд

-Биднийг иртэл энэ феодалын хөрөнгийг данслаж бай! гэж тушаав. Чухамдаа ямар гээчийн язгуур угсаатай хэн хүний үр болох нь мэдэгдсэнгүй.

Гэрийн эзэгтэй чичирч салганасан гараар авдруудын цоожийг ольчин онгойлгож эд хогшлоо эмхгүйхэн овоолвоос аав бүртгэж эхлэв. Эхнэр хүний толгойн боолт, мөнгөн аяганууд, шүрэн толгойтой хаш хөөрөг, чулуун соруултай ганс, үзүүрийн ба угны сувдан даруулга, сувдан сам, мөнгө төгрөг, бас хаант оросын “цолхоов” хэмээх цаасан төгрөг зэрэг элдэв зүйл хоймроор нэг хөглөрнө.

Эзэгтэй “давсаг хагарах нээ” гэж царайчилахад “шээгээд ир” гэж байна. Түүнийг гарсан хойгуур гансны мод мэт төө хэрийн нэгэн гонзгой юмыг Найдан монгол гутлын түрий рүү гулгуулж орхив. Төдөлгүй “До” яамны хоёр ирж бүх зүйлийг боож аваад аавын гараас дансыг шүүрэн авч эзэгтэйн эрхий хурууны хуаюурыг даруулаад гарахдаа хүүхний алтан ээмэг, бугуйвчийг мулт татаад арилав.

Үл үзэгдэгч: -Юу хулгайлсныг харав уу.

Сүнс: -Хаях юм аваа биз.

Үл үзэгдэгч: -Алт. Алтан Найдан ингэж хөлжсөн юм. Буу, даалуу хоёрын мөрийнөөс үлдсэний нь та хоёр яасныг хар!

-Мэдэхгүй...

Чингэлтэй хайрхны ониор Найдан Хөнхөр хоёр авирч ургаа чулуу, холбоо шинс модны хоорондох зайг алхмаар хэмжин товлож нүх цооноглон чандласан боодлыг булаад газрыг тэгшилж хөрс эсгэн нөхөж байна.

Үл үзэгдэгч:

-Энд юу булж байгаа юм бэ.

Сүнс: -Жаал зугаа хатуу юмаа л...

Үл үзэгдэгч -Яагаад нууж байгаа юм бэ.

Сүнс: -Яахав дээ. Ардын гэдэг засаг амь авдаг, авдар ухдаг л ажилтай шүү дээ.

-Тийм ээ. Тэгэхдээ харам сэтгэлдээ та нар хахсан шүү дээ... Харин алтан Найдан, хүний буяныг цөлмөсөн, ухархайг нь ухсан тэр хувьсгалч нэртэй зандалчидтайгаа цөм тамд байгаа. Тэд хэзээ ч эргэж хүний орчлонд төрөхгүй. Адгуус, араатан хорхой шавьж болж түмэн үхлээр энд л эргэх болно. Бүх гэмт хэрэг адилхан хар өнгөтэй. Тэр дундаа тэр улс төрийн гээд байгаа аллага таллага бол бүр тас хар гэж мэд. Энэ бол цайршгүй гэсэн үг хэмээн тачигнасан даа...

Эмч:

-Тэр ч тийм байж. Харин чи насаараа идэх хоолтой хүн юмаа?

-Урд насны хогшлыг хойд насанд өвлөдөггүй. Найдангийн Хөнхөрийн өв Бархасын Тооройд хүртээлгүй.

-Тэгэхдээ чи тэмдэгт газрыг олно доо.

-Олох байсан бол орд харшаар гайхуулж түрийвчин зүрхтэй мисс хүүхэн талхиад хэвтэж байхгүй юу.

-Монгол хүүхний заяа гомдоно.

-Би хомроголоогүй. Шуналын шуламнуудыг хэмлэж байна. Тэд чинь ногоон мөнгө харвал нохой отлуулахаас буцахгүй. Ходоодоороо дурлаж, хойгуураа сэтгэдэг юм. Улаан нүд нь цагаан мөнгөнд сохорсон болохоор ондгор бөгсөө зоосоор лайдуулж хэвтдэг.

-Эхээс төрсөн хүний амаар ийм үг багтаж гарлаа гэж үү?

-Та тэр савнуудаас ямар шавхруу гарна гэж бодоо вэ. Их сайндаа усны урсгал уруудаж уудаг хөгшин азарганы шандасгүй унага гарна. Тэгээд зогсохгүй хар шар зүс цус холигдсон эрлийзүүд хэрэгтэй цагт монголын төлөө амиа байтугай, аяга хоолоо харамлана. Одоо цагт харь улс биднийг зэвсгээр бус эмсийн салтаагаар байлдан дагуулах болно.

-Тэртэй тэргүй хорвоо чинь өвөр түрийдээ орж өмд гутлаа хольчихсон юм биш үү.

-Бид цөөхүүл болохоор улаан, цагаан шим, ургийн сангаа хадгалах ёстой. Хэрэв түүнийг хэмхлээд хаячихвал эргээд эвлэхгүй. Энэ бол бидний харамлах ёстой эрдэнэ. Би тэгж сөнөмөөргүй байна.

-Монголын заяа түшнэ биз.

-Тэр заяаны төлөө тэмцэх ёстой. Бүдүүн тоймоор хэлбэл монгол генийн батлан хамгаалах

яам байгуулмаар байна.

-Нөхөн үржихүйн асуудлыг тавиад л байгаа. Гадаадаас хүртэл мэргэжилтэн авчирч хичээл заалгаад...

-Эмч минь! Эрт урдын цагт энэ нутагт анхны хоёр хүн амрагийн жаргалаас хүүхэд өлгийдөж авахдаа гадаадаас мэргэжилтэн уриагүй, өөр зуураа өвөр түрийдээ ороод бусдын тусламжгүй бидний ганц чадах ажил энэ.

-Галуунаас тахиа гарах үлгэрээр ганц юманд санаа нийллээ. Гайхмаараа гэдэг чинь энэ хэмээн эмч мушилзсанаа “остоорт” бичсэн урдын оношныхоо ард анхаарлын тэмдэг босговой.

Есдүгээр тэмдэглэл

Эмч:

-Мартаснаас бурхантай тааралдав уу?

-Буруу номтонд бурхан харагддаггүй юм гэнэлээ.

-Эх болсон зургаан зүйл хамаг амьтан...

-Тиймээ. Эх болсон гэснээс бус эрлэг болсон гэж бурхны номонд байдаггүй. Ингэхэд та шүтлэгтэй юу?

-Одоо цагт намын гишүүд цугаараа л бурхны шавь болсон

-Энэ ч та нарын нүглийг нимгэлэхгүй л болов уу.

-Яагаад?...

-Та нарын олон өнгийн өвчих турсгатайд би гайхдагаа хэлсэн. Та хэзээ Жанрайсэгийн дуган шатаах гэж байна даа. Ормолзох хэрэггүй. Таны горьдож байгаа галзуугийн зэрэгт би хүрээгүй байна.

-Чи гүтгэж надаар шоронгийн хадаас хиймээр байна уу?

-Та нарыг чихээд багтаах гяндан монголд байхгүй. Тийм болохоор сэтгэлийнхээ шоронд хэвтэж бай. Би ийм нэг юм үзсэн ээ саналаа.

-Гандантэгчлэн хийд. Жанрайсагийн дуганын өмнө шөвгөр хар гуталтай харчуул, тайрмал үстэй хүүхнүүд, навс савсхан хувцастай борчуул цуглажээ. Эрүү малгай духдуулж суран бүс агсрагдсан зулман хөх хүн олны өмнө тамшаан хоолой засч

-Эрхэм журмын нөхөд өө, эрэгтэй эмэгтэй ардууд аа!

Өнөөдөр бид шар хувалзан харгисуудын ичээнд цуглаад байна. Бид ангийн тэмцлийн цусан дундуур туулж яллаа. Ард түмнийг мунхруулагч шарын шашны шавьж уравсан хулгай лам нарыг хувьсгалын хурц илдээр хяргалаа. Тэдэнд нөгөө авралт бурхан нь, гүрэм дором нь ч сум даадаггүй ид шид нь ч тус болсонгүй, шороонд булагдлаа. Ангийн дайснууд үүрд тониллоо. Одоо бид тэдний бузар үүрийг бут ниргэх болно. Энэ дуган дотор Жанрайсаг шүтээн гээч гуйлан мануухай байгаа. Том толгой феодал Богдыг сохорход хараа оруулах гэж босгосон гэдэг ч сохор түвд, нүдтэй монголын алинд ч тус болоогүй. Түүнийг газрын хөрснөөс арчихын төлөө урагшаа нөхөд өө! гэж бачуурав. Цугласан хүмүүс “ура” хэмээн бахиралдаж дуган руу дайран оров. Тэд царил, зээтүү, жоотуугаар их шүтээнийг балбаж байна. Тэр дунд Найдан аав нэг муу лантуу барьчихсан “хөлий нь хуга цохьё. Явж чадахгүй болог” хэмээн далайж, далайж буулгахад бойвогны чигчийнээс оч үсрэх төдийгөөс хэтэрсэнгүй. Нөгөө эрүү малгайт

-Найдан бол ёстой улаан хувьсгалч мөн байна. Түүнийг дагаад! гэж сүржигнэнэ.

Найдан тахилын ширээ рүү дайрч дээжний болон зулын, мөнгөн цөгцнүүд бас баримтагтай болон шоголтой ном судрыг авч шидлэх зуураа бяцхан алтан хорол өвөртлөв. Эрүү малгайт:

-Энэ новшнуудыг гаргаж шатаа! гэж зарлигдахад дуганын гадаа үүдэнд гал дүрэлзэн мод цаас торго даавуу холилдон хиншүүрч утаа олгодов.

...Жанрайсаг шүтээнийг оросууд хэмхчин хайрцаглаад ачиж буйд тэссэнгүй.

Сүнс: -Улаан оросоос ял асуу гэвэл

Үл үзэгдэгч: -Та нар оросын гүзээнд дэлүүрээ биз дээ. Тэдний бөгсийг хэлээ сугалж арчсанаа мартаа юу. Та нарын толгой манжийг дагаж мах, оросыг дагаж олгой болсныг худлаа гэх үү?

-Хөнхөрийн хувьд өөрийн бөндгөр мөрөн дээр явсан гэж сүнс хэгжүүрхэхэд Үл үзэгдэгч:

-Ха ха... Хар чи!

...Намын хурал. Хөнхөр индрийн ард ихэмсэн илтгэж байна.

Нөхөд өө! Шашины бурангуй суртал бидний дунд амь бөхтэй, зууралдсаар байна. Дээлийнхээ захыг сольсон шар феодалын шавхруунууд өдөр судар үзэж, сан тавьж, арга дом хийж хүн амын хоцрогдсон хэсгийг төөрөлдүүлсээр байна. Ийм учраас бид яруу алдарт чекистүүддээ туслаж хэрэгтнүүдийг илрүүлэн хомхой хоншоорыг нь тас цохих хэрэгтэй. Шашины аргамжаа болж байгаа тахилгат овоо, хүн чулуу, удган мод мэтийг орвонгоор нь үгүй хийе. Айл хунарын авдар савандаа нууж үлдээсэн бурхан тахил ном судрыг илрүүлж шатаая... гээд л чарлаж өгч байна. Үл үзэгдэгч:

-Энд хэний бөндгөр чарлаад байна вэ.

Сүнс: -“До” яаманд элсүүлсэн. Ангийн дайсныг илрүүлэх андгайнд гарын үсэг зуруулсан. Тэгээд л өөрийн амийг чирч гарахын тулд...

Үл үзэгдэгч: -Өрөөлийг бүрэлгэсэн гэж үү?

СҮнс: -Тушаалд тушуулсан... Намын даалгавар

-Самдан гэдэг хүний голыг чи гогодсон шүү дээ.

Сүнс: -Матаас бичсэн. Харин түүний өр рүү орсон цустай гар нь “доль” Чойдорынх...

Үл үзэгдэгч: -Бусад нь...?

Сүнс: -Мэдэхгүй

Үл үзэгдэгч: -Тэгвэл сануулья л даа...

...Үүрийн хяраанаар хүмүүс сүүдэгнэн байгаа газар Шар хад боллоотой. Хамгийн эхний хүнийг алман нүхний ирмэгт сөхрүүлэн дагз руу нь буудахуйд шувуу шиг хөвхөсхийн хийсэн унав. Энэ мэтээр өдөр цагийн хар солионд хүмүүсийг цааш харуулах тоолонд

-“Самдан, Буян, Ядам, Аюуш” гэхчлэн үл үзэгдэгч далдаас нэр цохов.

Сүнс: -Би эднийг алаагүй гэж сүнс гонгиноход

Үл үзэгдэгч: -Алалцсан гэж зандрав.

... “До” яаманд харлаг байшингийн дорхи хонгилын чангад тамлуулж буй хүмүүсийн цонхир царай үзэгдэв. Хар сахалтай шар нүдтэй эр, бас болжмор шиг давжаахан можгор бор хүн анч цагаан нохой шиг гуринхалсан шөвгөр хархүү зэрэг зүс таних хүмүүсийг цувуулан байцааж, Япон, Германы тагнуул гэсэн ял тулгаж байх юм. Балин хамарт хурандаа тэдний нүд рүү харандаагаар чичилж, бичгийн дараасаар нүүлгэж, онхолдтол өшиглөж шалан дээр дэвсэлж ёстой л чоно шиг зулгааж байна.

Үл үзэгдэгч:

-Монголын аль эрдэмтэй гэгээтэйг мангасын аманд чихсэнээ хүлээх үү?

-Тусгай даалгавараар мэдээлэл өгч байснаас бус алаад аль гээгүй.

-Матаасныхаа шан харамжийг авч байсан шүү дээ.

Сүнс: -Хэдэн бор төгрөг сарвайдаг байсан... Хоёр хүний завсар нэг мэдээлэгч шаантагласан болохоор хов зөөж, хоол иддэг хүн олон байсан гэв. Үнэн юман дээр үг амандаа үхдэг гээч энэ.

Эмч:

-Би бол цаг нь тийм байсан гээд л цааш нь түлхчихнэ.

-Таны түлхээс тархин дээр чинь ойчно. Тэр ертөнцөд хөөн хэлэлцэх хугацаа дуусах юм уу, арван жилээр таслаж архив шатаах гэж байдаггүй.

-Яахав дээ. Ганц би гал руу унахгүй. Олуулаа шатнаа хө.

-Тэглээ гээд тэнд таны ял хөнгөрөхгүй.

-Тэнгэр онгойсон гэж бодож суугаа шүү.

-Үгүй шүү. Үүлэн чөлөөний нар. Цув давхацтай явж бай.

-Золиг чинь зовлого цочоочихлоо гэж эмч сортосхийснээ харцаа займчуулж “остоортоо”

шизофрени (органик бус солиорол) гэсэн үг залгавай.

Аравдугаар тэмдэглэл

Эмч:

-Чамайг ажаад байхад үндсэрхэх үзэлтэн юм шиг...

-Энэ бол эх орончдыг яллаж байсан та нарын зүйл анги. Хөсрөх яс хөрөх зовлогоороо би монгол.

-Миний багад чам шиг юмыг чигжүүн хижиг гэдэг байсан юм. Төрийн төмөр хуурай гэж бий.

-Танд төр байсан гэж үү.

-Насны бөгсөнд надаар нас засгийг минь хараалгах гээ юү?

-Үгүй ээ. Та юу ч гэсэн наад холбоо үгээ тусд нь хэлж баймаар юм.

-Чи ер нь яахаараа манай намаар нохой саалгаж байдаг хүн бэ.

-Цаг хугацааны алслал гэж байдаг. Энэ нь өнгөрснийг эргэж үзээд өөгий нь харахыг хэлдэг. Урд нас минь зовсныг мэдэх болохоор танайхныг ерөөж чадахгүй юм. Харин та тэр үндсэрхэх үзэл гэдгээ надад тайлж өгөхгүй юу.

-Өөрийн үндэстнийг өрөөлийн дээр тавьж дээрэлхэхийг хэлдэг юм.

-Харийн хөлд турсгаа дэвсэхийг эх оронч үзэл гэх үү?

-Ари үндэстэн бүхний дээр байх ёстой гэж Адольф Хитлер хэлсэн

-Тэр далиу халимагт чинь хаа очиж “Монголчууд бүхний дор байх ёстой” гэж хэлээгүй юм билээ.

-Хэн мэдэхэв. Би түүний “Миний тэмцэл” гэдгийг шагайгагүй.

-Тэр нь дээр. Харин өвгөдийнхөө мөрийг шагайсан бол өчигтэй суухгүй юу. Гэхдээ төөрсөн хүн, нохойн дуу чимээлж, утаа үнэрлэх хэцүү. Би тэнд нэг ийм юм үзсэн юм. Харваас хотын намын хорооны хурлын танхим мөн дөө.

-Чи ч арай түүнийг мэдэхгүй.

-Та андуураад байх юм. Тоорой бус Хөнхөрий сүнс л байцаагдаж байгаа.

-Тэгээд юу үзсэн гэж...

-Хөнхөр таван хушуу сийлээстэй сарампай модон халхавчны ард Жагарын орны хөгжимсөг могой шиг цогнойгоод бурж байна. “Нөхөд өө! Үндсэрхэх үзэл бол империализмын хорт

тахал мөн. Манай сэхээтний дотор шургалсан зарим бэртэгчингүүд хөрөнгөтний балчигт шигдэн марксизм-ленинизмийг оппортунизмээр солихын төлөө улайран тэмцэж байна. Тэд нам ард түмний буянаар өдий хүрснээ мартаж, пролетарийн интернационализмаас урваж биднийг мөхлийн хар ангал руу түлхэхийг завджээ. Тэдний энэ бузар үйлдлийг манай нам цаг тухайд нь мэргэн олж харсны хүчинд бид нүүрлэж байсан оюулаас аврагдлаа. Үл бүтэх, хорон санаат тэр хөрөнгөтний зарцууд хүн төрөлхтний заналт дайсан, жигшүүрт алан хядагч феодал, Чингисийг амаа цангатал магтаж, манай үеийн баатруудад босгоогүй хөшөөг “Турван нуурт овоолсон нь ялт хэрэг. Чингис бол нөж атгаж төрсөн... гэтэл хоёр гараа сарвалзуулан дуу хадааж буй нялхас тодров.

Үл үзэгдэгч:

-Есүхэйн хаяанд Тэмүүжин хүү төрж байна. Түүний атганд чиний хэлээд байгаа нөж байна уу.

Сүнс: -...

Үл үзэгдэгч: -Та нар бас Гэсэрийг зүүн гартаа шагайн чинээ нөж атгаж төрсөн гэдэг биз дээ.

Сүнс: -....

Үл үзэгдэгч: -Домог зохиогоод дов элэгдэхээр үнэн болдог юм биш. Үнэн ч юу байхав үнэмшилтэй болдог. Чингис хааныг яллаж байх чи хэн юм бэ. Тэр хүний сүүдэр чиний дэргэд Сүмбэр уул бус уу. Өндөр уулын оройд өт хорхой хүрдэггүй. Өрөөл дээлэндээ өмөрцөг, өмдний шуумагтаа өнхөрцөг бус уу чи!

Сүнс: -...

Дахиад л индэр. Хөнхөр:

-Чингис хаан бол цус нулимсаар амласан юм гэтэл

...Тэмүүжин хүү эхийнхээ мөөмийг цагаан сүү цахруулан хөхөж байна.

Үл үзэгдэгч:

-Өэлүн эхийн хөхнөөс цус сорж байна уу...?

Сүнс: -...

Дахиад л индэр. Хөнхөр:

-Зөвлөлтийн зохиолч Ян Бичихдээ “Тэрвээр бөөвийсөн муусайн морьдоо унаад жартгай явдаг хатнаа дагуулаад” гэсэн нь түүхэн үнэний толь мөн... Гэтэл:

...Ер бусын их хүрээний гадна түмэн хүлгийн дэл шаширлан зоонд нь салхи хальтран харгэлтэж, онцгойдуухан од эрэх мэт үүрсэх хоёр загал морь нислийн өмнөх шонхор мэт

цогнолзоно. Хүрээний хүйсэн дэх өргөөний алтарсан сэнтийд өргөн магнай өндөр нуруутай хүрэгтэр сахалтай ханхар эзэн заларч зүүн гарт нь богтго малгай, хоргой торгон дундас давхраат нүд талимааруулан, хасын царай, гайхуулах дөрвөн хатан эгнэжээ.

Үл үзэгдэгч: -Чи танив уу

Сүнс: -Чингис хаан гээч нь юм болов уу.

Үл үзэгдэгч: -Уяан дээр нь адууны сэг хажууд нь хатдын тамтаг байна уу?

Сүнс: -...

...Умрын дүнхэр улаан уул, өмнийн хадан хар уулын хооронд цэлгэр хөндийд загасны нүд шиг хоёр нуур хөвхөрлөх агаад цайдамд хүрээлэн буусан олон гэр, асар цацар алаглан түүний голоос цомцойх үзэсгэлэнт өргөө гялбалзна. Хуяг, хөлтрөг бүхий зүс зүсмийн морьд багширч, төмөр дуулга хөө хуяг хөмөн хувцас бүхий цэрэг баатад хөлхөлдөх нь үлгэрийн балгадын сүр хүчийг гайхуулна.

Есөн хөлт цагаан сүлд, их хар сүлд ер бусын хүчийг илтгэнэ.

Чингис хаан хурсан олны өмнө цагаан эсгий дээр залран “Мөнх тэнгэрийн хүчин дор их Монгол улсыг тунхагласнаа дэлхийн чихнээ сонордуулъя. Бидний зовж байгуулсан улсыг дотор самуун, харь халдаарыг сөрөн батад тогтоож явахыг үеийн үед зарлиг болгоё... хэмээнэ...Дахиад л индэр. Хөнхөр:

-Чингис хаан бол монгол улсыг балласан заналт дайсан. Тэр зөвхөн биднийг төдийгүй айл хөрш орнуудыг уулгаласан дээрэмчин учир эх орны түүхийн хуудаснаас тасдан хаях нь зүйтэй.

Үл үзэгдэгч: -Чингис та хоёрын хэн нь монгол улсыг балласан юм бэ.

Сүнс: ...

Үл үзэгдэгч: -Чингис хааныг чи, айл хөрш улсаа уулгалан дээрэмдсэн гэв үү. Үүнийг хар!

...Чалма хэмээх ороомог малгайн цохонд очир алмас шигтгэсэн хазааран сахалт харийн нэгэн хаан бололтой эр алтан аяганаас дарс шимэнгээ “Монголын тэр худалдааны элчүүдийг хүйс тэмтэрч хөсөг тэнгий нь султан миний санд хураа” гэхэд хөөрхий худалдаачдыг толгой дараалан цавчилж багйаа нь харагдав.

Үл үзэгдэгч: -Чи үүнийг танихгүй. Энэ бол хорезмын султан Мухамед. Хэн нь эхлэж илд далайж вэ?

Сүнс: -...

Үл үзэгдэгч: -Түүхийн хуудсыг коммунистууд урж хаядаг. Та нар тэгсэн. Үндэсний бичиг ёс төрөө үгүй хийсэн. Чингис хаан дэлхийн дээвэр дор алтан аргамж татсан бол та нар түүнийг

тасдаж хаяад орос руу хүн мал хоёр бойнд туух цусан зам болгосон...

Сүнс: -Наад ял чинь томдож байна.

Үл үзэгдэгч: -Чи тэгвэл яах гэж толгойдоо томдсон малгай өмсч байсан юм бэ.

Сүнс: -Хойшоо харахаас өөр арга байгаагүй.

Үл үзэгдэгч: -Өөр зүгт харах гэсэн бүхэнд тугалга залгиулснаа яах гээ вэ. Хөнхөрт үнэнийг хэлээд үхэх зориг байгаагүй, Тийм үү гэж тас дайрсан даа...

Эмч:

-Чингисийг, чи хэн гэж үздэг вэ.

Ахмад төрөхгүй аугаа их хүн гэж... Харин та?

-Феодал ангийн төлөөлөгч...

-Та өөрөө...?

-Ард түмний...

-Дарга ангийн албат!

-Чи тэнд амаа үдүүлсэн мэт арчаа алдаж зогссон мөртөө, энд агсрах чинь илүү зан.

-Тэнд улаан халз үнэн уруул цоровдчих юм билээ. Тан шиг далан худалч бол даалуучдын хэлдгээр “Эрүүгээ авч нуруугаа маажих”-аас өөр аргагүй.

-Чи яагаад намайг ял, ясанд хахаах гээд байгаа юм бэ.

-Та бол хам бус дам хэрэгтэн. Зандалчдыг өмөөрснөөрөө, амь алдагсдыг дахин хөнөөсөн. Та нар сүүдрээс дайжсан бүхнийг алж халж цөлж үр удмаар нь тарчлаасан.

-Энэ бол хуурай гүжир.

-Ардчиллыг бид эхэлсэн гэдэг чинь нойтон үнэн үү?

-Би төрийн бус ерийн эмч сэхээтэн.

-Тиймээ, нялцгай сэхээтэн та ардчиллын залуусыг цусанд нь самар гэж хашгирч байсан хүмүүсийн нэг л биз.

-Үнэнийг хэлэхд манай хэдэн зөнөг тэнэг дарга нар ганц ч буу дуугараагүй байхад гараа өргөсөн. Би тэгнэ чинээ санаагүй.

-Буудах байсан гэж үү?

-Алахгүй гэхэд ачих байсан...

-Хойно өмнө чинь цэнхэр хар хоёр нүд цэнэгтэй буу шагайж байхад бид цөөхөн сумаараа үр хүүхдээ үгүй хийвэл үнсээ хийсгэнэ.

-Хоёр их хөршийн буянд л овоохойтой яваа биз дээ.

-Үгүй ээ. Хэн нь ч хэнээсээ булааж чадахгүй хэрээд зогсож байгаа чөлөөнд гэж хэл. Таны үзэн ядаад байгаа тэр үндсэрхэх үзэл гэдгийг биднийг овоохойгүй болгохын тулд тулгасан юм. Монголоо гэж хэлж чадахгүй, сэтгэж чадахгүй болгох гэсэн ёстой далдын хорон санаа.

-Тэгвэл даяаршил гэдэг чинь юу юм бэ.

-Ялгаа байхгүй. Үндэсний бүхнээ үрэн таран хийчихсэн улс үерт урсахдаа амархан.

-Амтай бүхэн л ангалзаад байна даг.

-Тийм ээ. Найрын сургаар согтож байгаа юм. Хорьдугаар зуунд та нар монголын хөх үндсийг сэндийлсэн болохоор залуус хамхуул болсных. Унаган газрын нь ус, шороо, ухаан гурваар бордохгүй бол хааныхын ч эрэгний мухарт тэд хагдарч мэднэ.

-Сэвсэр дэлсэх гэж хуучцуул хэлдэг байсан даа. Хөгшин хүн үхсэн хүн хоёр адилхан болсон цагт цорхийвэл, хярамцагны савгүй болно биз. Дуугай явсан хүн бүтэж үхсэн гэж дуулаагүй... хэмээн эмч урамгүйхэн өгүүлэхэд түүний царайг явгарсан эрийн цөхөрсөн гунил бүрхвэй.

Арван нэгдүгээр тэмдэглэл

Эмчийн нүдний будан үрэгсэнгүй. Насны харигт мэлмийн хиртэл сийрдэггүй гэдэг нь сэтгэлд яргаатайх биз. Тэгвэл энэ будрал миний нүдэнд ч харваж таараа гэсэн огцом бодлоос би айх шиг болов.

Эмч тоомжиргүйхэн:

-Тэнд чамд үзээгүй хараагүй юм ер нь бий юу?

-Үнэг бид хоёр хөтөл даваад л...

-Мартах санах юм бий. Дэмий юм асууя. Дарга даамалуудтай тэнд тааралдав уу?

-Дарга нарыг дархалдаг бололтой юм билээ.

-Юу гэсэн үг вэ?

-Бурхны орон ч юм уу, хүний орчлонд хувиаргүй дэг.

-Тэгвэл дарга яагаад цөөрдөггүй юм бэ.

-Тэд чинь нэг толгойгий нь авахад хоёр толгой шинээр ургадаг эртний Грекийн домгийн ерэн толгойт Гидратай төстэй юм.

-Тэнд ямар даргатай тааралдаа вэ?

-Гайхсныг яана. Ямар нэгэн үнэтэй модоор доторлосон том тасалгаанд орос, монгол хэдэн хүн сууж байх юм. Ногоовор өмд цамцтай, махир ганстай сахалт эр холхиж байснаа нааш харав.

Үл үзэгдэгч: -Энэ хэн бэ?

Сүнс: -Сталин багш!

Үл үзэгдэгч: -Чамд юу заасан юм бэ.

Сүнс: -Капитализм алгасахыг...

Үл үзэгдэгч: -Тэгээд алгассан уу.

Сүнс: -Санаатай гэлдэрч яваад буцсан.

Үл үзэгдэгч: -Энэ сахалт Гүрж нартай адилхан байна уу.

Сүнс: -Үгүй...

Үл үзэгдэгч: -Чи тэгвэл яагаад манай наран Сталин гэж байсан юм бэ... Гэтэл

Сталин, Гэндэн бас хоёр монгол хүнийг гансаараа чичлэн “Та нар улс доторхи улс, лам нарыг устга” гэж зарлигдаж байна. Тэгтэл монголын уул талаар лам нарыг цувдай шиг чихсэн ачааны тэрэгнүүд адуу мал, айл амьтан үргээн тоос чирэн сүлжилдэж, хуврагуудыг сум тоолон хядаж, тэр байтугай махан овоо хөдлөж байх нь ёстой аюул юм билээ. Хаврын шар ус ганга жалгаар цусан хоормоглож урсахыг хүртэл харсан:

Үл үзэгдэгч: -Энэ бүхнийг хэн хийсэн вэ?

Сүнс: -Коментерн, большевикууд...

Үл үзэгдэгч: -Оросын үстэй гар хэний бугуйг атгаж байсныг мэдэх үү.

...Чойбалсангийн дүр тодроод ирэх нь тэр.

Үл үзэгдэгч: -Энэ хэн бэ.

Сүнс: -Маршал Чойбалсан.

Үл үзэгдэгч: -Эцэг чинь үү?

СҮнс: -Үгүй чиш.

Үл үзэгдэгч: -Тэгвэл яагаад эцэг Чойбалсан гэж байсан юм бэ.

Сүнс: -...

Үл үзэгдэгч: -Чойбалсангаас бусад нь хайчсан юм бэ?

Сүнс: -Байгаа л биз.

Үл үзэгдэгч: -Булшинд уу?

Сүнс:-...

Үл үзэгдэгч: -Сталины “тусгай хавтас”-анд уу?

СҮнс: -Уравсан хулгай...

Үл үзэгдэгч: -Хэн нь хулгай байсныг хар!

“До” яамны урт байшин бөртлөн сүүмийж, албаны бололтой хүмүүс тал бүрээс адган ямар нэгэн хуралд ирж буй бололтой. Гэтэл хэрэг бишидлээ. Орсон бүхнийг шууд баривчлан хонгилын шорон руу тууж байна. Гялалзтал тосолсон орос хороомон гутал жийсэн Чойбалсан тэвхэлзэж нэрсийн жагсаалтыг бүртгэн “Үлдсэнийг нь хаа байгаа газраас нь олж ир” хэмээн тачигнэж байна. Түүний дэргэд орос сургагч бас буриад, халимаг алин болох нь үл мэдэгдэх

халхаар хазгай ярьдаг орчуулагч захандаа гуулин шоргоолжтой “балин хамарт” хурандаа нар гөлөлзөн маршлын харцаар хавталзаж байх юм.

Үл үзэгдэгч:

-Энэ их алаан хядааныг зөвтгэж Хөнхөр олон жил омруугаа индэрт холгож хашгирсан байхаа.

Сүнс: -...

Үл үзэгдэгч: -Бодоо Дандан, Догсом, Амар, Гэндэн, Дэмид гэж дуулсан уу?

Чиний тэр эцэг Чойбалсан чинь энэ мэт олон сайхан хүмүүсийн хүүрээр гүүр тавьж, монголын толгойд гарсан. Яахав Хөнхөрийг эргүү боолтрого байсан гэж бодъё. Гэтэл чи улайны үнэр аваагүй гэх үү? Чингис хааны голомтыг цусаар самарахад чи сарвуу дүрээгүй гэх үү? Машинтай чононд хонины арьс нөмөргөөд та нар өчнөөн хүний зовлогоор тэжээснийг Найдангийн Хөнхөр сүнсэндээ хүртэл өмөөрсөөр л байна уу.

Сүнс: -Чойбалсанд алдаа ч гавьяа ч бий.

Үл үзэгдэгч: -Гавьяа нь юу гэж?

Сүнс: -Монголын тусгаар тогтнолыг хамгаалж үлдсэн.

Үл үзэгдэгч: -Чиний орос улаан мангас социализмын ганц жараахайгаа залгивал олзноосоо гарзын гай болох байсан.

Сүнс: -Урд айл...

Үл үзэгдэгч: -Тэдэнд галзуу баавгайн аманд сарвуу шургуулах тэнхээ байгаагүй.

Сүнс: -Тэгвэл манай дарга нарын гавьяаг...?

Үл үзэгдэгч: -Гавьяаг бид энд галт тамаар шагнасан... гэхэд нь халуун цонох шиг болсон.

Эмч:

-Дарга нарт дургүй чамд уухайн тас байв уу.

-Би Тоорой гэдгээ дахиад хэлье.

-Тэгвэл Хөнхөрт?

-Хөнхөр бол тантай адилхан даргад хайртай хүн байсан юм билээ. Миний хувьд тушаалтан бүхэн эх оронч байдаггүй болохоор тэдэнд дургүй.

-Энэ бол атаархал...

-Сайн хүн бол атаархам байдаг, саар нь бол жигшим.

-Тэгвэл тэд ял үүрээд бид монжих нээ.

-Үгүй шүү. Бидний зүрхний сэг хуурамч долдойрол, дагаар шургасан авгал, үндэсний гамшигийг үйлийн үрд өлгийдсөн номойрол, цагийн салхи дагасан уруудал, оюуны ганшил, сэтгэлийн цөлшил энэ бүхэн нуруунд үүрээстэй байгааг мэдсээр байж бухах арга байхгүй гэж уншсан юм байна.

-Чи чинь филоофддог эр байх нээ?

-Урд насандаа ухааны ээдрээ тайлах гэж сүүжээ цоортол тэлчилсэн гэвэл эрхбиш тэр Хөнхөр гэдэг хүний үсэрхийлэл надад наалдсан байж болно.

-Удамшлын тухай шинжлэх ухаанд үзэгдээгүй үг байна.

-Судалгааны бус сурах бичгийн хулгананд тийм байж болно.

-Чиний ухаан орон гаран юм.

-Ойчин босон хүнд бол тийм биз.

-Намайг усан тэнэг гэж байгаа юм уу.

-Үгүй ээ, махан мангаахай ч гэх гээгүй.

-Чи бол тэрс үзэлтэн...

-Тантай адил өчигдөр чонотой нэг үүрэнд өнөөдөр хоньтой нэг хотонд байж чадахгүй. Та өнөөдрийн монгол улс хаашаа явж байгааг мэдэж байна уу?

-Зүүн тийшээ.

-Танд ямар балай нь тэгж шивнээ вэ?

-Манай нам зүүнийх болсон.

-Ашгүй дээ. Одоо л монголчууд лууны эвэр хуга мушгих нь дээ. Уг нь би тантай явмаар байна. Гэвч буцахаас нь төвөгшөөгөөд байна.

-Түүх давтагдана гэж үү.

-Түүх давтагддаггүй. Өөр цаг үед өмнөхөө санагалзах тохиолыг хүмүүс тэгж зүйрлэдэг юм. Хэрэв та социализмыг хүлээж байгаа бол зүрх чинь зүүн тийшээ явах замд зогсох вий дээ..

-Биднийг үхэж далдар гэж байгаа юм уу.

-Хараасан ч, ерөөсөн ч хаалгаар гарах өдөр ирнэ. Таныг нийгмийн бүтээгдэхүүн гэвэл аль эрт зааз болсон, байгалийх гэвэл арьсан дотор амьсгаа тээж яваа. Хогийг боловсрууллаа гэхэд

хоёрдох түүхий эд л гардаг юм...

Эмч над руу гөлрөн, эрхий хурууныхаа хумсыг мэрэн мөнөөх гайхал “остоортоо” хоёр үг бичсэн боловч үсэглэх зав өгөлгүй хамхиад

-Компьютер оношлогоогоор хог ялгасан хойно хаюулаа цэвэрлэгээ хийх үү гэж намайг дамшиглаад гарын дохиогоор “яв” гэсэн боловч би нохойтон зогсоод л байв. Өвчтөнүүдийн “остоорыг” эмч ээлжлэн үзэж хэсэг зуур сууснаа миний аягт тааруулан

-Чи хөшөө болох нь уу? Би л лав цэцэг өргөхгүй шүү гэж ёжлоход ландгар эгч намайг хулгана барьж байгаа муур шиг сэвхийтэл базан гаргаад өгзөг рүү алгадан “Тасагтаа маарш” гэж шивнэв. Би эмч, сувилагч хоёртойгоо дасах бүү хэл эрхэлдэг болжээ. Харин ингэсээр байгаад “хурцыхан”-тай ижилсчихвэл яанаа. Хүн гэдэг алив орчинд өөриймсөхөөрөө тэндээсээ гарч чадалгүй ганддаг нь худлаа ч биш дээ. Үүнийг үнэнд гүйцэгдэх, худалд автахын алин болохыг ялгах ухааны шавхруутай л явах юмсан...

Арван хоёрдугаар тэмдэглэл

Эмчяөнөөдөр ирсэнгүй. Уг нь хоёулаа муур хулгана болж тогловол өдөр амархан өнгөрдөг юм. Би дэмий арга саам эрж холхив.

Манай энэ хавь “неврозыхон” хэмээх хөнгөн тасаг. Манайхаас нэг хүн сэмбэлзээд “эмнэлэг ч ачтай газар юм. Эмч нар ч бурхан юм” гэж магтсаар гарав. Би нэрий нь ч асууж амжсангүй. Үлдсэн хоёртойгоо танилцаж амжаагүй тул үг өдье гэж шийдэв.

Бид өрөөндөө дөрвүүлээ байсан юм. Гарсныг байтугай одоо байгаа хоёрыгоо хэн болохыг мэдэхгүй. Нэгдэх нь гэвэл халимагаа хусуулсан бололтой зараалж бууралтсан үстэй, царай хөхөлбөр өвөгжөөр эр. Тэрвээр босон суун хааяахан үгний тасархай эзэнгүй чулуудах боловч хэл ээдэрсэн буюу угийн дультраа ч байж болох юм. Би илүү загнаж түүний үгийн сэжүүрээс “Жаалаачикийн качгоор” “класынний борьба” “Марксист, Ленинис паарт” гэсэн хэдэн хэлтэрхий шүүрсэн төдий. Тэгээд л түүнийг цагтаа онолдож явсан толгой болов уу гэж таасан учир “Марксист” гэж дотроо нэрлээд байгаа. Энэхүү хөх дэрс шиг хөрзгөр өвгөн миний урд насны хөнхөртэй төсөөний санагдаад байгаа юм.

Хоёрдох нь нүд хөмсөг болсон чацархуу цагаан шар хархүү. Тэрвээр гөлрөө туссан юм болов уу гэтэл заримдаа хэн нэгэн Цээмаатай тэрүүхэндээ шивнэлдэн бүр тар тур хийнэ гээ. “Цээмаа! Би чамд, чи надад хайртай. Тиймээ. Чи яагаад дуугарахгүй байгаа юм бэ гэснээ орондоо шурган хөнжлийнхөө сэжүрийг сөхөн “Цээмаа ороод ир. Уухайс даа. Чиний бие торго шиг... Юу? Үгүй гэнээ... Хүнтэй болсоон... Би тэгвэл үхлээ... гэж гөвтнөснөө нүдэнд нь нулимс цийлэн “өвөртөлж унтаад алдна гэдэг...” хэмээх дууны мөрийг эв хавгүй гиншин тайтгарна. Би түүнийг “Гоож-Нан-ай” гэмээр юм уу гэж бодов. Гэвч хайран сайхан залуу гэж дотроо харуусна.

Хайр дурлал гээч хүнийг агууруулж бас үгүйрүүлэх юм даа. Энэ гай намайг хэзээ дайрах бол...

Энд би ном тэврээд хэвтчихдэг болохоор эдэнтэй үг солиогүй юм л даа.

Өнөөдөр уйдаад ч гэх үү “марксист”-ыг өдөж

-Та философич хүн юмаа гэвэл намайг хяламхийснээ

-Марксист, Ленинис паарт гэхихээд буруу харж дуугаа хураав. Ийм хүнтэй юу ч ярихсан билээ.

Гоож-Нан-ай-г аргадах санаатай

-Цээмаагаа л бодоод байна уу гэвэл.

-Цэцэгмаа юм л даа. Бид ангийн хоёр л доо. Амьддаа салахгүй гэж ам өчгөө өгөлцсөн байлаа.

-Ам алдана гэдэг амь алдана гэсэн үг биш л дээ.

-Тийм юм байлгүй. Цэцэгмаагийн зан хувирснаас хойш би нойр хоолноос гарчихаад... Нэг л мэдэхэд энд ирчихсэн байлаа.

-Мартахаа мартаж, санахаа санаж явахгүй бол энэ хорвоог элээхэд хэцүү гэж би уншсан юм байна.

-Тэгээд намайг яалгах гэв!

-Сайхан хайрын суурин дээр цэцэг тарьнаа хө.

-Яаж?

-Ийм сайхан залуу ганц гадас тойроод яах юм бэ. Эмс мундсан биш, эрвээхэй барихгүй юу.

-Үгүй ээ, би чадахгүй.

-Цэцэгмаа хаачсан юм бэ.

-Нэг муу ганзгачин бид хоёрын дундуур орчихсон юм. Мөнгөтэй хүн дуртай юмаа хийдэг болж дээ.

-Тэгэх тусам агаархтал нь амьд яв.

-Чи намайг Цээмааг март гэх гээд байна уу.

-Санааныхаа мухарт чулуудчих. Сайхан дурсамж үлдэг.

-Үгүй, үгүй... гэснээ шал руу нүд унаган гөлөрч орхив. Ухаан нь орон гаран гэдэг нь бололтой. Би түүнийг цочоосонгүй. Гэтэл мань эр гэнэт ормосхийж нүд нь гялалзан

-Цээмаа ирж явна. Бид хоёрын хурим өнөөдөр байхгүй юу... гэхэд нь би түүнийг орхин гартал сувилагч авгайтай халз тааралдав. Энэ булиа сувилагчийг би ландгар эгч гэж дотроо өхөөрддөг болоод байгаа юм. Хаалга харанхуйлаад орж ирдэг энэ эгч над мэт шавилыг зангидаад шидчихээр ханагар л даа. Энэ газар иймэрхүү бядтай хүн хэрэгтэй байгаа биз. Ландгар эгч намайг ширвэсхийн харснаа:

-Эмчийн эзгүйд сэлгүүцэхгүй шүү

-Доовгор хайчсан юм бэ.

-Төвд хуралтай. Юу гэж?

-Зүгээр л... Манай өрөөний хөгшин ямар мэргэжлийн хүн юм бол?

-Суртлын дарга байсан юм гэнэлээ. Номын цагаан солио туссан юм байх. Их уншиж л дээ хөөрхий.

-Нэг юмыг олон уншсан байлгүй. Залуу нь...?

-Юухан хээхэн бичдэг байсан гэдэг юм. Нэг салтгар юмнаас болсон юм даг уу.

-Сэтгэлийг ухаанаар жолоод гэдэг байхаа.

-Хүнийг битгий тавлаж бай гөлөг минь. Чиний толгойг ч гэсэн нэг годгор эргүүлж хаячихаад самуураад явчихвал солиорно гайгүй.

-Тэгж ч заяа нь хаяхгүй шүү

-Ам гарах амархан. Ачир дээрээ тулахаар амь тавьж л таарна. За за, үгэнд битгий дурлаад бай. Ор! гэж тасхийв.

Би зандруулсан гөлөг шиг дальдчин дэрэнд нүүрээ шааж хэвтээд дуг хийчихжээ. Гэтэл гэнэтийн шуугиан намайг сэрээхэд огло үсрэн хаалгаар шагайтал нэгэн хүлээтэй эр цамнаж байв. Тэрвээр амнаасаа цахарсан хөөсийг нулимж

-Чононуудаа. Та нар монголыг цуслаад цадаагүй юу. Одоо юу идэх гэв. Намайг идэх үү? За тэр ирж явна. Мангас ирж явна. Жороо морьтой, ногоон торгон дээлтэй хүүхэнтэй... Хүүе ээ... ЖИП-тэй болоод давхилаа. Намайг мангас залгилаа... амь авар... гэж бахирав.

Бух шиг хоёр хархүү түүнийг сугадан тэлчлүүлсээр эмчийн өрөөнд оруулснаар төдөлгүй чихний чийр тасрав. Гэвч миний сэтгэл түгшин уйтгар хорслоор хямрав. Монголд улс төрийн чононд хэмхүүлсэн шинэ галзуу өвчтөн гарах нээ гэсэн айдасд царцаж жихүүцхүй “мангас залгилаа” гэсэн сайхь галзуугийн үг зүрх зүсэв. Бурхан минь! Бид чинь маанайж суусаар мангасын аманд орох юм уу? Арван таван толгойтой бус зуун тавин толгойтой мангас намайг идэхээр ирж явах шиг... Одоо л би жинхэнэ ёсоороо галзуурч байгаа юм болов уу. Энд удвал би анги дэвшиж нөгөө “хурцынхны” сүрэгт нийлэх биз. Би тэднийг харахаараа нүд хальгардаг юм. Зарим нь үүлэг гөлрөө, нөгөө нь омголон, хэн нэгэн нь наана уйлж, цаана дуулна. Эмсийн үс сэгсийж царай гундсан, эрчүүдийн ухархай цөмөрч, нүд гурвалжилсан нь өрөвдөм агаад цэрвүүштэй. Тэдэнд загнахгүй зан үгүй. Хэн нэгнийг дуудаж, хараал урсгаж шороо цацна. Буг зэтгэр харагддаг юм уу аллаа, хядлаа гэж орь дуу тавин зугтна. Нэгэнтээ би чармай нүцгэн хүүхэн харсан юм. Тэрвээр умдгаа алгадан “май авах уу, горьдвоо түй” гэж бахирхад асрагч авгай шалны нойтон алчуураар ороолгоход цовхрон зайлж билээ. Уг нь тэрвээр залуудаа “эрчүүдийн хормой сэнсрүүлсэн сайхан амьтан байсан юм гэнэ лээ” гэж манай ландгар эгч ам алдсан юм. Түүнийг хэн нэгэн хархүү олны урдуур орж сэтгэлий нь уяаг алдууруулаад эцэст нь өөр эмтэй сүүлрэн орхиж гомдоосон гэх юм билээ. Одоо бол түүний гоо сайхнаас би л лав сүүдэр ч олж хараагүй. Бас нэг олигор хар өвгөнцөр бий. Тэрвээр өөрийгөө хурандаа гэх боловч хэн ч үл үнэмшинэ. “Хурандаа” үе үе хоёр гар алдлан илтгэнэ.

Тэгэхдээ “Нөхөд өө! Ангийн дайснуудыг устгая. Би сая Шар хаданад хэдийг буудаад ирлээ. Гэвч үлдсэн байна. Гал нээгээд” гэсэн нэг л хэвийн өгүүлбэр давтана. Энэ гайхал цагтаа цаазчин байж өчнөөн хүн хядаад эцэст нь лайгаа үүрч галзуурсан ч байж болох юм. Түүнийг харахаас миний зэвүү хүрч үзэн яддаг юм. Энэ хүмүүсийн дунд өрөвдмөөр өширмөөрийн аль

нь ч буй гэхэд хүн болсон ганц заяандаа адгуус араатны олиг олж амь гээнэ гэдэг юутай харуусал. Эдэнд ах дүү амраг садан байсан ч байхгүй. Хэн ч эргэж ирж аяга цай оочуулахгүй. Амьдралын буруу хаалгаар уван цуван буцахад нь уй гшуу болохгүй. Алтан сав нээлгэж хойд мөр айлтгаж, хоног хураахгүй. Эд нар хорвоод хамгийн азгүй хохирогсод. Өвчний тохуу болж буруугүй атлаа буруудсан өмгөөлөлгүй цээрлүүлсэн ялтнууд. Эдний дэргэд хог ухаж, траншейд орогнож, өвгөнтийн хөндийд салгалж яваа хүмүүсийг би бараг л бурхны оронд байгаа гэж хэлмээр санагддаг юм. Гэвч миний мэт нь эдний төлөө юу ч хийж чадахгүй. Тэр байтугай агуу их эрдэмтэд, бурхан эмч нарын хэн нь ч хоёр гар өргөнө. Ийн бодохул, хүн төрөлхтөн өөрийгөө устгах аргыг олсон мөртөө аврахын тусад адгуусны хэмжээнд л байгаагаас хэтрээ гэж үү...

Би ер нь яалтай билээ? Ямар ч атугай галзуугийн данстай үхэхгүйн тулд, “үнэнээ хэлж байна. Итгэхгүй байлаа бол шинжлэх ухааны нотолгоо гаргуулж өг” гээд гэдийж суухад яс цайна гэдэг нь болохоос өөр арга бодоод олохгүй байна. Хайран цаг хугацааны гарз л гарах нь дээ. Гэхдээ монгол хүн гээч “цагийг цаас шиг урж хоногийг хог шиг хаядаг” гэсэн үг гарсан байна лээ. Ингэж л түр зуур өөрийгөө хохироохоос доо.

Арван гуравдугаар тэмдэглэл

Эмч өнөөдөр хусран гүү мэт хуйсганажээ. Тэрвээр улс орны төлөө санаа сандаах хүн бус тул аяга цайны арцалдаа төдийгөөс юу л гавиа аж. Амьдралын хөлд хаваржааны турлиах шиг өвдөл цөвдөлд цөмцөгнөх хүмүүс бор хэрийн богшоонд ийн аяглахыг алийг тэр гэх вэ.

Эмч:

-Ажил, гэр хоёрт голын хийтэй улстай гойгорсоор байгаад өөрөө өвчтөн болох нээ гэж урваганав. Би түүний салхийг сатааруулах гэсэндээ

-Амьдрал гэдэг өдөр бүр хүнийг зулгааж байдаг. Би ч бас залуугаараа залхаж байгаа хүн. Та хашир хандгай. Хорвоог хоёр хөл дороо гишгэж байгаад тэнгэрийн хаяа хараад үз. Малгайн утаа сэргэж толгойн эргээ гардаг гэх юм билээ.

-Олон жилийн хөр, төмөр хунгар болдог юм байх. Баргийн салхинд ханзрахгүй дэг. Эхнэр авна гэдэг махан хавханд мөчөө хавчуулж ясны янтай нас элээхийг хэлдэг юм биш үү.

-Эр хүн гэдэг үйлтэн гээгтэй чөтгөртэй дэр хуваахгүй бол бурхантай таардаггүй.

-Ингэхэд чи шүтлэгтэй гэл үү.

-Удам хөөвөл дээдэс маань харын бөө талынх. Бурхны шашныг сүжгээс тийрдэггүй ч гэсэн одоогийн орхимж нэмнэсэн бухнуудад итгэдэггүй. Харин та ямар шүтээнтэй вэ.

-Би бурхангүй буг.

-Итгэлгүй амьд явах гэдэг сэтгэлгүй хүүхэнд сэмжрэхтэй адил гэх юм билээ.

-Чи миний хамаг шүтээнийг дэвсчихээд юунд мөргүүлэх гээд байгаа юм бэ?

-Зах зээлийн бурханд...

-Мөнгө зоос уу...

-Нуруулдаж хэлвэл тийм. Тэгэхдээ ажлаас ашиг ургуулж амин зуулгаа залгуулах ухаан.

-Дагвын мөрөн дээр дахиад нэг толгой ургавал болох л юм. Тэр яахав. Чи нөгөө тамын тогоо гээчийг хараа л биз дээ.

-Манайхны төсөөлдөг манзны тогоо биш, галт уулын хайланг шиг юм даргилж байх юм билээ. Бас л барьсан эзэн нь үл үзэгдэх мөртөө түүн рүү шор гудрав уу гэтэл хэн нэгний өлгөн гаргаад харуулав. Тэр нь “до” яамны “балин хамарт” хурандаа

Үл үзэгдэгч:

-Хөнхөр энэ хоёр бугуй бугуйл хоёр. Эд нэр махчингийн ам руу хүн хөөж явсан тууварчин. Харин нядлагчийн нэг нь энэ. Тэд цөм энд байгаа. Хэзээ ч хүн төрөл олохгүй гээд чулуудахад нөгөө хурандаа живж орхив.

Хэн барьж байгаа нь харагдахгүй нөгөө шор мэт зум хутгах шиг болоод миний зүс гадарлах хүмүүсийг надад ээлжлэн харуулав. Тэнгэр минь хэн хэн байсан гэж санана. Манай хоёр ч маршал, бас нууц албаныхан тэнд л шалзарч байдаг юм билээ... Үүнийг ярьж үлдэгсдийн сэтгэлийг үйрүүлээд яахав.

...Ямар ч юм бэ хурал. Хөнхөр үг хэлж байна.

-Бал дарга минь биднийг дөч гаруй жил удирдахдаа бүх амьдралаа монгол улсын тусгаар тогтнолын... гэтэл тасарч орхив. Ямар нэгэн бичгийн үсэг тодорхуйг ажваас “Ийм учраас социализм байгуулж байгаа Монгол улсыг Зөвлөлт Холбоот улсын бүрэлдэхүүнд нэгтгэхийг хүсье... гарын үсэг...”

Үл үзэгдэгч: -Харав уу.

Сүнс: -Итгэмээргүй юм.

...Дарга нар хуралдаж байна. Бал дарга:

-Зөвлөлтийн нөхдийн тавьж байгаа саналыг үндэслэж хилийн асуудлыг шийдэх хэрэгтэй. Эсэргүүцэгчдийг хатуу арга хэмжээ ав гэж байна.

Үл үзэгдэгч: -Энэ тухай чи дуулсан уу?

Сүнс: -Увс нуур, Давст уул, Тагинын нуруунаас оросууд тасдаж авсан юм гэнэлээ. Хүчинд автсан байхаа.

Үл үзэгдэгч: -Хүргэн хүүгийн хүзүү ч бас сунасан. Тэгээд ч танай дарга нар холбоот улс, орос эхнэр хоёрт угнуулаад сүүлдээ боол болсон. Гоёж хэлбэл монголд тохоогдсон оросын амбангууд.

Сүнс: -Оросууд элсүүлэх гэж өвөрт нь гүнж хийсэн гэлцдэг юм.

Үл үзэгдэгч: -Гүнж ч юу байхав. Танай дарга нарт аягачин шивэгчнээс илүү юм зайдлуулаагүй.

Сүнс: -Мэдэхгүй. Шар толгойтой юмнууд чирээд л ирдэг байсан.

Үл үзэгдэгч: -Тэдний үсний өнгө яахав. Дотор нь их гүрний өргөс зоодог байсан юм.

Сүнс: -Бид чинь дарга нараа сонгодог...

Үл үзэгдэгч: -Сонгодог биш сунгадаг. Тэд чинь албаны моринд янгиа тохсон л бол оросууд аваачиж алтал ховхордоггүй байгаа биз дээ. Хөнхөрийн хайртай дарга нарыг бид бурхны орон

хүний орчлон хоёрын аль алинд явуулж чадаагүйдээ хүлцэл өчье гэж ёж бараалхуулаад

Үл үзэгдэгч: Хөнхөрийг эцэг эхээсээ илүү даргад хайртайг мэднэ. Тийм зусарчид өчнөөн хүний амь амьдрал сүйтгээчдэд сүү хадаг барьж долдойлж байсныг ч мэднэ. Түүнийхээр бол бид Алтан, Хучир, Түшээт хан Гомбодоржийн Бунтар, Эфү Цэрэнгийн Цэнгүүнжав, бас танай дарга нарыг бурхны оронд явуулаад амь эрсдсэн бүх хүмүүс, Амарсанаа, Чингүүнжав мэтийг тарвага зурамны хүүхдүүдтэй хашиж суух болж байна уу. Нэртэйгээр нь алуурчдыг бус алуулсны нь цээрлүүл гэл дээ. Хувьсгалын хугархай хутга чи үүнийг хар... гэв.

...Мөнөөх барьсан эзэнгүй шорорхуу гэхээр юм халуун хайлмал руу гудран тэмтчиж байснаа Хөнхөрийн аавыг сөрлөж гаргаад харуулах нь тэр. Нүд хальтраад аньсан боловч зовхи нэвт харагдсан биз. Зүсэн бүрийн дарга нарыг шалзарч байхыг хараад цэрвэсхийх төдий байсан ч Найданг тэлчилж байхыг хараад сүнс тарчилсан даа.

Үл үзэгдэгч:

-Алтан Найдан амьдын ялаа эдлэж байгаа нь энэ. Түүнд төрөл арилжих эрх байхгүй гээд буцаагаад шидэж орхисон...

Эмч:

-Базарвааний хумпад!

-Наад үг чинь намын амнаас гарамгүй юм.

-Миний амнаас унаж байгаа юм. Нам гэснээс манай намын хянан шалгах ч чанга байсан шүү.

-Өөрсдөө мухар юм шиг өдөр бүр салтаанд хуцсан хэдэн хар нохой байсан юм гэх чинь билээ. Та залуудаа шагайсан байлгүй.

-Нэг удаа орж нэмнээгээ уруулсан. Тэгэхдээ улс төрийн хэргээр бишээ.

-Хүүхэнтэй хүзүү сээр холбосон уу.

-Хоёр биендээ сайн байсан болохоор уулздаг “койтус” хийдэг байлаа. Гай болоход хэн хэн нь хань ижилтэй болохоор “ёс суртахууны доголдол” гээчээр хусуулсан.

-Яаж?

-Намын орлогч болоод хөдөө хөөгдсөн. Хэдэн жил хөхөрч гандсандаа. Тэр үед чам шиг юм байсан бол нохойн хороо, гахайн хашаанд новширч үхэх байсан биз.

-Та жинхэнэ хайр дурлалаа хяргуулчихсан юм биш биз.

-Айл гэрээ буснихгүйгээр сэтгэлээ шагнаж болно.

-Хайр дурлал гэдэг эр эм биеийг эзэмдэх улангасал. Энэ хорвоод үхлийг мартуулдаг цорын

ганц галзуурал гэнэ. Таны номоор бол өвчлөл, даамжрал, эдгэрэл гэсэн гурван үетэй гэж болно. Та эхнэртээ ухаангүй дурлаж суусан уу?

-Чи яах нь вэ.

-Хүний сэтгэлийн түймэр үргэлж ноцож биш, цурванд ордог юм. Эр эм аль ч хүнд байдаг, уйдал, сониучлалын эрхэнд зуурдын цэнгэлээр зогоол хийх гэсэн таны алдуурлыг би зөвтгөж байна.

-Огт сонсоогүй үг байна.

-Бид чинь бие биедээ цөөврүүд. Өнгөтэй өөдтэй бүхнийхээ буруутган хяргаж барсан. Одоо ч гэсэн энэ шавхайн шар улаан сонинууд хонготой, хормойтой хүн үлдээсэнгүй. Нам номоор нь ялгаж улс үндэстнээ хагалж, монголын их голомт руу сарьцгааж байна. Энэ мэт новшнууд тамд шалзартал эх орон амаржиж, гал өөдөө ноцохгүй.

-Арай ч чангадна.

-Тан шиг билбүүрдсэн билүүний бааснууд өвдгөө зулгартал мөлхөж байгаа цагт харин ч зөөлдөнө.

-Тэгээд яах гэж?

-Ядаж өөртэйгөө тэмцэж эхлээд өөрийгөө ялах ёстой. Ойлгож цөхсөн орооцолдооноор бус амьдралыг арай энгийнээр хэлэгчээ болж байгаа царай минь энэ.

-Бурхны ном шиг дуулдаад байна. Ардыг мунхруулагч хар тамхи гэдэг шиг...

-Энэ таны хэлсэн үг үү

-Үгүй ээ. Суут Марксынх

-Та өөрийн амаар ганц удаа ч болов будаа бувар бувар идэж үзээч. Тэгээд ч хар тамхийг заавал татах албагүй.

-Ревзионизм ч гэж байсан.

-Засварлах үзэл гэж үү. Та бол дагаварлах үзэлтэн.

-Бүхнийг ялагч сургаалаар хүмүүжсэн.

-Яасан сайн юм бэ. Үхэл зовлон үгүйрлийг ялаад өгөөч.

-Зах зээлтэйгээ заргалд, хүү минь!

-Тэгвэл таны сургаал бүхэнд ялагджээ.

-Бүү мэд. Насаараа дугуйландсан юмаа л хэлж байна.

-Аргагүй ээ. Ганц гадас тойроод ээрүүлдэхээр эргүү тойруу болдог юм гэнэлээ.

-Чи их мэдэгч юмаа.

-Бассан басаагүй багаа би мэдэж байна. Хүний амаар хуцдаггүй нохой явья л гэж боддог. Би хэрүүлчдээ бус өөрийгөө өмгөөлөхийн тулд ярзганаад байгаа юм.

Эмчийн царай минчрэн уурандаа шатаж байгаа бололтой.

-Чамтай хэрэлдэж байх зав алга. Солиотой нь цэцэн, согтуу нь баян болж дон нь илэрдэг юм. Өнөөдөр чи хангал азарга шиг сагсалзаж л бай. Нэг л өдөр нэмнээтэй бяруу болно гэж зандчаад “хурц үе, хурц үе” гэж үглэн давдаганаж “остоортоо” шизофрени хурц үе, хурц гэж амандаа үглэн бичвэй.

Арван дөрөвдүгээр тэмдэглэл

Эмч өнөөдөр ер бус хөхүүн, зүрхнийхээ гижгийг нууж үл чадан нүд нь жортийсхийн гурвалжилж аальгүй мишээл алдуурах нь юусан билээ.

Эмч:

-Чамаас нэг юм асууя гэж урд шөнө нойр хөрвөж хэвтэхдээ бодлоо. Чиний очсон газар... би бас л самуураад... Хөнхөрийн очсон тэр Эрлэгийнд эм сүвтэй амьтан дайралдах юм уу?

-Та шинэ шөл уугаа юу? Өчигдөр Та сувилагчаа явуулчихаад яльгүй гажигтай болов уу гэмээр нэг хүүхэнтэй хаалгаа түгжээд эмчилгээ хийсэн биз дээ. Тэгэхдээ би таныг буруутгах гээгүй. Амаа барихгүйн тулд амьдралын хишгийг олдож л байвал хүртэх хэрэгтэй. Жаргалаас гадна цэнгэл гэж бий. Үүнийг та юу эс андах вэ.

-Тоорой чи судас барихдаа хоосонгүй бололтой.

-Оргүй биш, тэгэхдээ ор дэрнээс холдохгүй.

-Орчлонгийн явдал, оймс өмдний ороомог яах вэ. Би чамаас тэр газар гээээгтэй юмны бараа харав уу гэж асуугаад байна шүү дээ.

-Бас л үнэмших аргагүй юм даа. Хэн нэгэн хааны хатан бололтой богтго малгайтай шүр сувд болсон авгайг харууллаа. Уг нь насжаар боловч царай тунгалаг, нүд хөмсөг болсон эзэгтэй юм.

Үл үзэгдэгч:

-Чи үүнийг таних уу? Энэ бол Өгөөдэй хааны Дөргөнө хатан...

Түрүүчийнхээс нас залуу агаад хянгадуу хамартай шарангуй царайтай хүүхэн үс нь сэгсийн асгартал уйлан мөлхөж байх юм.

Үл үзэгдэгч: -Энэ бол Гүюг хааны хатан Огул Каймыш.

Тэгээд ташаа тулсан, ширүүн дүртэй, давхар эрүүтэй цэнхэр нүдтэй, шонтгор авгайг харуулав.

-Энэ хэн бэ? Чи сайн хар!

Нөгөө эхнэр цашаа харан зогсож буй цагаан толгойтой хүний энгэрийн жижиг халаас руу алгын чинээ эвхээстэй бичиг шургуулж “Чи мартдаг шүү. Наана чинь ажлаас халах шинээр томилох сайд нарын нэрс байгаа. Энэ ёсоор тогтоол гарга” гэхэд нь зүс танив.

Үл үзэгдэгч: -Танай хэдэн ноёдын ноорцог энэ эхнэрийн эрүүний шөл ууж салтаанд нь хоргодож байгаа биз дээ.

Сүнс: -Ойртож чадсан хүн, олз омогтой л гэж ярьдаг байсан.

...Филатова авгай үл тоомсорлосон байдалтай ярвайсхийн зогсох агаад сайд дарга нар боллолтой хүмүүс хадаг дээр тугтуйлсан мөнгө тавьж хоёр гардан барихуйд тоомжиргүйхэн тосч аваад урт ширээнээ шидэсхийн овоолж байна.

Үл үзэгдэгч:-Танай бялдууч нар энэ чавганцыг эмгэн шулам болгож байна. Та нар “ажаа мама” гээд ширэгсэн дэлэнгий нь үлгэх шахаа биз дээ.

Сүнс: -Монгол хүүхний хундган цагаан мээмээр дутаагүй.

Үл үзэгдэгч: -Тиймээ чи олон эмийн хөх гувшсан. Чамд харуулна. Харин одоо гэтэл...

...Дөргөнө хатан эрх эвдрүүлж хордон үхэж байна. Огул Каймышийг эсгийд ороогоод ус руу шидэж байхад “мама” оросын хөндий байшинд амьсгал хураана.

Сүнс: -Эх хүнийг...

Үл үзэгдэгч: -Эх хүний нь хувьд бус эмэгчин барс болж төр самардсаны гэсгээл. Та нар өглөө босоод өрхөө татахдаа өчигдрөө мартдаг. Түүх бол шүүх! гэсэн шүү.

Эмч: -Төрд халдсаныг нь гэсгээдэг байж. Төрхөм зуур бүсгүйчүүдийг яаж байхын юм бэ.

-Харуулаагүй.

-Эмэгтэйчүүдийн шорон гэдэг шиг тусдаа юм болов уу.

-Мэдэхгүй. Та яагаад хүүхнүүдийн мууд дурлаад байгаа юм бэ.

-Тэр алмасууд чинь бухан дээр харайдаг үнээ шиг өөрсдөө өдөж өмдөө шувталдаг. Тэгэхэд заавал бүлүүр нь буруудаж хөхүүр нь яагаад цагааддаг юм бэ. Тэгэхээр шударга бус юм тэнд чинь байна л гэсэн үг.

-Өөдөө харсан бүхэн дээр өвчүү тохдог нь буруу байхгүй юу. Таны муу хуучин буу гэхэд хичнээн ч эмийн хэцүү нэрт дээр шондоостой байсан юм билээ.

-Тэгвэл бурхантай л заргалдах болж дээ. Үхэхийн хоорондох зайд үзүүр, ёзоор хоёр яах гэж хуваасан юм бэ.

-Арга билэг гэдэг. Энэ бол зохицол. Түүнээс бус хуялын солиоролд, хуухнагаа зумлаж, дайралдсан бүхнээ дагиж бай гээгүй.

-Чи чинь бурхантай уулзаагүй гэсэн биш үү?

-Бурхантай бас чөтгөртэй гээч

-Тоорой минь худлаа шаахад хэмжээ бас бий.

-Та бид хоёрт бол байхгүй. Та бол олон түмнийг ёстой хамраар нь газар хатгуулсан. Тэгээд л өчнөөн хүн өөрийгөө нээж чадалгүй, өглөг горьдож оюуны гуйлгачин болсон. Орон бүхний пролетари нартай нэгдэх хүмүүс чинь та нарын ухуулгаар хувхайрсан барлагууд биш гэх үү? За за больё. Таны шөл ууж шөрмөс чангалсан сэтгэлийг унтраагаад яхав.

Эмч:

-Ах зах хүнээр тогловол амныхаа хишгийг бардаг юм. Над шиг намрын ухна гайхуулаад юу шалихав. Гайгүй сайндаа галзуу ганц л биз. За, за чамтай халуурсаар байгаад чацуу юм шиг болох нээ гэж жумалзсанаа мөнөөх “остоороо” хамхиад ширээний гуяны шургуулга руу шидэж орхивой.

Арван тавдугаар тэмдэглэл

Эмчийн царай бүрзийжээ. Түүний ам гарилтаж буй бололтой хүйтэн ус залгилж ёйлох хараах хоёрын хооронд ямар нэг юм үглэгчээ аядаад

-Золигнуудаас болж зовлого тарж явчих нээ гэж бачимдав.

-Архи уусан хүнд өөрийн буруу байх биш дээ.

-Би ч уг нь нэг их гулраад байдаг гудрага биш. Хааяа нэг алдуурчихаад болохгүй юм.

-Эр хүнд тэр зэргийн юм байхгүй яахав. Тэгээд ч амьдралын гачаал, нийгмийн солиорлоос хэлхээ хэлтэрч, сэтгэл санааны сэвнээс хагацаж байх нь зөв.

-Архийг зөвтөгдөг хүнтэй анх удаа таарч байна. Хөх монгол хөлчүү мэлхий болж байгаад би харуусдаг. Бүгдээрээ лонхонд орчихвол бөглөчих эзэн мундахгүй.

-Тиймээ. Тэгэхдээ архийг цагдаад хэн дийлсэн юм бэ. Лангуугий нь хураачихаар гутлынхаа улнаас эхлээд дайралдсан бүхнээс нэрж тахал хижгээр хиарч байсан түүх бий.

-Хор нь тэр. Ашиг нь юу юм бэ.

-Хор бус зовлон анагаах жаргал дэврээх эм ч байж болно. Архи уусан хүн баярхаж, бяралхаж, уйлж, дуулж, үнсэж үнгэх гэж шүлсдэж есөн шидээр аашилдаг биз дээ. Тэр чинь өөрийгөө мөн чанарт нь хүртэл шалдалж тараа таниулж байгаа нь тэр. Эс тэгвэл торго даавуу, арьс хөрсөн нэмнээн дор хэн байгаа нь мэдэгдэхгүй болдог. Таны архи хаашаа ордог вэ.

-Ходоодноос өөр хаана орох юм бэ.

-Хоёр улаан хоолойны аль нэг рүү ордог гэнэ. Дээшээ гарвал ам доошоо орвол дотоож урдаг юм.

-Хэлэмгүй хүн сурамгай гэдэг.

-Хэлдэггүй хүн дадамгай ч гэж бий.

-Бурхан харж байгаа.

-Буг ч бас нүдээ аньдаггүй.

-Тэр эрлэгийн чинь бүрлээдчийг харж болохоос бус энэ орчлон дээр юу болж байгааг хаанаас харав гэж.

-Харуулдаг юм.

-Яагаад?

-Байцаалт дээр барин тавин шүү дээ.

-Яана гэнээ. Ард үлдсэн хүмүүс яаж байгааг уу?

-Тиймээ. Тэгэхдээ бүгдийг биш. Эд мөрийн баримт хэрэгтэй болвол энд юу болж байгааг үзүүлнэ шүү.

-Жишээлбэл?

-Доль Чойдор гэж До яамны мэдээлэгч зэс хошуутай зэвтэй хадаас байсан юм. Тэр золиг “Хөнхөр ч барж идэхгүй хоолтой хүн” гэж илүү үзэн танддаг байснаа үхсэн хойно сүнс эргэлдэх хооронд түүний муу хашаа байшинг эрхэндээ авч онгичсон юм. Хатуу юм л эрээд байгаа царай нь тэр. Тэгээд нэг муу вааранд хийсэн өгөөшнөөс хэтрээгүй гэнэ. Тэгтэл шатсан хүүр харуулаад Үл үзэгдэгч:

-Хүнд танигдахааргүй болсон байгаа биз. Чойдор гэж байсан хүний хярвас энэ. Хөнхөр ч ялгаагүй хүний ул шөвөгдөж явсан угаадасны золбин

...Бүрлээчийн байшингийн доод газрыг алга дарам газар үлдээлгүй зоорлин ужжээ. Чойдор юу ч эс олсондоо урам хугарсан бололтой овоолготой шалны модны дор ганцаараа тамхи баагиулан шилтэй архи амаар нь хөнтөрч сууна. Харуй бүрийд ийнхүү ганцаар хохийн суух мөртөө “Алтан Найдан түй” гэж хараал тавих аж. Тэрвээр нилээд согтож хажуулах буюу дугхийх гэсний алин болохыг бүү мэд. хэвтмэр аядсанаа хухирч байх юм. Түүний шидсэн тамхи шалны модны сэлтэс, цаас мэтэд унгадан асч харанхуй май болов. Төдөлгүй гал авалцаж түймэр оволзох нь тэр. Гал командын машин ирж усаар тургисан боловч юу ч үлдсэнгүй. Чойдорын хуйхлагдсан хүүрийг тэд сэжиглэнгүй харан зогсно.

...Өглөө үүрээр орон сууцны байшингийн хогийн савыг төнхөн хэн нэгэн авгай бөгтөлзөж байна. Түүний буртаг хувцас, осгортож хөхөрсөн царайг харвал Сайнаа. Хөөрхий минь насны хярд эрийн өвөр бүлээцүүлж байсан амьтны үр шүү дээ.

Үл үзэгдэгч: -Энэ хүүхнийг Хөнхөр л хогийн саванд хийсэн дээ.

Сүнс: -Орох орон, оочих аягатай л үлдээсэн юмсан.

Үл үзэгдэгч: -Хөнхөр түүний хэвлийн илчинд царцуу шар сэмжээ гэсгээж байсан мөртөө итгээгүй. Булсан буянаасаа сохор зоос өгөөгүй. Түүний салтаа тэнийж байснаас сарвуу тэнийгээгүй. Тийм үү?

Сүнс: -Бага юм болохоор барьц муутай л гэж бодсон биз.

-...Соёмботой өндөр сандал дээр нэгэн шилбэлзүүр хүүхэн баруун зүүн этгээдийн арай нам сандалд мануухай мэт эр эм хоёр суужээ. Шүүх хурал болж байх юм. Тэгтэл юу болсон гэж санана. Өргөмөл ганц хүү Оргил нь ялтан болжээ. Дархан хотод “Гоон” гэдэг нэрмэл нууцаар зарж эхнэр хүүхдийнхээ голыг зогоож байсан амьтан аж. Тэгтэл нэг лүд нөгөөхөөс нь гудраад үхсэн бололтой. Арван жил ерийн дэглэмтэй колонид гэсэн тогтоол уншиж байх юм. Эхнэр

хүүхэд нь нулимсандаа хутгалджээ.

Үл үзэгдэгч: -Хөнхөр бол хүний шаар. Энэ муу гөлөгний идүүрт хусам хийгээгүй.

Сүнс: -Уг нь эцгийн буянаар амыг нь тослоё гэж бодсон биз. Даанч хэлэн дээрээс нь үг унагах завгүй та нар дуудчихсан.

Үл үзэгдэгч: -Дуудаагүй бол түүний хэл ирвэгнэхгүй байсан. Харамчийн гар ханцуй дотроо зангидаастай байдаг болоод л тэр гэж ашигласан...

Эмч: -Би бүр айх шиг боллоо.

-Та айх хэрэггүй. Танд харамлах юм байхгүй. Социализмээс сохор зоосгүй үлдсэн хүн сэтгэл жаваргүй байж болно. Харин амин зуулгын зэмсэнд арван хуруугаа түлж явсан хүмүүсийг жижиг хөрөнгөтөн гэж адлаж байсныхаа зэмийг дуулж магадгүй.

-Алив мөлжлөгтэй тэмц гэсэн Маркс Ленин хоёрыг урдаа барина даа.

-Хүн дууриасан толгойноос, мал дагасан хөл дээр л гэх байх даа. Та өмчийг үзэн ядаж, өөрийгөө хувхай мод болгох сургаалаар амьтныг шавхуурдаж амин зуулгагүй болгосон. Хамтрал “хомуун” нэгдэл гээд өнгөрсөн зуунд та нар малчдыг дахин дахин шуургадаж хувхайлсан.

-“Хомууныг” мэдэхгүй. Нэгдэл бол хамтын аж ахуйн дээд хэлбэр байсан.

-Ямааны годны мэдэлгүй ялтай мал дагуулж, хар цайтай хатсан гээд л...

-Уг нь би улаан засагтай ч улсын өмчтэй байсан. Даанч өл залгах юм надад өгөлгүй идчихлээ.

-Та хэдэн мал дагасан бол шөлний төлөг шулгалах байсан. Цалингийн зэснээс уяатай зараал болохоор завсарт үлдсэн. Тэгээд ч улсын өмч дээр язанганаж байсан өтний завсар таны хушуу багтах зай байгаагүй биз.

-Өмч хувьчлалын ягаан, хөх тасалбар тараахаар нь шудрагаар хувааж авах нь гэж бодоод хүлээсэн

-Ноёны гадаалахыг хүлээж нохой гуриатахын үлгэр болж дээ. Тэнгэр газрын алинд ч таны дуу хүрэх нь өнгөрсөн.

-Бурханд...?

-Та түүнийг дэндүү их гомдоосон...

-Толгой хамуурч гүйцлээ.

-Тархи самуурч гэвэл ононо.

-Ингэхэд чи эрлэгийн элч гээч үү?

-Хэнээр элсэгдсэн бэ гэж асуугаад хэрчээд хаячихаж байсан шигээ намайг сэрдэх нээ.

-Чи яагаад “До” яамыг ад үздэг хүн вэ?

-Тэдний үхлийн хавтсанд та бид хоёрын нэр байгаа шүү. Та цаг өөр болсон гэж цагаан санах хэрэггүй.

Эмч ширээн дээрээ гурван хуруугаар доголлон хэмнэл тоншиж доод уруулаа хэгзэртэл зуувай.

Арван зургадугаар тэмдэглэл

Эмч өнөөдөр хөл нь газар онохгүйгээр хөөрчээ. Түүний энгэрт ойн медаль гялалзана. Гэвч хөөрхий амьтан чихрийн жаал шиг хууртан гэрэл цацарсан мишээл асгаруулж энгэрээ сэм харцаар мялааж буйг хараад би өрөвдөв. Тэртээ тэргүй тэтгэвэрийн данстай буй түүнд орчлонгоос авч буцах юм нь энэ л юмсанж. Эмч нарын хувьд энгэр бүтэн хорвоог элээдэг болохоор түүний сэтгэлийн сэвсэрлийг хэрхэн буруутгах билээ. Би түүнд

-Баяр хүргэе. Угаахгүй бол булган сүүл нь бухын сүүл болчихдог юм гэнэ лээ гэв.

-Угаалгүй яах вэ. Төрийн мэлмийд өртөнө гэдэг бага юм биш. Биеийн байцаалын “гавьяа шагнал” гэсэн хүснэгт олон жил онгорхой явсны эцэст бөглөрлөө.

-Төр таныг мөлжиж дууссан хойноо л нүдний булангаар хяламхийж дээ

-Нүдний булангүй нүхэнд орох алийг тэр гэхэв. Эрлэгийнд энгэр хувхай очихгүй боллоо.

-Тэнд тэмдэг цуглуулдаггүй.

-Гавьяатай гэхэд гал руу шидчихгүй байлгүй.

-Таны гэнэн барагдах болоогүй байна. Та бид хоёр юу эсийг үзэхийг би яаж мэдэх вэ. Харин Хөнхөр бол тарчилсан шүү. Манайхан арван найман там гэж ярьдаг даа. Тэр бүрээр ороогүй. Шуналын, худлын, тэчъяалын гурван там дайрсан. Эхлээд шуналын тамд орсон.

Цөөврүүд биежсэн сүнсийг зулгаасаар ёстой л мөлжүүр барсан. Сүнс үгүй болж өгдөггүй. Арга ч үгүй юм. Голыг нь таслалгүй зовлонгийн зогоол болгодог юмсанж.

Үл үзэгдэгч:

-Чамайг хэн зулгаав? Цөөврүүд бишээ. Шунал зулгааж байна. Хөнхөр бол насаараа дэнэмгийрч өрөөлийн аяганд нүдээ унагаж явсан. Тэгсэн мөртөө өглөө үхэхээ мэдэхгүй өөрөөсөө хүртэл хармалсан бэрд. Цэвэлжид, Сайнаа, Оргил гуравт хармын хар сарвуугаа сарвайгаагүй. Тэднийг зовлонгийн зоог болгосон.

-Хөнхөр хушгаа холгосноос бус хуруугаа хуйхлаагүй. Хов живэнд холхиж улаантны улыг долоож олсон цалин нэртэй зарцын хөлсөөр хоног төөрүүлж ойр тойрныхондоо шавхруу төдийг амсуулсан. Түүний ам ангалзаж, хэл гозгоносоноос бус алганд нь цэврүү үсрээгүй гэснээ үүнийг биежүүл гэж тушаав. Хоромхон зуур түүний араг ясыг арьс мах нөмрөв.

Зөвхөн үүгээр дууссангүй. Таваг овоолон хэрчсэн алт мөнгө, шүр сувд урд нь тавиад Үл үзэгдэгч:

-Чи амьддаа идэж чадаагүй буяныг цадтал ид гэж тушаагаад үл үзэгдэх гараар ам руу чихүүлэв.

Улаан хоолой цагаан мөгөөрстэйгээ урагдаж, ходоод нь сэг болоод цусан зам татав.

Үл үзэгдэгч:

-Найдангийн Хөнхөр шуналын тулам байсны шан энэ. Сүнсний нь худлын тамд хая гэж уулгалав.

Худлын тамд сүнсний хэлийг өргөстэй өрөлбөөр хавчин сунгалаа. Хүний хэл мөн ч их сунадаг юм билээ. Утас шиг сунгах мөртөө зангидахыг нь яана. Тэр тоолон “Чи ингээд матаж бай”, “Ингээд худал суртал бурж бай”, “Ингээд хүн мэхлэж бай” гэж тавлана. “Байяа” гэж орилох гэвч хэл гэдэг зэл болсон болохоор дуугарах арга байхгүй. Эцэст хэлийг нь хурц хайчаар үйртэл хэрчиж хаяв. Ёстой нөгөө махаа иднэ гээч энэ.

Үл үзэгдэгч:

-Чи надад хорсож, муугий минь үзлээ гэж бодож байна. Энэ бол чиний тэнэглэл. Сайн муу үйл алин боловч хойчийн өдөр өнгө ялгарч, өршөөл, гэсгээлийн хувь хүртдэг. Бид хуурай гүжрээр ялд унагадаггүй. Танайхны ширээ тэвэрсэн хэрээнүүд шиг хилсээр хэрэг тасалж нүд ухдаггүй. Бусдын зовлонгоор зоолж байсны чинь хариу энэ гэж аашлав. Тэчъяалын тамыг би танд ярина.

Эмч:

-Үрэгдээд биежээд байдаг нь хачин л юм даа.

-Тиймээ. Арьс махы нь барсан ч амий нь үлдээж байгаад дахин биежүүлж шүүдэг гэсэн шүү дээ.

-Чи тоолов уу. Хэдэн там байх юм бэ

-Түүнийг Хөнхөр л мэднэ. Гүйцээгээ биз.

-Чи яагаад мэдэхгүй гэж...

-Миний санамжинд тэд үлдээсэн мэдээлэлээ гурван тамаар хязгаарлаад бусдыг арчихаж л дээ.

-Чи барьц алдаад ирэхээрээ баашлаж байна уу.

-Анхнаасаа асган цутган юм чинь. Хүнд байдаг орчлонгийн мэдээллийн зургийг та шагайгаад үз л дээ.

-Чиний үгэнд үнэмшвэл манай аюулаас хамгаалахынхны тамалгаа ч дэргэд нь хүүхдийн шоглоом юмсаж.

-Эд нар амьдад нь тэд үхсэн хойно нь тарчлаадагаараа ялгаатай гэх үү дээ. Ингэхэд та хүн матаж байв уу?

-Намын даалгавараар хянан шалгахад мэдээлэл өгч байснаас гойд юм надад байхгүй.

-Тэд чинь халж, цөлж, үр удмаар нь үнсий нь хийсгэдэг байсан, буу жадгүй яргачид биз дээ.

-Чи ардчиллын гөлөг мөн байна.

-Би бол гэрийн нохой. Та нар бол хонь ч иддэг, хүн ч иддэг нийгмийн чоно.

-Намайг буудмаар байна уу.

-Үхдлийг бууддаггүй юм.

-Би хорлогч биш.

-Хохирогч ч гэж бас болно.

-Хөнхөрийн хойд нас болгож чамайг нааш нь илгээсэнд би гайхаж байна.

-Тамалдагаа тамлаад, “үхэхийн чинь өмнө чамайг оронд чинь хатааж бодолд чинь ширгээсэн. Эрхбиш чи өөрийгөө ялласан гэж тооцоод чамайг хугацаж үзье. Энэ удаад тамд “жаргаахаа” азнаж хүн төрөл олгож буцаая. Энд үзсэн харсныг бүгдийг нь бус хагас хугасыг нь санах ой сүнсэнд нь байг. Чиний мэтэд санамж сэрэмж болох юуны магад гэхийг нь би сонссон. Түүнээс хойш хаагуур тэнэж эрдэнэт хүний биеийг олж Тоорой болсноо би мэдэхгүй. Миний мэдэхгүй юм эндээс эхэлдэг юм.

-Тэгвэл би ч сэглүүлдгээ сэглүүлээд хоёр муу хүүхэддээ эргэж төрж болох юм шив дээ.

-Үхлийн элч биш болохоор үүнийг би мэдэхгүй.

-Би өөрөө мэдэх гээд үзэж тарах уу?

-Өөрийгөө егүүтгэх гэж үү? Ял дээр ял л болно.

-Тэгээд чи намайг яа гээв?

-Үзэл сэтгэлээ ариусгаж тоос тортогоо жаахан ч гэсэн сэгсрэх гээд үз.

-Ардчилагч бол гэж үү?

-Таны дотоод ертөнцөд тийм орон зай махбодод цаг хугацаа үлдээгүй. Зүгээр л зүрхнийхээ мөсийг гэсгээхийг хичээ. Таны үеийнхний гол алдаа бусдыг өөчлөх мөртөө буруугаа хүлээх эрэгцүүлэн бодох чадваргүйд байсан юм. Бурхны элч гэж андуурч чөтгөрийн зарц явсан хэвээрээ хар нөмрөгтэй буцаад яахав. Уучлаарай би хөвөнд боогоогүй чулуу тан руу нүүлгэчих шиг боллоо...

Эмч эргэлзэл, шийдлийн алин болохыг ялгахын аргагүй өргөсөрсөн харцаар намайг

шилбүүрдэвэй.

Арван долдугаар тэмдэглэл

Эмч маань халд хахирч хатуу зөөлөн үгэнд чих дөжирч сэтгэл хусарсан чиг хүний хуйх нь тэгтлээ бээрлээгүй бололтой. Төөлдрийн бидний сөрмөлцөөний дорсойл өрөвлөг нь хамжирсан мэт. Сац бас ширхэг бүдүүн, овсгоо цэхий хөөрлийн хөтөл давж, уруудахын уйдалд амьдралыг тээршээх, яршиглах болсон тул өтлийн чөдөр хэржээ гэж би бодов.

Тэрвээр шургуулганаасаа мөндөл гэж хүмүүсийн хочилдог хугасын хугас гожин архи гарган жимсний чанамалын жижиг шилэнд тусаагаад

-Одонгийн хишиг, ооччих хэмээн сарвайв. Би түүнийг нь ёсорхон авч ядам хуруугаар духаа мялаагаад

-Баярлалаа. Дүү хүү нь эр хүний гурван эрдмээс энний нь тойрзноод байгаа юм хэмээн буцаав.

Эмч:

-Амьдралаас олдсон бүхний нь хүртэж бай гэж чи номлоод байдаг биш билүү.

-Тиймээ. Тэгэхдээ хамгийн амттай нь энэ биш л дээ.

-Дэмий хөлд нь суухаас дээрээс хазаарла гэж үг бий.

-Та бол дээрээс нь эхлэсэн биз?

-Хүүхнүүд уруулаа соруулсан л бол бусды нь “би өөрөө” гэдэг юм гэнэлээ.

-Дуулаагүй юм байна.

-Тийм байх даа. Чи л болоод чихээ бөглөө юу.

-Хүсмээр зовлон биш юм билээ.

-Уухайс хө, тэнд бас л буруудах юм уу.

-Ярихаас яс үйрэх шиг болдог юм.

-Тэртэй тэргүй хим болчихсон миний яс ямар гарзтай юм биш үйрэх байтугай үнс болог. Сонсьё л доо.

-...Тэчъяалын там гээч нь хуял шивтэр нилхийсэн хар агуй л юм даа. Хананд нь загасны мэт шүдтэй, үхмэл өнгөтэй эм сүв умалзаж байлаа.

Үл үзэгдэгч:

-Хөнхөр бол нүд шилж нүх голдоггүй явсан шүү дээ. Ухнаас ялгаа нь уруул хөх хоёр үлгэдэг л юм биз дээ. Наадахыгаа хөвчрүүл! гэв.

-Яасан гэж санана. Биежсэн сүнсний муу мах гүрвэлзэж, судас нь чивчрэн чинэртэл жадрав. Үл үзэгдэгч, “наадахыгаа дуртай дулдга, дулаахан хамлдга руу нь шургуулаад өг” гэхэд харагдахгүй гар түүнийг тэврэн ханан дахь нүх рүү хэрэгслий нь шургуултал, нөгөөх оодойны загасан шүд тас хивж орхив. Эр хүний энэ муу нүгэлт хар хамгийн эмзэг эрхтэн юмсанж.

Үл үзэгдэгч: -Ханав уу гэж тавлахад сүнсэнд хэдэрлэх сөгөө байсангүй. Тэгээд ёстой л хөгөө хөлдөө, хөгнөө хүзүүндээ чирсэн дээ.

Эхлээд Цоохондой хятадын эхнэр, хөнжлөө ярахад хөх нь сэрийж салтаа нь сүү долоосон гөлөгний ам шиг харагдав. Үл үзэгдэгч:

-Хөнхөр энэ эмийг эхлээд эзгүйчилсэн. Цориг! гэхэд улайссан шөвөг тас татуулсан шодойны гол руу харван шааж орхив. Цус мах хярвасран гол тасрах гэдэг л энэ. Энэ мэтээр, Хөнхөрийн сүүлэрсэн эмсийг нэг нэгээр харуулж дөчин нэгэн удаа цоргив.

Үл үзэгдэгч: -Хуялдсан эмс нь гүйцэв үү. Мэлзэх санаа байна уу? Тэгтэл яасан гээч

...Халыг харахад Туулын хар усан тохой бололтой. Нэг охинтой Хөнхөр ямбий тэргээ угааж байна. Зүлгэн дээр чихэр, боовхон харагдана. Хоёр салаа гээг цагаан туузаар шодойлгон боосон охины савантай алчуур барьсан гарыг тэрвээр бумбадан авахад охин үргэсэн тором мэт сэртэсхийснээ гараа алгуурхан гулгуулж авах юм. Олон хүүхэдтэй айлын тэр сээмгэр охин, машинд суухыг хорхойсож надтай явсан хэрэг л дээ. Хөнхөр түүнийг аргадан магнайг нь илж “Танай ангийн охид цөм хүүхэн болчихоо биз дээ гэвэл “Па яанаа” гэж годгонов. Хөнхөр жимсний хуурай дарс аялгалж өгөхөд нэг балгаад “гашуун байна” гэвээс “Амьдрал амсахад гашуун, амтыг нь авсан хойно чихэр л гэсэн үг” гэж шахсаар байгаад уулгачих юм. Охины царай төдхөн үл мэдэг улаа бугархад нүүрээ даран түрүүлгээ харж хэвтэв. Хөнхөр түүний ууцыг илснээ хажуугаар нь хэвтэж “эм хүн нэг л өдөр охин насаа орхидог юм. Энэ бол хүний ёс” гэж шүлэнгэтхэд “Яанаа, хүн харчихна” гэж тэрвээр үл ялиг айлгүйтэх аядав. Хөнхөр барьцаа ахиулж түүнийг давхийн тэвэрч авахад “ээжээ” хэмээн сулбуухан дуудсанаа намайг тас тэврэх юм. Хөнхөр хацар, хоолойг нь үнсэж байснаа хоромхон гэдрэг харуулаад мордчихдог юм байна. Охины царай минчрэн тийчилж байснаа эрхэнд автсанаа мэдрэв бололтой эсэргүүцэх төдийхөн гиншив. Хөнхөр дотоожийг нь өрөөсөн гараараа шувтлангуутаа дүрж орхиход охин ёйлон түүнийг нүүр нүдгүй балбан “та муухай” хэмээн үглэснээ асгартал уйлах нь тэр...

Үл үзэгдэгч: -Муу төгцөг завжны нь сүү эгшээгүй амьтныг яаж байгаа нь энэ вэ.

Гэтэл бэлтрэг мэт зэгэл амьтан үсэрч ирээд сүнсний “хэцүү нэртийн” нь үлдсэн ёзоорыг зулгаан залгиж орхих нь тэр...

Эмч:

-Хоёр хүн сэтгэл нийлээд “койтус”-дахад буруу нь ч юу вэ дээ.

-Уг нь тийм. Гэвч тэнд тэгдэггүй юм билээ.

-Тэгвэл ганц би биш, эр сахиустай бүхэн эрэмдэглүүлэх юм шив дээ.

-Эхнэртэйгээ нохойтсоныг харин асуудаггүй юм билээ. Танд эвгүй байна уу?

-Чамд эвтэйхэн байна уу? Урд насандаа улартай явсан хүн хойт насандаа хормойн донтой.

-Та нарын үед хоцрогдсон даргыг “бөөн хар практик” гэдэг байсан шиг та ч “сексийн сэтгэшгүй туршлага” юмаа.

Эмч өөрийгөө магтлаа хэмээн додийсон боловч хорвоо хотойж, магнайгаа сархиалтал үнэнийг олж хараагүй гэсэн миний далд дөгөөг ухаарсангүй. Түүний мөчиг мунхралыг мэдэх тусмаа миний өрөвчлөл аажимдаа ханьсаж зэвүүрхлийн ир хялайж буйг би гадарлавай. Хүмүүн хэмээгч нь өөрийн сэтгэхүйг өдөөж учир утгын шинэ эрэлд цаг наргүй эс автвас үлэмжийн амарлингуйд өөрийгөө бүүвэйлэн арчаагүй номойроод нүд бүрхэж, сэтгэл хөхөөр хөрөх гамшиг нүүрэлдэг ажаам. Би тэр л замаар мөнхийн зогсоолдоо очих юм биш байгаа гэхээс айх шиг болж жихүүцэв.

Эмч эргэлзээ, ухаарлын алинд автсан нь үл мэдэгдэн түүний баргар царай дэлүүрэн хөхөлвөртөж:

-Чи шашны ном зохиол уншсанаа яриад толгой эргүүлээд байнаа даа.

-Үгүй дээ. “Молом тойны намтар” “Чойжид дагины тууж”-ийг саявгархан харсан. Халууны найм, хүйтний найман там, бирдийн орон, завсрын хавцгай ч гэнэ үү Төмөр балгасанд гэрэл гялбуулан суух эрлэг номун хаан, толь барин шүүх үхэр толгойт эрлэг, бичиг сачиг барин суух хүдэр толгойт эрлэг мэтийн тухай гардаг юм билээ. Тэнд Хөнхөрийн үзсэн харсан юманд эдний аль нь ч байхгүй.

-Тэгвэл гадаадын зохиолоос шамбодоо биз.

-Дантегийн “Тэнгэрлэг туульс”-аас өөр ном сөхөөгүй. Түүнийхээр там гээч нь газрын гүн рүү хавсан есөн бянттай цооног гэсэн байна лээ. Үүнээс өөр хэлэх юм байхгүй.

-Яахав дээ чи өөрөө зохиогоо биз

-Баярлалаа.

Эмч “ёв...” гэх нь “үхсэн элэнцэгтээ баярлаа юм бол” гэсэн дохио гэж би таалаа. Тэрвээр бичиг цаасаа хумхиж далд хийгээд ганц үг ганхийлгүй намайг орхиод шурхийн гарав. Түүнийг эргэж ирэх юм болов уу гэж хүлгэлзсэн боловч сураг алдрав. Намайг өөрийнхөө бодолд богшог гэсэн юм болов уу даа. Хүнийг зоргын зовлонд нь ширгээж төгсгөх нь тийм ч муу арга биш байж болох юм.

Арван наймдугаар тэмдэглэл

Сувилагч намайг бараг л чирсээр эмчийн өрөөний үүдээр түлхэв.

Эмч хяламхийснээ:

-Муу чөтгөрийн гурил чи дэгэслэх юмаа бодож хонов уу гэхэд нь би жуумалзав. Тэрвээр агсран

-Чи ард түмнийг, анагаах ухаантай нь мэхлэх гээ юу. Чам шиг чалчаагийн мөч богинодно. Чамд харах бараа барих биенээс өөр үнэн юм байхгүй. Ийм юмыг хуучцуул, “сүнсээ түймэрдэж, сүдрээ шатаасан сүг” гэдэг юм. Энэ хорвоод нүдний булай болоод удаагүй байж элэнцэгнийн чинь эрлэг, там гэж донгосоод байгаа юм бэ. Үнэнээ хэл! гээд ширээгээ дэлдэв.

Би цухалдсангүй.

-Эмчээ, галзуу чинь халдварт өвчин мөн үү

-Галзуу хүний шүлсээр, галзуу амьтны соёогоор халддаг юм.

-Би таныг ураагүй...

-Чиний шүлсийг идэхээрээ нэг боллоо.

-Тэгээд л...

-Галзуурч гэх нь үү. Чи ч ёстой арван сарвуутай амилсан буг юм даа. Надад чамтай заваарч байх цаг алга.

Чи нохой гаслаж, гахай шээтэл худлаа шаалаа. Үүнийгээ хүлээж үнэнээ бичээд ир гээд над руу хуудас цаас түлхэв.

Би тасагтаа ороод “Бархас овогтой Тоорой хэмээх Найдангийн Хөнхөрийн сүнс би эмч таны тушааснаар харснаа хараагүй мэдсэнээ мэдээгүй болж өөрийгөө галзуурсанд тооцов” хэмээн хэдэн үг хэлхээд оруулж өгөв.

Эмч гүйлгэж харснаа урж нүүр рүү шидээд

-Яасан их тоглоомтой газрын бэтэг вэ чи. Элдэв юм донгосолгүй үнэнээ хэлээд орон гэрийнхээ барааг харахыг бод мал минь гэж тачигнав.

Би аргадангуй царайлан:

-Мал гэж та тун онож хэллээ. Мах иддэг хүн малдаа хайртай байдаг. Та намайг бэлчээрт гаргаад явуулчих. Би өвс идэж ус ууж тэвээрээд ченжийн гарт орж “хүчит шонхор” захын лангуун дээр зовлогоо тавья. Хотын цайны газруудад улаан махны бузар гэж байх биш

гэчихсэн чинь бүр ярдагий нь хөдөлгөж орхив. Тэрвээр “бэлтрэг, бэлтрэг” гэж давдганаснаа суу! гэж зандраад дахин хуудас цаас зүглүүлээд миний хэлснийг бич хэмээн дуудсан нь:

“Бархас овогтой Тоорой би бусдыг мунхруулахын тулд урд насаа мэддэг, эрлэгийнд байцаагдсан, тамд тарчилсан мэтээр санаанаас зохион дэмий ярьдагаа хүлээж байна. Би гэнэн залуугийн харгайгаар ийнхүү ёс суртахууны алдаа гаргасандаа маш их гэмшиж байна. Үүнээс хойш энэ мэт үзэл суртлын хувьд ялзарсан авир гаргахгүйгээ нам... гэснээ... намаар ч яахав ард түмнийхээ өмнө тангараглаж байна. Гарын үсгээ зур! гэв. Би адармаалж “Найдангийн Хөнхөр” гэж гаргахааргүй шахам эрээчээд хуудас цаасаа хоёр гардан өгч ёсорхов. Эмч анзаарсангүй, санаа нь амарсан бололтой

-Ингээд л болчих юманд төвөг удаж өчнөөн хоног хүний нерв бараад гэж үглэснээ тасагтаа оч гэв.

Би толгой салаавчлан хэвтээд эмчийн хилэгнэсэн учрыг олох гэж бодолхийлэв. Тэгтэл гэнэт “мань хашир элдэвлэж байгаад миний оношийг тогтоох гэж оролджээ” гэсэн таамаг зурсхийв. Үнэхээр намайг ирснээс хойш, ихэрхэж, найзархаж, уурсаж инээж аягласан нь аргагүй л туршлагатай эмчийн сорил байснаас зайлахгүй нээ. Уг нь ч намайг олон овоор туршиж байгаа юм л даа. Сэтгэл судлаач хэмээх урт улаан хумстай будагтай хүүхнээр яншуулсан. Тэр нь Фрейдээс иш татаж, миний сэтгэл зүйг задран шинжлэх юм болов. Тэрвээр Фрейд гэж дуулсан уу гэхэд нь би “Зүүдний тайлал”-аас хэтрээгүй. Өөрийгөө жолоодох, оюун ухааны дарангуйлал тогтоох, ер бусын “Би”-гийн тухай бодож үзсэн, ухаан дугааж байна лээ гэсэнд басамжилсандаа ичсэн үү тэгсхийгээд явсан. Дараа нь зөвлөх эмчийн үзлэгт оруулахад цагаан толгойтой нүдэнд дулаахан хижээл насны эр миний өвчний түүхийг сонирхож үзлэг хийгээд “Энэ залууг сумо болгох гээгүй л юм бол энд тэжээхээ боль” гэж түс тас хэлсэн. Гэвч эмч маань хаширлаж харыг нь барах гэж саатуулаад байгааг үүлгэртэн бодож хэвтгэл хаалга угз татан ландгар эгч миний эмчид бичиж өгсөн андгайг надад өгөөд

-Наад бичигтээ Найдангийн Хөнхөрөөр өөрөөр нь үсэг зуруул гэж байна.

-Би яаж зуруулах юм бэ.

-Хэн мэддэг юм. Утсаар дуудахгүй юу.

-Тийшээ утасны үзүүр очоогүй л болов уу.

-Хотын захад юм уу

-Хорвоогийн захад...

-Үхсэнээ хийж тэнэж яваа юм бэ.

-Үхээд л тэнэж явахгүй юу.

-Энд би элдвийн л амьтантай таарлаа. Чам шиг эрүүл өвчтэй нь мэдэгдэхгүй лайтай хүний үрийг үзсэнгүй. Манай эмч аль ч хүнтэй аяа олдог хүн. Гэтэл чи л гэж чигжүүн хижиг гээч

нь юм байлгүй дээ. Миний хүү эмчийг минь зовоохоо больж үз. Өвчин гэдэг хэнд ч ирдэг гай. Зовох юмгүй зовиураа хэлээд эмчлүүлж үз. Хар нялхаараа амьтан хайран залуу насаа гаргуунд гаргаад яах юм бэ. Эгчийнхээ үгэнд ор гэж учирлав.

Би түүний үгэнд уядаж

-Үнэнээ хэлэхээр эмч итгэхгүй, худлаа хэлж би чадахгүй юм.

-Эцэг чинь! Энэ хорвоод үнэнээр яваад чи хаа хүрэх юм бэ. Миний муу аав намайг бурхны урдуур чөтгөрийн хойгуур зайгий нь олж яв гэдэг байсан юм.

-Би тэгээд галзуу хүн болж өөрийгөө гүтгэх хэрэг үү.

-Сургууль чинь оношлогоо, магадлагаа нэхсэн юм байх чинь билээ. Аргалж байгаад аминаас холуурхан акт гаргуулаад зайлахаа бод. Аав ээжээрээ яриулаад хэрэггүй биз. Урж тастчих гэсэн айхавтар улс билээ бурхан минь.

-Та эмчид хэлээд эдгэшгүй өвчтөн гэсэн бичиг хийлгээд өгч чадах уу.

-Үгүй чиш. Цаадах чинь тийм юм хийх хүн биш. Харин миний хүү аргаа сүйхээл гэж толгой илээд гарав.

Би сувилагчийн авчирсан сайхь бичгийг хэсэг зуур харж гайхалзсанаа цуу татаад хогийн саванд шидэв. Харин миний цөлшиж хоосорсон толгойд “үнэнч байгаад чи хаа хүрэх юм бэ” гэсэн сувилагчийн үг эргэлдэн энэхүү амьдын тамаас салахын тулд Хөнхөр, Тоорой хоёрыг хилсдүүлэхээс өөр гарцгүй гэсэн шахаа намайг түлхэж шаналгав. Гэвч өрөөлийг болдог юм гэхэд өөрийгөө мэхлэх зориг мохох нь юутай чавцаглал.

Асрагчийн сарвайсан төмөр аягатай шийжүү будааг хараад яагаад ч юм бэ, уяатай нохойн өмнө тавьсан төмөр идүүртэй угаадас шиг санагдан ой гутав. Ёстой л галзуурмаар энэ өдөр амьдарлаас би ямар нэгэн гэрлийн гялаан олж харахгүй болж хүн болсон хувь заяандаа гутрах нь тэр. Ийм үед үхлийн өнгө цайж мөнхийн амаршлын мөрөөр ормоор санагдах юм билээ. Гэвч нөгөө эрлэг тамд Хөнхөрийг эрдэмдэглэсэн айдас өрвөсхийж “бурхан” гэсэн үг сүжиг сэтгэлд өөрийн эрхгүй харваж бодол зогтусав. Бурхан гэснээс тэр авралтан яагаад Хөнхөрийг өмөөрөөгүй бараа нь харагдаагүй юм бол гэж санаа зувчуулваас бас улс төрждөг юм болов уу гэж инээд хүрэв. Ийнхүү элдвийн новш чихсэн толгойгоо дэрэнд хаяж хөрвөөсөөр нам унтаж өглөө сэрэхдээ нойр бол үхлийн төдийгүй амьдралын балар хагас юмсанж хэмээн хачирхаж билээ.

Арван есдүгээр тэмдэглэл

Өнөөдөр бидний заншсанаар хагас сайн өдөр. Хугас ажилтай байх үед энэ өдрийг ийнхүү шоодсон биз. Аав маань нэгэнтээ цухалдахдаа “бүх өдөр амардаг, дээр нь балжинням дашнямтай байдаг болоосой” гэж билээ. Тэгэхэд нь ээж “Монгол ухаан гээч нь үү” гэж амыг нь тагласан юмдаг. Эмнэлэгийн хувьд “Сайхь өдөр эл хуль” агаад жижүүрийн эмч сувилагч төдийхөн бөртөгнөнө. Эргэлтийн цөөвтөр хүнийг эс тоолвол хөл татруу. Миний мэт шинэхэн галзууг эргэж тойрохоос бус архагуудыг ах дүү садан нь мартдаг гэцгээнэ. Цөхрөнгөө бараад тэгдэг биз. Зөвтгөхөд хэцүү ч буруутгах аргагүй.

Манай ангийн охин эргэж ирэв. Нэр Солонго гэдэг боловч оюутнууд Соолоо гэж дууддаг юм. Соолоо бол очилсон бор нүдтэй шар охин. Тэрвээр удгалсан түргэн хөдөлгөөнтэй шилбэлзсэн адтай сэргэлэн гайхал. Эцэг нь Эрээний ганзгаар хөлжсөн цулгар гэлцэнэ. Би бараагий нь хараагүй.

Соолоо үнэтэй бус гэхэд дэгжин хувцсаар гангарах агаад саявтар нүдэндээ давхраа хийлгэсэн нь түүнийг улам шаавайлж өгснийг яана. Оюутнууд түүний халаасанд хайрын захиа байн байн шургуулна. Гэвч тэрвээр эс тоон тачигнатал хөхөрч надад үзүүлэн “солиотой амьтан. Янаг хайр гэсэн байгаа биз. Яг ш дээ” гэж тас шилбүүрднэ.

Соолоо намайг харангуут

-Хүүеэ, яана аа, Сайн уу... гэж доогтой мэнд чулуудаад манай ангийнхан чамайг галзуугийн гавтай үсрээд алаад хаяж байгаа гэсэн чинь зүгээр л байна шүү дээ гэж намжирдав. Би өжүүлж:

-Гоц халдварт галзуу юм гэнэ. Гар барихад л шууд авдаг гээч. Холхон байгаарай.

-Яадаг юм бэ. Эрүүлдээ хамт байж болдоггүй юм чинь,

-Хоёр галзуу нэг дор байвал... Хорвоо хөрвөөнө биз.

-Зовлонгоо мэдэхгүй жаргана.

-Тэр яах вэ. Сургуулиар сонин юу байна даа.

-Аягүй сонинтой. Манай ангийн Ламка, уран зохиолын багштай хандраад... чи яасан гэж санана. Багшийн эхнэр гэж лаг бүдүүн авгай нөгөө муу Ламкааг үсдэж байгаад бут авах гэнэ.

-Лаамка дурлачихаа юу?

-Яалаа гэж дээ. Дандаа нойлтож байдаг болохоор дүнгээ засуулах гэж панаалдсан байхгүй юу. Ёстой балай.

-Тэгээд дүнгээ засуулаа юу.

-Мэдээж ш дээ.

-Өөртөө байгаа бололцоог л ашиглаж л дээ.

-Па яанаа. Чи багш байвал тэгэж балайрах уу?

-Залуу бүсгүй зам дээр хэвтэж байвал тойрч гарах хэцүү байлгүй.

-Муухай амьтан.

-Тэр яахав. Ямар ном уншиж байна вэ.

-Хар мянган ном унш гэсэн. Нэгийг нь ч уншдаггүй шүү дээ. Хэдэн цаг хичээлд суусан болоод л орой нь рок поп, Баар, цэнгүүн... Аргаа барвал солонгос кино үзнэ гээд л бодчих.

-Уншихгүй амьд явах хэцүү л байх даа.

-Цугаараа л уншихгүй амьд явж байгаа биз дээ.

-Арай ч бүгдээрээ их хурлын гишүүн болчихоогүй байхаа.

-Их уншвал чам шиг л болно гэдгийг тэд мэддэг л байхгүй юу.

-Галзуу юу?

-Чи бол номноос гадна амнаасаа болсон юм биш үү.

-Юу гэсэн үг вэ.

-Урд насаа мэддэг гэж буу халсан гээ биз дээ.

-Үнэн юмыг үгүй гэлтэй биш

-Ямар аймаар юм бэ.

-Харин тиймээ. Соолоо минь үүнээс хойш надаас холхон явж бай гэж эрсхэн хэлэхэд тэрвээр гомдсон бололтой зовхи нь бууж тонгойн хар цагаан дуугүй өлмийгөөрөө шал үрчиж зогссоноо гялгар ууттай юм хөл дор тавьчихав.

Би түүнийг цаашлуулж:

-Баярлалаа. Гараар өгвөл галзуурхаа мэдэж байна шүү гэвэл

-Чи бол хүнийг ойлгодоггүй адгийн залуу гээд эргэхдээ нүдээ нухлаж байгаа харагдав. Энэ цагаан салхи шиг охин надад талтай байдаг ч миний сэтгэлийн гижиг хүрдэггүй гэх үү дээ. Ер нь би эгоист гээч хохь ёдор ч байж болох юм. Ийм хүн л бусдын сэтгэлийн дөл рүү мөс чулууддаг гэж уншсан санагдах юм.

Үдээс хойш ээж ирлээ. Тэрвээр

-Муу хүү минь турж эцээд нүднээс гарчихаж. Эрүүл саруул хүнийг өвчтөн болгож тамлах гэдэг чинь юу гэсэн үг вэ. Эмч чинь хаана байна гэж тачигнав.

-Өнөөдөр амралтын өдөр шүү дээ.

-Цаад банхар хар чинь юу гээд байгаа юм бэ.

-Оношлох гэж оролдоод...

-Ярих гэхээр янцаглаад яршигтай гахай... Харьж үз. Явая.

-Та харьзнаж бай.

-Чи яах гэж...

-Яахы нь үзье.

Ээж минь эхлээд тачигнаж бас аргадаж, сүүлдээ нулимс унагаж намайг бүр хямраачихаад явав. Эх хүний зовлон эцэсгүй аж. Эр хүн болж төрсөндөө азархмаар ч юм шиг.

Аав нэг удаа ирэхдээ “дарваан доовтрыг” хэмлэж өгсөн. Цаадах нь эрүү нь зуурсан мэт үг унагаагүйд уур нь шатахдаа “Үхсэн хойноо үнэгүй хайрцаг аваарай” гэж зангаад арилсан. Эмч маань түүнээс хойш надаас “аавын чинь бие зүгээр үү” гэж асуудаг болсон билээ. Миний хувьд аавынхаа бухимдлыг ойлгодог юм. Хөөрхий эцэг минь цагийн шуурганд төөрөөд одоо хэр орон зайгаа олоогүй яваа юм л даа. Хэдэн ч нам дамжив даа, хэрэлдээд л зайлдаг. Ард түмний төлөө нам байна уу гэж бухимдана. Яаж байхав дээ. Төөрсөөр яваад төрөл арилжих юм байх даа.

Би эргэлтийн хоолонд тээрч маанайгаад дугхийчихжээ.

...Үхэр шиг эвэртэй, илжиг шиг сүүлтэй, чоно шиг соёотой, бар шиг эрээн атлаа хүнэрхүү нүүртэй зэвүүн амьтан эрхий долооворынхоо хооронд намайг имэрч “Чи муу бөөс хүний зовлонгоор жаргал хийнэ гэнээ” гээд гал руу шидэж орхив. Би орь дуу тавих гэвч дуугарч болдоггүй дэмий л сарваганан шатаж үхдэгийн даваанд намайг хэн нэгний гар татаж авсан нь Соолоо... Би сэрчихэв. Халуурч байгаа мэт хамаг биз арзайн дагжиж хар хөлс цувжээ.

Амьдрал гэдэг унтахуй сэрэхүйн зүүд ажээ гэсэн хачин бодол харвахад би гайхазнав. Гэвч үүнээс илүү оносон тайлал хийж үл чадан ухаан балчирдав. Цас борооны холио шиг орчлонд би цагаасаа өрсөж буюу хоцорч төрсний алин болохыг мэдэхээ байлаа.

Өнөөдөр аргагүй л хагас нь муу өдөр аж. Хөөрхий муу “марксист” минь амьсгал хураачихав. Уг нь унтаж байх шиг л байсан юм. Гэтэл ландгар эгч орж ирээд хөнжлийг нь татсанаа “Хүүе яана” гээд ухасхийн гарч, жижүүрийн эмч авчирсан боловч хожиджээ. Гоожин Нан-ай бид хоёрыг хоёр цаг тасагтаа битгий ороорой гэв. Би ландгар эгчээс “яагаад” гэж шивнэн асуувал клиникийн үхэл гэж сулбуухан хариулав. Би учры нь олсонгүй. Миний хувьд үхэлтэй анхлан

улаан нүүр тулж буй учир жихүүдэс хамаг биеэр тархаж, талийгаачийн орны зүгээс хий үзэгдэл мөсөн жавар хайрах шиг болов. Үхэл гээч цэв хүйтэн байдгийг ийнхүү мэдэрсэн юм. Хэдийвээр хоёр цагийн дараа талийгаачийн цогцсыг хөргүүрт хийж, өрөөг маань ариутгасан боловч, түүний хэвтэж байсан орыг эзэгнэн үлдсэн үхэл, миний өвөрт орж ирэх гэж байгаа мэт санагдан цэрвээтсээр тэр шөнө би унтаж чадсангүй. Хөөрхий “марксист”-ын хувьд зовлонгоос ангичирсан нь яамай даа гэж бодох гэтэл амь нь унтарсан хойноо түүний эдлэх хойт насыг төсөөлж үл чадав. Үхлийг тэрсэж болдоггүй ч эвлэрэх аргагүй юм билээ. Аавын хэлдгээр буянтай хүн зовдоггүй буудуулсан мэт нүд аньдаг нь үнэн ч байлаа гэсэн түүнд олзуурхах юм огт байсангүй. Үхэл гээч юу юм бэ гэж би эрэгцүүлсэн боловч амьдралын төгслөд эцсийн амьсгалаараа тавьдаг хар цэг гэхээс өөр ончтой үг олсонгүй. Ум маани бадь ми хум!

Хорьдугаар тэмдэглэл

Сувилагч эгч нэгэн дугтуй сарвайж

-Чамд өгөөрэй гэсэн юм.

-Хэн?

-Хэн мэдэх вэ. Годгор шар охин байна лээ. Нэрийг нь асуугаагүй Намайг хариугий нь аваарай гэсэн гээд эргэв.

Дугтуйг задалвал Соолоогийн захидал. Түүний бичсэн нь:

“Тоолоо! Би чамд аймаар гомдсон. Танай эмнэлэгээс уйлаад явсан. Тэгсэн чинь хүйтэн төмөр наагаад үсэрсэн. Яасан гээч мангар бүдүүн амьтан намайг “Эргүү пизда чи үхэх нь үү. Хүн шоронд хиймээр байна уу” гэснээ замын хажуугийн зүлэг рүү шидээд будаа болгосон. Би ухаангүй айж ангайхад нөгөө амьтан “солиот” гэж хашгираад сүн. Би дуугараагүй л байхгүй юу. Гэртээ хариад ч үнэнгээ хэлээгүй. Чамаас л болж байгаа. Чи аан гэж бай. Чи намайг алах нээ, ёо ёо.

Ламка чамд хайртай гэж чи бодож байна уу. Үгүй шүү. Галзуу хүүхэд гаргаж үхэхээ больё гэж байх чинь билээ. Ямар аймаар юм бэ.

Би чамд Low you болж болохгүй юу чи намайг эгч ээ гэлүү, яанаа. Чи өөрийгөө чка залуу гээд байгаа юм уу. Больж үз. Охид чамайг галзуу Тоолоо гээд аймаар шоолж байна. Би л лаг эрдэмтэй гэж хуга өмөөрдөг байхгүй юу. Энэ цаас балиар байгаа биз. Миний нулимс ойчоод тэгчихсэн гээд л бодчих. Мэдээ...

Ламка намайг цаад галзуугаасаа эртхэн холдооч. Орой хоёулаа гарч барууныхныг панаалдаж ногоон саая. Харууд нь ДОХ-той шаруудтай сэксдэхэд яах ч үгүй гээд байгаа юм даа. Ичдэггүй амьтан. Тэгээд би яах юм бэ. Чи ч яв л гэнэ дээ. Яг ш дээ. Тэгээд Ламка байна, найз залуудтай байгаад хог дээр гаргасан байхгүй юу. Чамайг ч гэсэн дээ.

Тоолоо, чи бол галзуу биш тий ээ. Панаал л байхгүй юу. Чи биднийг бодвол их уншдаг болохоор панаал л байхгүй юу. Тий ээ.

Манай ангийн Боогий яанаа, надад захиа өгөөд байгаа юм даа. Тэр чинь шүлэг бичдэг. Инээдтэй юм. Тэгсэн чинь, гэрийн багана болоё, гал түлээ ч гэх шиг балайрсан байхгүй юу. Хоёр мод болох гээд байгаа юм уу, шатаж үхэх гээд байгаа юм уу, хаашаа юм бэ. Солиотой байхаа. Солиотой хүн шүлэг бичдэг тий ээ. Би түүний захиан дээр “паах” гэж бичээд хаясан. Надтай дуугарахгүй байгаа. Байг л дээ.

Аа бас шар сонинд чамайг юу гэж бичсэн гээч. Нэгэн дээд сургуулийн оюутан Т хэмээгч урд насаа мэддэг, эрлэгийнд очиж үзсэн гэж бүлтэрчээ. Гэтэл эмч нар ер бусын галзуурал болохыг тогтоожээ. Одоо тэрвээр хүлээтэй байгаа бөгөөд анагаахын түүхэнд анх удаа тохиолдож байгаа энэ үзэгдлийг эрдэмтэд судлаж байна” гэсэн байна. Би яг үгээр нь бичлээ

шүү. Ямар аймаар юм бэ. Яаж ингэж худлаа хэлж чадаж байнаа. Энэ ч яая гэхэв. Тоолоо! Аав ээж хоёр намайг жолооны курсэд оруулахаар болсон. Хүргэн охин хоёртоо “нүдэн бенз” авч өгөх юм гэнэ. Хүргэн нь хэн гээч. Нэг компанийн босс гээд байгаа юм даа, болье. Би, надад аягүй лаг залуу бий гээд хаясан. Хаанахын хэн бэ гээд байна лээ. Хэлээгүй л байхгүй юу. Хоёулаа нэг л өдөр сүр сюрприз барья. Тэгэх үү. Тэгье гэж хэл л дээ за юу. За гээч дээ. Тэгэхгүй бол би яах юм бэ. Шувуу болоод нисэх юм уу. Шувуу ч гоё л доо. Тэнгэрт аягүй гоё л доо. Би чамд нугасгүй. Чиний Соолоо” гэсэн үүнийг үг бүү хэл цэг гээлгүй буулгав. Би Соолоогийн захидлыг үг хэлээр нь өөчлөх гэсэнгүй, бидний үеийхэн ингэж л ярьж бичдэг болоод байгаагаас үндэсний хэврэгшил гэдэг үг босч олноор шуугиж байгаа билээ. Ер нь алив үндэстэн мөхлийн шалтгаанаа өөртөө агуулж байдаг гэсэн ухаарал тэнэгийн толгойд тогтдоггүй юмсанж. Миний мэтийн нэртэй болохоос зүсгүйчүүд монгол толгой тээж явахад хэцүүеэ. Хэрэв бид толгойгүй хөл болчихвол хэн энэ улсын малгайг өмсөх юм бэ. Гэвч над мэт нь улсын маргааш бүү хэл өөрийнхөө өнөөдрийг харахгүй тэмтэрч яваадаа хар толгойдоо гомдож, гутрахаас илүү гарахгүй. Ийм хүн ирээдүй гэдэг үгээр яах ч юм билээ. Бүхий л амьдрал нь өнөөдөртөө багтдаг хүний хувьд ямар ч атугай Соолоогийн захианд хариу бичье гэж шийдэв. Тэгэхдээ Ламка-гийн талаар түүний бичсэн зүйл нь өрсөлдөгчөө замаас зайлуулах гэсэн санаа гэдгийг би гадарлаж байгаа болохоор энэ тухай дурсахгүй өнгөрье гэж шийдсэн юм шүү.

Соолоод илгээсэн миний захидал

“...Соолоо! Захидал бичсэнд баярлалаа. Золгүй өвчтөн би хайр дурлал гээчийн чихэр давс хоёрын алийг ч амтлаагүй явна. Чи бол дөл шиг охин. Чамаас гал авах гэж олон эрвээхэй далавчаа хуйхлана гэдэгт эргэлзэхгүй байна. Ламка чамд үнэн үг хэлжээ. Үнэхээр чи галзуу хүний үр удам тээхээр хүүхэн биш. Үерхэл маань ариун сайхнаараа үлдэг ээ. Харин чи амьдралд өширхөж, өөрийгөө бузарлах хэрэггүй шүү. Үүнийг би чин сэтгэлээсээ гуйя.

Надаас болж чи хувь заяагаа зовлонд хаясан хорвоогийн хамгийн азгүй бүсгүй байх ёсгүй. Галзуу хүн хамгийн эхлээд хайртай хүндээ халддаг тэр бүү хэл, өлгийтэй хүүхдээ тогоотой цай руугаа шиддэг юм гэнэлээ. Одоогоор би тэрэндээ хүрээгүй ч яваандаа өвчин даамжирхаар яаж ч мэднэ. Өвчний түүхээ хааяа нэг хяламхийхэд хий юм харах, дэмийрэх зэргээр улам даамжирч байгаа бололтой юм. Манай эмч их хашир хүн болохоор тойруулж тандаад, надад шийдтэй юм хэлэхгүй нуугаад байх шиг. Би энэ бүхнийг чамд хэлээд ч яах юм билээ. Энэ өвчин намайг зуурсан чигээрээ үхэх өдөрт маань аваачиж өгөхөөс зайлахгүй.

Хүн гэдэг энэ хорвоод явуулын гийчин. Түүний ирэх буцахын хоорондын алга дарамхан зайг амьдрал гэдэг юм биш үү. Тэгэхээр би чиний аз жаргалыг хагаслахыг хүсэхгүй байна.

Соолоо! Чи өнөөдөр надад гомдовч маргааш баярлах болно. Бурхан чамд сайн хань сайхан үрийн жаргал хайрлана гэдэгт итгээрэй. Тоолоо” гэж бичээд ландгар эгчид өгчихөв.

Дотор онгойж, бие хөнгөрөх шиг. Яагаад тэгээ юм бол. Соолоо миний зүрх сэтгэлд зай эзлэж байгаагүй атал түүнийг хажигласандаа тайвшрах нь юусан билээ. Ерөөс миний өөртэйгөө тэрсэлдэх оёг надад байгаа болов уу.

Энэ нь миний араншин уу эсхүл, аминд орших Хөнхөрийн ад мөрийн алин болохыг ялгахуйяа

бэрх. Ямар сайндаа аав минь надад хоргодсон сүнсийг хөөлгөхөөр лам залж байхав дээ. Нэг үдэш хөглөрсөн шар торгон дээлтэй мухар толгойтой нэгэн ирж, хонх дамар тачигнуулж үл мэдэх хэлээр дүнгэнэж баахан будаа цацаад явсан. Гэтэл миний ой санамжид өчүүхэн ч өөрчлөлт гараагүйг бодоход тэр ламбугай ээжийн дооглосноор “шар халзан бух” байсан биз. Сүжиг, сэжиг хоёрт ээж бид хоёр эх хүү л дээ. Бид хоёрыг “номгүй хар лусууд, замгүй улаан тийрэнгүүд” гэж аав цэхвэлздэг юм.

Миний хувьд бурхан дэндүү хол атал, чөтгөр сүүдэр шиг дагаад байх шиг санагддаг. Бурхан хүний оюун санаанд байдаг гэвээс мөн ч олон хүний дотор чөтгөр хоргодох зай бий. Лав л би биеэрээ чөтгөрийн оромж биз гэсэн бодлоосоо цэрвэсхийв.

Хөх будаг загалтуулсан цэвдэг хана, он жилийн хөв чийг нэгшсэн зэвгэр өрөө, нойтон алчууртай модонд хэдрэгдүүлсээр хавирганы яс шиг болсон шал, цөхөрч гутрам энэ орчинд би идээшиж чадахгүй нээ. Энэ зовлонгийн үрнээс түргэн зайлж эрх чөлөөт амьдрал хэмээх гэгээн тамд би бурхантай учрахгүй гэхэд хүмүүстэй тогломоор байна. Тэднийг мэхлэж, өөрөө хулхидуулж, бас амаа ангатал ярихыг нь чихээ дөжиртөл чагнамаар байна. Үнэнчээ үгээр гайхуулж үнэг шиг сүүлээрээ хуурахыг нь хармаар байна. Миний оюун ухаанд бяцхан чөтгөр орогносныг би мэдэрч байна. Энэ чөтгөр өсөхийн хэрээр би хүнээ байх болно. Чөтгөр, чөтгөрөө гайхахгүй гэдгээр би олонтойгоо зүс нийлж түр зуурын ч атугай амаршлыг олно. Амаршил ч юу байхав дээ тэдэнтэй эвлэрэн унтрах болно. Ийнхүү хүн хэмээгч яваандаа чөтгөр болохыг нартын жам гэдэг байж тун магадгүй.

Хорин нэгдүгээр тэмдэглэл

Шар нар бор хоног гэж хэлдэгийн учир юу юм бол? Өнөөдөр гэхэд л зэвхий өдөр... гэж би тэмдэглэлээ эхлэв.

Би охины ордных юм л даа. Өрнийн зурхайгаар бол эрч хүч сексийн хүсэл их байна гэсэн бол Төгсбуянтын зурхайгаар бол миний сүнс бэлхүүс, хоёр гуяны завсар, нууцдаа байна” гэсэн байх юм. Ерөөс энэ зурхай, мэрэг төлөг гээч бол хүн төрөлхтний зохион бодох сэтгэлгээний хийсгэл таамнал төдийгөөс хэтрээ гэж үү. Олон мянган жилийн турш од гаригийн орчил хөдөлгөөн, байгал цаг уурын давтамжаас ургуулсан уран зөгнөлийг сүсэг бишрэлийн хязгаарлалд хураасан төдий юм шиг. Энэ мэтийг төрсэхгүй гэхэд итгэхийн аргагүй юм.

Өнөөдрийн энэ өлзийтэй гэсэн өдөр намайг манай ангийн охин буюу бидний нэрлэдгээр Ламка эргэж ирэв. Эргэх гэж дээ, эсэргүүцэж ирсэн юм.

Түүний нүд булингартжээ. Тэрвээр тоомжиргүйхэн мэнд сольсон болоод гар сарвайв. Түүний гарыг барихад мөс атгах шиг цэв хүйтэн аж.

Ламка:

-Бие чинь яаж байна.

-Яахав дээ.

-Чи үнэхээр өвдсөн юм уу.

-Үхэл бүхэн үнэн байдаг юм.

-Тийм байх аа. Хүн алдаг хүн л сайн мэддэг биз.

-За за, ийм муухай юм яриад яах юм бэ. Сонин сайхан мэдээ дуулгаач. Найз нь энд хэргээ таслуулаагүй хоригдол шиг л байна.

-Удахгүй шүүхээр орж, жинхэнэ шорондоо очно биз. Ламка энэ үгийг хэлэхдээ уруул нь шазвалзаж ер бусын хорсолоор нүд нь гялалзаж байхыг хараад би гайхав. Тэрвээр тэсрэх мэт агдасхийж

-Чи хүн юм уу... эсхүл... Чамд өрөвдөх сэтгэл зүрх гэж бий юү. Чи өөрийгөө юу гэж бодоод байгаа юм бэ. Багш нарыг панаалдаж гайгүй дүн талиулахаа гайхуулахаас өөр чамд юу байгаа юм бэ. Чи даанч яав даа.

-Чи галзуу хүнд байдаггүй юмыг надаас нэхэх гээд байгаа юм биш биз.

-Чи галзуу хүн биш. Зүгээр л биеэ тоосон гажиг амьтан. Чи гэмгүй царайлаад хэрэггүй шүү.

-Ямар гэм хийсэн гэж гэмт царайлах юм бэ.

-Аа тийм үү. Дуулаагүй гэх үү

-Юуг?

-Соолоог...

-Соолоо яасан юм бэ.

-Чамаас болж есөн давхараас үсрээд...

-Тэгээд..?

-Одоо тэр хүн байхгүй. Чамд сайхан байна уу.

-Чи үнэн хэлж байна уу.

-Үхэл худал хэлдэггүй гэж чи ярьсан биз дээ.

Би дуугарах гэвч хоолой зангираад үг гарсангүй дэмий л гөлрөн зогсов.

Ламка дуугаа намсгаж:

-Цаадах чинь чамд үнэхээр дурласан. Тэгэхдээ бүр ухаангүй шүү. Тэгэхэд чи түүнийг яаж гомдоосноо мэдэж байна уу. Галзуу хүний хүүхэд тээх гээгүй бол зайл гэсэн шиг юм бичээ биз дээ. Эмэгтэй хүнийг ойлгох гэдэг эр хүнд тийм ч хэцүү юм биш. Чи түүнийг ганц удаа ч гэсэн эрхлүүлж болсонгүй юу. Тийм сайхан охиныг үнэнээс биш чиг ганц удаа үнсэж зовлонгий нь нимгэлж болсонгүй юу. Нимгэлж болсонгүй юу.

-Ламка минь, тэгсэн бол би ямар нүүрээрээ чамтай уулзах юм бэ.

-Училж болох алдаа гэж байдаг юм.

-Чин үнэнээсээ хэлж байна уу.

-Харууссандаа хэлж байна.

-Сэтгэлгүй хүнтэй...

-Эрчүүдийг мэднээ. Би юу гэж хэлэхээ мэдэхгүй байна. Ямар ч байсан чи Соолоог бага ч гэсэн тайтгаруулсан бол хөөрхий амьтан өдийд амьд гялалзаж явахгүй юу гээд Ламка шуугтнан уйлав.

Би түүний толгойг илж аргадан яагаад ч юм бэ хацар дээр нь үнсчихэв. Ламка цааргалсангүй. Нөгөө хацраа өгч үнсүүлээд аньсгаа нь дарагдах шиг болохуйд би нулимсыг нь алгаараа илбэн арчихдаа дэмий сандчин уруулыг нь үнсэхэд тэрвээр наласхийн намайг тэврэх нь тэр. Энэ явдал хормын төдийд санаандгүй болсон юм.

Ламка явахдаа:

-Бид хоёр хэн хэн нь чамд сайн байсан. Талийгаач чамд юу ярьдаг байсныг би мэдэхгүй. Намайг тас хориод өөрөө санаандаа хүрэх гэж зүтгэсэн юм. Хөөрхийдөө бодохоос нулимс урсаад... гэгчхээд миний уруулыг шовхийтэл үнсээд эргэж ч харалгүй дэгдэн одов. Тэрхэн агшинд миний биеэр цахилгаан гүйх шиг ирвэсхийж ер бусын цочроон хүлээс таслах мэт болов. Надад анх удаа тохиолдож буй энэ гайхалтай мэдрэмжийг таашаах эсэх аль ч учраа олсонгүй.

Би тасагтаа орж энэхүү гайхамшигт учралыг тэмдэглэлдээ бичиж сууна. Харин эхлээд бичсэн “зэвхий өдөр” гэдгээ алаг гэмээр ч юм уу хэмээн эргэлзлээ.

Хөөрхий Соолоо минь... гээд бичтэл цаасан дээр ганц дусал нулимс унан нэвчив. Энэ нулимс шүлэгчдийн бичдэгээр зүрхний шархнаас урссан байж болох юм. Ямар ч атугай амьдралын сум гээч нь намайг оножээ. Ламкагийн хэлсэн үг санаанд орж “нээрэн чи юу юм бэ” гэж өөрөөсөө асуувал хүнэрхүү мич, эсвэл мичирхүү хүн гэсэн хачин тайлалд төөрөөд хариу олж чадсангүй. Талийгаач Хөнхөрийн амь надад оршив гэхэд санаа бол Тооройнх учир урд насаа буруутгах аргагүй. Миний өөрийн алхам бүхний нүгэл миний л нүдээр гарах ёстой гэж амандаа бувгнав. Би үнэхээр Соолоог аргадаж тайтгаруулж чадсангүй. Миний захидлыг ландгар эгчээс аваад надтай уулзалгүй явсан учрыг ч эрэгцүүлсэнгүй. Түүний хайр сэтгэлийн эрчмийг алгуурхан сааруулж аюултай тэсрэлээс хаацайлж чадаагүйдээ харамсавч хожимджээ. Шувуу болоод ниснэ гэсэн үгний үзүүрийг барьж авсангүй. Би Солоог алаагүй гэхэд аварч чадсангүй. Өнөөг хүртэл би хайр дурлалыг адгуусны ороо мэт төсөөлж явжээ. Ер хүнд байдаг цорын ганц дээд төрөлтний аугаа их уярал хайлал, ханьсал агаад амьдрал үхлийн аль руу ч эрслэн дайрах ер бусын ид шидийн хүчин гэдгийг таних ухааны нүд нээгээгүй гөлөг гэж өөрийгөө хараахаас өөр яахсан билээ.

Би эндээс амьд мэнд мулгарч чадвал Соолоогийнхоо шарилын өмнө сөхөрч уучлал гуйх болно. Хэрэв би айл гэр болж охин хүүхэдтэй болдог юм гэхэд түүний нэрийг өгч хайрлана.

Би уг нь Соолоог бус Ламкаг нууцлаг сэтгэлд тээж явсан нь үнэн. Гэвч түүнээсээ эмээж хоёр найзын хооронд орохоос төвөгшөөн хэнд нь ч төдий л тал өгөлгүй унших, үзэхээ урьтал болгож сургуулиа төгсөхөөс өөр юм бодоогүй. Соолоо маань Ламкаг элдвээр хэлж байхад итгээгүйтэй адил, хайрын үгэнд нь уяраагүй. Миний хажиг зожиг зан, оюуны саваа бал цал дүүргэх гэсэн их санаа, өсөж өндийсөн гэрийн болон түүний гаднах орчин намайг хүн адгуус хоёрын завсарт хаясан ч байж болох юм.

Би амьдралдаа өнөөдөр шиг хямарч, орох гарах зайгаа олохгүй эргүүтэж байснаа санахгүй юм. Амьдрал гээчтэй халз тулах нь энэ юм байлгүй дээ. Номонд бичсэнээр бол ийм үед хамгийн зөв шийдэл олох хэрэгтэй гэнэ. Яаж? Шархтай туулай шиг бүлхэлзэн хэвтээ би ямар ч шийдэл олохооргүй эргүүтжээ. Ийм үед нөгөө “шувуу шиг нисэх” гэсэн үг санаанд оровч гагцхүү Ламкагийн үнсэлт намайг аргамжиж байх шиг. Гэвч мөнхийн аргамж гэж юусан билээ. Яг одоо эрлэгт очив гэхэд би хүн амины хэрэгт унах уу, эсхүл хэлсэн, хийсэн нүгэлгүйн учир хэлтрэх үү. Хэрэв миний сүнсийг буцаадаг юм гэхэд хүн төрөл олголгүй олны хэлдэгээр нохой болгож мэднэ. Тэгэхдээ бамбагар буйдан дээр тарвалзаж эзнийхээ хоолноос хуваадаг ямбаны нохой бус хог шиншлэж яваад “Нөөц” компанийн суманд өртөөд

эргэж төрөл горьдох золбин төдийгөөс юуны хэтрээ аж. Уран зохиолд гардаг шиг хөдөө газрын дөрвөн нүдтэй улаан халтар болох заяа ч олдохгүй л байх даа. Алба тамга хашиж амьтны амны хишиг булаагаагүй болохоор халуун тамд арай шалзрахгүй, авгай хүүхний явдал асаргүй учир салтаа саамаа зулгаалгахгүй биз. Энэ ч бас аз шүү. Ийн бодсоноо инээдээ барьж чадсангүй түсхийв. Гэвч ганцаараа инээх нь галзуугийн ёр гэсэн сэжиг нэмэхээс болгоомжилж амаа бариад инээж ч болохгүй энэ орчлонд уйлах буюу зовлонгийн эрх чөлөө хязгааргүйд урам хугарлаа.

Энэ мэтээр элдэв бодол зувчуулан өөрийгөө сатааруулах гэсэн боловч Соолоо, Ламка хоёр нүдэнд харагдан ер амар заяа үзүүлсэнгүй. Арга мухардаад шүлэг бичиж тайтгардаг гэсэн найрагчдын үг санаанд оров. Гэвч үргэлжилсэн үгийн зохиол бишгүй уншиж хэл, найруулгын сорыг түүж хичээсний хүчинд энэхүү тэмдэглэл тэрлэж байгаагаас бус шүлгийн мөр тавьж ер үзсэнгүй. Нэгэн сонины тасархайд.

...Би нэг, хоёр, зуу дурлаж зүүднүүдэд би мянга үхэж зүрхнүүдэд би мянга амилж тэрэндээ би ноцож

Тэнгэртэй, бас шатаж байна гэснийг ч харснаа санах. Ямар ч гэнэв модернизм юм гэнэ. Ингэж бичиж би чадахгүй, чадаад ч яах юм билээ. Ийм юмыг гадаадын хүүхнүүд уншаад гал руу үсэрдэг юм байлгүй дээ. Монгол бүсгүй байтугай морь нь үргэх биз. За, за яруу найрагчид ямаа болж майлна уу үхэр болж мөөрнө үү надад падлий байхгүй. Харин “хайртай гэдгээ харцаараа хэл” гэсэн монгол арга ухаан тун голчтой. Би Ламкатай харцаараа ярихыг хичээдэг боловч тэрвээр “нүд уншиж” сураагүй л болов уу.

Ламка бол айлын ганц охин гэдэг юм билээ. Энхрийлсэн үү, эсхүл гарсан буд гаригий нь бодсон уу эр хүний нэртэй боловч манайхан Ламка гээд нэршүүлчихсэн юм. Нутгийн нь банди нар өхөөрддөг юм уу, түүнийг Найман нуурын лусын охин гэгцгээдэг. Тэр нь ч юу юм бэ. Ер нь харц хоргоосон сайхан охин л доо. Үл мэдэгхэн бидэртэй тэргэл сар шиг түүний дугариг царайд тормолзох хоёр алаг нүд, энгэрээ түлхэж эгдүү хүргэсэн хоёр хөх, дал мөрөө таширлуулан урсгасан дан сүлжээстэй тас хар гээг, эрхэмсэгийн зохицол шиг надад санагддаг юм. Нэгэн удаагийн шинэ жилийн цэнгээнд түүнтэй бүжиглэж байхдаа задгай даашинзны зайгаар түүний цээжин тус газар долоон бурхан од шиг мэнгэ би олж хараад над шиг борогхон заяаны хүн биш юмдаа гэж биширч бас айж билээ. Ийм сайхан охин азаар надад заяав гэхэд түүнийг би насан туршдаа хадгалж чадна гэдэгтээ нэг л итгэхгүй байгаа юм. Сайн хүлэг, сайхан хүүхэн хоёр эзэн олонтой гэдэг биз дээ. Хэрэв би түүний хүссэн жаргалыг өгч чадахгүй бол хэн нэгэн рүү Ламка од шиг харвана. Тэр цагт хайр сэтгэлийн тамд унасан би яах вэ. Зовлонгийн золгүй боол байх уу, эсхүл Соолоо шиг нисэх үү.

Гэгээн хайр дурлалыг юу гэж оноож хэлмээр юм бэ дээ гэж бодолд эрэгцэн санаандаа орсон бүхнийг тэр чигээр нь тэмдэглэв. Гэгээн хайр дурлал бол гоо сайхны ертөнцийн төөрөлд ижлээ олж харсан дэндүү аминчхан таашаал. Чөтгөрийн нүдийг хариулж бурхны чулуудсан хишиг. Зам зуурын уулга алдуулсан учирал. Ганцаардлаас дүрэвсэн сохор эрлийн олз. Сэтгэлийн дарсанд ухаан алдсан хөлчүүрэл. Эрх чөлөөнөөс татгалзсан сайн дурын гэрийн хорио. Гал үр хоёроо газарт үлдээх цорын ганц торгон агшин. Учрал хагацлын хоорондох үд дундын үүлэн чөлөөний нар. Арга билэг хёорын амраглахуйн захицол. Өндрөөс нүд анин үсрэх эрсдэл агаад бэлээс оргил руу тэмүүлэх увайгүй санаархал. Хорвоог бүхлээр нь мартаж

чадах эз бөгөөд аз. Орчлонг үхмэл цөл болгохгүйн тулд аманд нь тусааж буй мөнхийн рашаан... гэхчлэн эмх цэгцгүйхэн үгс хөврөв. Гэвч энэ бүхэн миний ой тойнд хоногшоогүй атал Ламкагийн өөрийн гараар бичиж өгсөн “Бусад хүнд байхгүй тэвчээр гаргаж бас өршөөж би чаддаг. Миний орон зайд хүн нэвтэрэхэд хэцүү. Зөвхөн миний хайртай хүн л нэвтэрч чадна” гэсэн энэ хэдэн энгүүхэн үг миний зүрхэнд хуржээ. “Ламка би чамд хайртай” гэж яг одоо хашгирмаар ч юм шиг. Гэвч галзуугийн шалтаг гаргаж өөрийгөө энд үүрдийн хоригдол болгож болохгүй. Би гэгээн хайрынхаа төлөө Ламкагийнхаа төлөө амьд явах ёстой гэж өөртөө тушаав. Цаг орой болжээ. Орондоо орж нүд анин хажуулахдаа, Ламкагийн бүлээн амьсгал намайг дулаацуулж, түүний бал мэт уруулын шүргээн дунд хуруундаа сувдан бөгжтэй болборойхон гарын илбээн, хацар ирвэгнүүлэх ширүүвтэр гээгний сэрвэгнэхийг би мэдэрч байх шиг санагдав. Хайр дурлалын ид шид гээч нь энэ үү. Яг одоо “Ламка! Би чамд хайртай” гэж байдаг тэнхээгээрээ хашгирсан ч яадаг юм бэ, намайг галзуу гэнэ л биз. Тэртэй тэргүй энэ хорвоо чинь асар том галзуугийн больниц биш юм уу. Би халуун толгойтой хүйтэн зүрхтэй амьдарч чадахгүй нээ. Амьдралд орох үүд нь ганц атал гарах үүд нь дэндүү олон болохоор буцах хүнд уг нь эрлийн зовлонгүй юмсанж. Гэвч би хорвоод хоргодож байна. Миний зоргоор зүрх Ламкагийн цээжинд дүрвэн орогнол эрээд байх шиг. Аймшигт ганцаардлаас амь зулбахын тулд дурладаг гэсэн мэргэдийн үгний үнэнд би гүйцэгдэх нээ.

Гоож-Нан-ай маань сүүлийн үед илааршиж, өнөөдөр эмнэлэгээс гарч байна. Тэрвээр надад

-Чи надад зөв юм хэлж байжээ. Найз нь сэтгэлээ барьж чадлаа. Болдог л юм байна. Харин чи маань юу л болоод байна даа. Эхний ирсэн охин сэргэлэн нь дэндэхгүй бол аятайхан л эрвээхэй байсан. Харин өнөөдрийн ирдэг сайхан тоомсог чинь над шиг юмыг бол хуга гуядчихмаар санагдсан. Эхлээд дотры нь өнгийж харахыг бодоорой. Юу юуны духанд хүрэлгүй сэтгэлээ шавхчихав даа. “Сайхан эм эд, сайн эм эрдэнэ” гэж Наполеон гайхал хэлсэн. Тэр төмөр цэрэг сэтгэлдээ сэлэмгүй байж л дээ. Чи ч яахав номоор зодно л гэх биз. Үхрийн чихэнд тарни шившээд зэлэн дээр хоцров доо.

-Харин ээ... Ингэхэд чи шүлэг бичээд ч байх шиг...

-Эрээчдэг шуу юм.

-Нөгөө шинэчлэгч мундагуудын нэг үү

-Чоно бусдад, шүлэгч өөртөө том харагддаг юм. Харин чи өдрийн тэмдэглэл хөтөлдөг юмаа.

-Эд мөрийн баримт гэх үү дээ

-Үзсэн харсан, бодсон санаснаа цоохорлож байхгүй бол үргээд алга болчихдог юм. Хэзээ нэгэн цагт хэрэг болно.

-Чи намайг уучлаарай. Цээмаагаас сураг байна уу.

-Маш сайхан захидал авсан.

-Тийм байх аа. Чи даанч өөр болчихсон юм.

-Сэтгэлийг сэтгэлээр л засдаг юм байна. Чи харин шархадсан бололтой харагдах юм. Хоёулаа сөгдөж бус сээрдэж амьдарнаа хө. Хорвоогийн гэгээтй зайнд уулзъя. За баяртай...

Би түүнийг хашааны хаалга хүртэл гаргаж өгөөд буцаад салгалж явахдаа Ламка намайг бүрэн эзэгнэсэн эсэхэд эргэлзэв. Тэрвээр саявтархан нэг ирэхдээ Цагаан Дар-эх шиг будаж шунхалсан байв. Оо энгэсгээ үргээчих вий гэж цэрвэж цэмцэгнээд найз охинтойгоо уулзна гэсэн шалтгаар жавар сэнгэнүүлээд явсан. Энэ бол хуурмаглал гэдгийг би гадарласан л даа. Царайлаг хүүхнүүд цагийн өнгөөр үнээ нэмдэг юм гэнэлээ. Ламка өөрийгөө өргөмжилсөн сэхлүүн агаад эршүүдхэн, буулт хийх дургүй, дэндүү зоргоор тархидуу хүн л дээ. Энэ нь бус “эрчүүдийг мэднээ” гэсэн түүний үг голд горойгоод үлджээ.

Юм гэдэг учиртай гэж хуучцуул хэлдэг дээ. Нээрэн тийм юм билээ. Нэгэн жилийн ханын хуанлийн олон зурагнаас “сайхан монгол охин оо” гэж миний шүүрс алдаж байсан эгдүүтэй амьтан хожмын Ламка байсан нь төдийгүй, оюутны ширээнд ингэтлээ ижилсэнэ гэдгийг би яахан тааж төсөөлөх билээ. “Өстэй хүн өл хөтөл дээр” гэдэг дээр би “хайртай хүн ханын хуанли дээр” гэж нэммээр санагдаад байгаа юм. Ламкаг би цагаан, ногоон нь бус “Цэнхэр Дар-эх” гэж дотроо өхөөрдөөд байгаа л даа. Тэрвээр надад цэнхэрлэн харагддаг нь мөнөөх гайхал зурагнаас л сэдэлтэй бөгөөд элчилгүй алс тийш эзгүйрэн алсардаг цэнхэрхэн хөдөө л дөө.

Алаг өдөр арайхийн өнгөрхүйд би Ламкаг зүүдэндээ шөнөжин эрээд олсонгүй. Харин манай доод ангийн Чука гэдэг том цагаан шүдтэй, нүдээрээ дэндүү хөөрхөн инээдэг, болборойхон охин намайг ширтэн зогсож байгаад гэнэт нэр үл мэдэх цагаахан шувуу болоод үүлсийн чөлөөгөөр цайвалзан одох юм. Би түүний хойноос ухасхийх гэсэн боловч хоёр хөл газарт зоосон гадас мэт хөдлөж өгсөнгүй.

Амьдрал гээч ер нь зүүд юмсан бол би нойрондоо төдийгүй сэрүүндээ ч зүүдлэж л яваагаас гараа гэж үү. Тэгсээр нэгэн нартай ч юм уу, бороотой өдөр аль хий үзэгдэл нь барин тавин болж, аавын хэлдгээр баг идээнд баригдах юм биз дээ. Тэр болтол аятайхан харагдсан охидод хайр дурлалын тоос хүртээх гэж яваад нүнжигээ барчихгүй юмсан гэж өөрийгөө тохуурхан инэвхийлэв. Тоорой гэдэг хүн хорвоогийн хохь элэг доог болж гүйцэх бололтой. Энэ бол ганц миний үйл үү, хохьмойт бүхний лайюу? Бурхан, чөтгөр хоёрын хэнээс нь асуухаа мэдэхээ байлаа.

Хорин хоёрдугаар тэмдэглэл

Эмч ирсэн боловч намайг үзсэнгүй. Би нүдэнд нь өртөх санаатай бараагаа харуулах гэж бөртөлзөөд ч нэмэр болсонгүй. Ном унших гэтэл миний толгой хөлдсөн бололтой. Арга баран холхиж байтал манай ангийнхны авчирсан шар сонинууд гудсан дор байгааг санав. Ийм муусайн сонин манай гэрт нүдний гэм. Аав “Миний хүү ийм бузраас болмоор юм битгий уншиж бай” гэдэг бол ээж “Тэртэй тэргүй хогоо дийлэхгүй байна” гэж ад үздэг юм.

Гудамжны сонинууд бол ховын хортон шавьж гэдгийг би мэддэг болохоор уншдаггүй. Уншлаа гээд оюун ухаан буртаглахаас өөр олз нь юусан билээ. Харин өнөөдөр бол уншиж болмоор санагдав. Надад цагийг дэмий хядахаас өөр арга байсангүй.

Бүх сонины духан дээр “чөлөөт хэвлэл” гэсэн үг би олж харав. Хэд хэдэн сонин зэрвэс эргүүлвэл хонь ямаа шиг нам, намаар нь ялгаж болмоор тул, дор бүрдээ аргамжаатай нь хялбархан танигдах юм гээч. Нэг сонинд “Хуучин зандалчдын Ху нам хувааж идэгчдийн нам болов гэсэн байхад нөгөөд нь “Ардчилсан хүчнийхэн хэмээгчид албан тушаалд үхэлдэж “алтан гадас” гэдэг мангасын аманд оров” гэсэн байх юм. Хоёр чоно нэгнийхээ махсагийг гайхав гээд байгаа нь энэ байх нээ.

Миний хувьд аль нэгэн нам гэж дэлүүрдэггүй. Харин зарим оюутнууд тав гурван бор цаас өгвөл хэний нь ч талд хамаагүй хашгардаг. Тэдний цаана хэн нэгэн хэнээт нудрага зангидан түлхэж байгааг хараад дургүй хүрдэг. Энэ муусайн новшин намууд залуучууд, оюутан, эмэгтэйчүүдийг салтаандаа хавчуулж тахар болгодог гэсэн. Тэгээд ардчилал гэдэг нэг л булууг хоёр талаас нь зулгааж хэрэлддэг юм гэнэлээ. Эд нар монголчуудыг хагалж, улс үндэстнээ талцуулан сульдааж, үнэн хэрэгтээ, хорлон сүйтгэж буй тухай бичжээ. үүнээс бусад нь хов жив. Эмс охидыг элдвээр эрээчихдээ энэ сонинуудын хорхой гозгонодог гоц эрдэм нь бололтой. Од, мисс, топ гэхчлэн нэр хоч өгч цаад годгорууд нь ч үүнд нь дуртай янзтай “олны танил байх хэцүү” гэж ирээд бүлтэрсэн байх юм. Ичдэггүй юм байх даа. Хэн ч гэнэв, нэг адуу шиг зузаан уруултай, бас нэг самсаа нь шигдсэн тайрхай хамартай охины зураг тавиад үлэмжийн үзэсгэлэн гэж үгээ олж ядан магтжээ. Тэд нар нь “монголд үерхэхээр залуу байхгүй. Тэд залхуу, заваан, архичин амьтад. Би гадаадын хүнтэй сууна” гэж бурсан байна. Чааваас даа.

Бас нэг будмал үстэй, хөх дэлэнгээ гаргасан эм “Групэн секс” хийж чадна. Энэ бол өнөөгийн соёлт ертөнцөд түгээмэл зүйл гэж олны хэлдгээр “унгас” алджээ. Гэтэл нэг эргүү согоо нь алт мөнгөтэй хөгшин хар юмны өвөрт тэлчилж байгаагаа ариун дурлал, амрагийн жаргал гэж ичих ч үгүй гайхуулсан байх юм. Тийм амьтнаас хайр сэтгэл, хүний үнэр эрээд ч яахсан билээ.

Энд тэндээсээ элдвийг санжуулж үс сахалдаа үнгэлдсэн нэгэн баравгар эр “Тэнгэртэй ярьдаг долоон үеийн бөө” гэж цуурсан бол шар тарлан үнээ шиг шалхгар авгай “рак” эмчилдэг гэж донгосжээ.

Хэдэн хүний халтар зураг бас хэвлэжээ. Тэд бол Гандан хийдийн хавиар урдаа шоо, зоос хөзөр дөчин нэгэн чулуу мэт новш овоолж, шороонд дарагдсан луйварчид агаад сүнс сүлдний

академич гэсэн бичиг өлгөн төөрөг үзэж амьтны халаас хусрааж суудаг аж. Энэ мэтийг уншихад зальтангуудыг ад үзэхээсээ тэдэн дээр салгалж очдог тэнэгүүдийг “хохь нь” гэж тавлалтай. Гуравдах мянган гэж дэлхий даяараа дээшээ тэмүүлж байхад манайхан мухар сүсэгт хүлүүлж сохор мэт мөрөглөж явах ч гэж дээ.

Нэгэн сонинд сайд дарга нарын гоёмсог орд харшийн зураг тавиад “та цалингаараа ийм байшин барьж чадах уу” гэж ам асуужээ. Зэвүү хүрэх шиг. Яам тамга, ямбанд үхэлддэг “сайчуул” маань ард олныхоо буянг хумсалж хагартлаа баяждаг байх нээ. Уг нь энэ гайхлуудыг нөгөө “ганц худагт” нь жаргааж болдоггүй юм байх даа. Манай аав “цаад луйварчингууд чинь бүгдээрээ хөл хэрээтэй, хүзүү холбоотой” гэдэг нь ортой болох нээ.

Шар сонингууд бас баахан машины зураг тавиад “захиалсан хүнд өгнө” гэж буян амласан байх юм. Энэ ч харин зөв арга биз. Эд мөнгөөр даллаж хошгоруулж байгаад эрээн цаасаа гүйлгэнэ гэдэг наймааны нарийн ухаан өнөөдөр манайд яг таарна. Энэ мэтэд явган бодол дэмий тэнэсэн төдийгөөр хэдэн муусайн сониноо гадаах хогийн саванд хийх гэтэл асрагч хүүхэн “Гал ноцооё” гээд авчихав. Өөр юунд ч хэрэглэсэн билээ дээ.

Сувилагч ландгар эгч биднийг сонжин харснаа надад

-Чи ч болдог юмаа уншиж дээ гэж зэвүүтэйхэн өгүүлэв. Би түүний янзыг үзэх санаатай

-Өнөөдөр л шагайж байна.

-Тэгээд?

-Шоронд орох хүн яасан олон юм бэ.

-Чи тэднийг орно гэж бодоо юу

-Тэгж л таарна.

-Гэнэн ч хонгор болдоо.

-Яагаад?

-Гэмт хэргийн бүрэлдхүүнгүй, хэрэг хийсэн нь нотлогдоогүй гээд л тавиад туучихдаг юм. За за дэмийрээд яахав. Тасагтаа орж бай. Эмчийн үзлэгтэй гэж шилбэлзэв.

Би орох гэж яарсангүй, гадаа агаар наранд хоргодон хэсэг зуур холхив. Уг нь хойноосоо задгай салхины урсгалтай амны хөлд хот захдуулан барьсан энэ эмнэлэгийн ханхай хашаа буйдхан байжээ. Гэвч сүүлийн үед газрын дажин дэгдсэнээс гэрийн хороололд бүчүүлжээ. Үүнээс болоод дотор нь галзуу, гадна нь согтуу гэдэг үг гарсан гэлцэнэ. Намайг харсаар байтал нэгэн согтуу эр, хашааны хүрдэн хаалгатай эргэлдсэнээ орооцолдон унав. Амьдралын хил хязгаар ч гэж юусан билээ дээ. Дотроо эл хуль хашаанд мөн ч их зай байгааг хараад, энд ямар байгууллагад газар өгвөл зүгээр юм бэ гэж бодтол шар сонинууд санаанд оров. Тэртэй тэргүй мэдрэлийн гажигтэй улс гаргадаг гэмээр юм чинь энд нэгэн тогооноос хоол идэхэд болох юм гэсэн этгээд нээлтэндээ би олзуурхсан боловч хаа сайгүй ийм орчин байгаа болохоор хаана ч

яахав дээ гэж өөртөө хариу хэлээд урамгүйхэн сажилсаар эмчид үзүүлэхээр чулуун хороондоо шургавай.

Хорин гуравдугаар тэмдэглэл

Эмчийн нойр ханасан, эсхүл түүний сэтгэлийн гижиг хүрсэн алин болохыг таахуйяа бэрх хөхүүн цолгин аяглаж

-Хөнхөр, Тоорой хоёр сайхан нойрсов уу гээд жуумалзав. Би хэгжүүрхэж

-Тамд хүн унтдаг гэж та хэнээс дуулаа вэ гээд инээмсэглэл чулуудав.

Эмч:

-Хорвоод хонхор таарвал дугхийж бай гэж хуучцуул хэлдэг. Нойр бол эм гэснээ өнөөдөр хоёулаа үг хөгжлийн хичээлэрхүү юм хийнэ. Би чамд орон гаран асуулт тавина. Чи оновчтой түргэн хариулах ёстой.

-Дайралцаан уу?

-Хөөрөлцөөн

-Галзуугийн улсын шалгалт байх нээ.

-Аваа, өгөө төдий. За эхлэе. Хүн гэдэг юу юм бэ.

-Сэтгэдэг араатан

-Чи?

-Сүүдэртэй сүнс.

-Би?

-Үргэлжлэлгүй төгсгөл

-Амьдрал?

-Үхэлд хүрэх бартаат зам

-Тэгвэл үхэл

-Эцэсгүй, эдлэхгүй эрх чөлөө.

-Жаргал?

-Өөрийгөө мэхлэх агшин

-Дурлал?

-Тэчяалын туйлшрал

-Эр хүн?

-Нулимстай чулуу

-Эм хүн?

-Өргөстэй цэцэг

-Эх орон?

-Хоргодох байр

-Нам?

-Нийгмийн халдварт өвчин

-Дарга?

-Намын хувалз.

-Өнөөдөр?

-Өчигдрийн шавхруу

-Ирээдүй?

-Сэрүүн зүүд

-Баян хүн?

-Цустай зоос

-Гуйлгачин?

-Төрийн золбин

-Төр?

-Төмөр сараалж

-Шашин?

-Сэхээтний төөрөгдөл

-Хувь заяа?

-Зэрэглээ
-Итгэл?
-Хоносон хоол
-Ард түмэн?
-Дээлтэй сүрэг
-Айл?
-Хилэнцэт диваажин
-Нөхөр?
-Жаргалын шумуул
-Дайсан?
-Итгэлийн боохой
-Зусарч?
-Шалны алчуур
-Матаач?
-Хорт могой
-Авилгач?
-Тамгатай хулгайч
-Хоол?
-Амталсан хор
-Архи?
-Чөтгөрийн хишиг
-Мөнгө?
-Дөнгө
-Хувьсгал?

-Нүдгүй шуурга

-Эрх чөлөө?

-Цуурхал

-Ардчилал?

-Аргамжаа...

Эмч намайг зэв мэт гурвалжин нүдээр сөрлөн ширтсэнээ

-Яахав дээ. Ойр зуурын цэцтэй юм байна.

-Сэтгэцийн тамир тасарчихаагүй байна уу.

-Гаж сэтгэлгээ гэж байдаг юм. Энэ хорвоод өчигдөр, өнөөдөр, маргааш гурав сундалдаг. Чи энэ зайнд багтвал яасан юм бэ.

-Би яасан гэж?

-Өчигдрөө урж хаяад байх юм

-Тэртэй тэргүй урагдаж унасан юм биш үү

-Өчигдрийнхөн энэ улсад гай тарьсан гэхэд гал манасан юм шүү.

-Унтраагаагүй ээ.

-Одоо л нэг оосор бүс ойртохнээ

-Тэгэхдээ уяа хүрэхгүй л болов уу.

-Зам салахаас заяа салахгүй. Эрлэг номун хааныхан ямар хэлээр ярих юм бэ.

-Хөнхөртэй л лав монголоор ярьсан.

-За тэр дээ. Манай улс чинь энэ орчлонд байтугай тэнд данстай гэсэн үг. Бид хоёроос эхлээд эзэд нь гологдоод байгаа юм.

-Урагшаа алхахгүй мөртөө урдаа оруулахгүй юу?

-Тийм ээ. Би тамд, чи диваажинд очих юм байгаа биз.

-Үгүй ээ эмч ээ. Цувж очоод цуг нэг тамд буцлана.

-Тэгвэл энэ нутагт эргэж төрөх эзэн олдох юм уу.

-Айх юм л энэ.

-Үнэмшиж бас үгүйсгэх аргагүй чиний домог сэтгэлийг минь сэндийлчихлээ. Хажууд нь бас хахахад цацах гэгчээр Хөнхөр Тоорой хоёрын хөл толгойнд орооцолдож гүйцлээ.

-Та байтугай би урд хойт насны хооронд тарж орхилоо. Бид хоёрын ноололцооны тухай миний цоохорлож байгаа навтрага бас хоормог болоо биз. Эрлэгийн өгсөн хагас ой санамж, энд миний эргүү толгойгоор дамжиж байгаа болохоор эвлэж ядсан эрээн тасархай байхаас яахав.

-Би чиний хувьд киноны хэдэн тайрхай хальстай үлдлээ.

-Харин би таны хувьд тасархай ч үгүй хоцрох шив дээ.

-Магадгүй. Муу ах нь, баруун зүүнээ ялгахгүй, барьсан, тавьснаа мэдэхгүй болж яваа толгой. Түүн дээр чамайг чагнасаар байгаад чөтгөр байна гэхэд Маркс хөөрхий, чөтгөр байхгүй гэхэд би хөөрхий гэдэг дээр” туллаа. Даваагаа даваад уруу руу нь шааригдаж яваа миний хаана очиж хад мөргөхийг заяа нь мэдэг.

-Та ч үгэндээ харам хүн дээ.

-Үг гээч үнэтэй юм шүү. Одоо л даанч гамгүй эдлэх болж дээ. Үхэр буунд мэнд гараад үгэнд үхнэ гэдэг цаанаа ёзооргүй юм шүү. Чи нас залуу цус шингэн дээрээ яваа хүн. Хэлэхээ хэлж хэлмээргүйгээ залгиж явахад гэмгүй.

-Шударга бус бай гэж үү.

-Бараг тийм. Шударгадуу нь байхаас шударга хүн гэж одоо л төрөөгүй бол огт байхгүй. Үг олширвол үнээ алдана. Түүний хэрээр чи шар цайгүй болно.

-Энэ чинь та өөрийнхөө тухай ганц үг ганхийхгүй гэж хаяагаа манаж байгаа хэрэг үү.

-Чамайг шохоорхоод байвал хаяа шуухгүй гэхэд ханын шийр харуулж болох л юм.

Би бол чиний дотрыг өнгийлөө. Харин чи намайг таниагүй. Би удам хөөвөл ургийн хаялгаар нэг муу тайжийн шавхруу. Тэгэхдээ ядуу малчны хүүхэд гэж гөрзөндсөний хүчинд сургууль соёл дамжиж намд шургаж хүзүүндээ нэг муу чагнуур өлгөөд энэ эмнэлэгт элэгдэж байна. Эхнэр маань хүү охин хоёр үлдээгээд бүрлээч болсон. Охин минь Эрээнээс гахай үүрч, эр нөхөр нэртэй эргүү архичинг тэжээж байдаг юм. Хүү минь хувийн сургуульд багш. Уг нь “капитализмыг алгассан БНМАУ-ын дэлхийн түүхэн туршлага” сэдвээр цол хамгаалсан. Одоо юугаа зааж байдгийг мэдэхгүй. Би цайны хань болгож, өөрөөсөө хориод дүү хүүхэнтэй суусан хүн. Надаар эмчлүүлж байсан балайдуу, өрөвдмөөр амьтан бий. Нийгэм журамд орно гэж горьдож яваад нийтээрээ журамгүйд орооцолдсон олны нэг би гэх үү дээ. Ингээд манайх гэдэг айлын тооно хэлтгий чиний хэлдгээр би утга учиргүй нартыг барах гэж байгаа цоорхой нэгэн оймс. Өтөл насандаа өмч байхгүй, зорилго ч байхгүй хуурай сайран дээр өвчүүгээрээ гулсах өт шиг би үлдлээ. Баруун Нарангийн Энгэрт алсдаа алд газар олдвол тэнд нутагтай

болж магадгүй.

Амьтны ярьдгаар анхаарлын, асуултын тэмдгэн дундуур мөлхөж яваад амьсгалаараа амьдралын эцэст цэг тавина л биз. Айгаад атирах зай байх биш дээ. Энэ бол азгүй заяа. Харин хэд хоног чамтай хэл амаа билүүдсэний эцэст би бүр уймарчих шиг боллоо. Тэгэхдээ Эрлэгийн гэсгээл, тамын тарчлаанаас хулчийх юм алга. Энд надад хоргодоод байх юм ч байхгүй. Хоёр муу хүүхэд хоол идэх хувиа дагана. Би байлаа гээд тэднийг тэнгэрийн умдаг атгуулж чадахгүй...

Би түүний яриаг чагнаад үг дайх санаатай

-Эмч минь. Амьд явах хэцүү ч үхэхээс доргүй. Энэ хорвоогоос уйдлаа ч эргээж чангаа аргамжаа бас бий. Тэр уяа бол монгол туургатны гал голомт, бид хоёрын эх орон Монгол улс. Хилийн дээсээр хөл хоригдон харьшиж яваа ах дүүс минь элэг татан бидний сэтгэл рүү итгэлээ юулж байна. Хэрэв бид гаднын шуурганд галаа унтраачихвал монгол угсаатныг хүмүүн төрөлхтний судраас арчих болно. Ийм учраас бидний үзэл санаа баруун зүүн хаяанд байвч эх орон хэмээх ариун шүтээний өмнө сүсэг нэгэн байх учиртай. Үүгээрээ бид хоёр адилхан үнэ цэнтэй. Хэдийвээр та өнгөтэй өөдтэй үеэ дарангуйллын золиос болгосон ч хүний өөрийн нохойд бариулчихалгүй ус уух хувьтай үлдсэнээрээ азтай хүн.

-Азтай ч юу байхав. Аймхай амьтан гээ биз дээ. Хажуудах нөхрийнхөө толгойг цавчиж байхад хараад зогсож байсан хулчгаруудын нэг нь үнэн. Бүх дэлхийг улаан тугаар өлгийднө гэж сэхүүрч явснаас бус хоёр хөл ард түмний зовлонд зоолттой байгааг мэдэхгүй явснаа нуултгүй болжээ. Миний мэтийн хуучин хааны хугархай эвэртнүүд далдрахаас нааш, монгол улс цэвэршихгүй янзтай даг.

-Уруул давахад хэцүү ч уг нь үнэн үг. Ингэж хэлэхээр таны үеийнхэн “хоормогны савгүй” болгочих гээд цовхчоод унадаг юм. Үе солигдох нь насны эрх, нартын жам. Аливаа цаг эзэнтэйгээ ирээд хамт буцдаг. Тэгэхдээ та бухимдлаа гээд тэнгэр цэлмэчихгүй. Харахад залуу мэт боловч дотоод ертөнц зөнөсөн арчаагүй хүмүүс эх орныг минь өнөөдөр новшилж байна. Хүний нийгэм, манай хот шиг хогоо арилгаж бардаггүй юм.

-Буруугүй үг байна. Гэхдээ муу “дарваан доовтор” нь залууранд тэгшрэхгүй, загийн үндэс хэвээрээ үлдэж дээ.

-Мах бодийн болон оюуны хөгшрөл заавал зуузай холбох албагүй. Цэц булаацалдах халуунаар би таныг хорсгосон бол өс өвөрлөсөн юм уу, гэм нь барагдаж эрдэм нь тодорсондоо давлиурхсаных биш шүү. Дүүдээ хар буруу санаагүй биз.

-Муу ах нь царай нь хар ч гэсэн цаанаа гэгээ бий. Чи бид хоёр хэн хэн нь адармааны агт араатай юм байна. Би өжүүлж хуучнаа хуу өмөөрч чи өөнтөглөж шинэ цагийнхаа өндгийг дарж бишгүй нэг тар тур хийлээ. Ардчилал гээчийн эхэнд хувхай лангуу хусран түрийвчтэй картан булуу мэргэ суухдаа монголын заяа хөмөрчихлөө гэж бодсон өдөр олон бий. Гэтэл контрбандууд гэгддэг ганзгын наймаачид өл залгуулдаг байгаа. Бурханд алга тосоод чөтгөрийн савраас цөвдөл гоочлох гээч л болсон.

-Ганц та биш олон хүн хөл, толгойгоо эрсэн байх шүү.

-Тийм ээ. Санаанд багтамгүй юм аль болсныг тэр гэхэв. Хаашаа явж хад мөргөх бол гэж айж байсан. Харин хэзээ хойно эргэж харвал эрхбиш голдоо нүхтэй мах юм болохоор та нарын зам биднийхээс дээр юм биш байгаа гэсэн бодол дотор минь тонгочих боллоо. Үүнийг өнгөн дээрээ гаргахаас өөрөө ч эмээж явна. Энэ бол би чиний сурталд унаад асга ат шиг ачаа дагана гэсэн үг бас биш. Өвгөн хожуулд өнчин нахиа нүдэллээ гээд намрын хяруунд хялайлгүй мод болж та нарын ойд ургахгүй. Би цагийнхаа бул чулууг буурал толгойдоо дэрлэж нойрсох болно. Хоюулаа хар хоргүй хоёр тийшээ больё. Чи эрүүл биш ч галзуу хүн бас биш юм. Би чамд онош тавьж чадсангүй. Оношлоогүй эмчилгээ байдаггүй гэснээ мөнөөх гайхал “остоороо” шидээд магадлагааг чинь албан ёсоор явуулна гэж тамиргүйхэн инээвхийлж “баяртай” гээд гар сарвайв...

Би үнэн голоосоо:

-Танд баярлалаа. Та намайг эргүүлж тойруулж элдвээр үзэж эцсий нь харлаа. Хэрэв тантай бус хэн нэгэн домчтой таарсан бол миний заяаг хааш нь хаях байсныг мэдэхгүй. Сүнсний мөнхийн хэлхээнд орооцолдсон намайг галзуу биш гэхэд эрүү биш гэх нь таны түмэн зөв. Би эндээс өөрийгөө авч гарахын тулд ярдаглахдаа таныг гомдоосон бол өршөөгөөрэй гээд гарахдаа эргэж харвал дотроосоо гэрэлтсэн дулаахан мишээлээр үдэж билээ.

Эмчийг Би гэгээрүүлж гийгүүлээгүй ч, тэрвээр өөрийгөө эргэж харсан болов уу гэсэн горьдоотой бид хоёр салсан юм. Би түүнийг ад үзэх бүү хэл эр хүний ёсоор эргэж уулзъя гэж бодсоор байсан ч иг маг гэсээр байгаад хоног холджээ. Нэг өдөр хэрэг болгож очвол тэрвээр байсангүй. Тандваас бурхан болсон сураг гарахад гаслан гашуудсан билээ л.

Би урд насандаа Найдангийн Хөнхөр байж бидний нэрэлдэг нөгөө ертөнцөд очсон, тэнд үзсэн харснаа хэний ч чихэнд дахин үгний хугархай шивээгүй бөгөөд хүмүүс ч намайг элий балай эргүү тойруугаар дуудаагүй. Ийнхүү хахь төрж хохь болсон би вээр хүмүүн гуай нарын эрхшээлд хүлцэн ижилссэн болж өлмий зулай хоёрынхоо хооронд өөрийгөө агшаасан өчүүхэн нэгэн оньсого үлдэзнэм бөлгөө.

2002-2004 он

Улаанбаатар

Table of Contents

“Амьдралын нулимс” хэмээх дээд бүлэг

Алаг зэрэглээ

Амины уяа

Амины өр

Солгой санаа

Ялт эзэгнэл

“Тамгатай” буг

Бичил там

Төөрөл

Бузрын шүглээс

“Үхлийн инээмсэглэл” хэмээх дэд бүлэг

Хар олзын үүд

Хоёрдох долоо хоног

Гуравдах долоо хоног

Дөрөвдөх долоо хоног

Тавдах долоо хоног

Зургаадах долоо хоног

Долоо дахь долоо хоног

“Төөргийн төөрөл” буюу тооройн тэмдэглэл

Хоёрдугаар тэмдэглэл

Гуравдугаар тэмдэглэл

Дөрөвдүгээр тэмдэглэл

Тавдугаар тэмдэглэл

Зургадугаар тэмдэглэл

Долоодугаар тэмдэглэл

Наймдугаар тэмдэглэл

Есдүгээр тэмдэглэл

Аравдугаар тэмдэглэл

Арван нэгдүгээр тэмдэглэл

Арван хоёрдугаар тэмдэглэл

Арван гуравдугаар тэмдэглэл

Арван дөрөвдүгээр тэмдэглэл

Арван тавдугаар тэмдэглэл

Арван зургадугаар тэмдэглэл

Арван долдугаар тэмдэглэл

Арван наймдугаар тэмдэглэл

Арван есдүгээр тэмдэглэл

Хорьдугаар тэмдэглэл

Хорин нэгдүгээр тэмдэглэл

Хорин хоёрдугаар тэмдэглэл

Хорин гуравдугаар тэмдэглэл